

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТЭМДЭГЛЭЛ

/Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар эрх
бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах/



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР

Та сонсголын тэмдэглэлийн цахим хувьтай дараах QR
кодыг уншуулан танилцах боломжтой.

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр /Лхагва гараг/ зохион байгуулсан “Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар эрх бүхий байгууллагуудын тайлан, мэдээлэлтэй танилцах ерөнхий хяналтын сонсгол”-ын тэмдэглэл

Ерөнхий хяналтын сонсголыг 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 13.00 цагт Төрийн ордны “Их Монгол” танхимд зохион байгуулж, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг даргалав.

Ерөнхий хяналтын сонсгол явуулсан сэдэв:

1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааны хүрээнд өнөөг хүртэл төлбөрийг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй /Оффтейк/ болон төлбөрийг урьдчилан авч ашигласан гэрээнүүдийн талаар;

2. Нүүрсний асуудлаар 2013 оноос хойш шийдвэрлэгдсэн, хэрэгсэхгүй болсон хэргүүдийн талаарх мэдээлэл болон шалгагдаж байгаа хэргүүдийн явц, шийдвэрлэлтийн байдлын талаарх мэдээлэл;

3. Монгол Улсаас 2020-2022 онуудад нийт хэдэн боомтоор, ямар хэмжээний нүүрс гаргасан, хэдэн аж ахуйн нэгж ямар хэмжээгээр олборлож, ямар аж ахуйн нэгж тээвэрлэж, хэдий хэмжээний орлого олсон, коксжих нүүрсний дэлхийн болон БНХАУ-ын зах зээл дээрх үнэ, хилийн үнэ, уурхайн аман дээр борлуулж буй үнийн зөрүү, түүний шалтгаан. Энэхүү үнийн зөрүү нь хоёр улсын тодорхой этгээдүүдийн авлига, хууль бус үйл ажиллагааны орлого, татвараас зайлсхийхэд нөлөөлсөн эсэх;

4. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслүүдэд ямар хэлбэрээр, хэдий хэмжээний санхүүжилт гарган оролцсон болон эдгээр төмөр замуудын 1 км тутмыг ямар өртгөөр барьж байгуулсан тухай.

Сонсголд оролцогчид:

Сонсголын үйл ажиллагаанд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүн Ц.Цэрэнпунцаг, Д.Батлут, Б.Баттөмөр, Д.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Н.Ганибал, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Т.Доржханд, Б.Жавхлан, Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл, С.Чинзориг нараас гадна Ш.Адьяаа, А.Адьяасүрэн, Ц.Анандбазар, С.Амарсайхан, Г.Амартүвшин, Б.Батжаргал, Ж.Батсуурь, Б.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, С.Бямбацогт, С.Ганбаатар, Г.Ганболд, Г.Дамдинням, Ц.Идэрбат, Н.Наранбаатар, С.Одонтуяа, Д.Өнөрболор, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Сэргэлэн, Д.Тогтохсүрэн, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, Д.Цогтбаатар, Н.Энхболд, Т.Энхтүвшин нарын гишүүд оролцсон.

Сонсголд тухайн сэдвээр мэдээлэл өгөх эрх бүхий байгууллагын удирдах албан тушаалтныг сонсголд дуудан мэдэгдэл хүргүүлсний дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Үндэсний Аудитын газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Хил хамгаалах ерөнхий газар, Монгол Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Боомтын сэргэлтийн үндэсний хороо, Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ, Барилга инженерийн цэргийн удирдах газар, Халдварт өвчин судлалын

үндэсний төв зэрэг төрийн 19 байгууллагын удирдах албан тушаалтнууд болон “Эрдэнэс тавантолгой” ХК, “Монголын төмөр зам” ТӨХК, “Тавантолгой төмөр зам” ХХК, “Улаанбаатар төмөр зам” ХНН зэрэг төрийн өмчит 4 компанийн төлөөлөл, “Бодь Интернэшнл” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Эс энд Эй трейд” ХХК, “Бридж констракшн” ХХК, “Сан” ХХК, “ЧММ” ХХК, “Литонпро” ХХК, “Монгол тээвэр нэгдэл” ХХК зэрэг хувийн өмчит компанийн төлөөлөл сонсголд оролцсон.

Сонсголыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулагдаж байгаа эсэхэд хяналт тавих, сонсголд өөрийн биеэр оролцон тодорхой асуудлаар санал хэлэх, сонсголд зайлшгүй оролцох шаардлагатай сонсголд оролцох хүсэлт гаргасан нийт 225 иргэн, хуулийн этгээд бүртгүүлснээс 108 иргэн сонсголд оролцож, хэвлэл, мэдээллийн 17 байгууллага сонсголын үйл ажиллагааг сурвалжилсан.

Сонсголын үйл ажиллагаанд Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүн Ц.Цэрэнпунцаг, Д.Батлут, Б.Баттөмөр, Д.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Н.Ганибал, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Т.Доржханд, Б.Жавхлан, Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл, С.Чинзориг нарын 15 гишүүн хүрэлцэн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр сонсгол 13 цаг 10 минутад Төрийн ордны “Их Монгол” танхимд эхлэж, 9 цаг 30 минут тасралтгүй үргэлжилж, 22 цаг 40 минутад дуусав.

Ерөнхий хяналтын сонсгол эхлэхээс өмнө сонсголын дэг, сонсголын зохион байгуулалттай холбоотойгоор сонсголд оролцогчдыг саналаа хэлэхийг сонсгол даргалагч зөвшөөрсөн тул сонсголд оролцогч 12 иргэн саналаа хэлж, сонсгол даргалагч тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Н.Ганибал, Т.Доржханд, Ш.Раднаасэд, Д.Өнөрболор, О.Цогтгэрэл, Д.Цогтбаатар нарын 7 гишүүн асуулт асууж, үг хэлсэн бол сонсголд оролцож санал хэлэхээр урьдчилан хүсэлт гарган бүртгүүлсэн 55 иргэн саналаа илэрхийлж, холбогдох албаны хүмүүс давхардсан тоогоор 44 удаа тайлбар, мэдээлэл өгөв.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, С.Одонтуяа нарын гишүүд санаачилж нийгмийн дунд үүсээд байгаа нүүрстэй холбоотой эргэлзээтэй асуудлаар олон нийтэд мэдээлэх зорилгоор ерөнхий хяналтын сонсгол явуулах нь зүйтэй гэсэн санал гаргасан. УИХ-ын дарга гаргасан саналыг хүлээн авч, УИХ-ын гишүүн Г.Ганболдоор ахлуулан С.Одонтуяа, Т.Доржханд нарын гишүүдийг бүрэлдэхүүнд нь оруулсан ажлын хэсэг байгуулах тухай захирамж гаргаснаар ерөнхий хяналтын сонсгол явуулах бэлтгэл хангах ажлын хэсэг ажиллаж, өнөөдрийн нээлттэй сонсгол явуулж байгааг та бүхэнд бас хэлэхийг хүсэж байна.

Би та бүхэнд нээлттэй сонсгол явуулахтай холбоотой товчхон мэдээлэл өгье. Хэчнээн хүн оролцуулж байгаа, ямар бүрэлдэхүүнтэй оролцож байна вэ гэдэг талаар. УИХ-аас ерөнхий хяналтын сонсголыг 3 дахь удаагаа зохион байгуулж байгаа ба энэ нүүрсний асуудлаарх 3 дахь ерөнхий хяналтын сонсгол. Өмнө нь бид агаарын бохирдлын Хөгжлийн банкны асуудлаар ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулж байсан. Энэ удаагийн ерөнхий хяналтын сонсголоор мэдээлэл авах зорилгоор нийтдээ төрийн 18 байгууллагын удирдлага болон хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байгаа төрийн өмчит 4 компани, хувийн өмчийн 16 компанийн эрх бүхий албан тушаалтнуудыг сонсголд оролцуулахаар мэдээлэл хүргүүлж, дуудаж оролцуулж байна. Мэдээлэл хүргүүлсний дагуу 107 албан тушаалтан сонсголд оролцохоо мэдэгдэж, өнөөдрийн сонсголд оролцож байгаа гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Энэ нүүрсний асуудлаар явуулах ерөнхий хяналтын сонсголд 225 иргэн оролцохоо илэрхийлж хүсэлт ирүүлсэн. Эдгээр иргэдийг нээлттэй, ерөнхий хяналтын сонсголд

оролцуулах боломжоор тэгш хангахын тулд бид Төрийн ордны “Их Монгол” хуралдааны танхимд сонсголынхоо үйл ажиллагааг үргэлжлүүлж байна.

Сонсголын үйл ажиллагааг бид аль болохоор иргэдэд нээлттэй, ил тод явуулах зарчим баримталж байгаа. Энэ хүрээнд ерөнхий хяналтын сонсголыг иргэд, олон нийтэд хүргэх зорилгоор хэвлэл мэдээллийн 17 байгууллага хүсэлт ирүүлж, ерөнхий хяналтын сонсголыг сурвалжлах хүсэлт ирүүлснийг хүлээн авч оролцуулж байгаа гэдгийг бас та бүхэндээ хэлэхийг хүсэж байна.

Мөн парламентын сэтгүүлч нар сонсголын үйл ажиллагааг нээлттэйгээр сурвалжилж, олон түмэнд хүргэхээр бас ажиллаж байгаа гэдгийг та бүхэндээ хэлэхийг хүсэж байна. Би та бүхэнд нээлттэй сонсголын дэгтэй холбоотой зүйлийг танилцуулъя.

1 дэх асуудал. Бид ерөнхий хяналтын сонсголоор олон нийтэд зарлагдсан 4 сэдвийн хүрээнд холбогдох байгууллагуудаас бэлтгэсэн 6 илтгэл, мэдээллийг сонсоно. Эдгээр мэдээллийг хийж байгаа албан тушаалтнууд индэр дээр гарч ирж мэдээллээ танилцуулна. 1 мэдээлэл танилцуулах хугацаа 10 минутаас ихгүй байх дэгтэй байгаа гэдгийг мэдээлэл хийх албан тушаалтнуудад анхааруулж хэлье. Мэдээлэгч нар үндсэндээ сонсголд үнэн зөв мэдээлэл өгөх, бодитой дүгнэлт өгөх үүрэгтэй гэдгийг бас сануулж хэлж байна.

Мэдээлэлтэй танилцсаны дараагаар илтгэл болон мэдээлэл өгөхөөр сонсголд дуудагдаж ирсэн оролцогчдоос Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авах дэгтэй. Гишүүд танхимын дээд индэр дээр асуулт асуух, гишүүдийн санал авахаар техникийн боломж байхгүй учраас асуулт асуух гишүүд гараа өргөж бүртгэлд орно. Сонсгол даргалагчийн зүгээс гишүүдийг Улсын Их Хурал дахь намуудын төлөөллөөс ээлжлэн асуухаар зохион байгуулах саналтай байна. 1 гишүүний асуулт үндсэн 5 минут, хариулт хангалтгүй байна гэж үзвэл нэмэлт 1 минут, хариулт хангалтгүй байна гэвэл мөн нэмэлт 1, ингээд нийтдээ 7 минутаас хэтрэхгүйгээр 1 гишүүн асуулт асууна гэсэн ийм дэг байна.

Сонсголд оролцож байгаа иргэдээс бас нэг хүлцэл өчих юм байна. Та бүхний саналыг л сонсьё гэж бодож байна. Энэ ерөнхий хяналтын сонсгол зохицуулагдсан хуультай, хуулиараа явагдана. Тэгэхдээ нөхцөл байдал, бас жаахан ойлголцоод зохих зөвшилцөлд хүрэх шаардлага байгаа учраас би дэгийг жаахан өөрчлөөд явчихвал яадаг юм бол гэсэн ийм бодолтой байна. Та бүхэн зөв ойлгоно биз.

Хуулиар бол оролцож байгаа иргэд, мэдээлэл хийсэн албан тушаалтнуудаас асуулт асуухгүйгээр зөвхөн саналаа хэлэх ийм хуулийн зохицуулалттай юм байна. Гэхдээ оролцогч иргэд та бүхэн мэдээлэл хийсэн албан тушаалтнуудаас асуулт асуухаар бол сонсгол даргалагчийн зүгээс ийм боломжийг хангах зохицуулалтыг дэгэндээ оруулбал ямар вэ гэсэн бодолтой байна. Та бүхэн дэмжиж байгаа бол гараа нэг өргөөдөх үү. Ийм дэгээр явбал. Гэхдээ нэг зүйл байна, бас ойлголцох. Хуулиараа сонсголд оролцож байгаа иргэдээс санал хэлэх бүртгэлийг урд өдрийн 17 цагаар тасалбар болгож авсан байгаа. 2 өдрийн өмнө асууж авсан.

2 дахь асуудал нь, сонсголд оролцож байгаа иргэд үг хэлэх нэрсээ өгсөн байгаа. Өнөөдрийн байдлаар 59 иргэн өгсөн байгаа. 59 иргэд үг хэлнэ гэж бүртгүүлсэн байна. Цаг жаахан хоцорч үдээс хойш сонсгол эхэлж байгаа учраас та бүхэн зөвшөөрвөл шинээр үг хэлэх, асуулт асуух иргэдийн нэр авахгүйгээр энэ 59 хүн дотроосоо 50 хувиар нь ч юм уу асуулт асуулгаад, 50 хувиар нь үг хэлүүлээд ингээд сонсголоо явуулчихвал яасан юм бэ гэсэн сонсгол даргалагчийн зүгээс санал байна. Энэ дээр манай иргэд, оролцогчид саналаа илэрхийлбэл зөв байна. Би бол 59 хүнээсээ нэг хэсгийг нь санал, үг хэлүүлье. Нэг хэсгээр нь асуулт асуулгаад явчихъя гэсэн ийм саналтай байна гэдгийг хэлье.

Үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байж байгаарай. Би дэгээ эхлээд танилцуулаад дуусгачихъя. Улсын Их Хурлын гишүүд мэдээллээс асуулт асуусны дараагаар үг хэлнэ. Үг хэлэх гишүүдийн нэрийг техникийн боломжоосоо шалтгаалаад дахиж гар өргүүлж авна. Гэхдээ Улсын Их Хурлын гишүүд давуу эрх эдлээд байна гэж та бүхэн харж магадгүй. Тийм учраас үг хэлэхдээ Улсын Их Хурлын гишүүд, тэгээд иргэд гэсэн байдлаар явуулъя гэсэн дэгтэй байгааг хэлье.

Харин үг хэлэхдээ хуульд заасан 5 минутаараа хэлэх дэгтэйгээр өнөөдрийн энэ сонсголыг явуулахыг та бүхэнд танилцуулж байна. Үг хэлэх хүсэлт ирүүлсэн 59 иргэд хэн нь үг хэлэх, асуулт асуух тухай хүсэлтээ зохион байгуулагч нарт өгвөл хүсэлтийн дагуу боломжийг хангаж явуулъя гэж бодож байна. Энэ дээр иргэд байр сууриа илэрхийлэх үү. Түүнийг нь сонсоод дэгээ тогтоогоод явчихъя гэсэн бодолтой байна.

Ерөнхий хяналтын сонсгол эхлэхээс өмнө сонсголын дэг, сонсголын зохион байгуулалттай холбоотойгоор сонсголд оролцогчдыг саналаа хэлэхийг сонсгол даргалагч зөвшөөрсөн тул сонсголд оролцогч 12 иргэн саналаа хэлж, сонсгол даргалагч тайлбар хийв.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Ингээд сонсголтой холбогдуулаад маш олон иргэд санал бодлоо хэлчихлээ. Тийм учраас дийлэнх нь сонсголоо явуулъя. Нэгэнт иргэдийнхээ саналыг сонсьё гэсэн Улсын Их Хурлаас зарласан шийдвэртэй. Холбогдох албаны мэдээллийг сонсож тайлбар авъя гэж байгаа. Энэ сонсголыг эхэлсэн нь зүйтэй. Эхлүүлж байгаа нь сайн хэрэг. Ингээд явуулъя гэж дийлэнх иргэд нь санал нэгдсэн гэж үзэж байна.

Тийм учраас сонсголоо үргэлжлүүлье. Харин тэр 6 мэдээллийг зургууланг нь сонсох юм уу, үгүй юу гэдэг асуудал байна. Хэрвээ та бүхэн өөрсдөө QR кодоо уншуулаад мэдээллийг авчихсан, сонсох шаардлагагүй ээ, зайлшгүй шаардлагатай зарим нэг мэдээллийг л сонсоё гэвэл сонс.

Хоёр дахь асуудал нь урьдчилсан байдлаар 59 иргэн үг хэлье гэсэн саналаа өгсөн юм. Энд Улсын Их Хурлын гишүүд ороогүй. Улсын Их Хурлын гишүүд үг хэлж, асуулт асууж, санал хэлэх бол ингэж асуухаар гараа өргөж саналаа өгнө шүү. Тэгээд тэр 59 хүн дээр нэмэгдэнэ. 59 хүн дан иргэдийн төлөөлөл байгаа.

Иргэд чөлөөтэй үгээ хэлье гэж байгаа бол 59 дээрээ нэмээд овог нэрээ өгөөд иргэн бол иргэнээр, аль нэгэн байгууллага, ТББ, иргэний хөдөлгөөнийг төлөөлж байгаа бол тэрийгээ бичээд цаасаар зохион байгуулж байгаа ажлын албанд өгчих. Ингээд сонсголоо эхэлбэл яасан юм гэж бодож байна.

Би бол гишүүд ч асуух хэрэгтэй, иргэд ч асууж, үг хэлэх хэрэгтэй гэж бодож байна. Гишүүд бол гишүүдээсээ асуухгүй шүү дээ. Гишүүд холбогдох мэдээлэл, тайлбар хийж байгаа эрх бүхий албан тушаалтнуудаас асуултаа асуугаад үгээ хэлнэ.

Тийм учраас гишүүд, иргэд адилхан, асуулт асууж, хариулт авч, үг хэлэх эрхтэй. Ээлжлээд сөөлжүүлээд ингээд явъя гэсэн саналтай байна. Асуулт, санал нэг гээд 5 минутаар явбал яасан юм бэ? Тэгж тогтлоо шүү. Одоо бүгдээрээ мэдээллээ сонсож эхэлье.

Эхний мэдээлэл нүүрсний олборлолт, тээвэрлэлт, экспорт болон нүүрсний салбараас төвлөрүүлсэн төсвийн орлого, нүүрсний үнийн зөрүүний талаарх мэдээллийг УИХ-ын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулъя. Жавхлан сайдыг индэрт урьж байна.

Мэдээлэл хийж байгаа албан тушаалтнууд 10 минутад багтаана. Бид дэг ярьсан учраас 10 минутдаа багтаагаад маш товч тодорхой мэдээлэл өгөхийг хүсэж байна. Индэрийн микрофон өгье.

УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан: Өнөөдрийн сонсголд оролцож байгаа та бүхэнд өдрийн мэнд хүргэе. 6 мэдээлэл байгаа учраас товчхон шуурхай хийхийг хичээе.

Өнөөдөр энд танилцуулж байгаа тоонууд нь бол дандаа албан ёсны статистик тоонууд байгаа шүү. Нүүрс олборлодог, экспортолдог ийм ААН компаниудын санхүүгийн тайлан болон татварын тайлан, мөн Засгийн газрын өөрийн бүтцийн аудитын хяналт шалгалтын байгууллагуудын хяналтын шалгалтын тайлангаас албан ёсоор авсан тоон мэдээллүүд байгаа.

Ер нь Монгол Улс маань 1995 оноос жижиг том ер нь экспорт хийж эхэлсэн байдаг юм. Тэрнээс хойш нийтдээ 336 сая тонн нүүрс экспортолсон байна. Үүний 298.4 сая буюу 80 хувь нь үндсэндээ 2011 оноос өдийг хүртэл хийсэн экспорт байна.

Энд нэр дурдагдсан 6 компани нийт экспортын үндсэндээ 90 хувийг дангаараа экспортолдог. “Эрдэнэс Тавантолгой” ХК, МАК ингээд энд дарагдаж байгаа нийт 8 компани байгаа. Энэ 8 компани “Эрдэнэс Тавантолгой” ХК, Энержи Ресурс, Монгол алт компани буюу МАК, Тавантолгой, Саус гоби, Мон энко, Чинхуа МАК, Хангарьд эксплоришн гээд энэ 8 компани нийт экспортын 90 гаруй хувийг хийсэн байна. Саяын 336 сая тонн нүүрсийг экспортлоод үүнээс энэ хугацаанд нийтдээ 45.2 их наяд төгрөгийн борлуулалтын орлого олсон байгаа. Үүний 43.5 буюу 95 хувийг нь 2011 оноос өнөөдрийг хүртэл олсон борлуулалтын орлого ийм байна. Үүнээс нийтдээ 10 их наяд төгрөгийн татвар авсан байна. 8.9 их наядыг төлсөн 0.7 нь татварын өр буюу энэ акттай холбоотой тооцоонууд байна. Ингээд нийтдээ 10 их наяд. Нүүрсийг тойроод ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 77, үүнийг экспортолдог дамжуулдаг, ийм 372 трейдер компаниуд одоогоор санхүүгийн тайлангуудаа өгсөн байна.

Ер нь нүүрс тойрсон, бид хулгай гэж яриад байгаа хяналт шалгалтаар илэрсэн энэ зөрчлүүдийг 5 үнэгт хувааж байгаа.

Нэгдүгээрт, тээвэртэй холбоотой асуудал. Энэ дээр нэлээд том, далд эдийн засаг үүссэн байгаа юм. Өөрөөр хэлбэл орлогоо нуун дарагдуулсан байж болзошгүй гэж.

Хоёрдугаарт, оффтэйкийн асуудал. Оффтэйк талаар бол би нэлээн дэлгэрэнгүй мэдээлэлтэй болсон. Хилийн хяналтын байгууллагад бүртгэлгүй, эсвэл хоосон гэж бүртгүүлсэн тээврийн хэрэгслийн тоо хэмжээ зөрсөн.

Гуравдугаарт, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эзэмшлийн буюу тэр том талбай дээрээс хөндлөнгөөс орж ирж, 340 мянган тонн нүүрс бидний нөгөө мөргөцөг гэж яриад байдаг. Энийг зөөгөөд аваад гарчихсан ийм зөрчил байгаа.

Дөрөвдүгээрт, оффтэйк гэрээтэй холбоотой. Нөгөө талдаа бүтээн байгуулалтын хэт өндөр үнэлгээтэй ийм хохирол учруулсан байж болзошгүй гэж харж, судалгааны шалгалтуудыг үргэлжлүүлж байна.

Тавдугаарт, татварын хувьд энэ хугацаанд татварын байгууллагаас нийтдээ 239 удаа шалгалт хийсэн байдаг.

177 компанид 239 удаагийн шалгалт хийсэн нь бага тоо биш. Өөрөөр хэлбэл татварын байгууллагын хувьд нүүрс тойрсон, нүүрстэй холбоотой экспортод олборлодог, мөн тодорхой хэмжээний баяжуулалт хийдэг компаниуд татварын хувьд нэлээн эрсдэл бүхий ААН-үүд байжээ гэсэн үг. Ингээд 1.6 их наяд төгрөгийн зөрчил илрүүлсэн. 295 тэрбум төгрөгийн акт тавьсан байна. Ингээд компани бүрээр тоонуудыг харуулсан байна. Та бүхэн QR кодоор дамжуулаад мэдээлэл дэлгэрэнгүй очиж байгаа учраас нэг бүрчлэн тоог нь харж болно. Тэгээд аль болох товчлоод явъя. Энэ нь мөн л тээвэртэй холбоотой. Татварын байгууллагын шат шатны хяналт шалгалтууд энэ хугацаанд хийгдэж байсан. Нийт 267 ААН-д татварын хяналт шалгалт хийсэн байна.

Ингээд 1.1 их наяд төгрөгийн зөрчил илрүүлээд 80 тэрбум төгрөгийн акт тавьсан байна. 2018-2022 онд хамгийн их буюу 267 ААН-үүд дээр шалгалт хийсэн. 18 ААН дээр одоо хяналт, шалгалт хийгдэж байгаа. Энэ хяналт шалгалттай холбоотой нэлээд шүүхийн асуудал үүссэн. Татварын байгууллагаас гэрээний үнэ биш, цаана яг бодитоор явагдаж байж болзошгүй өндөр үнээр татварыг тавьсан боловч тэрийг хүлээн зөвшөөрөлгүй шүүх дээр очсон. Энэ шүүх дээр очсон тохиолдол бүр дээр татварын актууд харамсалтай нь ялагдсан байгаа.

Өөрөөр хэлбэл өнөөдөр хүртэл яг гэрээн дээр байгаа тэр бага дүнтэй борлуулалтын орлогоосоо татвар төлсөн ийм байдалтай явж иржээ. Мөн АМНАТ-тай холбоотой зөрчил бий гэж иргэд, улс төрчид ярьж байгаа. Харин бид энэ хугацаанд АМНАТ дээр бол харьцангуй бага алдсан, ер нь бол алдаагүй гэж хэлж болно. Акт, зөрчил, үнэлгээ, жин гээд иймэрхүү зөрүүнүүд байгаа. Гэхдээ ер нь бол 2014 оноос хойш 2014, 2019 оны тогтоолд манай Засгийн газрын үед өөрчлөлт орсон байгаа. Анхны тогтоолд өөрчлөлт оруулсан бөгөөд бүх тогтоол дээр хэзээ ч бид яг амны үнээс АМНАТ авч байгаагүй. Дандаа хил нөхцөлтэй үнэлгээнээс авч ирсэн. Тийм учраас АМНАТ дээр алдсан хэрэг зүйл бол харьцангуй бага гэж хэлж болно.

Оффтэйк гэрээний бүх мэдээллүүдийг ил болгосон. Үндсэндээ Тавантолгой, “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр ийм 7 оффтэйк байна. Эхний 2 нь Тавантолгой, Гашуун сухайттай холбоотой.

Дараагийн 3 нь Богдхан төмөр замтай холбоотой. 6, 7 дахь оффтэйкүүд нь бол хараахан хэрэгжиж эхлээгүй байгаа. Ийм гэрээнүүд байна. Эндээс бид ийм зөрүү байна. Энийг алдсан байж болзошгүй. Алдагдсан боломж ийм гэж ингэж тооцоо гаргасан. Ингээд 187.7 тэрбум төгрөгийн үнийн зөрүүнээс ийм боломж алдагдсан байна гэж тооцоолол хийсэн. Энэ 3 зөрчил бол гаалийн байгууллагын дотоод хяналт шалгалтаар илэрсэн ийм зөрчлүүд байгаа юм шүү. Энийг 2018, 2019 онуудад хуулийн байгууллагуудад шилжүүлсэн. Өнөөдрийг хүртэл хуулийн байгууллагууд шалгаж байгаа гэсэн. Би ийм ойлголттой байгаа. Ингээд 3 төрлийн зөрчил байгаа юм.

Нэгдүгээрт, энэ гэрээгүй болон гэрээнээс илүү тоо хэмжээгээр экспортолсон. Энд 21 компани гэрээнд заасан хэмжээнээс нэг сая тонн нүүрс илүү экспортолжээ. 12 компанийн эх үүсвэр нь тодорхойгүй, гэрээгүй 515000 тонн нүүрс экспортолсон байна.

Хоёрдугаарт, гаалийн бүртгэлд хоосон машин хил гарсан зөрчил байгаа юм. Үүнийг мөн л гаалийн байгууллага дотоод хяналтаараа илрүүлж, хуулийн байгууллагад мэдээлсэн байгаа. Энэ дээр ийм статистик байна.

Гашуун сухайт боомтоор 86 компанийн 2527 тээврийн хэрэгсэл олон удаагийн давтамжтайгаар ачаагүй гэсэн бүртгэлээр гарчээ. Энэ хяналт шалгалтаар илэрсэн зөрчил нь экспортын гаалийн бүрдүүлэлтгүйгээр улсын хилээр гарсан байгаа. Ямар ч бүрдүүлэлт

байхгүй. Тэгээд 3758 тээврийн хэрэгслээр нийт 379000 тонн нүүрс экспортолсон гаалийн мэдүүлэг мэдээлэл манай дээр байхгүй байна. Түрүүн дурдагдсан энэ Тавантолгой ХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эзэмшлийн талбай дээрээс 340000 тонн нүүрс зөвшөөрөлгүй олборлож ашигласан нь актаар тогтоогдсон. Харилцан хүлээн зөвшөөрсөн. Энэ актын дагуу 2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийтдээ 69000 тонн нүүрсийг буцааж өгсөн. Хоорондын тооцоогоор 270000 тонн нүүрсний авлагатай байгаа. Ийм мэдээллүүдийг ингээд товчлоод хүргэе.

Т.Доржханд гишүүн 40 их наядыг өөрөө тайлбарласан. Үүн дээр би түрүүн хэлсэн. АМНАТ дээр бол алдагдал байхгүй шүү. Бид АМНАТ-ыг яг хилийн үнэлгээгээр чадлаараа маш сайн авч байсан. Уул уурхайн компаниуд нэлээд гомдол, зөрчилтэй байдал дундуур явж ирсэн ч ямар ч байсан АМНАТ дээрээ бол харьцангуй хэл ам багатай, орлогоо шахаад төлөөд явж байгаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Б.Жавхлан сайд яг минутдаа багтлаа.

Хоёр дахь мэдээлэл улс хоорондын тээвэр, Си зөвшөөрөл олголт, гаалиар болон хилийн боомтоор нүүрс тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн талаарх мэдээллийг сонсоно.

Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт сайдыг индэрт урья.

Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт: Та бүгдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Си зөвшөөрлийн олголт хилийн боомтоор сүүлийн жилүүдэд нэвтэрсэн тээврийн хэрэгслийн талаарх мэдээллийг та бүхэндээ өгье. Монгол Улс БНХАУ-тай 1991 онд Засгийн газар хооронд Авто тээврийн хэлэлцээрийг байгуулсан. Энэ хэлэлцээрийг 2011 онд шинэчлэн баталсан байдаг юм. Энэ хэлэлцээрийн протоколыг 2011 онд БНХАУ-ын ЗТЯ, Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам байгуулж, хэлэлцээрийн хүрээнд хэдэн төрлийн зөвшөөрлийг өгдөг юм.

Засгийн газар хоорондын авто тээврийн хэлэлцээр болон хэлэлцээрийг хэрэгжүүлэх 2 улсын Зам, тээврийн яамдын харилцан баталсан протоколын дагуу БНХАУ-тай зорчигч тээврийн тогтмол А зөвшөөрөл, тогтмол явдаг зорчигчдын А зөвшөөрөл. Зорчигч тээврийн тогтмол бус тээврийн В зөвшөөрөл, байнгын ачаа тээврийн машинуудад С зөвшөөрөл. Түр хугацааны ачаа тэвээрт D зөвшөөрөл, овор ихтэй ачаанд E зөвшөөрөл, аюултай ачаанд F төрлийн зөвшөөрлүүдийг олгодог болсон. Ийм 7 төрлийн А-аас С зөвшөөрлийг олгож, зөвшөөрлийн бичгийн дагуу тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулдаг.

Монгол Улсын Засгийн газар, Хятад улсын Засгийн газар хоорондын авто тээврийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай яамд хоорондын протоколын нэгдүгээр зүйлд нь Авто тээврийн үндэсний төв, БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны болон Шинжан Уйгарын өөртөө засах орны Зам харилцаа, тээврийн танхим жил болгон уулзаж зөвшөөрлүүдийнхээ бичгийн тоог харилцан тохирч энэ тохирсон хэмжээгээр 2 талдаа зөвшөөрөл тэнцүү тоогоор олгодог, ийм хэлэлцээр хийсэн. Үүний дагуу үндсэндээ зөвшөөрлийг сүүлийн жилүүдэд олгож ирсэн. Жишээ нь Өвөр Монголын өөртөө засах оронтой 2002 онд 39500, 2021 онд 38000, 2022 онд 38000 С зөвшөөрлийг харилцан олголцох, ингэж зөвшөөрөл олгогдсон. Үүний дагуу Замын-Үүд, Баянхошуу, Бичигт, Ханги, Гашуун Сухат, Шивээ хүрэн, Булган гэсэн боомтууд энэ зөвшөөрөлд холбогдож байгаа.

2020 онд нийтэд олгосон С зөвшөөрлийн 89 хувийг л ашигласан. 2021 онд 95 хувийг нь ашигласан. 2022 онд 75 хувийг нь ашигласан ийм байдалтай байгаа. 2023 оны байдлаар манай Авто тээврийн үндэсний төв, Өвөр Монголын Шиньжан Уйгарын өөртөө засах орны

2 тээврийн танхимууд 50000 С зөвшөөрлийг харилцан ижил тоогоор олгохоор тохироод байгаа. Өөрөөр хэлэх юм бол өмнөх онуудаас ихээхэн хэмжээгээр нэмэгдсэн, ийм тоогоор С зөвшөөрөл олгогдсон байгаа.

Монгол Улсын Засгийн газраас бас гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхтэй холбоотой тогтоол гарсан. Үүний урьд нь бас ковид цар тахалын хөл хорионы хувьд тээвэрлэлтийг эрсдэлгүй зохион байгуулах, нүүрсний тээвэрлэлтийг нэмэгдүүлэх ийм шийдвэр гарсан. Энэ хүрээндээ өнгөрсөн хугацаанд Авто тээврийн үндэсний төв холбогдох С зөвшөөрлийн бичилтийг хийдэг, олголт, зохион байгуулалтыг боомтын үндэсний зөвлөл хийж ирсэн. Сая батлагдсан Засгийн газрын 362 дугаар тогтоолоор үндсэндээ С зөвшөөрлийг олгох, зохион байгуулалтыг уурхайн компаниудад, уурхайн олборлогч компаниуд хийхээр, бичилтийг нь Засгийн газар хоорондын комиссын дагуу Авто тээврийн үндэсний төв туршилтийг нь хийж өгөхөөр шийдвэр гарсан. Үүнтэй холбоотой үл ойлголцлын асуудал үүсэж байгаа. Манай тээвэрчид, Зам, тээврийн хөгжлийн яам, Боомтын үндэсний хороо бусад байгууллагууд харилцан ойлголцож ажиллаж байгаа гэж та бүхэнд энэ дашрамд хэлье. Авто тээврийн үндэсний төв төрийн өмчит улсын үйлдврийн газар нь улс хоорондын ачаа тээврийн газраас С зөвшөөрлийг олгох талаар урьд нь нэлээн хэл амнаас хамгаалдаг байсан. Та бүхэн мэдэх байх. С зөвшөөрөл дагасан, авлигал, хээл хахуул, янз янзын асуудал яригддаг байсан. Энэ асуудлыг харьцангуй нээлттэй, ил тод болгож тээврийн нэгдсэн системийг бий болгосон. Тээврийн нэгдсэн системээр улс хоорондын ачаа тээвэрт зөвшөөрөл олгох үйл ажиллагааг ил тод болгосон. Энэ байгууллагууд Тээврийн цагдаа, НДЕГ, ЭМД-ын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Албан журмын даатгагчдийн холбоо, УБЕГ, Уурхай эзэмшигч байгууллагууд тээврийн хэрэгслийн бүртгэлийн нэгдсэн системд байна.

Энэ олон мэдээллүүдийг нэгтгээд, мэдээллүүд дээр ямар нэгэн зөрчилгүй дутагдалгүй, ялангуяа татвараа цаг хугацаанд нь төлдөг ААН-үүдийн С зөвшөөрлийг олгож эхэлсэн.

Үүнийг дагаад С зөвшөөрөл авсан хэл ам сүүлийн жилүүдэд харьцангуй багасаж байгаа.

Цаашдаа С зөвшөөрлийг боловсронгуй болгох талаар манайхан нэлээд тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлж ажиллаж байгааг та бүхэнд хэлье. Тээврийн нэгдсэн системд одоогийн байдлаар Гашуун Сухайт, Шивээ хүрэн, Ханги, Замын-Үүд, Баянхошуу, Бичигт, Булган, Бургастай боомтуудад ажиллаж байгаа нийтдээ 500 орчим аж ахуйн нэгжийн 27900 гаруй тээврийн хэрэгсэл, 26400 орчим мэргэшсэн жолооч бүртгэлтэй байгаа. Үүнээс Гашуун сухайтын боомт дээр 320 орчим аж ахуйн нэгжийн 21600 орчим тээврийн хэрэгсэл 22000 мэргэшсэн жолооч ажиллаж байна. Эдгээр нь нийт Монгол Улсын гадаад руу, Хятад улс руу тээвэр хийж байгаа С зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн 65 хувь, нийт тээврийн хэрэгслүүдийн 77 хувийг эзэлж байгаа гэдгийг та бүхэндээ бас хэлье. Нийт жолооч мэргэшсэн жолооч нарын 84 хувийг эзэлж байна. Хилийн боомтуудаар нэвтэрсэн, тээврийн хэрэгслийн судалгааг үзэх юм бол Гашуун Сухайтын боомтоор 2018 онд 261000, 2019 онд 258000 тээврийн хэрэгсэл нэвтэрч байсан. Гашуун Сухайтын боомтуудаар 19 сая тонн нүүрс тээвэрлэж гаргаж байсан байна.

Ковид цар тахлын үед 2020 онд 167000, 2021 онд 79000, 2022 оны одоогийн байдлаар бол 63 орчим мянган тээврийн хэрэгсэл хилээр нэвтэрсэн байна. Нүүрс гаргасан байна гэдэг мэдээллийг Хил хамгаалах ерөнхий газраас бидэнд өгч байгаа. Үндэсний статистикийн мэдээлэл болон бусад мэдээллүүдээс үзэх юм бол нүүрс тээвэрлэлт ер нь байнга тасралтгүй өсөж байгаа. Анх 2003 онд 400 орчим мянган тонн нүүрс тээвэрлэдэг байсан бол 2010 оноос 16000000 тонн болж өссөн. Мөн 2016 оноос нэмэгдэж 24000000 тонн. 2018-2019 онд 32-

33000000 тонн нүүрс, экспортод Монгол Улсаас гарч байсан. Энэ бол үндсэндээ Монгол Улсын нүүрс тээврийн нэлээд оргил ачааллын үе. Энэ нүүрс тээврээс Монгол Улсын төсвийн гол орлого экспортын валютын нөөц их хэмжээнд мөрддөг хамаардаг. Үүнийг манай Монголын жолооч, тээвэрчид маань гол ачааг нуруун дээрээ тээж үндсэндээ гол эдийн засгийн судас нь болж тээвэрлэгчид бол ачаа үүрч байгаа. Жолооч тээвэрчиддээ талархах ёстой байх гэж бодож байна.

2020 онд хоёр цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор 21 сая болж буурсан.

2021 онд тээвэрлэлтийн байдал 16000000 тонн болсон. 2022 оны одоогийн байдлаар үндсэндээ 28 сая тонн орчим нүүрс тээврийг бид нар зохион байгуулж, тээвэрчид маань гаргасан байна. 2022 онд хэдийгээр энэ тоонуудаас харахад, нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо буурсан ч гэсэн нөгөө талдаа тээвэрлэж гаргасан нүүрсний хэмжээ нэмэгдэж байгаа. Энэ бол битүүмжилсэн бөмбөлөг тээврийн зохион байгуулалт сайжирсантай нэг талаасаа холбоотой. Нөгөө талаасаа багтаамж ихтэй, бүтээмж ихтэй давхар чингэлэг, давхар чиргүүлтэй машин нүүрс тээвэрлэсэнтэй холбоотойгоор бүтээмжүүд нь тодорхой хэмжээнд нэмэгдэж байгаа гэдгийг та бүхэндээ хэлье.

Иймэрхүү мэдээллийг та бүхэндээ өгье. Нэмэлт асууж тодруулах зүйл байвал хариулахад бэлэн. Түрүүн би бас хэлсэн. Ер нь тээвэрлэлттэй холбоотой асуудал дээр ялангуяа уул уурхайн олборлогч компаниуд С зөвшөөрөл олгох болсонтой холбоотойгоор, мөн дээрээс нь уурхайн ам нөхцөлөөр, хилийн үнэ нөхцөлөөр тээвэрлэлт хийх болсонтой холбоотойгоор тодорхой хэмжээний, тулгамдаж байгаа шийдүүлэх асуудлууд байгаа. Үүнийгээ бол жолооч тээвэрлэгчтэй харилцан ярилцаж аль болох Монгол Улсынхаа эрх ашигт нийцүүлж, мөн Монголынхоо тээвэрчдийн эрх ашгийг хамгаалах, энэ чиглэлдээ тодорхой бодлого зорилтыг дэвшүүлж ажиллана гэдгээ Зам, тээврийн хөгжлийн сайдын хувьд дэмжидгээ илэрхийлье.

Баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Бямбацогт сайдад баярлалаа.

Гурав дахь мэдээлэл “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай холбоотой нууцаас ил болсон 7 гэрээний талаарх мэдээллийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн бүрэн эрх төлөөлөгч Ж.Ганбат дарга танилцуулна.

Ганбат даргыг индэрт урьж байна.

Мэдээлэл хийж байгаа илтгэгч нар 10 минут мэдээлэл хийнэ, тэнд тохируулга хийчихсэн. Тэгээд 10 минутад багтахгүй бол автоматаар микрофон хаагдах юм байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК дахь Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат: “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар ил болгосон гэрээтэй холбоотой болон 2010 онд үүсгэн байгуулагдаад 2011 оноос эхэлж нүүрсээ борлуулж эхэлсэн байдаг. Нийт 12 жилийн хугацаанд 86000000 тонн нүүрс борлуулж, 12.8 их наяд төгрөгийн орлого олсон байгаа. Мөн энэ хугацаанд нийтдээ 3.1 их наяд төгрөгийн татварыг улсын төсөвт үйлдвэрлэснээс 54 хувь нь буюу 1.7 их наяд төгрөг нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт төвлөрүүлсэн ийм дүрэмтэй ажиллаж иржээ.

Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 449 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК нийтдээ 7 гэрээг бол ил болгосон. Үүнээс Тавантолгой, Гашуун Сухайт чиглэлээр төмөр замын санхүүжилтийн төлбөрийг нүүрсээр барагдуулахтай

холбоотой 2 гэрээ, Богдхан төмөр замын санхүүжилтийн болон төлбөрийн нүүрсээр барагдуулах 3 гэрээ, нийтдээ 5 гэрээ байгаа. Төмөр замтай холбоотой.

Үүнээс гадна яг “Эрдэнэс Тавантолгой” ХК яг өөрийнх нь үндсэн үйл ажиллагаатай холбоотой Заган усны хоолойн гүний усны ордоос “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрсний уурхай хүртэлх усан хангамж, шугамын барилга угсралтын ажлыг компанийн нууцад оруулчихсан байсныг ил болгосон. Мөн Тавантолгой ордын далд уурхайн хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэх 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн гэрээг мөн ил болгосон. Энэ гэрээний ажил нь эхлээгүй, нийтдээ бол 7 гэрээг 12 дугаар сарын 9-ний өдөр ил болгож, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн өөрийн вэб сайтаар гэрээг эхээр нь тавьж байршуулсан байгаа. Энэ 7 гэрээг задлаад товч мэдээллээ хүргэе.

Тавантолгой, Гашуун Сухайт төмөр замын санхүүжилтийн гэрээ 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан анхны ТЭЗҮ дэх нийт өртөг нь 1 тэрбум 68.6 сая ам.доллар. Энэ дүн дотор Монголын төмөр замын хийж гүйцэтсэн ажлын төсөв дотор 276.4 сая ам.доллар бол 1 тэрбум 68.6 сая ам.доллар орж ингэж тооцогдсон байгаа. Мөн урьдчилгаа төлбөрийг бэлнээр Тавантолгой төмөр замаар дамжуулаад шилжүүлсэн 110 сая ам.доллар байгаа. Энэ бол 2019 оны 10 дугаар сарын 11, 23-ны өдөр 110 сая ам. долларыг Тавантолгой төмөр замаар дамжуулан олгосон ийм дүнтэй байгаа. Мөн 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдөр энэ гэрээндээ нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Энэ гэрээнд өөрчлөлт оруулахдаа ТЭЗҮ-г нь бол тодотгосон. Тодотгоод 1 тэрбум 282 сая ам.доллар болгож тодотгосон байгаа. Тэгээд бусад мэдээллүүд нь бол ингээд байна. Тавантолгой, Гашуун Сухайт төмөр замын санхүүжилтийн гэрээнээс нүүрсний санхүүжих дүнгийн 895.6 сая ам.доллараас 478.1 сая ам.долларын төлбөрийг нүүрсээр барагдуулсан ийм дүнтэй байгаа.

Энэ санхүүжилтийн гэрээний асуудал бол ингээд нүүрсээр төлбөрүүд нь хийгдээд өнөөдрийг хүртэл явж байгаа гэдгийг хэлье. Энэ гэрээн дээр холбоотой гол мэдээллүүдийг нь хэлчихсэн. Энэ гэрээн дээр хэд хэдэн заалтууд бол оруулсан байгаа. Гүйцэтгэгчийн төслийн санхүүжилтийг олон улсын банк, санхүүгийн байгууллага болон бусад талуудаас хөрөнгө босгох замаар санхүүжих бөгөөд хөрөнгө босготой холбосон санхүүгийн болон бусад зардлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК нүүрс нийлүүлэх гэрээний дагуу нүүрсний үнэд хөнгөлөлт үзүүлэх замаар нөхөн төлнө гэдэг ийм заалт оруулж өгсөн байгаа. Мөн хэрэв гүйцэтгэгчийн дансанд шилжүүлэх үед ханшийн зөрүү үүсвэл “Эрдэнэс Тавантолгой” ХК нь нийлүүлэх нүүрсний хэмжээнд тохируулга хийх замаар хохиролгүй болгоно оо гээд энэ заалтын дагуу урьдчилгаа төлбөрийн зүгээс үүссэн ханшийн зөрүүний алдагдал 1 сая 248.9 ам.доллар, “Эрдэнэс Тавантолгой” ХК-д төлөхөөр ийм болсон байгаа. Бид нар 110 сая долларыг төлснийг хэлсэн. Мөн Тавантолгой Гашуун сухайт чиглэлийн төмөр замд ашиглалтад орсноос 60 хоногийн дотор Тавантолгой төмөр зам нь “Эрдэнэс Тавантолгой” ХК гүйцэд нийлүүлэх нүүрсийг тэргүүн ээлжид тээвэрлэх гэрээг гүйцэтгэгчтэй байгуулна гэдэг ийм нөхцөлүүдийг оруулсан гэрээг байгуулсан байгаа.

Дараагийн гэрээ нь бол Богдхан төмөр замын санхүүжилт байгаа. Нийт төсвийн санхүү, нийт төсөвт өртөг, төслийн санхүүжилт нь 1.4 тэрбум ам.доллар байгаа. Үүнд нүүрсээр, бэлэн мөнгөөр санхүүжүүлэх нь 734.6 сая ам.доллар. Бэлэн мөнгөөр санхүүжүүлэх болон нүүрсээр санхүүжүүлэх төслийг нь “Бодь Интернэшнл” ХХК энэ төсөвт өртөг нь 734.6 сая ам.доллар. Үүнээс 2022 оны 7 сарын 19-ний өдөр 100 тэрбум төгрөгийг Тавантолгой төмөр зам руу шилжүүлсэн байсны үлдэгдэл нь 11 сарын 25-ны өдөр 57.2 тэрбум төгрөгийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д буцааж төлсөн. 26.3 сая ам.долларын төлбөрийг нүүрсээр “Бодь Интернэшнл” ХХК-д барагдуулсан байгаа.

Мөн Тавантолгой төмөр замтай 670.2 сая ам.долларын гэрээг байгуулж, ингээд энэ гэрээний хувьд ийм байна.

Дараагийн гэрээ бол Богдхан төмөр зам дээр мөн ялгаагүй энэ заалтууд нь өмнөх гэрээтэй адил утга бүхий заалтууд орсон байгаа.

Дараагийн слайд нь энэ нийт 5 гэрээний хувьд бол эхний 2 Тавантолгой Гашуун Сухайт төмөр замын төсөл дээр бол 5-13 хувийн үнийн хөнгөлөлт өгсөн. Эндээс бол зөрүү нь 174.3 тэрбум төгрөгийн зөрүү үүсэж байгаа. Мөн Богдхан төмөр замын 3 гэрээн дээр 13 хувийн хөнгөлөлт өгөгдөж байгаа.

Энэ дээр 13.4 гээд зөрүү нь бол 187.7 тэрбум төгрөгийн зөрүү Тавантолгой, Гашуун Сухайт болон Богдхан төмөр зам дээр үүсэж байгаа.

Дараагийн гэрээтэй холбоотой Заган усны хоолой усан хангамжийн төсөл бол энэ компани өөрөө нууцад гарган оруулсан. Энэ бол төмөр замтай холбоогүй, баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахтай холбоотой усны төсөл байгаа. Энэ төслийг гүйцэтгэгч нь энэ компаниуд, Монголын компаниуд гүйцэтгээд, ажил нь 69.7 хувийн гүйцэтгэлтэй. Энэ дээр бол нүүрсээр, мөнгөөр төлбөрийг нь барагдуулаад, ажил нь хэвийн явж байгаа. Энэ дээр бол нууцад оруулсан учраас сонгон шалгаруулалтгүйгээр гүйцэтгэгчид нь шууд гэрээ байгуулж, энэ төслийг явуулж байгаа ийм асуудал байгаа.

Дараагийн далд уурхайн төслийн нийт санхүүжилтийн төсөвт өртөг нь 69.9 тэрбум төгрөг геологи, хайгуул, судалгааны ажил байгаа. Үүнийг мөн нууцад хамааруулан тендер зарлахгүйгээр гүйцэтгэгчийг сонгосон. Энэ дээр бүр 5 компани байгаа. 10 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулсан. Гэрээний үнийн дүнгийн 30 хувь буюу 20.9 тэрбум төгрөгийн гэрээ байгуулснаас хойш ажлаа 10-нд багтаан төлөхөөр гэрээндээ тусгачихсан байсан. Тэгээд урьдчилгаа төлбөрийг баталгаагүйгээр 10 дугаар сарын 27-нд санхүүжилт гаргах ийм асуудал үүссэн учраас энэтэй холбогдуулан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн холбогдох 5 албан тушаалтныг Авлигатай тэмцэх газарт шалгуулах нь зүйтэй юм гэж үзээд Авлигатай тэмцэх газарт хүргүүлж ажиллалаа.

Дараагийн асуудал нь “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр нүүрс борлуулах нийтдээ коксжих нүүрсний 31, эсэлдсэн нүүрсний 109, төслийн санхүүжилтийн нүүрсээр барагдуулах 4 гэрээ, түүнд холбогдох 38, нийт 178 нүүрс борлуулах гэрээ байна. Энүүнийг 2022 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр компанийн цахим хуудсанд гэрээний ерөнхий мэдээллийг нь байршуулж ажилласан. Сая өмнө дурдагдсан 7 гэрээг ил болгосон асуудлыг мөн компанийн вэб сайтад байршуулж ажиллалаа.

Мөн үүнээс гадна төлбөрийг урьдчилан авч ашигласан буюу урьдчилгаа төлбөрөө авч, дараа нь нүүрсээр барагдуулах нөхцөлтэй байгуулсан нийт 4 гэрээ байгаа. 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 386 сая ам.долларын үлдэгдэлтэй байна. Энэ дээр бол өмнө нь 603 сая ам.долларын урьдчилгаа аваад энэ дүндээ мөнгөөр нь аваад дараа нь мөн нүүрс нийлүүлэх ийм нөхцөлтэй гэрээ байгуулаад үүнээс бол 213-ыг нь барагдуулаад өнөөдрийн байдлаар л 386 сая ам.долларын үлдэгдэлтэй байна. Мөн уурхайн ажил гүйцэтгэгч компаниудын гэрээг төлбөрийг нь нүүрсээр барагдуулдаг. Олборлолт талдаа бол үндсэндээ 4 компани дээр нүүрсээр төлбөрийг нь барагдуулах гэдэг ийм гэрээнүүдтэй ажиллаж байсан. Өрөмдлөг тэсэлгээн дээр 2 компани, нүүрс ачилт дээр 2 компани, олборлолт баяжуулалт тэсэлгээ гэдэг дээр нийтдээ 4 компани нүүрсээр төлбөрийг нь барагдуулах энэ асуудлуудыг 10 дугаар сарын 26-наас эхлэн ажлыг зогсоогоод гүйцэтгэсэн төлбөрийг нь бид мөнгөн хэлбэрээр олгох нь зүйтэй юм гэдэг ийм байдлаар төлбөрийг нь олгоод явж байгаа.

Дараагийн асуудал нь олборлолттой холбоотой нүүрсээр барагдуулах гэрээ гэдэг дээр 6 компанийн байгаа. 1 компани нь компаниудад түншлэл байдлаар орчихсон. Энэ дээр

бол нийлүүлсэн нүүрснийх нь хэмжээ нь 781.4 мянган тонн нүүрс гээд 103.3 сая ам.долларын нүүрсээ барагдуулах гэрээг бол сая би өмнө дурдсан. Энийг бол зогсоогоод үүнийг мөнгөөр ажлын гүйцэтгэх дүнгээр нь олгох нь зүйтэй юм. Ийм гол шийдвэрүүдийг гаргаж ажиллаа.

Дараагийн слайд дээр “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн дараах 6 томоохон төслийг ерөнхийдөө санхүүжээд үүн дээр Тавантолгой, Зүүн баян чиглэлийн төмөр зам, Тавантолгой, Гашуун Сухайт, Тавантолгой, Зүүн баян төмөр замыг холбох, Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв, нүүрс баяжуулах үйлдвэр, Тавантолгой дулааны станц, газрын тос дамжуулах хоолойг энэ 6 төсөл дээр мөн хөтөлбөрийг санхүүжүүлж бэлэн мөнгө хэлбэрээр болон нүүрсээр төлбөрийг барагдуулах байдлаар энэ дээр ажиллаж байгаа. Үүнээс яг Тавантолгойн станц, дулааны станцын үндсэн ажил нь одоогоор эхлээгүй байна. Бусад төслүүдийн санхүүжилтийг нь гүйцэтгэлтэй нь уялдуулан олгоод явж байгаа гэдэг ийм мэдээлэлтэй байна.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Ж.Ганбат даргад баярлалаа.

Дараагийн мэдээлэл “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн зүгээс Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслүүдтэй холбоотой нууцаас ил болсон 2 гэрээнүүд. Тэдгээр гэрээнд тусгагдсан төмөр замын өртөө, бүтээн байгуулалтын хэрэгжилтийн талаарх мэдээллийг “Тавантолгой Төмөр Зам” ХХК-ийн бүрэн эрхт төлөөлөгч Х.Мягмар танилцуулна.

“Тавантолгой Төмөр Зам” ХХК-ийн бүрэн эрхт төлөөлөгч Х.Мягмар даргыг индэрт урьж байна.

“Тавантолгой Төмөр Зам” ХХК-ийн бүрэн эрхт төлөөлөгч Х.Мягмар: Тавантолгой Зүүнбаянгийнх биш, миний мэдээлэл бол Тавантолгой-Гашуунсухайт, Бондхан төсөлтэй холбоотой мэдээлэл байсан. Энэ танилцуулах материал буруу гараад ирчихсэн байна. Ярьж байх уу?

Ерөнхийдөө Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын нийт төслийн өртгийг 1 тэрбум 282 сая.долларын өртөгтэйгөөр ТЭЗҮ тодотгож гаргасан байдаг юм байна лээ. Өөрөөр хэлбэл анхны ТЭЗҮ нь Австралийн Эйком гэдэг компаниар хийлгүүлж, 1 тэрбум 68 сая ам.доллартой тэнцэх төмөр зам болно гэдэг нь ТЭЗҮ гаргаад Тавантолгойгоос хилийн 208 километр хүртэлх урттайгаар төлөвлөсөн анхны ТЭЗҮ байсан байгаа юм. Энэ ТЭЗҮ-г 2020 онд тодотгоод, өөрөөр хэлбэл хил рүү 233 хүртэл дөхүүлэх тодотголыг хийгээд, энэ тодотголын хүрээнд гаргасан ТЭЗҮ-ээр 213 сая ам.доллар болно гэдэг. Ингээд энэ ТЭЗҮ дээр нийлүүлсэн дүнг нэгтгээд үзэхээр 1 тэрбум 282 сая төгрөгийн, сая ам.долларын төсөвт өртөгтэй төмөр зам болно гэдэг ТЭЗҮ гаргасан байгаа юм. Тэгэнгүүт сая “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн илтгэлд гарсантай холбоотойгоор өмнө нь хийсэн ажил болох 273.6 сая ам.долларыг хасаад “Бодь Интернэшнл” ХХК-тай байгуулсан барилгын ажил гүйцэтгэх гэрээгээр 1 тэрбум 5 сая ам.долларын өртөг бүхий гэрээг ил болгосон гэрээндээ байгуулж явсан байгаа. Өөрөөр хэлбэл тодотголын дүн болох 213.4 сая, өмнө нь хийгдсэн ажлыг хассан 1 тэрбум 68-аас хассан дүн болох анхны дүн 792 сая ам.доллар, энэ хоёрын нийлбэрээр “Бодь Интернэшнл” ХХК-тай 1 тэрбум 5 сая ам.долларын барилгын ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Энэ хоёрыг ил болгох гэрээнд туссан байгаа юм. Энэ доод талд нь өмнөх тооцооллыг яаж ТЭЗҮ дээрээ ямар дүнгүүд туссан байна, өмнө нь хийсэн 276.4 сая ам.долларыг хасаад “Бодь Интернэшнл” ХХК-тай 1 тэрбум 500 сая ам.долларын гэрээ байгуулсан байна.

Дараагийн слайд руу оръё.

Энэ дээр барилгын ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас санхүүжүүлсэн мөнгөн хөрөнгө болон оффтэйк гэрээгээр нийлүүлсэн хөрөнгийг шилжүүлж авч “Бодь Интернэшнл” ХХК хэчнээн төгрөгийн гүйцэтгэл хийв гэдэгтэй холбоотой мэдээлэл гарч ирэх юм. Энэ дээр “Эрдэнэс Тавантолгой” ХК 110 сая ам.долларыг гэрээний ажил эхлэх үед бэлнээр өгсөн байгаа юм. 2019 онд. Үүн дээр 2019 онд мөн 72 сая ам.доллартой тэнцэх оффтэйк гэрээгээр нүүрс өгсөн байгаа юм. 2020 онд 183.5 сая, 2021 онд 122.1 сая, 2022 онд 81.4 сая ам.доллартой тэнцэх оффтэйк нүүрсийг өгсөн. Энэ нийлбэр дүнгээрээ 459 сая ам.доллартой тэнцэх нүүрсийг өгсөн байгаа юм.

Энэ хоёрын нийлбэр дүнгээр “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас 569 сая ам.доллартой тэнцэх хэмжээний санхүүжилтийг “Бодь Интернэшнл” ХХК-д өгч гэрээний гүйцэтгэлээрээ үлдэгдэл нийлүүлэх ёстой өртөг нь 436.5 сая ам.доллартой тэнцэх ажлын гүйцэтгэлийг хүлээж байгаа юм байна. Энэ төслийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 86 хувьтай, баталгаажуулалтыг хийсэн. Нийтдээ 2022 оны 3 дугаар улирлыг дуусах хүртэлх хугацаанд нийт 23 удаагийн ажлын гүйцэтгэлийг хүлээн авч “Тавантолгой Төмөр Зам” ХХК-иас ажлын гүйцэтгэлийг нь хүлээж авч 589.3 сая ам.доллартой тэнцэх хэмжээний ажил гүйцэтгэжээ гэдгийг баталгаажуулсан байгаа юм. Захиалагч үлдэгдэл ажлын дүнг 416.3 сая ам.доллартой тэнцэх ажлыг хүлээж авна гэсэн хүлээлттэй байгаа. Ийм дүнтэй байна. Энэ үндсэндээ “Бодь Интернэшнл” ХХК болон “Тавантолгой Төмөр Зам” ХХК хоёрын хооронд байсан барилгын ажил гүйцэтгэхтэй холбоотой гэрээнд тусгагдсан тэрбум 500 сая ам.долларын хүрээнд барилгын ажлын гүйцэтгэл болон түүнийг баталгаажуулж авсан дүн мэдээ ингэж харагдаж байна.

Дараагийн “Богдхан төмөр зам”-ын төслийн хувьд одоогоор зогссон бүтээн байгуулалтын ажил байгаа. Энэ бүтээн байгуулалт бол төслийн ТЭЗҮ-ээрээ 1.4 тэрбум төгрөгийн өртөгтэй ажил болно гэдэг ТЭЗҮ батлагдсан. Дараагийн энэ дээр байна. Өөрөөр хэлбэл, ТЭЗҮ-г 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлын шийдвэрээр ийм өртөгтэй байна гэж баталсан байгаа юм.

Батлахдаа ... /бичлэг сонсогдоогүй/ хэсэгт 734.6 сая ам.доллар, дэд бүтцийн гүйцэтгэлийн юун дээр 328.2 сая ам.доллар, доод утас буюу барилгын ажлын хүрээнд 342 сая ам.долларын өртөг бүхий бүтээн байгуулалт болно гээд нийлбэр дүнгээрээ 1.4 тэрбум ам.долларын өртөгтэй ТЭЗҮ батлагдсан байна. Энэ ажлын хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас 100 тэрбум төгрөгийг 2022 оны 07 сарын 19-ний өдөр шилжүүлсэн байгаа юм. Энэ 100 тэрбумыг шилжүүлж “Тавантолгой Төмөр Зам” ХХК-д шилжүүлж өгөөд энэ ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор 30 тэрбум төгрөгтэй тэнцэх мөнгөн зарцуулалт гарсан байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-д 104 тэрбум төгрөгийнхөө 57 тэрбумыг нь буцаагаад шилжүүлсэн. 30 тэрбумын ажил гүйцэтгэсэн. Энэ хүрээнд 12.6 тэрбум төгрөг хийж байгаа ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор хүлээгдэж байна. Энэ хийгдсэн зарцуулалтын дүн газар шорооны нийт ажлын хүрээнд зохицуулагдсан хөрөнгийн дүн мэдээ байгаа юм. Ингээд товч танилцуулж дууслаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Х.Мягмар даргад баярлалаа.

Дараагийн мэдээллийг сонсьё.

Нүүрс экспортлох үйл ажиллагаанд Гаалийн байгууллагаас хэрэгжүүлсэн дотоод хяналт шалгалтын талаарх танилцуулгыг Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал танилцуулна.

Р.Отгонжаргал даргыг микрофонд урья.

Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал: Та бүхний энэ өдрийн мэндийг эрье. Гаалийн байгууллагаас 2013, 2018, 2022 онд хийсэн дотоод хяналт шалгалтаар Гашуунсухайт боомтоор нүүрс экспортлох үйл ажиллагаанд хууль зөрчсөн байж болзошгүй үндэслэл бүхий тоо баримт, материалуудыг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар 3 удаа шилжүүлсэн байгаа. Эхнийх нь 2010-2011 оны 07 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд 3,758 тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн 379 мянган тонн нүүрсийг гаалийн бүрдүүлэлт хийлгүй улсын хилээр гаргасан байж болзошгүй үйлдлийг Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрын байцаагчийн дүгнэлтээр Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албанд шилжүүлсэн. Мөн 2013-2017 оны хооронд нүүрс тээвэрлэгч 86 аж ахуйн нэгжийн 2,527 тээврийн хэрэгсэл, 17,149 удаа улсын хилээр гарсан бүртгэлтэй. “Тавантолгой” ХК-иас экспортын бүрдүүлэлт хийж гаргасан нүүрсний тоо хэмжээнд тус компанитай нүүрс худалдах, худалдан авах гэрээ байгуулсан 21 аж ахуйн нэгж гэрээнд заасан тоо хэмжээнээсээ 1 сая тонн нүүрс илүү экспортолсон. Мөн 12 аж ахуйн нэгж эх үүсвэр нь тодорхойгүй, гэрээгүй, 515 мянган тонн нүүрс экспортолсон зэрэг асуудлыг нягтлан шалгуулахаар Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт 2018 оны 07 дугаар сарын 17-ны өдөр шилжүүлсэн.

Гуравт, 2018 оноос 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацааг хамруулсан шалгалтаар 2,213 хамтарсан манифестаг 1,748 тээврийн хэрэгслээр, 186.4 мянган тонн нүүрс экспортын гаалийн бүрдүүлэлтгүй гаргасан байж болзошгүй нөхцөл байдал урьдчилсан байдлаар тогтоогдсон тул шалгалтын дүнгийн талаарх танилцуулга, холбогдох материалыг энэ оны 12 дугаар сарын 15-ны өдөр цагдаагийн байгууллагад мөн шилжүүлэн шалгуулж байна.

Дээр дурдсан 3 удаагийн шалгалтаар тогтоогдсон тоо хэмжээ, мэдээллийг Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо, Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан хууль хяналтын байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг, мөн Цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газарт Гаалийн ерөнхий газраас шилжүүлэн нягтлан шалгаж, эцэслэн тогтоох арга хэмжээг хамтран хэрэгжүүлж байна. Мөн та бүхэнд нүүрсний экспортын статистик мэдээллийн талаар товч мэдээлэл өгье. Гаалийн ерөнхий газрын гадаад худалдааны статистик мэдээллээс харахад 2019-2022 онд Монгол Улсаас БНХАУ, Их Британи, Сингапур, БНСУ, ОХУ, Бүгд Найрамдах Герман улс, Хонг Конг, Испани зэрэг улс орнууд руу Гашуунсухайт, Шивээ хүрэн, Ханги, Замын-Үүд, Булган зэрэг боомтуудаар чулуун нүүрс экспортоор гаргасан байна. Нүүрсний экспортын 2019-2022 оны эхний 9 сарын статистик мэдээнд Бүгд Найрамдах Хятад Ард улс руу гаргасан нүүрсний нийт экспортод эзлэх жингийн хувьд 92.1-98.2 хувийг, үнийн дүнгээр 90.8-98 хувийг эзэлж байгаа бол үлдэх хувь дээр дурдсан улс орнуудад ногдож байгаа юм. Эдгээр улс орнууд руу хийгдэж байгаа нүүрсний экспорт БНХАУ-аар дамжин хийгддэг ба 2019 онд нийт 36.4 сая тонн нүүрс экспортолсноос 35.7 сая тонн, 2020 онд 26.6 сая тонн нүүрс экспортолсноос 27.2 сая тонн, 2021 онд 15.7 сая тонн нүүрс экспортолсноос 14.5 сая тонн, 2022 оны эхний 9 сард нийт 19 сая тонн нүүрс экспортолсноос 17.5 сая тонн тус тус БНХАУ руу хийгдсэн.

Энэ экспорт байна. Статистик үзүүлэлтээс харахад зөвхөн нүүрс төдийгүй бусад бараа бүтээгдэхүүний хувьд ч талуудын бүртгэлийн аргачлал, гаалийн хууль, журам, горимын онцлогоос хамаарч тэр болгон тохирдоггүй, аль аль талдаа зөрүү гарах тохиолдлууд байдаг.

Гаалийн ерөнхий газраас БНХАУ-ын Гаалийн ерөнхий газартай зарим бараа бүтээгдэхүүний статистик үзүүлэлтийг жил тутам хийж, талуудын уулзалтаар үзүүлэлтийн

зөрүүг гаргаж, нөлөөлсөн хүчин зүйлүүдэд дүн шинжилгээ хийж, тодотгол хийдэг. Сүүлийн уулзалтыг 2019 онд хийснээс хойш цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан өнөөг хүртэл дахиж уулзалт хийгдээгүй байна. БНХАУ-д цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан хориг хязгаарлалтын арга хэмжээ суларч, ердийн горимд шилжих үед 2 талын гадаад худалдааны статистик үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, ажлын уулзалтыг ойрын хугацаанд хийх саналаа БНХАУ-ын Гаалийн байгууллагад илэрхийлээд байна.

Дээрх зөрчил дутагдалд дүн шинжилгээ хийх, Гаалийн байгууллагад тулгамдсан эрсдэлт хүчин зүйлсийг тогтоох, цаг алдалгүй хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, ажлын хэсгийг байгуулж, 2019 оноос хойш хэрэгжүүлж байгаа гаалийн шинэчлэлийг эрчимжүүлэх, нүүрсний экспортын бүртгэл, хяналтын тогтолцоог сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллаж байна. Гаалийн шинэчлэлийн хүрээнд Шивээ хүрэн, Замын-Үүд, Гашуунсухайт зэрэг боомтуудад нэвтрүүлж буй ухаалаг гарцын системээр тээврийн хэрэгслийг хүний оролцоогүйгээр бүртгэл мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, Гаалийн ерөнхий газрын шуурхай удирдлагын төв болон хөндлөнгийн хяналт тавих боломжийг бүрдүүлж ажиллаж байна. Энэ хүрээнд ухаалаг гарцын бүртгэлийн системийг Хил хамгаалах ерөнхий газартай холбох ажлыг нэвтрүүлэх эрх зүйн болон техникийн нөхцөл боломжийг тодорхойлж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Нүүрс экспортлох үйл ажиллагаанд хяналт тавих, рентген төхөөрөмжүүдийг Гаалийн ерөнхий газрын шуурхай хяналт, удирдлагын төвтэй холбох, телекамераар давхар хяналт тавих техникийн нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн.

Цахим бүрдүүлэлтийн нэгдсэн системийн хүрээнд гэрээ, бүртгэлийн нэгдсэн системийг Татварын байгууллага, Гааль, татварын мэдээлэл технологийн төвтэй хамтран боловсруулж гаалийн бүрдүүлэлтийн цахим системд холбох бэлтгэл ажлыг дуусгасан. Үүний үр дүнд нүүрс экспортолж буй аж ахуйн нэгжүүдийн гадаад худалдааны гэрээнд заагдсан тоо хэмжээнээс экспортын бүрдүүлэлт хийгдэх тухай бүрд хасалт хийгдэж, гэрээний үлдэгдлийг цахимаар хянах, гаалийн татварын мэдээллийн нэгдсэн системд чиг үүргийн байгууллагууд бүртгэл хийж, хяналт тавих боломж бүрдэж байгаа юм. Энэ ажил 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс бүрэн хэрэгжиж эхэлнэ.

Туршилтын журмаар хэрэгжүүлээд явж байна. Мөн гаалийн төв болон салбар лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, нүүрс, ашигт малтмалын бүтээгдэхүүний чанарын иж бүрэн шинжилгээг олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар хийх боломжийг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Гаалийн төв лаборатори нь БНХАУ-ын итгэмжлэлийн байгууллагаас 2022 оны 10 дугаар сард магадлан итгэмжлэл авснаар гаалийн лабораторийн шинжилгээний дүнг БНХАУ-д хүлээн зөвшөөрөх боломжтой болсон. Энэ нь нүүрсний экспортын үйл ажиллагаанд тавих хяналтыг түргэн шуурхай болгох, экспортоор гаргаж байгаа нүүрсний чанар, орц найрлагад үндэслэн ногдуулдаг ашигт малтмалын нөөц ашигласны татварыг бодитой тооцож төвлөрүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа. Мөн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саатуулалгүй экспортын ашигт малтмал, нүүрс зэрэг бараанаас автоматаар дээж сорьц авч үзлэг, чийглэг, илчлэг болон зарим дагалдах химийн элементүүдийн агууламж тодорхойлох тоног төхөөрөмжийг Гашуунсухайт, Шивээ хүрэн, Булган зэрэг авто замын 6 боомтод суурилуулахаар төлөвлөснөөс эхний төхөөрөмжийг Шивээ хүрэн боомтод энэ онд суурилуулж, туршилтын журмаар ашиглаж эхлээд байна.

Цаашдаа Гаалийн байгууллагаас хөрш орнуудтай гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслалцах гэрээ эрх зүйн орчныг сайжруулах, хууль сахиулах хамтарсан арга хэмжээний чанар, давтамжийг нэмэгдүүлэх ажлыг Гаалийн байгууллагын 2023 оны нүүрсний төлөвлөгөөнд тодорхой тусгаж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Ухаалаг гарцын системийг БНХАУ-ын Гаалийн байгууллагын ухаалаг гарцын системтэй холбож, нэгдсэн

бүртгэл, үзүүлэлтийг хэрэгжүүлэх нөхцөлийг судалж шийдвэрлэх, мөн гаалийн хяналт бүрдүүлэлт, удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагааг хуульд нийцүүлэн ил тод байлгах, Монгол Улсын Засгийн газрын боомтын шинэчлэлийн бодлого хөтөлбөрийн хүрээнд 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Гаалийн шинэчлэлийг эрчимжүүлж, цахимжуулалтыг бүрэн нэвтрүүлэх, Гаалийн байгууллагын алба хаагчдын томилгоо, сэлгээ, сэлгэн ажиллуулах журам, хандлага, ёс зүй, сахилга хариуцлагад тавих хяналтыг сайжруулж, дотоод хяналтыг гаалийн байгууллагын бүх шатанд эрчимжүүлэх арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Нүүрсний асуудлаар 2013 оноос хойш шийдвэрлэгдсэн, хэрэгсэхгүй болсон, шалгах, шалгагдаж байгаа хэргүүдийн шийдвэрлэлтийн байдлын талаарх мэдээллийг сонсохоор Улсын Ерөнхий Прокурорын Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын ажилд хяналт тавих хэлтсийн дарга Д.Баянжаргалыг урьж байна.

Байна уу? Баянжаргал дарга байна уу? Ерөнхий прокурор байгаа, Та бүхний асуултад хариулна.

УЕП-ын Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын ажилд хяналт тавих хэлтсийн дарга Д.Баянжаргал: Та бүхний өдрийн амгаланг айлтгая. Нүүрс, нүүрсстэй холбоотой хэргийн талаарх мэдээллийг товч та бүхэнд танилцуулъя. Энэ танхимд Улсын Ерөнхий Прокурор хүрэлцэн ирсэн байгаа. Мөн хууль хяналтын байгууллагын удирдлагууд ирсэн байгаа. Цагдаа, Авлигатай тэмцэх газрын удирдлагууд ирсэн байгаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Мэдээллээ сонсчихъё, мөрдөн байцаах ажилд хяналт тавьдаг, дарга учраас яг энэ талаар мэдээлэл өгөх нь зүйтэй гэж прокуророос мэдээлэл ирүүлсэн. Сонсчихъё. Тэгээд Ерөнхий прокурор зааланд сууж байгаа. Та бүхний асуултад дараа нь чөлөөтэй хариулна.

.... Мэдээллээ эхэлье ээ.

УЕП-ын Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын ажилд хяналт тавих хэлтсийн дарга Д.Баянжаргал: Цаг хэмнэх үүднээс 2 мэдээлэл үндсэндээ нэг хугацааны хувьд 2013-2022 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар, өнөөдрийн байдлаар ямар хэргүүд ямар байдалтай, яаж шалгагдаж байгаа гэдэг талаар та бүхэнд товч мэдээлэл хүргэе ээ.

Прокурорын хяналтад 2013-2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд нүүрсний олборлолт, экспорт, тээвэрлэлт, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой нийтдээ 36 гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг мөрдөх байгууллагууд хүлээн авч шалгасан. Энэний 89 хувийг нь Авлигатай тэмцэх газар, 11 хувийг Цагдаагийн байгууллага шалгасан байгаа. Шийдвэрлэлийн байдлыг авч үзвэл 31 буюу 86.1 хувь нь хэрэг бүртгэлтэй хэрэг нээж шалгасан, 5 буюу 13.9 хувийг хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзаж шийдсэн байгаа. Ер нь энэ гомдол, мэдээллийн 72 хувийг нь мөрдөн шалгах байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд өөрсдөө мэдээллээр илрүүлж, шалгасан байгаа. 28 хувийг нь иргэн, хуулийн этгээд, холбогдох албан тушаалтнаас гаргасан гомдол, мэдээллээр шалгасан байдаг. Гомдол, мэдээллийг хугацаагаар нь авч үзвэл 2012-2017 оны хооронд 7 гомдол, мэдээлэл байна. 2018-2022 оны хооронд 29 гомдол, мэдээлэл буюу дийлэнх нь сүүлийн жилүүдэд хүлээн авч шалгасан гомдол байна. Түрүүн хэрэг бүртгэлтийн 32 хэрэг нээсэн гэж ярьсан. Эдгээр 32 хэрэгт хэр бүртгэлтийн ажиллагаа явуулна. Ер нь хэрэг бүртгэлтийн ажиллагаа гэдэг бол зөвхөн нотлох баримт цуглуулдаг ийм

шат байж байгаа. Энэ шатанд нийтдээ 32 хэргээс 16 хэрэгт 72 хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан бол 8 хэргийг хааж шийдвэрлэсэн байгаа.

Тухайн үед 8 хэрэг шалгагдаж байсан. 2013 оноос 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд нийтдээ мөрдөн байцаалтын 16 хэрэгт ажиллагаа явуулснаас 3 хэргийг шүүхээр шийдсэн байгаа. Өнгөрсөн 12 сард нэг хэрэг нь шүүхээс буцаж ирсэн. 2 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдсэн.

Тухайн үедээ мөрдөн байцаалтын ажиллагаанд нийтдээ 11 хэрэг шалгагдаж байсан. Ер нь энэ нүүрсний олборлолт, экспорт, тээвэрлэлт, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой энэ хэргүүдийн шалгаж, шийдвэрлэх ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор УЕПГ-ын шийдвэрээр мөрдөх байгууллагуудын хамтарсан ажлын хэсгийг байгуулж ажиллуулсан. Энд авлига, цагдаа, тагнуулын байгууллагын мөрдөгч нар ажиллаж байгаа. 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдөр буюу өнгөрсөн 1 дэх өдрийн байдлаар хамтарсан ажлын хэсгийн хүрээнд нийтдээ нүүрсний олборлолт, экспорт, тээвэрлэлт, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой 39 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсны 22 нь хэрэг бүртгэлтийн шатанд нотолгоо цуглуулах ажиллагаа хийгдэж байна. 2017 оны мөрдөн байцаалтын хэрэг хийж байгаа юм. Хэрэг бүртгэлийн хэрэг нээсэн оноор нь энэ 39 хэргийг авч үзвэл 2013 оны 2 хэрэг, 2015 оны 1, 2017 оны 2, 2018 оны 6, 2019 оны 1, 2020 оны 6, 2021 оны 6, 2022 оны 14 хэрэг байна.

Энэ оноор нь сая би хэллээ. Одоогийн байдлаар энэ 39 хэргийн шийдвэрлэлтийн байдлыг аваад үзвэл 23 хүнд холбогдох 4 хэргийг яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн. Хэрэг бүртгэлд 22 хэрэг шалгагдаж байна. Мөрдөн байцаалтын шатанд 53 хүнд холбогдох 13 хэрэг байна. Нүүрсний хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан 76 хүн байгаа. Үүнээс 36 нь нийтийн албан тушаалтан байна. 31 нь аж ахуй нэгжийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, бусад ажилтнууд байгаа. Энд мөн хувиараа нүүрс тээвэрлэдэг 4 иргэн, бусад иргэн, БНХАУ-ын 2 иргэн байгаа. Ингээд нийтдээ 76 хүн энэ хэрэгт холбогдож шалгагдаж байна. Нүүрсний олборлолт, экспорт, тээвэрлэлт, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой хэргүүдэд хойшлуулахгүйгээр 15 хүнийг сэжигтнээр баривчилсан байгаа. Яллагдагчаар татагдаж, шалгагдаж байгаа 76 хүнээс 10 нь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, хориотой байна. Монгол Улсын хилээр гарах хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан 22, хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан 38 байна. Мөн 3 хүнд тодорхой үйл ажиллагаа явуулах, албан тушаал эрхлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авагдан шалгагдаж байна. Нүүрсний олборлолт, экспорт, тээвэрлэлт, худалдах үйл ажиллагаатай холбоотой хэргүүдэд Авлигатай тэмцэх газрын 25, цагдаагийн байгууллагын 58 нийтдээ 83 мөрдөгч хамтарсан ажлын хэсэг ажиллаж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Нийслэлийн прокурорын газрын 12 прокурор энэ хэргүүд дээр хяналт тавин ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд хамтарсан ажлын хэсгийн мөрдөгчид нийтдээ 2,871 хүнээс гэрчийн мэдүүлэг, 139 үзлэг, 71 нэгжлэгийн ажиллагаа хийгдсэн. Нийтдээ 65,549 хуудас цаасан суурьтай баримтыг холбогдох байгууллагуудаас хураан авах зэрэг мөрдөн шалгах ажиллагаануудыг явуулсан. Прокурор нийт 118 зөвшөөрөл олгож ажилласан. Эндээс холбогдох байгууллагаас мэдээлэл, баримт бичиг гаргуулан авахаар 18 прокурорын зөвшөөрөл олгогдсон, 78 нэгжлэгийн 22 нь хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах зөвшөөрлийг тус тус олгосон байна. Ажлын хэсгийн хүрээнд нийтдээ өнгөрсөн хугацаанд түрүүний хэлсэн татгалзсан, хэрэгсэхгүй болгосон, хаасан хэргүүдийг бүгдийг нь дахин нягталж шалгах аргаар сэргээж шийдвэрлэсэн. Товч мэдээлэхэд ийм байна.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Д.Баянжаргал даргад. Одоо ажлын хэсгээс сонсголд холбогдох албан тушаалтнуудаар бэлтгүүлж, хэлэлцүүлэх мэдээллүүдийг сонсож дууслаа. Одоо мэдээлэлтэй холбогдуулаад мэдээлэл

хэлэлцүүлсэн болоод уг мэдээлэлтэй холбоотой холбогдох албан тушаалтнуудаас асуулт асууж, үг хэлэх үйл ажиллагааг эхлүүлье. Түүрүүн асуулт, үг хамт 5 минут байхаар дэгээ тогтсон. Одоо цаас явуулж авсан гишүүдийн нэр эцэслэж ирэх хүртэл иргэдийн төлөөллөөс үг хэлүүлээд эхлүүлье.

Уржигдар энэ бүртгэлд нэр орсон дарааллаар эхлээд асуулт болгон дээр хариулт авч явах нь зөв байх, тийм үү? Нэг бол 3 хүн асуугаад 1 багц хариулт авах уу?, эсвэл асуулт асуугаад тухайн үедээ хариултаа аваад явах уу? 3 иргэн эхэлж асуулт асуугаад нэг, нэгээрээ асуултаа асуугаад хариулт аваад явна. Би ажлын албанаас гаргаж өгсөн, бүртгүүлсэн нэрсийн дарааллаар нь дуудаад явна. Тэгээд зүүн талд байна уу, баруун талд байна уу? аль ойр байгаа микрофон дээрээ ирээд, үгээ хэлээд яваарай. Урьдчилсан байдлаар 50 иргэн нэр өгсөн байгаа. Энэ 50 хүнд нэр ороогүй байгаа, одоо нэмж нэрээ өгье гэсэн иргэд байвал нэг давхрын зүүн урд буланд сууж байгаа ажлын албаныханд нэрээ бичгээр өгөөрэй. Ингээд асуулт асууж, үг хэлэх үйл ажиллагаандаа орёе. М.Гэрэлчулуун. “1072 хувьцаа ТББ-ын төлөөлөл” 1 номерын микрофон. Хэн гэдэг албан тушаалтнаас асуух гэж байгаа гэдгээ нэр, албан тушаалтай нь тодорхой хэлээд асуултаа асууя. Асуулт, үг 5 минут гэсэн горимоор явна. Ингээд зүүн талын 1 номерын микрофон өгье.

Сонголд оролцогч, “1072 хувьцаа” ТББ-ын төлөөлөл М.Гэрэлчулуун: 1072 хувьцаагаа хамгаалах хөдөлгөөний гишүүн Гэрэлчулуун байна. Улсын Их Хурлын гишүүн Ганболдод хандаж 3 хүсэлт байна. Та нүүрсний хулгайн ажлын хэсгийг ахалж байгаа. Тэгэхээр энэ нүүрсний хулгайд холбогдоод байгаа нэр бүхий 7 гишүүний эрхийг нь үнэхээр холбогдчихсон юм бол түдгэлзүүлээч ээ. Өөрсдөө болохоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр бид нар ямар ч холбогдолгүй энхийн цагаан тагтаанууд гээд байгаа юм. Тэр 17 хүний нэр дотор чинь энэ 7 гишүүний нэр орчихоод байна. Үнэхээр холбогдсон юм бол түдгэлзүүлээд, холбогдоогүй бол холбогдоогүй гэдгийг нь ард түмэнд хэлж өгмөөр байна. Тэгэхгүй бол энэ хүмүүсийн толгой эргээд явчихлаа.

Хоёрдугаарт, нүүрсний хулгайг шалгах Улсын Их Хурлын түр хороонд ард түмний төлөөллийг оруулж өгөөч ээ, ард түмний төлөөлөл энд цуг ормоор байна.

Гуравдугаарт, нүүрсний хулгайг шалгах Засгийн газрын ажлын хэсэг байгаа. Энэ ажлын хэсэгт бас ард түмний төлөөллийг оруулж өгөөч гэсэн ийм хүсэлт байна.

Сонгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Санал байна. Дараагийн асуулт асууж, үг хэлэх Өмнөговь аймгийн иргэн. Ж.Баатархүү. 1 дүгээр микрофон дээр. Дараа нь Ц.Гэрэлт-Од үг хэлэх юм байна, бэлтгэж байгаарай. “Дорнод Эв нэгдэл” ТББ.

Сонголд оролцогч, Өмнөговь аймгийн иргэн Ж.Баатархүү: Өмнөговь аймгийн иргэн Тавантолгой ХК-ийн хувьцаа эзэмшигч Ж.Баатархүү байна. Би нутгийнхаа өмчийг төрд булаалгахгүйн төлөө сэтгэл зүрх цохилсон иргэн. Ер нь төрд очсон юм бол ерөөсөө л замхардаг, дандаа л цагаан захтнуудын гар, хөлөөр ороод алга болдог. Ийм үйл ажиллагаа манай аймагт “Эрдэнэс Тавантолгой” ХК-иа идээд ханахгүй, Өмнөговь уурхайг идэх гээд бүрэн эрхт төлөөлөгч гэдэг юм томилчихоод байна. Би Ерөнхий сайдаас асуумаар байгаа юм. Энэ хүнээ татаж аваач ээ, Өмнөговийн энэ уурхай, ууган уурхай 66 жил ажиллахдаа улсаа татаасаа төлөөд, орон нутгаа хөгжүүлээд, иргэндээ нутгийн хишиг хөтөлбөр хэрэгжүүлээд өдий хүрсэн шүү. Иргэн болгон 500 мянган төгрөг авч байсан түүхтэй. МАХН тэр мөнгө өгөхийг болиулаад зогсоосон. Ерөөсөө ард түмнээ хайрладаггүй нам, сүүлийн 8 жилд 6-д нь мөнгө олгохоор ядаад өнөөдөр ард түмэн ийм байдалд хүрч байгаа. Энийг ард иргэд ойлгох ёстой. Тавантолгой, Өмнөговь бүгд л хулгайч юм шиг ийм сэтгэгдэл төрүүлэхээр болчихлоо. Хүмүүсийг зарлаж болохгүй, шүүхээр тогтоогоогүй байхад

хэлчихээд, Адьяасүрэн, Бат-Эрдэнэ гээд орхичихно. Тэгэнгүүт нь манай Монголчууд чинь яс харсан нохой шиг булаацалдаад, тэр 2 идсэн, уусан, энээ тэрээ ёстой шуналтай гээд явчихдаг. Ийм сценараар 32 жил явлаа.

Монголд ингэж ард түмнээ хагалж, бутаргахгүй шүү. Энэ Энхболд, Сугар тэргүүтэй манай аймгийн МАН-ынхан 13 оноос л эхэлсэн. Тухайн үед 2018 оноос эхэлсэн, ийм хулгай хийсэн гэж яриад, тэрийг шүүх, прокурорынхон шийдээгүй юм. Тэр шүүх, прокуророо ярь. Зүгээр л хулгайлчихсан хүн бол нэг аргалаад өнгөрөөчихсөн юм шиг, 2 жил шахам “Тавантолгой” ХК-ийг шалгаад үйл ажиллагаа, борлуулалт нь тасалдаад, хувьцааны үнэ нь унаад ямар их муугаар нөлөөлж байгаа вэ, ард иргэддээ? Та нарын явуулсан үйл ажиллагаа, энэ МАН-ын явуулсан үйл ажиллагаа, энэ Засгийн газрын явуулсан үйл ажиллагаа ингэж л хохироосон. Тэгээд 2016-2020 онд Өмнөговь аймгийн МАН төр барихдаа тэрийг сайн цэгцлээд янзалсан юм хаана байна? Худлаа учраас л өдий болтол илрээгүй. Тэгээд л тийм хулгайч байгаа гээд ярьчихдаг. Буянгийн Жаргалсайхан буюу Базарсадын Жаргалсайхан “Тавантолгой” ХК-иас эзэмшлийг хулгайлаад дарцгийн компанид өгсөн байсан. Тэгээд Монголоос хэн дуугарсан юм, Өмнөговийн тэр муу хэлээд байгаа Бат-Эрдэнэ чинь 7, 8 жил хөөцөлдөж байж авчирсан. Тэгээд орон нутгийн өмчтэй байх гэдэг маш чухал юм байна, орон нутаг нь өөрөө төсөв мөнгөө зарцуулаад явна гэдэг чинь маш чухал гэдгийг нотолсон баримт юм. Монголын бүх уурхайнууд “Тавантолгой” ХК-ийн туршлагыг судлах хэрэгтэй. Тэгж явна уу гэхээр ингээд мөлжөөд дуусах гээд хүмүүсийг нь айлгаж ичээгээд, гүтгэж харлуулах байдлаар энэ үйл ажиллагаа явахгүй. Тэр бүрэн эрхт төлөөлөгч гэдэг хүн нь БНМАУ-ын 1991 оны хуулиар бүрэн эрхт төлөөлөгч гэдгийг томилсон байгаа юм.

Монгол Улс 91 оноос хойш шинэ Үндсэн хууль батлагдаад явж байгаа биз дээ. Энэ чинь тэгээд 91 оны БНМАУ-ын хууль, тэр БНМАУ гэдэг манж гоё тийм сайхан үгээ тэгж их хүсээд байгаа юм уу. Тэр хуулиа өөрчилдөггүй юм уу. Энэ шинэ цаг үедээ тохирсон ардчилсан Үндсэн хуультай, ардчилсан Монгол Улс гэдэг чинь хаана байна. БНМАУ гэдэг, Оросоос тохоож өгсөн нэрийг уншаад, тийм үеийн цаг хугацааны хуулиар Өмнөговь аймгийн нутгийн өмчийг булааж, одоо шууд булаагаад нааш нь өгчихгүй ч гэсэн энэ жилийн 9 дүгээр хурлаар аймагт зөндөө төлөвлөгөө байгаа. Тэдэн километр зам тавина, дандаа өөрийнхөө хөрөнгөөр. Тэгээд нөгөөдөх нь цаг хугацааны хувьд ч юм уу, мөнгө төгрөгийн хувьд дутуу ч юм уу, цаг хугацааг нь хойшлуулаад бүрэн эрхт төлөөлөгч гэдэг эндээсээ үүрэг даалгавар аваад саатуулаад байвал Өмнөговьчуудад хохиролтой шүү дээ. Ийм маягаар саад тотгор болох магадлалтай байна. Тэгэхээр энэ орон нутгийн “Тавантолгой” ХК-иас савраа татахыг Монгол Улсын Засгийн газраас хүсэж байна. Хэрэгтэй шаардлагатай байвал хувьцааны үнэ ханш яаж унасан юм, яаж борлуулалт нь хэдээс хэдэн онд тэгж их шалгуулж байхдаа борлуулалт нь яаж буурсан юм, яагаад харилцагч нь тэр үеэр холдоод, харилцагчгүй болох шахсан юм зөндөө зовлон бий шүү. Энэ “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр бас яагаад иргэддээ “Тавантолгой” ХК шиг ногдол ашгийг нь жил болгон өгөөд явж болдоггүй юм. Та нар тэдэн их наядын хулгай хийчихээд Монголынхоо ард түмэнд, 3 сая гаруй иргэддээ ногдол ашгийг нь “Тавантолгой” ХК-иас үлгэр жишээ аваад өгч сур. Тийм байдлыг тогтоо. Та нарт тэртээ тэргүй сул мөнгө орчихдог учраас тэр хамаагүй байх.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Хэн хариулах вэ? Жавхлан сайд хариулах уу? Амарбаясгалан дарга хариулах уу? Амарбаясгалан даргыг дуудаад орж ирэхээр нь хариулъя. Баатархүү гуай таны асуултад Хэрэг эрхлэх газрын дарга орж ирэхээр хариулъя. Одоо Ц.Гэрэлт-Од “Дорнод эв нэгдэл” ТББ-ын төлөөлөл.

Уучлаарай. миний бие муудаад байна, ядраад байна. Сахарын өвчтэй.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Төмөр-Очир яагаад гараад ирэв ээ. Үгүй ээ, дарааллаараа явъя Төмөр-Очир оо. Миний хөгшин дараа нь нэр орж ирж байна

Төмөр-Очир оо. Ц.Гэрэлт-Од хаана байна? Ц.Гэрэлт-Од зөвшөөрч байгаа бол За Төмөр-Очир.

Сонголд оролцогч, жагсагчдын төлөөлөл А.Төмөр-Очир: Өнөөдөр сонин зөвлөгөө хийж байна. Монголчууд төрийнхөө ордон дотор энэ их наядын хулгай, ийм юм яриад сууж байна гэдэг нь энэ хувь заяа минь хаашаа болов оо? Бид өнөөдөр 30 жил, багаар бодоход 32 жил хуурчихлаа. Үндсэн хуулиа үгүй болгоод, дахиад Үндсэн хууль хийх тухай ярьж байгаа. Ийм эгзэгтэй цаг үеэр би төрийн тэргүүнүүдэд Ерөнхийлөгчид, Ерөнхий сайдад олон удаа хэлж байсан. Урьд өмнө нь хэзээ ч гарч байгаагүй шинэ аргаар гарна шүү гэж. Өнөөдөр ийм нөхцөлтэй ирлээ. Би юм асуухгүй ээ, цаг барахгүй ээ.

Монгол хүнийг жаран жилд нэг удаа тархийг сэлбэ, цусыг нь шингэл гэсэн үг байдаг юм. Хуучны үг. Жаран жил болоод Монголын төр нэг шинэчлэх ёстой. Одоо гучин жил болоод юу болов? Би цусаа шингэлмээр байна, тархиа сэлбэмээр байна. Та нар ийм боломжтой. Эх орны дайны үед, Халх голын дайны үед Дэндэвийн Пүрэвдорж бичиж байсан юм. Улаан тамхи, ногоон цайны уутыг нь сэгсрээд хаясан байлаа гэж. Тэгээд өнөөдөр та нар ард түмнээ хар, улаан тамхи, ногоон цайны уутаа сэгсрүүлэх байтугай, ууж идэх усгүй болоод дэлхий чинь уйлж байна. Өмнөговь байхгүй болж байна. Өмнөговь гэдэг чинь миний дэлхий, манай Монголын нутаг. Энэ зүйлийг хэлмээр байна. Та нараас би олон зүйлийг асуумаар байна. Гэхдээ ярьж чадахгүй ялгараад байна. Би энэ намд 1981 онд элсээд өнөөдөр 42 жил болж байна. Та бүхнийг зөвшөөрвөл энэ Сүхбаатарын одон. Энийг би Монгол төрөөс авсан. Монгол төрд нь би буцааж өгье. Хулгайч нартай би зэрэг авсан. Хулгайч нараас авсан. Хулгайн нүүрсний үед би төрийн одонгоосоо татгалзъя гэж бодож байна. Би 12 оны Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн. Би Ц.Элбэгдоржоос авсан. Ц.Элбэгдоржийг өнөөдөр бууд гэж байгаа. Би ч буудахад бэлэн байна. Гэхдээ дайснаасаа авсан шагнал амттай байдаг юм. Ардчилсан намын даргаас би авсан. Дахиад би энийгээ өгөхгүй. Би энэ одонг 12 сарын 03-ны өдөр Дарьгангад очоод төрийн тахилгатай Алтан овоондоо, төрсөн нутагтаа төгссөн сургууль дээрээ хүмүүсийн өмнө хэлсэн юм. 4-нд жагсаал цуглаан болно шүү. Би өнөөдөр 03-нд хэллээ шүү гэж. Нийгмийг ингэж сонсож, дуудаж, үнэртэж, амталж байх ёстой. Энэ нийгэм бол буруу зүг рүү явж байна, булхай руу явж байна гэдгийг би дахиад л мэдэрч байна. Дахиад үзвэл надад МАН-ын гишүүдийн үнэмлэх байна. Энэ нам өнөөдөр бидэнд эх оронд хэрэгтэй, эх орон бидэнд хэрэгтэй, нам бидэнд огт хэрэггүй, одоо намыг татан буулгадаг болж болно. Би 1981 онд элсээд 2016 онд намаасаа гарсан. Би 2016 онд намаасаа гарахдаа өөрийгөө буруу байна, гажигтай байна, сэтгэлгээ буруу байна гээд өөрөө өргөдлөө өгөөд гарсан. 2020 онд би намдаа орсон. Одоо би гарвал энийг уриалаад, шатаагаад эх орноо угсардаг намыг бид нар хэдий болтол тэвчих вэ? Ийм учраас энийг би хэлмээр байна.

Та бүхэн өнөөдөр хөдөө нутгаа ярихгүй байна. Монгол Улсад ямар ч зуд бэрхшээл, хамгийн хэцүү үйл явдал болж байна. 10 литр түлш олдохгүй. Алдсан малаа олоод шөнөдөө буцаад үрээд. Сонгуулиар та нар хэдэн малчид дээрээ очих байх. Энийг бас бодох хэрэгтэй. Монгол хөдөөтэй, хоттой ард түмэнтэй шүү. Би өнөөдөр ийм сэтгэлзүйтэй ирлээ. Би 01 дүгээр сарын 03-ны өдөр энэ одонг өгнө гээд хэлчихсэн. 01 дүгээр сарын 03-ны өдөр. Та нар Цэдэнбалын одонг түүхэндээ байгаа. Хэдэн мянган жилийнх нь гавьяаг хураагаад авдаг юм чинь, Төмөр-Очироос 13-хан одонг харамлана гэж байхгүй. Худлаа. Би авах ёстой. Хураагаад авна, гаргаад ир гэвэл би өгчихнө. Өнөөдөр надад татгалзал бэлэн байгаа шүү. Монголын ард түмэн та нар Ардын намтай, Ардчилсан намтай байж амьдрахгүй шүү. Эх оронтой байж л амьдарна. Ийм зүйлийг хэлмээр байна. Би олон зүйл асуумаар байна. Огиудас хүрээд, дургүй хүрээд, бөөлжис цутгаад би асууж чадахгүй байна. Та нар олон тайлбар, үнэн худлыг хэлж байна. Өнөөдрийн хэлэлцүүлэг ч гэсэн цагтаа эхэлсэнгүй, цаашаа явсангүй. Нэг нохой хорих маягаар хаашаа юм дээ, цаг нөхцөөх маягаар 10, 11 цаг гэж хэлчихээд 1, 2 цаг. Хаашаа юм. Ийм дайчин давшингуй байхгүй. Хулгай хийчихээд,

мухардчихаад туйлдаа хүрчихлээ шүү дээ. Ийм аргаар бид явахгүй шүү. Энэ нээлттэй хэлэлцүүлэг гэдэг сонгодог сайн юм ч биш. Та нар шинэ арга сэтгээрэй, Тархи толгойгоо ажиллуулаарай. Ер нь Засгийн газраа дэмжиж байгаа. Засгийн газар энэ хулгайчдыг хатгаж, хутгаж гаргаж ирсэн. Засгийн газар хариуцлагаа нэхэх ёстой, тооцох ёстой. Засгийн газар дотор үл бүтэх нөхөр байгаа. Нямбаатар энэ тэр гээд. Нямбаатар аа чи Монгол орны сэлмийг огцом дэмжинэ шүү. Эрлийз морь уралдуулахыг дэмжиж өнгөрсөн жил бүх уралдааныг будилаантуулсан шүү. Монголын ард түмэнгүйгээр МАН энэ эх оронд зогсож явахгүй шүү. Тэрийгээ уучлаад.../минут дуусав/

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Төмөр-Очир үг хэллээ. Одоо Ц.Гэрэлт-Од. “Дорнод эв нэгдэл” ТББ-ын төлөөлөгч.

Сонсголд оролцогч, “Дорнод эв нэгдэл” НҮТББ-ын төлөөлөл З.Гэрэлт-Од: Сайн байцгаана уу? Цагдаагийн ерөнхий газрын дарга, Нийслэлийн цагдаагийн газрын дарга нараас асуулт байна. Яг одоо Сүхбаатарын талбай дээр мянга орчим залуучууд бөөгнөрчихсөн байж байна. Монгол төрөөс Улсын Их Хурал дээр нээлттэй сонсгол хийж байгаа. Энэ нээлттэй сонсголоос ямар үр дүн гарах вэ, ямар дэвшил, ямар урагштай арга хэмжээ болох вэ гээд нүд цавчилгүй хараад сууж байна. Гэтэл НЦГ-ын дарга аа, Цагдаагийн ерөнхий газрын дарга аа, энэ мянга орчим залуучуудын төлөөлөл болсон Засгийн газрын ордны баруун хаалган дээр 20 гаран залуучууд нүцгэлээд шаардлага тавьсан. Энэ танхимд орё гэж. Гэтэл энэ залуучуудыг маань бүгдийг нь ачаад, яг одоо тэр Дэнжийн 1000-д байгаа түр саатуулах газарт 20 гаран, 30-аад залуучуудыг хорьсон байна.

Хоёрт, Нийслэлээс 4 гэр барьж өгсөн. Өчигдөр Нийслэлийн цагдаагийн албаны хэдэн хүмүүс ирээд ачаад явсан. Та нар гэрээ харамлаад байгаа юм уу, ард түмний Үндсэн хуулиар олгогдсон эрхийг нь хясан боогдуулаад байгаа юм уу? Хэрвээ та нар үнэхээр гэрээ харамлаад байгаа бол 4 айлын гэрийг буулгаж авч ирээд бид нар барья. Та нар энэ зөвшөөрлийг олгож өгөөч. Нийслэлийн цагдаагийн алба болон Цагдаагийн ерөнхий газраас асууж байгаа юм.

Хоёрт, 5 ширхэг хуулийг яаралтай горимоор баталж өгөөч ээ. Улсын Их Хурлын дарга чинь бид нарын дэргэд ярьсан шүү дээ. Улсын Их Хурлын даргыг оруулж ирээд суулгачих гээд. Тэгсэн чинь Улсын Их Хурлын дарга нь байдаггүй. Улсын Их Хурлын дарга аа, төлөөлүүлээд та нарт хэлчихье. Улсын Их Хурлын дарга аа, 5 ширхэг хуулийг 5 минутын дотор батлаад өгөөч ээ. Ард түмний шаардлага шүү.

Нэг. 22.1 гэж та нар баталсан. Энэ бол маш дутуу дулимаг юм болсон. Энд чинь хий зай, авлигачдад цаашаа алхах боломжийг олгосон дутуу хууль баталсан. Энэ хуулиа янзалж өгөөч.

Хоёр.Газрын тосны тухай хууль

Гурав.Улс төрийн намын санхүүжилтийн тухай хууль

Дөрөв.Ашигт малтмалын тухай хууль.

Энэ гаднын санхүүжилтээр баталсан захиалгат хуулиа яг одоо 5 минутын дотор шинэчлэн найруулж баталж өгөөч. Монголд хууль, эрх зүй мэддэг маш олон боловсролтой залуучууд байна. Та нар үнэхээр баталж чаддаггүй юм бол энэ залуучуудаас тусламж хүсэж байгаад эдгээр хуулиудыг та нар нэн яаралтай баталж өгөөч. Дээрээс нь Улсын Их Хурал дахь Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр гэж хүн байгаа. Бид нар тэр хүнд яг одоо шаардлага хүргүүлэх гээд сууж байна. Манай дараагийн залуу маань

уншиж танилцуулах байх. Энэ хүнээс ямар шаардлага хүсэх вэ гэхээр энэ авлигачин, албан тушаалтан өөрийнхөө бүрэн эрхийг хамгаалдаг энэ хүмүүсийг Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороогоор оруулаад бүрэн эрхийг нь түдгэлзүүл, гадаад руу зорчих, хөрөнгөө ийш тийш нь гуйвуулж завшуулах арга хэмжээг таслан зогсоож өгөөч, Авлигатай тэмцэх газрын дарга аа, Тагнуулын ерөнхий газрын дарга аа, Хил, гаалийн дарга нараа, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга чинь байгаа юм уу энд. Дэг дээр бид нар яриад байсан. Хүмүүсийг гүйцэд оруулаач гээд, тэгэхэд та нар яасан. Хурал даргалагч аа, Улсын Их Хурал дээрх ажлын хэсгийн дарга аа, Салдангийн Одонтуяа гишүүн ээ, тэр ХҮН намын дарга Доржханд аа. Хүмүүсээ бүрэн бүрэлдэхүүнээр нь оруулаагүй байгаа учраас энэ чинь нохойн баас шиг юм болж байгаа юм. Та нарын чадамжгүй байгаагийн чинь илрэл.

Хоёрт, энэ нээлттэй сонголыг өнөөдөр тарааж болохгүй. Энэ хүмүүсийг хариуцлага тооцож, арга хэмжээ автал Монголын ард түмэн 7 хоног байдаг юм уу, хэд хоног байдаг юм, үргэлжлүүлье. Талбай дээр зогсож байгаа залуучууд өнөөдөр 17, 18 хоног жагсаж болсон юм чинь 2, 3 сар жагсъя. Ээлж, ээлжээр, цаг, цагаар жагсъя. Монголын ард түмэн авлигад идэгдсэн хүмүүстээ арга хэмжээ авч чадахгүй бол Монголын ард түмэн шал ондоо хэлбэр доор, жагсаалын ондоо хэлбэрийг сонгоё. Дараачийн юм нь болохоор хүний бүрэлдэхүүн чинь дутуу байна. Тэр Сү.Батболд хааччихсан юм бэ? Сү.Батболд. Дэрээс нь Жаргалтулгын Эрдэнэбат яасан юм бэ? Дэрээс нь Сумъяабазар чинь яасан юм бэ? Дэрээс нь Чимидийн Хүрэлбаатар, Чойжилсүрэн энэ нөхдөө бүрэн бүрэлдэхүүнээр нь авчраач. Улсын Их Хурлын гишүүн чинь хэн, хэн байгааг нь хармаар байна шүү дээ. Сандлыг нь эргүүлээд наашаа харуулаад суулгачихаач. Гуйж байна та нараас. Ажлаа хиймээр байна. Монголын ард түмнийг та нар жоохон гурилдаад өнгөрнө гэж бод.../минут дуусав/

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Одоо дэгээр явъя. Цагдаагийн удирдлагаас хэн байна? Саяын тэр Гэрэлт-Одын асуултад хариул. Наашаа гараад ир. Хэн гэж хүн байна гараад ир. Та албан тушаал, нэрээ хэлээд хариулт өгөөрэй.

Цагдаагийн ерөнхий газрын Дэд дарга, цагдаагийн хурандаа П.Оростогоо: Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа Оростогоо гэж хүн байна. Саяын асуусан асуултад хариулъя. Гадаа үүсэж байгаа цагийн нөхцөл байдалтай холбогдуулаад цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч Удирдах ажилтан буюу дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга, цагдаагийн хурандаа Ганбат нар ажиллагааны удирдлагын штабт ажиллаж байна. Энэ жагсаал цуглаан эхэлсэнтэй холбогдуулаад Монгол улсын Ерөнхий сайдын захирамжаар Ажиллагааны удирдлагын штаб, Цагдаагийн ерөнхий газар дээр байгуулагдсан. Энэ журмаараа бол ажиллагааны удирдлагын штабыг Хууль зүй, дотоод хэргийн сайд ахалж ажилладаг. Нарийн бичгийн даргаар нь Цагдаагийн ерөнхий газрын дарга ажилладаг юм. Ингээд хууль сахиулах байгууллага болон төрийн захиргааны байгууллагуудын төлөөлөл оролцсон ийм ажиллагааны удирдлагын штаб ажиллаж байгаа. Энэ ажиллагааны удирдлагын штабын ажиллаж байгаа гол зорилго бол хүний эрхийг дээдэлж, энэ өвлийн хүйтэнд жагсаж байгаа жагсагчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой ажиллагаануудыг зохион байгуулан ажиллаж байгаа. Сайд, ерөнхий газрын дарга, нийслэлийн цагдаа, удирдах газрын дарга нар штаб дээр ажиллаж байна. Сая энэ ордны баруун хаалга дээр жагсагчид маань ирж бас шаардлага тавьсан.

Энэ шаардлагын хүрээнд 27 залуу нүцгэлж, эхний нүцгэлсэн залуу маань цаг гаруй хугацааны дараа осгосон байдалтай, биеийн байдал нь хүндэрсэн. Энэ үйл ажиллагаанд НЭМГ, Сүхбаатар дүүрэг дэх нийгмийн ЭМТ, Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн эмч нар ирж 9 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаад энэ дээр осголтын шинж тэмдэг үүсээд байгаа учраас амь насанд нь аюул учрах нь гэсэн дүгнэлтийг хэлж, цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллах дэмжлэг хүссэн. Дэмжлэг хүссэн учраас эдгээр нүцгэлсэн

залуучуудыг эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх чиглэлээр авч явсан. Би мэдээллээ өгчихье. Дуусаагүй байна шүү дээ. Мөн зохих, эмх замбараагүй байдал үүсгэсэн, янз бүрийн байдлаар шалгах шаардлагатай зарим залуучуудыг аваачсан байх. Бид нар нүцгэлсэн залуучуудыг бүгдийг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр авч явсан юм. Энийг та бүхэн бас ойлгох ёстой. Би одоо холбогдоод дахин мэдээлэл аваад та бүхэнд бас тодорхой мэдээллийг өгье. Яг одоогийн байдлаар ийм байдалтай байна. Би сайн тодруулаад та бүхэнд эргээд танилцуулъя. Та ч гэсэн энэ мэдээллийг авсан байна шүү дээ. Гаднаас нь ямар нэгэн байдлаар жагсаал үймүүлэх зорилгоор согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн хүмүүс байсан учраас тэндээс нь дэнжийн 1000 руу авч явсан. Яг нүцгэн залуучуудыг бол бүгдийг нь эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр авч явсан юм. Товчхондоо хариулж дууслаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Одоо дэгээрээ явна иргэдээ. Гэрэлт-Одын тэр 5 хуультай холбоотой асуудал бол санал байна гэж ойлголоо. Санал байна. Нэг юм би түрүүн хэлсэн шүү. Оролцогчид минь. Энэ ерөнхий хяналтын сонсгол бол тухайн хэлэлцэж байгаа асуудлаар эрх мэдэлтэн, албан тушаалтнуудын мэдээлэл сонсож, тайлбар авдаг ийм онцлогтой сонсгол. Тэр гэрч дуудах асуудал, нотлох баримт шаардаад байгаа асуудлууд бол өөр хэлбэрийн сонсголоор явдаг гэж би түрүүн хэлсэн. Тухайн асуудлаар хянаж шалгах түр хороо байгуулагдаад, тэндээ шинжээч томилоод нотлох баримт цуглуулаад, сонсгол дээр гэрч дуудаж нотлох нотлох баримтдаа үнэлгээ хийдэг тэр сонсгол бол өөр сонсгол. Тэрийг яг тухайн асуудлаар хянан шалгах чиг үүргээр байгуулагдсан түр хороод зохион байгуулдаг. Магадгүй манай энэ ерөнхий хяналтын сонсголын дараагаар яг энэ нүүрсний асуудлаар байгуулагдсан түр хороо тэр гэрч дуудах, нотлох баримт цуглуулах, нотлох баримтыг үнэлэх сонсгол бас үргэлжлээд явагдана. Тийм учраас энэ ерөнхий хяналтын сонсгол тэр хяналтын чиг үүргээр байгуулагдсан түр хорооноос хийх сонсгол, эд нар чинь 2 өөр чиг үүрэгтэй, ийм сонсголууд байгаа шүү гэдгийг бас манай иргэд оролцогчид маш сайн, ялгааг нь гаргана биз дээ? Ингээд 4 иргэн үг хэллээ. Одоо нэг гишүүн үг хэлүүлж болох байлгүй гэж бодож байна. 6 гишүүн асуулт асууж үг хэлэхээр санал ирүүлсэн байна. Эхний төлөөлөл болгоод Доржханд гишүүнийг асуулт асууж, үг хэлэхийг урьж байна. Индэр дээр байгаа учраас индэр дээрээс хариулчих. Бусад гишүүд заалнаас ярьчих.

УИХ-ын гишүүн Т.Доржханд: Баярлалаа. Би маш товчхон асууна. Би 4 хүнийг энд ирээд зогсоод, тэгээд иргэд рүүгээ харж байгаад мэдээллээ өгөөч гэж хүсэж байгаа юм.

Нэгдүгээрт, ЗХЖШ-ын удирдлага,

Хоёрдугаар, Авлигатай тэмцэх газрын удирдлага Дашдаваа дарга та наашаа хүрээд ир.

Гуравдугаарт, “Бодь интернэйшнл” компанийн захирал Баясгалан гэж ирсэн байсан. Та наашаа гараад ир.

Дөрөвдүгээрт, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн бүрэн эрхт төлөөлөгч Ганбат гэдэг хүн та наашаа гараад ир. Наашаа гарч ирээд зогсчих.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Бодийн төлөөлөл байна уу.

УИХ-ын гишүүн Т.Доржханд: Тэгээд энэ дарга нар гарч ирж байх хооронд би нэг товчхон мэдээлэл өгье. Ер нь өнөөдөр энэ сонсгол яагаад хийгдсэн юм бэ. Яагаад иргэд жагссан юм. Яагаад өнөөдөр ийм бухимдал байгаа юм. Яагаад үр дүнд нь энэ оффтэйк гэрээ бий болсон юм бэ гэдгийг бас бүгдээрээ нэг ойлгоё. Өнөөдөр иргэд, залуучууд олон хоног

жагссаны үр дүнд, мөн энэ Их Хурлын тодорхой нэр бүхий гишүүд энэ нээлттэй сонголыг явуулна гэсний үр дүнд энэ оффтэйк гэрээ чинь ил болсон шүү. Үр дүн гарч байгаа.

Хоёрдугаарт, одоо яг энэ оффтэйк гэрээгээ тойроод бүгдээрээ яг тодорхой асуудлуудыг яримаар байгаа юм. Би сөрөг хүчний намын дарга хүн шүү. Сөрөг хүчин шүү. Эрх баригч биш. Гэхдээ яг хуулийн хүрээнд, хулгайтай бүгдээрээ яг л тодорхой тэмцье, тодорхой асуултуудыг тодорхой баримттайгаар яримаар байгаа юм. Тэгэхлээр ЗХЖШ-ын төлөөлөл байна уу? Та микрофон дээр оччихгүй юу? Тэр микрофон дээр. Оффтэйк гэрээ гээд гэрээнүүд бий болсон, үүний хүрээнд төмөр замын бүтээн байгуулалтууд гээд сая мэдээлэл дээр байна. Ерөнхий мэдээллүүд нь байна. Гэтэл хулгайч нь тэр туслан гүйцэтгэгчээр дамжуулаад, улс төрд эрх мэдэлтэй нөхөд чинь түүгээрээ мөнгөө хийчихсэн байгаа. Цавчаагаа авсан байгаа. Тодорхой. Тэгээд танайх бол зүүн тийш явсан замыг бүтэн санхүүжүүлсэн. Гүйцэтгэгчийг нь хийсэн. Туслан гүйцэтгэгч нартай гэрээ байгуулсан. Хэзээ гэрээнүүдээ ил болох юм.

Хоёрдугаарт, яг 1 жилийн өмнө Улсын Их Хурал дээр 1 ширхэг “Талх чихэр”-ийн атар гэдэг талхыг 20-25 мянган төгрөгөөр нийлүүлсэн гэдэг мэдээлэл ирсэн. Гишүүд битүү ярьсан. Одоо тэр мэдээлэл байна уу? ийм гэрээнүүдээ хэзээ ил болгох юм?

Хоёрт нь энэ Баясгалан гэж хүн байна уу? Нэг дэх өдөр маш олон сэтгүүлчдийг цуглуулж байгаад мэдээлэл хийсэн. Тэр мэдээлэлд эдийн засагч хүний хувьд итгэл үнэмшил байхгүй байна. Ямар мэдээлэл хийсэн бэ гэхээр бид нар ерөөсөө маш хямдхан төмөр зам барьчихсан шүү дээ. Ерөөсөө өртөг нь болохоор нэг километр, 1.5, тэгээд тэр чинь болохоор ерөөсөө төмөр зам тэгээд доод бүтэц 2 л байдаг байхгүй юу даа гэсэн нэг буруу мэдээлэл явчихлаа. Одоо би асуумаар байгаа юм. Дэлхий даяар төмөр замын нэг километр өртгийг төмөр замаар нь тооцдог юм уу? Суурь бүтцээр нь тооцдог юм уу? Суурь бүтэц гэдэгт доод бүтэц, дээд бүтэц, салаа зам, өртөө зөрлөг, байшин барилга, дохио холбоо орно. Бүгдээрээ орж байж нэг километрийн өртөг гардаг олон улсын жишиг юм. Ганцхан хөдлөх бүрэлдэхүүнийг оруулахгүй, вагоныг оруулахгүй, түүнийг засварладаг, депог нь оруулахгүй. Гэтэл бүгдийг нь хамж шимж оруулснаа бид бол маш хямдхан төмөр зам барьчихсан гэдэг ийм мэдээлэл өгөөд, иргэдэд буруу эндүү ойлголт өгөөд байна. Тэгээд бидэнд ямар ч хамаа байхгүй. Тэр төрд чинь л хамаг асуудал байгаа шүү дээ. Бид яаж мэдэх юм, бид бизнес хийдэг, бизнесээ л хийж байна гээд. Уучлаарай, тийм юм байхгүй шүү. Гэтэл өмнөх өдөр нь тэр төрөөс шийдвэр гаргасан хүн зугтаачихсан байхгүй юу. Гэтэл маргааш нь гарч ирээд сайхан ярьдаг тийм байж болохгүй ээ. Олон бизнесүүд өнөөдөр татвараа төлөөд, банкнаас зээл аваад, тендерт ороод маш их ажил хийдэг. Гэтэл тэнд бол урьдчилгаа 30 хувь гэж аваад дэлхий дээр байхгүй нөхцөлөөр авчихсан ийм байж болохгүй ээ. Жирийн бизнесүүдийг харлуулж байгаа юм биш. Гэхдээ бусдынхаа өмнөөс боломжийг нь хулгайлдаг байж болохгүй. Ийм болохоор би тэр “Бодь интернэшнэл”-ийн Голомтын Баясгалан гэдэг захирлыг энд тайлбар өг гэж байгаа юм.

Хоёрдугаарт, би яг үүнтэй холбоотойгоор бүрэн эрх төлөөлөгч Ганбат гэдэг хүнээс Сангийн яамны ТНБД асуумаар байгаа юм. Их Хурал дээр 2 ч удаа мэдээлэл хийсэн. Дэлхий дээр ийм гэрээ би мэдэхгүй юм байна гээд. Тухайлбал ханшийн алдагдлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК хариуцна, Бодь хариуцахгүй, тухайлбал нэг өдөр л нүүрсээ... /минут дуусав/

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: 1 минут. Ер нь дэгээр явна. Иргэд бол 5 минут шүү дээ асуулт, үг. Гишүүд ч гэсэн адилхан асуулт, үг 5 минут гээд баталсан. Та тэгээд одоо 1 минутад асуултаа гүйцээгээд асуучих.

УИХ-ын гишүүн Т.Доржханд: Дашдаваа дарга аа, таны удирдлагад ажилладаг 1 хүн

бүтэн сайн өдөр энэ нүүрсний хэргийн оффтэйк гэрээний цаана байгаа Халтмаагийн Баттулга гэдэг хүнийг явуулсан. Дэлхийн хөл бөмбөгийн аварга шалгаруулалт явж байх үеэр бүгд анхаарал тийшээ нь сарнисан үед явсан. Тэгэхдээ нэгхэн мөрдөгчийн шийдвэрээр явж байгаа юм. Танайх босоо удирдлагатай биз дээ? Та нар явуулчихсан юм уу? Аль эсвэл тэр хүн оргочихсон юм уу? Явуулсан бол та нар хам хэрэгтэн болно. Та хариуцлага тооцох ёстой. Та тэр хүнд биш өөртөө хариуцлага тооцох асуудлыг бид ярина шүү. Хэрвээ тэр хүн оргон зугтаасан бол тэрийгээ шууд хэл. Энэ дээр тодорхой тайлбар өгөөрэй.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Хэн хариулах уу? Дашдаваа дарга хариулах юм уу, батлан хамгаалах хариулах юм уу? Батлан хамгаалах эхлээд хариулъя. Тэгээд яг саяын тэр 3 дахь асуулт.

Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа: Нээлттэй сонсголд оролцож байгаа нийт иргэд та бүхнийхээ энэ өдрийн амгаланг ирье. Доржханд гишүүний асуултад хариулъя. Нүүрсний гэх тодотголтой эрүүгийн 32 хэрэг цагдаагийн байгууллага болон Авлигатай тэмцэх газарт шалгагдаж байна. Оффтэйк гэрээтэй холбоотой асуудлууд, гэрээнүүд Авлигатай тэмцэх газарт ирсэн байгаа. Оффтэйк гэрээ дээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу мэргэжлийн нарийн шинжээч томилно. Энэ шинжээч томилогдсоноороо энэ гэрээ гэмт хэргийн шинжтэй байна уу? Энэ гэрээгээр халхавчилж бусдад давуу байдал олгосон байна уу? энэ гэрээ бусдад давуу байдал олгож, их хэмжээний ашиг олоход нь дэмжлэг болсон байна уу зэргээр Монгол улсад байгаа нарийн, мэргэжлийн шинжээч нарын баг томилж дүгнэлт гарна. Энэний дараа энэ гэмт хэрэг мөн үү, биш үү гэдэг асуудал яригдана. Та Монгол Улсын Ерөнхийлөгч асан Баттулга гуайг оргуулсан барьсан гэсэн асуудал ярьж байх шиг байна. Манай байгууллага тайлбар авсан. Ерөнхийлөгч асан Баттулгаас 3 асуудлаар тайлбар авсан. 3 асуудал дээр шалгаж байгаа. Энэ бол тодорхой. Эрүүгийн хэрэг хянан шийдэх ажиллагаатай холбоотой нууцлалтай учраас энэ 3 асуудлуудаар тодорхой дэлгэмээргүй байна. Эхний таны ярьж байгаагаар бол бид “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай холбоотой асуудлаар тайлбар авсан. Энд оргосон гэдгийг хэн нотлоод байгаа юм? Нэгдүгээрт, би Авлигатай тэмцэх газрын хувьд энэ хэргийг шүүхэд хэрвээ тэр хүн яллагдагчаар татагдсан тохиолдолд шүүх дээр очиход байгаагүй бол оргосон гэж үзнэ. Хуулийн заалт нь өөрөө тийм. Өнөөдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар эрүүгийн хэрэг шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нар, эрх үүргийнхээ дагуу оролцохоос хэн нэгэн албан тушаалтан, хэн нэгэн иргэн энэ эрүүгийн хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохгүй ээ. Энэ хуулиараа хориотой Доржханд гишүүн ээ. Та шүгэл үлээж болно. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэдэг чинь харилцан энэ хуулиараа үүрэг хүлээж, эрх эдэлсэн. Гэрч гэдэг нь ямар эрхтэй юм, ямар үүрэгтэй юм, хохирогч нь ямар үүрэгтэй, ямар эрхтэй юм, ямар тохиолдлоор яллагдагч болох юм, ямар тохиолдолд сэжигтэн байх вэ, ямар тохиолдолд шүүгдэж болох юм, энэ өөрөө эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиар харилцаж явах ёстой. Энд бид энийг нээлттэй сонсгол дээр ч ярьж болохгүй. Энэ өөрөө тусдаа бие даасан хуультай, энэ дээр нь прокурор хяналт тавьж явах ёстой ийм л журамтай. Хариулж дууслаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Зэвсэгт хүчний төлөөлөл Батсайхан хурандаа.

Барилга инженерийн цэргийн удирдах газрын дарга, хурандаа Х.Батсайхан: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрэн мэндчилье. Би Доржханд гишүүний асуултыг үндсэндээ 2 чиглэлээр асуулаа гэж ойлголоо.

Нэгдүгээрт, манай цэргийн албан хаагчид маань Засгийн газрын тогтоолоор батлагдсан цэргийн норм гэж байдаг хоолны. Өнөөдөр би яг албан ёсоор ард иргэдийнхээ төлөөлөлтэй хамт энийг эцэслэж шийдэх талаар нэг мэдээлэл өгье гэж бодлоо. Өмнө нь бол

3 удаа мэдээлэл өгсөн. Зэвсэгт хүчнийхэн талхаа өөрсдөө барьдаг юм. Үндсэндээ энэ чиглэлээр Үндэсний аудитын газрын 4 дүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Самбууням гэж хүнд бид нар өнгөрсөн хавар Улсын Их хурал дээр энэ асуудал яригдаад өнгөрсөн. Яг тухайн цаг үеийн байдал дээр зэвсэгт хүчний ангиуд нэг килограмм талхыг үйлдвэрлэхэд 720 грамм гурил, 0.5 грамм хуурай хөрөнгө, 0.3 грамм ургамалын тос ороод нэг килограмм талхны өртөг 1050-1080 төгрөгийн өртөгтэй, цэргийн албан хаагчид маань өөрсдөө хэвийн нөхцөлд барьж байгаа. Тийм учраас тийм 20-25 мянган төгрөгийн талхны хангалт гэж бол огт байхгүй.

Дараагийн асуудал бол зэвсэгт хүчин, бүтээн байгуулалтын томоохон ажлуудад оролцож байгаа. Бид бол хуулиар хүлээсэн үүрэгтэй байдаг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан. Жишээ нь 2018 оны 01 дүгээр зарлигаар Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсын хөгжүүлэх, бүтээн байгуулалтад оролцуулах журам ҮАБЗ-ийн шийдвэр 2019 оны 5 сарын 5-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 135 дугаар тогтоол, тэгээд үүнийг үндэслээд батлан хамгаалах Жанжин штабын даргын тушаал гараад Зэвсэгт хүчний Барилга инженерийн цэргийн удирдах газрын харьяа 7 ангитайгаа бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа. Энэ санхүүжилт бол манайхтай хамаагүй. Бид тухайн үед Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 34 дүгээр тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсэг Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 315 дугаар тушаалаар байгуулсан дэд ажлын хэсгийн шийдвэрийн дагуу давхардсан тоогоор 69 аж ахуйн нэгж.../минут дуусав/

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Тавантолгой Ганбат дарга. Бодийн төлөөлөл байна уу. Бодийн төлөөлөл бэлдэж байгаарай.

“Эрдэнэс Тавантолгой” ХК дахь Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат: Би түрүүний презентаци дээр танилцуулсан. Хянан шалгах түр хорооны хуралдаан дээр ч гэсэн тэр мэдээллээ давтаад хэлье. Эхэлж 1 тэрбум 68.6 сая ам.долларын ТЭЗҮ батлагдсан. Энийг 2019 оны 10 сарын 29-нд батлаад, 6 сарын 10-нд энэ ТЭЗҮ-ээ 213 сая ам.доллараар нэмэгдүүлсэн. Мөн урьдчилаад төлбөрийг бэлнээр 110 сая ам.доллар бол 2019 оны 10 сарын 11, 23-нд 110 сая ам. долларыг шилжүүлсэн. Үүнээс гадна 5-13 хувийн нийтдээ яг Бодитой холбоотой 5 гэрээн дээр 5-13 хувийн хөнгөлөлт өгөөд үүний зөрүү нь нийт 187.7 тэрбум төгрөг. Ийм зөрүү үүссэн байна. Нөгөө талдаа хэрэв гүйцэтгэлийн дансанд шилжүүлэх, ханшийн зөрүү үүсвэл “Эрдэнэс Тавантолгой” ХК-д нийлүүлэх нүүрсний хэмжээ тохируулга хийх замаар хохиролгүй болгоно гээд энэ заалтын дагуу 1.1 сая 248.9 мянган ам.долларыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д төлөхөөр болсон ийм их заалтууд байна. Мөн гэрээг нөгөө талдаа мэдэгдэхгүй зогсоох юм бол 20 хувийн алдагдал хүлээнэ гэдэг ийм ийм заалтуудтай гэрээг байгуулсан байгаа гэдгийг бол хэлье.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Бодийн төлөөлөл байна уу. Бодь интернэйшнэл үдээс өмнө байсан даа. Бодь байхгүй юм байна Доржхад гишүүн ээ. Одоо асуулт хариултаа үргэлжлүүлнэ. Д.Мягмарсүрэн “Гүрэнт Монгол” төрийн бус байгууллагын төлөөлөл. Түрүүн Гэрэлт-Од гэж залуу Баттөмөр гишүүн, Ёс зүйн сахилга хариуцлагын байнгын хорооны даргыг асуугаад байсан. Шаардлага өгнө гээд байсан. Тэрийгээ өгнө биз. Энэ урд эгнээнд сууж байна шүү. Д.Мягмасүрэн байна уу. “Гүрэнт Монгол” төрийн бус байгууллага байхгүй байна. Тэгвэл дараагийнх нь Ц.Баатархүү. Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо, Ц.Баатархүү, баруун талын микрофон.

Сонсголд оролцогч, иргэн Ц.Баатархүү: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Өвөрхангай аймгийн тойргийн уулзалт хийж байгаа юм шиг хэлэлцүүлэг болж байгаа гэдгийг хэлье. Үндсэндээ бол нэг ийм оромдох маягтай. Улсын Их Хурал гэдэг институтийг гүйцэтгэх засаглал, төрийн институт, бусад харьяа байгууллагууд чинь тоохоо больчихсон

юм байна. Үнэхээр Улсын Их Хурал гэдэг энэ парламентын дархлаагаа алдчихсан юм байна. Өнөөдөр ийм нөхцөл байдалд хүргэхэд эрх барьж байгаа нам, МАН-ын 62 суудалтай Ардын намын бүлэг буруутай. Шулуухан хэлэхэд өнөөдөр цоллоод байгаа, Доржханд гишүүний цоллоод байгаа тэр компани, тендергүйгээр гэрээ өгөхөд Улсын Их Хурал яагаад мэдээгүй байсан юм. Энэ хяналт тавьдаг Байнгын хороод яагаад ажиллахгүй байгаа юм. Тухайн үеийн Төсвийн байнгын хорооны дарга нь Хүрэлбаатар байсан шүү дээ. Юу хийж байсан юм энэ Байнгын хороонд. Одоо энэ Байнгын хороод чиглэл, чиглэлээрээ яагаад хяналтаа тавьж чадахгүй байгаа юм. Та нарын үгэнд ордог хүн байхгүй болчихсон байна. Яагаад өнөөдөр энэ зарим газрын дэд дарга нар байгаад байгаа юм. Ярьж, ярьж хийж байгаа энэ хэлэлцүүлэг дээр дандаа дарга нар нь ирэх ёстой. Ирэхгүй байна. Улсын Их Хурал ажлаа хий. Улсын Их Хурал дахь хамгийн олон суудалтай, эрх барьж байгаа нам ажлаа хий. Тогтохсүрэн гишүүн ёс зүйн хариуцлагаа хүлээ. Манай намаас нэг ч хүн нүүрсний хулгайд оролцоогүй гэж мэдэгдэж байсан. Энэ хүн бол ёс зүйн хариуцлагаа хүлээ гэж би бодож байна.

Хоёрдугаарт, Доржханд гишүүн асуугаад байна. Гэрээг 2 тал үзэглэж хийдэг. Яагаад бид нарын хардаж байгаа нэг компани тендергүйгээр, сонгон шалгаруулалтгүйгээр оффтэйк гэрээ өгч, төмөр зам гүйцэтгэх боломжийг олгосон юм бэ. Энийг Засгийн газар хариуцлага хүлээх ёстой шүү дээ. Энэ ямар компаниар энэ төмөр замын ажлыг хийх юм бэ гэдгийг гүйцэтгэх түвшинд зохион байгуулах Засгийн газрын үүрэг. Тухайн үеийн Засгийн газрын тэр хариуцаж гарын үсэг зурсан хүмүүсийг яагаад энэ хэлэлцүүлэгт дуудахгүй байгаа юм. Энэ хэлэлцүүлэг дээр чинь үе үеийн Гаалийн газрын дарга, үе үеийн цагдаагийн дарга, үе үеийн Авлигатай тэмцэх газрын дарга, Хил хамгаалах газрын дарга нарыг оруулах ёстой байсан. Гэтэл үгүй, өнөөдөр бол зүгээр Өвөрхангай аймгийн сонгогчдын тайлан шиг ийм ерөнхий юм яриад сууж байгаа байхгүй юу. Хэлэлцүүлгийн хувьд та хэд харин үнэхээр зохион байгуулж чадахгүй байна. Дараагийн удаа зохион байгуулахаар энд суугаа хуульч залуучуудаас зөвлөгөө авах хэрэгтэй. Хэлбэрийн хувьд бол Доржханд гишүүн зөв ярьж байна. Ингэж босгож байгаад л асуух ёстой байхгүй юу. Нэг нэгээр нь шүүх ёстой байхгүй юу. Дахиад би нэг зүйлийг хэлмээр байна. Иргэд чинь энэ мэдээлэл янз бүр байгаа учраас хардаад байна шүү дээ. 9 оффтэйк гэрээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд нууцалчихаад байхад 7-г нь ил болгосон. Яагаад 2-ийг нь ил болгохгүй байгаа юм. Ямар 2 гэрээ нуугаад байгаа юм. Тоо нь ч гэсэн зөрүүтэй, 11 гэрээ. Ямар гэрээг нь нуугаад, ямар гэрээг нь ил болгоод байгаа юм. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гэдэг байгууллага чинь өнөөдөр аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулаад, аж ахуйн нэгжүүдийн дунд энэ компанид өг, энэ компанид өгөхгүй гэдэг тийм зөвлөмж гаргасан юм уу, үгүй юм уу. Тэр зөвлөмж нь байгаа юм уу, протоколууд байгаа юм уу. Ийм тодорхой бус байдлаар бид нарыг ингэж төөрөгдүүлж болохгүй. Та нар бол өнөөдрийн хэлэлцүүлгээр бид нарыг зүгээр л талцуулаад хооронд нь сайхан хэрүүл маргаан үүсгэж байгаад л аргалж байгаад л гарна гэвэл гонжийн жоо. Араас чинь явдаг сэтгүүлчид бий болсон, араас чинь явдаг залуучууд бий болсон. Хамгийн сүүлд би дахиад нэг юм хэлье. Хулгайтай тэмцдэг төр засаг гэж байдаггүй юм. Хулгай хийлгэдэггүй, хулгай хийх энэ боломжийг хаах ёстой. Концесс, ЖДҮ, Хөгжлийн банк зүгээр л энэ хулгай гэдэг дээр МАН аль фракц нь ялалт авах уу гэдэг уралдаан хийдэг болсон. Асуудлаа Төрийн ордонд шийдэж чадахаа болихоороо талбай руу гардаг болсон. Шударга үнэн энэ шүү дээ. Үнэнийг та нар сонсох хэрэгтэй. Одоо үнэхээр хулгайтай тэмцье гэвэл Монгол Улсын Засгийн газар ковидын хуулиа болих хэрэгтэй. Хаалттай байна. Хаалттай байгаа учраас хулгай яваад байна. Эсвэл иргэд хардаад байна.

Хоёрдугаарт нь зүгээр энэ төрийн өмчит компаниудынхаа тогтолцоо, засаглалыг өөрчил. Нээлттэй болго. Олон улсын аудитын байгууллага оруул, засаглалыг сайжруул, иргэдийн төлөөллийг ТУЗ-д нь оруулаач. Тавантолгойн ТУЗ-ийн гишүүдийг харсан чинь зүгээр л Ардын намын карманы хүмүүс байлаа шүү дээ. Яаж хяналт тавих юм. Ард түмний өмнөөс тэр хүмүүс хяналт тавьж чадахгүй. Тийм учраас би 2 тодорхой санал байна. Монгол Улсын Их Хурал яаралтайгаар энэ төрийн өмчит, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын

засаглалыг яах юм бэ гэдэг хуулийн төслийг оруулж ирж, батлуул. Тэгэхгүй бол Дулмааг Гончигоор солиод хулгайтай тэмцэж чаддаггүй. Хэзээ ч хулгай байсаар байдаг.

Хоёрдугаарт, Эрдэнэт үйлдвэр дээр бусад өмчит газар тогтоосон онцгой дэглэмээ одоо зогсоо. Ковидын хуулиа одоо зогсоо.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа, Баатархүү. Яах вэ тэгээд Улсын Их Хурал шийдвэр гаргаад нээлттэй сонсгол зохион байгуулж байна. Иргэдийнхээ саналыг сонсож байна. Холбогдох албаны мэдээ сонсож байна. Энийг бас улс төржүүлэхгүй байвал сайн байна. Бие бие рүүгээ дайрсан, давшсан бүдүүлэг гэх үг хэллэг хэлэхгүй байвал сайн байна. Юм яривал ярьж болно. Одонтуяа гишүүн энэ ажлын хэсэгт чинь ороод л ажиллаж байгаа шүү дээ. Гол энэ хурлын зохион байгуулах ажлыг Одонтуяа гишүүн хариуцаж байгаа шүү дээ. Хамтраад зохион байгуулж байна шүү дээ. Тэгээд юу гээд бие бие рүүгээ улс төржөөд, хатуурхаад дайраад, улс төржүүлж болохгүй Баатархүү. Батбуян “Ард түмний хурал” ТББ-ын төлөөлөл. Батбуян гэж байна уу. Батбуян байхгүй байна. Ч.Золжаргал Монгол нүүрс ассоциацийн төлөөлөл. Зүүн талын микрофон дээр.

Сонсголд оролцогч, Монголын нүүрс ассоциацийн төлөөлөл Ж.Золжаргал: Нээлттэй сонсгол гээд ийм зүйл Доржханд гишүүн санаачлаад хийж байгаа нь их задгай ярих боломжийг олгож байна. Тэгээд их чухал болж байна гэж бодож байна. Түрүүний илтгэлүүдийг нэлээн сонслоо. Хулгайч хэн бэ гэдэг дээр шалгаж байна гээд гээд яриад байна. Баахан жолооч нарыг шалгаж байгаа юм байна. Тэгснээ 2 уурхайн хооронд хилийн цэс дээрээ зөрчиж ороод экскаватор наана, цаана нь орсон юмыг яриад байна. Хамгийн том хулгай чинь тэнд биш шүү дээ. Хулгайг эрх мэдэлтэй хүмүүс төр засаг нь хийх ажлаа хийж чадахгүй, зохицуулалтын алдаа гаргаснаас болж хулгайн нөхцөл бүрдээд, тэдний доор ажиллаж байгаа төрийн албан хаагчдын гараар дамжиж хулгай явдаг. Тэгээд л юм болохоор ажил хийж байгаа Монгол хүмүүс рүүгээ дайраад, иймэрхүү өнгө хандлага байгааг бас хэлмээр байна. Гол асуудал нь хаана байна вэ гээд. Монголын баялаг хил дээр байхгүй болоод байна. Мөнгө нь Монгол руу орж ирэхгүй Хятад руу яваад байна. Энийг олон өдөр яриад бид нар ойлгочихсон шүү дээ. Тэндээс хэн алдаж байгаа юм бэ?

Нэгдүгээрт, мэдээж Монголын төр алдаж байгаа. Төсвөө авч чадахгүй. УИХ-ын гишүүн, Сангийн сайд өөрөө хэдхэн хоногийн өмнө Блүүмберг дээр ярьж байсан. 1-1.5 тэрбум төгрөгийн орлогоо бид нар алдаад байна гээд. Ингээд төсвөө алдчихлаа, багш цалин, тэтгэвэр тэтгэмж байхгүй.

Хоёрдугаарт нь тээврийн компани, тээвэрчид алдаж байгаа. Уурхайгаас аваад хил давуулаад мөнгөө хийгээд монголчууд амьдрах мөнгө чинь хил дээр очиж байхгүй болчихоод 90 хувь нь хятад компаниуд байдаг. Төлбөрөө цаана нь хийдэг гээд ингээд байхгүй. Тэгээд нэг жоохон юмыг нь олж аваад тэрэндээ баярлаад яваад байдаг.

Гуравдугаарт уурхайнууд маш их алдаж байгаа. Монголчууд баялгийнхаа эзэн биш. Монголчууд хямд ажиллах хүчин болчихсон. Уурхайнууд маш их ажил гаргаад, нүүрсээ гаргаад зардаг, хил дээрх тэр тусгаарлачихсан өндөр өртгөөс болоод амны үнэ өсөхгүй, цаанаас нь мөнгө авч байгаа хүн чинь хил дээр гарах зардлаа тооцоод үнийг нь нэмдэггүй, тэгээд Монголын уул уурхайн салбар тэр чигээрээ алдаж байна.

Амны үнэ нь өсөхгүй байгаа болохоор ийм нөхцөл байдал үүсгэж байгаа. Амны үнээр нь урт хугацааны оффтэйк гэрээ байгуулбал ямар вэ. Худалдаж авч байгаа хүмүүст ашигтай биз. Төмөр зам яагаад одоо болтол дуусахгүй байгаа юм бэ. Хилийнхээ тээвэр, логистикийг яагаад зохицуулж чадахгүй байгаа юм. Тэрнээс чинь болоод уурхайн аман дээр үнэ өсөхгүй, хил дээр хулгай гараад байдаг, үнэ өсөхгүй болохоор оффтэйк гэрээ байгуулаад

оффтэйк гэрээгээ төрийн нууцад хамруулчихаад нүүрсээ хэдээр зарж байгаа нь тодорхойгүй, хэн ашиг олж байгаа нь тодорхойгүй ийм нөхцөл байдал үүссэн. Сайн хэрэг талыг нь нээлттэй болгосон. Цаана нь дахиад нээлттэй болгосон гэрээнүүдээс илүү том дүнтэй Хятадын компаниудтай байгуулсан том гэрээнүүд байгаа. Монгол Улсад хэрэгтэй бүтээн байгуулалтыг хийхийн тулд тэр ажлыг хийсэн нь зөв. Гэхдээ Монголын нүүрсийг ямар үнээр, ямар хугацаанд, яаж нийлүүлж байгааг чинь хүмүүс асуугаад байна шүү дээ. Энийг Хятадын тал дээр тавьж хамтарч нээлттэй болгоё. Хятадын талдаа тавиад хил дээр байгаа тэр том өртөг хаашаа яваад байгаа юм, задалж гаргамаар байна. Яагаад гэвэл Хятадын албан ёсны төр, бас эндээс чинь тодорхой хэмжээнд хохирч байгаа. Хятадын бизнесменүүд Монголдоо шударга өрсөлдөөнөөр нүүрс авах гэхээр хилийн энэ Хятад, Монгол нийлсэн холион бантан хутгаж байгаа бүлэглэл чинь тусгаарлачихаад монопольдчихоод байна. Асуулт байна. УИХ-ын гишүүн, Сангийн сайд АМНАТ-ын талаар дандаа зөв бодлого явуулсан гээд хэлсэн. АМНАТ-ын хил дээр тэр Монголын төрийн зохицуулах ажлаа хийж чадаагүйгээс болоод хэт өндөр өртөг гарчихаад, нөгөөхөө аж ахуйн нэгжүүд дээр аваачиж овоолж байгаад улсын зохицуулалтаас болж алдаж байгаа 2, 3 зуун долларын өртгийг та нар төл гэж хэлээд Хятадын дотор байгаа үнээс АМНАТ авч байсан. Энэний үр дүнд доод ангиллын нүүрсээ борлуулж чадахаа байгаад өнгөрсөн жил 10 сард Тавантолгойн танилцуулга дээр 3.8 сая тонн эрчим хүчний нүүрс овоолго болоод хаягдаж байна гээд байсан. Монголын төрийн зохицуулалтаас болж байгалийн баялгийг иж бүрнээр ашиглах бодлого хэрэгжихгүй байгаа. Хог болж байгаа. 2, 3 зуун компани тонн өөрснөө 2 аж ахуйн нэгжийн хооронд хэрүүл дээр их акцент өгчихөөд төрийн алдаанаас болж хэдэн сая хүмүүс алдаж байгаа гэдгийг бид нар анхаармаар байгаа юм. Тэгэхээр та энэ АМНАТ-ын зохицуулалтыг хэзээ эрүүл болгох юм бэ. Энэ чинь бүр энэ салбарын асуудал болчихоод байна. Энэ Хууль зүйн сайд байхгүй байсан. Гэхдээ ерөнхийд нь бас дунд нь хэлэх нь зөв байх. Хууль зүйн сайд, Гадаад хэргийн сайд Хятадын талд энэ асуудлыг тавиад хил дээрх тэр холион бантанг 2 талаасаа албан ёсоор шийдье. Манайд хаалттай байгаад байгаа гэрээнүүдийг нээлттэй болго. Найрсаг хөршийн итгэлцэл дээр үзсэн хамтын ажиллагаа маань хэдэн ийм хэл дээрх бужигнаан, орон нутгийн чанартай Монгол, Хятадын төрийн албан хаагчдын үйл ажиллагаанаас болоод бохирдоод байна. Энэ 2 улс чинь урт хугацааны турш хамтарч ажиллах ёстой ийм олон жилийн түүхтэй хөрш улсууд. Тэгээд эцсийн асуулт нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд.../минут дуусав/

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Жавхлан сайд хариулья. Тэр микрофон дээр.

УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан: Би хэд хэдэн асуултад хариулчихъя. Түүрүүн Амарбаясгалан сайдаас бас асуусан. Бидний нэрлэж заншсанаар жижиг Тавантолгой буюу ууган Тавантолгойтой холбоотой. Тэнд ямар хуулийг барьж онцгой дэглэм тогтоосон юм бэ гэж. 1991 онд батлагдсан Засгийн газарт эрх олгох тухай хууль. 1992 онд хэдийгээр Үндсэн хууль батлагдсан ч гэсэн тэр хүртэл батлагдаж байсан бүх хууль хүчингүй болно гэсэн тийм ойлголт бол байхгүй. 1992 он хүртэл батлагдаж байсан маш олон хуулиуд хүчин төгөлдөр хэрэгжээд явж байгаа. Манай Засгийн газрын хувьд энэ нүүрс тойрсон ийм асуудлууд байна гээд энэ дээр онцгой арга хэмжээ аваад арга хэмжээнүүд аваад явахаар бас болохгүй гэж байгааг юу гэж ойлгох вэ? Энэ хуулийг барьж Тавантолгойгоос гадна “Эрдэнэс Тавантолгой” ХК, мөн 2018 онд Эрдэнэт үйлдвэрийн 49 хувьтай холбоотой асуудал дээр холбогдуулж мөн онцгой дэглэм тогтоож байсан. Ингээд энэ хуулийг хэрэглээд явж байгаа. Хувьцааг үнэгүүдүүлэх гэж байгаа юм биш, харин ч ууган Тавантолгой маань 51 хувь нь Өмнөговь аймгийн эзэмшилд байдаг. Өмнөговь аймаг шүү. Өмнөговь аймаг өнөөдөр Монголын төрийн нэг бүрэлдэхүүн хэсэг хэвээр байгаа. Хувьчлагдаагүй байгаа. Өмнөговьчуудын өмнөөс Өмнөговьчууд нь эзэмших ёстой тэр хувьцааны харин эдийн засгийн үнэ цэнийг хамгаалах гэж энэ онцгой дэглэм тогтоож байгаа. Онцгой дэглэм тогтоож байгаа, хяналт тавьж байгаа юм. Засгийн газар эхлүүлсэн эцсийг үзнэ. Бид эндээс

эргэж буцахгүй. Хэрвээ ингээд хяналтдаа аваад тэгээд тэнд хэрвээ янз бүрийн зүйл байхгүй, алдаа мадаггүй, хууль журмынхаа хүрээнд байвал тэгээд л онцгой дэглэмжээ татан буулгаад л явна шүү дээ. Эндээс нэг их одоо эргэж буцах ч гэдэг юм уу, энд эмзэглэх зүйл байхгүй гэж бодож байна.

Сая тэр тээврийн асуудал ярилаа. Харин яг энэ тээвэр дотор чинь асуудал байгаа учраас өнөөдөр энэ зүйлийг ярьж байгаа шүү дээ. Түүрүүн би тайландаа хэлсэн энэ бүх тээвэртэй холбоотой, нүүрс тойрсон асуудал чинь өнөөдөр гэнэт гарч байгаа асуудал биш. Сүүлийн хэдэн жил, ялангуяа 2018 оноос хойш Засгийн газрын өөрийн хяналтын бүтцийн байгууллагууд, аудит, тэр манай Асралт даргын яриад байгаа. Асралт өөрөө энэ нэг байгууллагыг ахалж байхдаа, даргалж байхдаа энэ зөрчилтэй асуудлуудыг гаргаж ирээд, дотоод хяналтаараа ингээд хуулийн байгууллагад шилжүүлсэн. Ийм зүйлүүд болсон байгаа юм. АМНАТ бол Үндсэн хуулийн 6.2 дугаар заалтыг Монголын төр хэрэгжүүлж байгаа ил тод, шударга ганц ийм төлбөр юм байгаа шүү. Та хилийн цаад үнээс гэж байна, бас буруу л яриад байна. Бид сая энэ 2021 оны 6 сарын 3-ны өдөр 174 дүгээр тогтоолоор энэ АМНАТ авдаг журамдаа өөрчлөлт оруулсан юм. Тэрэн дээр Хятадын FX goal биржийн үнэ дээрээс тэр бирж рүү ороод та нар вэб сайтыг нь харах юм бол манай урд талын боомт болгоноор үнийг нь тавьчихсан байгаа. Боомт болгоноор үнийг нь тавьсан болохоор тэндээс бид нар тээврийн зардлыг нь Хятадын импортын зардлыг нь хасаж байгаад, яг хил дээр хүнээс нь АМНАТ авч байгаа. Өөрөөр хэлбэл Монголын ард түмний өмнөөс хөрсөн доорх тэр нийтийн баялгийг авч ашигласных нь төлөө төлбөрийг нь ингэж хамгийн өндөр үнэлгээнээс нь тооцож авдаг. Энд бол олон нийтийн эрх ашиг байгаа байхгүй юу. Олон нийтийн эрх ашиг. Энэ АМНАТ-ын үнэлгээ авах энэ журам, тогтоол сүүлийн 10 арваад жил ингээд явж байгаа. Энийг энэ уул уурхайн бизнес рүү орж байгаа А лиценз эзэмшиж байгаа хуулийн этгээд болон энэ хууль журам АМНАТ-ын дүрмийг мэдэж орж байгаа. Мэдэж авч байгаа, мэдэж орж байгаа. Ашигтай ажиллана уу, ашиггүй ажиллана уу, тэр технологи нь зөв байна уу, буруу байна уу тэрнээс үл хамаарч ард түмний олон нийтийн өмнөөс авч байгаа төлбөр байхгүй юу. Дараа нь ашгаа олох хэрэгтэй.

Тийм учраас энэ АМНАТ дээр бид эргэж үзэх зүйл байхгүй. Харин техникийн шинжтэй засвар хийж байгаа зүйлүүд байгаа. Нүүрсэн дээр 26 янзын нүүрс байгаа шүү. 26 янзын. 26 ангилал тус бүр дээр үнэлгээнүүд нь өөр байгаа. Тэр үнэлгээнүүд нь өөр болохлоор мэдээж тэрийгээ дагаад АМНАТ бол өөр өөр түвшинд тогтоогдоод, саяхан ийм зохицуулалт хийгдсэн байгаа.

Тийм учраас АМНАТ-ын бодлого дээрээ Засгийн газар тогтвортой байна. Энэ дээр эргэж буцах зүйл байхгүй.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Ямар юмаа? Асуулт, санал 5 минут гээд тогтчихсон шүү дээ. Яах вэ, дараагийн хүний асуулт дээр Жавхлан сайдаар хариулуулчихъя. Та өөрийнхөө ээлж дээр асуу л даа та. Дэгээрээ явъя. Дараагийн хүнийг нь ав.

О.Цэнгэлсайхан гэж хүн байна уу? “Гүрэнт Монгол” төрийн бус байгууллага. О.Цэнгэлсайхан? Цэнгэлсайхан зүүн бүс юм. Эрдэнэбат Ерөнхийлөгч зогсоод байх шиг байх юм даа. Таны нэр энэ жагсаалтад ирээгүй байх юм. Та нэрээ тэнд шинээр хэлээд, нэмээд өгөөдөх л дөө. Энэ 51 дотор таны нэр байхгүй байна. Айн?

Сонсголд оролцогч, иргэн Г.Эрдэнэбат: Аль түүрүүн өгсөн.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Ийш нь өгсөн үү?

Сонсголд оролцогч, иргэн Г.Эрдэнэбат: Тийм.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Тэгвэл энэ 50 хүний дараа л орно гэсэн үг. Та сууж бай. О.Цэнгэлсайхан.

Сонсголд оролцогч, “Гүрэнт Монгол” НҮТББ О.Цэнгэлсайхан: Сайн байцгаана уу? Баялагтаа эзэн Монгол байна гэж хошгироод, баялгаа хулгайд алдчихсан Монголчуудад энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгэхээр бид баялагтай эзэн байхад яах юм бэ? Эрх баригч нам сонгуулийн хөтөлбөрөө маш томоор хэлсэн. Баялагтаа эзэн байна гэж. Тэгээд бид нар энэ баялагтаа эзэн байгаа юм уу гэдэг асуудал чинь өнөөдрийн хамгийн том, чухал асуудал болж хувирчихаад байна. Та нарын амлалт амласандаа хүрээд байгаа юм уу, үгүй юм уу? Монголчуудын ирээдүйн баялагтаа эзэн байж чадах юм уу, чадахгүй юм уу? Та нар энэ Монголын ирээдүйн баялгийг хулгайлаад байгаа юм уу, үгүй юм уу? Энэ тусгаар тогтнол чинь ер нь цаашдаа байх юм уу, байхгүй юм уу? Ийм асуудал дээр бид нар тулж ирчихээд өнөөдөр ард түмэн бухимдаад байгаа юм.

Дээр нь энэ стратегийн зориулалттай 39 орд байна. Энийг уул уурхайн маш олон эрдэмтэд, судлаачид хэлжээ. Энэ стратегийн зориулалттай 39 ордноос зөвхөн 15 ордыг нь ард түмэн та нарт мэдээлжээ. Үлдсэн нь яасан? Нуугаад, хаагаад, дараад өнгөрсөн байна. Хэрвээ энэ стратегийн зориулалттай 39 ордоос чинь энэ Тавантолгойн жишгээр наад Монголын нийт иргэдэд 7-10 хувийн ногдол ашгийг нь өгөхөд Монголын ард түмэн өнөөдөр өргүй байх, өвчингүй байх, аз жаргалтай амьдрахад боломж чинь байжээ. Энийг та нар яасан байх нь уу? Хулгайлсан байна. Баялагтаа эзэн биш байна гэсэн үг.

Тэгэхээр одоо энэ хэзээ энэ Монголчууд баялагтаа эзэн байх юм бэ? Энэ асуулт. Монголчууд ер нь цаашдаа баялагтаа эзэн байх юм уу, байхгүй юм уу? Энэ бас асуулт. Тэгэхээр Монголын ард түмнийг ийм эргэлзээтэй зүйлд хүргэсний чинь үр дүнд Монголын ард түмэн өнөөдөр гаднаа энэ хүйтэн талбай дээр чинь хөлдөж үхэхээ шахаад байж байгаа шүү дээ.

Та нар олигтойхон ажилласан бол, та нар бодлогоо зөв тодорхойлсон бол, тэр зөв замаараа явж чадсан бол Монголын ард түмэн өнөөдөр бухимдаад микрофоны урд хашгираад байхгүй байсан байхгүй юу. Энэ хэний буруу юм? Эд нар төр удирдаж байгаа та нарын 100 хувийн буруу. Монголын ард түмэн, Монголын ард түмэн энд чинь ямар ч буруу байхгүй. Монголын ард түмэн хийдгээ хийгээд, өглөө нар мандахаас оройны нар жаргах хооронд яаж байгаа юм? Үүрэгт ажлаа хийгээд байж байгаа юм. Нүүрснээс чинь хулгай хийгээгүй. Бидний өвөг дээдэс бид нарт ямар баялагтай нутаг үлдээсэн юм. Дэлхий гайхахаар баялагтай ийм хөрөнгө үлдээсэн байна. Хэн хулгай хийгээд байгаа юм? Монголын ард түмэн хулгай хийгээгүй. Та нар хулгай хийгээд байгаа юм.

Тийм учраас Монголын ард түмэн бухимдалтай байгаа юм. Тэгээд нэг тайлбар хийхээрээ ийм баахан тоо тавиад л, баахан онолын юм яриад л, толгой эргүүлээд л ийм байдалтай та нар Монголын ард түмэнг 30 жил хуурч ирсэн шүү дээ. Одоо болиоч та нар. Яаж тоглох гээд байгаа юм? Та нарт өнөөдрийн байгаа Монголчуудаар биш Монголын ирээдүй, миний, таны, бид бүгдийн хүүхдийн ирээдүйгээр тоглож байгаа та нар бол эх орноосоо урвасан хулгайчид байхгүй юу. Монголын ирээдүйгээс урвасан хулгайчууд байхгүй юу та нар.

Тийм учраас Монголын ард түмэн өнөөдөр бухимдаад байгаа юм. Та нар гадаа гараад хар зүгээр. Олон юм яримааргүй байна. Ард түмнээ зүгээр очоод хар. Тэр зах дээгүүрээр яв.

Монголын ард түмэн талхаа хувааж, таллаж аваад байж байгаа. Энэ тэгээд баялагтаа эзэн Монголчууд чинь мөн юм уу? Биш биз дээ? Та нар иргэдээсээ асуу. Бүгд банкны боол болоод байж байгаа. Авсан цалингаа хуугаар нь яасан? Банканд өгөөд, хүүд нь өгөөд. Хүүд өгөөд дээрэлхүүлээд сууж байгаа. Энэ чинь баялагтаа эзэн Монгол мөн юм уу? Та нарынхаар бол мөн гээд сууж байгаа байхгүй юу?

Ердөөсөө л энэ ойлголтын зөрүү байдал чинь энэ дээр үүсээд байна шүү дээ. Үгүй ээ, та нар ажлаа хийж байгаа юм бол, та нар Монголын ард түмний төлөө явж байгаа юм бол, Монголын ирээдүйн төлөө зүтгэж байгаа юм бол бид нар бухимдаад микрофоны өмнө хашгичаад суух ямар шаардлагатай юм? Би хаа байсан Архангайгаас ажлаа хаян хаян, үр хүүхдээ хаян хаян энд бухимдаж суух ямар ч шаардлагатай юм? Монголын ард түмэн сайхан амьдарч байсан бол, төр засаг нь олигтой ажиллаж байсан бол би энд хашгираад сууж байхгүй шүү дээ.

Тэгэхээр нээх юу ч хэлээгүй. Бид нар бол хийгээд байгаа, ажиллаад байгаа, ажиллах гээд л шүгэл үлээгээд байгаа. Битгий ингэж худлаа хуцацгаагаач ээ. Яагаад би энд өнөөдөр бүдүүлэг үг, хэллэг хэлж байгаа юм? Та индэр дээрээс та нар бүдүүлэг үг.../минут дуусав./

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Цэнгэлсайхан санал хэллээ. Одоо Улсын Их Хурлын 1 гишүүнээр үг хэлүүлнэ. Одоо Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд гишүүн асуулт асууя.

УИХ-ын гишүүн Ш.Раднаасэд: Ард түмэн гадаа нүцгэн байдаг. Бид албан тушаалтнууд өнөөдөр энд нүцгэн ярих хэрэгтэй л дээ. Үнэнийг нь. Харамсалтай нь зарим мэдээлэл үнэн биш байна. Үнэн сонсогдохгүй байна. Олон тоогоор будилуулах тийм юм явагдаж байгаа нь харагдаж байна. Улсын төсвийг Монгол Улсын Их Хурал баталдаг. Бид тэрбумаар төлөвлөж баталдаг шүү дээ Жавхлан сайдаа. Гэтэл өнөөдөр энд явж байгаа оффтэйк гэрээ, энэнтэй холбоотой хулгай дандаа их наядаар яригдаж байна шүү дээ. Тийм байгаа биз? Тэгээд бид нар ямар боломжоо алдаж байгаа нь эндээс харагдаж байна. Одоо энэ дээрээ дүгнэлт хийе хэдүүлээ. Одоо засах ёстой юмаа засъя. Би юуны өмнө хэдэн асуулт асуучихъя. Минут цөөхөн учраас. Тэгээд дараа нь би ярих юмаа ярья гэж бодож байна.

239 удаа татварын шалгалт хийжээ. Нийт 11 уурхай дээр. 10 жилийн хугацаанд. Тэгтэл “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр яагаад 4-хөн удаа хийсэн байгаа юм? Энэ компани сүүлийн 6 жилийн хугацаанд 7.5 их наяд төгрөгийн худалдан авалт хийсэн. Энэ 7.5 их наяд төгрөгийн бараг 40 орчим хувь нь зөвхөн компанийн дотоод урсгал зардал, цаас, хувцас хунар, хоол, унд, 10 жилийн ойд зориулсан дууны үнэ, хөлс гээд. Энэ дээр татварынхан хариулах ёстой юу? Эс үгүй бол энийг жил бүр хянаж байгаа энэ аудитор хянаж байх ёстой юу? Нэг ийм асуудал байна.

Хоёрдугаарт, энэ прокурорынхноос би асууя гэж бодож байна. 2871 хүн гэрчээр байцаагдаж байна. Энэ хэрэгт. Бид Улсын Их Хурлын 7 гишүүн гэрчээр байцаагдсан байгаа. Би бусдыг нь мэдэхгүй байна. Миний хувьд гэрчээр байцаагдсан. Энэ 2871 гэрч дотор хэдэн төрийн өндөр албан тушаал хашиж байсан хүмүүс байгаа юм? Эс үгүй бол одоо хашиж байгаа хүмүүс байна уу? Сайд байсан болон сайд хийж байгаа, Улсын Их Хурлын гишүүн байгаа, Ерөнхийлөгч, Ерөнхий сайдууд хэдэн хүн байна вэ? Энэ тоог хэлж өгөөч.

Гуравт нь энэ хулгайн загвар 2, 3 янзаар явж байна. Оффтэйк гэрээгээр нүүрс үнэгүйдүүлэх хэлбэрээр явж байна. Энэ бол хамгийн том их наядаар яригдах нь.

Хоёр дахь нь тэр хоосон машин гарч байгаа. Яагаад 20 гаруй мянган машин гарсан юм? Яагаад энийг өнөөдөр хянаж байх ёстой хилийн тагнуул нь, гааль нь хянаж чадаагүй

юм? Энэний учрыг яагаад тайлж чадахгүй байгаа юм? Тэр 10 камер тавихад л хянаана биз дээ?

Сүүлийн үед надад янз янзын мэдээллүүд ирж байна. Нүүрс бууруулдаг хэд хэдэн арга байна. Нэгдүгээрт туг тойрох гэж юм байдаг юм байна. Туг тойрч нүүрс хулгайлдаг. Одоо энэ Тавантолгойгоос ачигдсан машинууд яагаад Хөөтийн уурхай дээр буугаад, нүүрсээ буулгаад тэндээс Хөөтийн уурхайн нүүрс гэж эрчим хүчний нүүрс гэж Замын-Үүдээр гарч байна. Энийг жишээлбэл судалж үзэв үү? Үүнд хэн хариулах ёстой вэ? Тэнд Тавантолгойгоос ачигдаж байгаа хүн, хариуцсан хэмжигч, нярав 2 л энийг хийхэд боломжтой.

Хоёр дахь юм нь энэ Улаанбаатарын энэ шахмал түлшний үйлдвэр рүү ирж байгаа мидлингийн машинууд яагаад тэр мидлингийнхээ хашаан дотор орчхоод, буцаад Говьсүмбэрт очиж нүүрс буулгаад байна бэ? Энэ бас хулгай. Хаяг, шошго өөрчлөх хулгай гэж. Бас л эрчим хүчний нүүрс болж энэ чинь .../бичлэг сонсогдоогүй/.

Энэ өнгөрсөн 10 жилийн хугацаанд 10 их наяд төгрөгийн татварыг бид нар нүүрснээс авсан гэж байна. Өнөөдөр тэгвэл авах ёстой мөнгөө дахиад алдаад байгаа юм байна шүү дээ. Дахиад л энэ чинь хулгай яваад байна шүү дээ. Энэ оффтэйк гэрээтэй холбоотой юмыг бол энэ Доржханд гишүүн энэ хурал дотор байгаа бүх хүн ярьж байгаа. Ний нуугүй хэлэхэд. Энийг Ардын намын бүлэг өөрөө санаачилж ярьж эхэлсэн. Бүлгийн хурлаасаа. Энэ арай хэтэрлээ гэдгийг.

Тийм учраас энэ оффтэйк гэрээний асуудал нэлээн нухацтай цаашаа шалгагдах ёстой гэж харж байгаа шүү. Энэний цаана бол хэдэн их наядаар тооцогдох хэмжээний мөнгө байгаа. Монголчууд нийт хүүхдийнхээ мөнгөнд 1.4 их наяд төгрөг жилд төлж байгаа. Гаргаж байгаа. Өнөөдөр бид нар энэ алдсан зүгээр энэ “Бодь” компанид өгсөн 4 тэрбумыг нь зүгээр татварт нь авах ёстой мөнгөө тооцоход тэрнээс бага байна шүү дээ. 4 тэрбум доллароо 1 компанид өгчхөөд 2 төрлийн замыг бариад өг гээд сууж байдаг.

Тэгээд тэр төмөр замыг нь жижиглээд л гэрээ хийж байдаг. Замыг нь нэг тусад нь, холбоо дохиоллыг тусад нь, тэр байшин барилгыг нь тусад нь ингээд гэрээ хийгээд, үнээ өсгөөд, тэрнийхээ хариуд хямдаар нүүрс аваад явж байдаг. Тийм байж болох юм уу? Хаана бэлэн мөнгө байна, тэнд өнөөдөр бизнес хийх боломжуудыг нээж өгч байна шүү дээ.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Жавхлан сайд тэр татварын хяналт шалгалттай холбоотой, компанийн худалдан авалттай холбоотой асуултыг хариулах уу? Татварын дарга байгаа юм уу? 2 номерын микрофон дээр хариул. Татварын хяналт шалгалт. Энд гараад ир. Энэ урд гараад ир. Бусад компаниудад нь яагаад 10 гаруй удаа шалгалт хийсэн байтлаа Тавантолгой дээр 4 удаа хийсэн юм? Тэр худалдан авалттай холбоотой юмыг нь хэн хариулах юм? Тэрийг бэлдэж байгаарай.

Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал: Хэлэлцүүлэгт оролцож байгаа нийт хүмүүст энэ өдрийн мэндийг хүргэе. Татварын ерөнхий газрын дарга Заяабал байна. Раднаасэд гишүүний асуултад хариулья. Раднаасэд гишүүн “Эрдэнэс Тавантолгой” ХК-д хяналт, шалгалтыг хийсэн байна. Яагаад “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр 4 удаагийн шалгалт хийсэн, бусад компани дээр яагаад их хийсэн бэ гэдэг ийм асуулт тавилаа. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьд бол 2011 онд байгуулагдаж үйл ажиллагаа нь эхэлсэн ийм компани байгаа. 2013 онд татварын алба анх хяналт шалгалт оруулахдаа 2011, 2012 оны үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийж, үндсэндээ 11.7 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 3.5 тэрбум төгрөгийн акт, төлбөр тавигдсан байгаа. Дараагаар нь 2013-2016 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулж 2017 онд 37.1 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 11.3

тэрбум төгрөгийн акт тавьсан байгаа.

Мөн түүнчлэн 2017-2019 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулж, 2020 онд актыг эцэслэж, 318 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 62.2 тэрбум төгрөгийн төлбөр, актыг тавьсан байгаа. Одоо бол 2020-2021 оны үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажиллагаа үргэлжилж явж байгаа. Үндсэндээ байгуулагдсан цагаас өнөөдрийг хүртэлх бүх үйл ажиллагаанд татварын хяналт шалгалт бүрэн хамрагдсан гэсэн үг.

Нүүрсийг зарж борлуулдаг нүүрсний салбарт үйл ажиллагаа хийдэг, өнгөрсөн 11 жилийн хугацаанд нийтдээ 449 ийм аж ахуйн нэгж байгаа. 449 аж ахуйн нэгж байгаа. Тэрний 177 нь “А” лицензтэй. Бусад нь бол лицензгүй, нүүрс худалдаж авч зардаг. Ийм дамжуулан борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг ийм аж ахуйн нэгжүүд байгаа. Ингээд эдгээр аж ахуйн нэгжүүдэд өнгөрсөн 11 жилийн хугацаанд 237 удаагийн хяналт шалгалтыг явуулж, нийтдээ 295 тэрбум төгрөгийн акт, зөрчлийг илрүүлж, төлбөрийг тавьж төлүүлэх ийм ажиллагааг татварын алба зохион байгуулсан гэдгээ хэлье.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Худалдан авахтай холбоотойд нь хэн хариулах юм? Жавхлан сайд хариулах уу? Хэн хариулах юм? Прокурор хариулах уу? Тэр хяналт, эрүүгийн хэрэг үүсгэж байгаа 2000 гаруй хүнээс хэд нь өндөр албан тушаалтан байгаа юм, хэд нь авсан байгаа юм, хэд нь өндөр албан тушаалтай улсууд байгаа вэ гээд байна шүү дээ. Урд талын микрофон руу гарч ирээд хэл.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах газрын дарга Х.Буянтүмэн: Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрчээр мэдүүлэг авах ажиллагаа мөрдөгчийн бие даан хийх ажиллагаа хийж байгаа. Өнгөрсөн хугацаанд энэ нүүрсний хэрэг дээр нийтдээ төрийн өндөр албан тушаалтан 8 хүнийг гэрчээр дуудаж, мэдүүлэг авсан гэж байгаа. Мөрдөн шалгах ажиллагааны онцлог бас бий. Бид хуулийн дагуу ажиллагаа явуулах ёстой. Нэрийг бол тодорхой хэлэх боломж байхгүй. Тооны хувьд бол сая тоо асуулаа шүү дээ. Гэрчээр төрийн албан тушаалтан 8 хүнийг гэрчээр асуусан.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Тэр гаалийн хяналт шалгалттай холбоотой асуулт. Гаалийн дарга байгаа юм уу? Гаалийн дарга хаана байна? Гаалийн хяналт шалгалттай холбоотой асуудал дээр хариулт өг. Нэр, албан тушаалаа хэлээд явна шүү.

Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газрын дарга Б.Сүхбаатар: Гаалийн ерөнхий газрын гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газрын дарга Сүхбаатар. Энэ мидлинг гэж ярьж байгаа. Энэ нь болохоор коксжих нүүрсийг угааж баяжуулах үед үүсдэг завсрын бүтээгдэхүүн. Барааны ангилал, код ангиллыг тодорхойлох код уялдуулсан системийн кодын дагуу энэ бараа нь коксжих чанаргүй, баяжуулсан нүүрс гэсэн ийм ангиллаар ордог. 2021 оны 1 сарын 1-нээс энэ оны 10 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд нийтдээ 15 аж ахуйн нэгж 1.2 сая тонн энэ ангилалд хамаарах нүүрсийг экспортлоор гаргасан байгаа юм.

Тэгэхээр одоо энэ “Тавантолгой” компаниас дотоодод худалдан борлуулсан гэдэг юм уу, тэр асуудал дээр гаалийн байгууллага хяналт тавихгүй. Монгол Улсын хилээр зохих бичиг баримтаа бүрдүүлээд, шаардлагаа хангасан аж ахуйн нэгж, иргэн бол ямар ч бараа бүтээгдэхүүнийг чөлөөтэй экспортлох эрхтэй. Энэ дагуу нь холбогдох гэрээ, худалдааны бичиг баримтад нь хяналт тавиад, экспортын бүрдүүлэлтийг нь хийж байгаа. Хөөтөд буух тэр дотоодын тээвэрлэлт, худалдан авалтын асуудал дээр гаалийн байгууллага хяналт тавихгүй байгаа. Хөөтөд бууна, ...бас бууж байгаа. ... /бичлэг сонсогдоогүй/ хяналтын бүсүүдэд захиалга, дуудлагаар бас манай хүний гаалиас очиж хяналт тавьж байгаа. Ачилтад нь.

Энэ бол коксжих нүүрс биш. Нүүрсийг баяжуулах, боловсруулах явцад үүсдэг завсрын бүтээгдэхүүн. Албан бус нэршил нь мидлинг гэж яриад байгаа юм. Эрчим хүчний нүүрс бас экспортын бүрдүүлэлт хийгээд гарч байгаа. Гарч байгаа тохиолдлууд байгаа. Тэр яг дотоодын тэр хяналт шалгалтын асуудал дээр хууль хяналтын байгууллага хяналт тавьж байгаа байх.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Тэр худалдан авалттай холбоотой, шошго өөрчлөлттэй холбоотой, оффтэйк гэрээтэй холбоотой асуудалд Ганбат дарга хариулах уу? Тэр 7.5 их наядын худалдан авалттай холбоотой асуудал яриад байна. Шошго өөрчлөлттэй холбоотой асуудлыг яриад байна. Шахмал түлштэй холбоотой асуудал яриад байна. Оффтэйк гэрээтэй холбоотой асуудлаар яриад байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК дахь Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат: Худалдан авалттай холбоотой асуудал дээр хариулъя. “Эрдэнэс Тавантолгой” ХК бол жил болгон борлуулалтын орлого бас ашгаасаа хамаараад жил болгон хөрөнгө оруулалт нь өөр. 2020 онд 900 гаран тэрбум төгрөг, 2021 онд 1.1 их наяд гаран, тэгээд энэ оных нь 3.2 их наядын нийт хөрөнгө оруулалт өөрсдөө хийдэг юм байна. Жил жилийнхээ ашгаасаа хамаараад. 26-нд томилогдсоноос хойш худалдан авалтынх нь юмнуудыг нь үзлээ. Ном журмаараа ч явдаг юм байна. Асуудалтай ч юм байна. Нууцын журамд оруулаад, шууд гэрээ хийдэг ч ийм асуудлууд байна. Тендерт ялчхаад гэрээ байгуулах гээд байгуулж чаддаггүй, гэрээгээ тодорхойгүй шалтгаанаар байгуулахгүй байж байгаад хугацааг нь дуусгачихсан ийм асуудлууд байна. Энэ бүгдийг нь үзээд шаардлагатай юмнуудыг нь Авлигатай тэмцэх газарт шалгуулахаар яг худалдан авалтын асуудлыг өгсөн. Одоогийн Авлигатай тэмцэх газар дээр яг энэ асуудлаар болон ер нь санхүүгийн сахилга бат муу, зөрчил гаргасан асуудалтай холбогдуулан нийт 9 албан тушаалтныг Авлигатай тэмцэх газар дээр шалгуулах гээд өгсөн. Нийт 6 аж ахуйн нэгжийг шалгуулахаар өгсөн. Ийм байдалтайгаар худалдан авалтын юм бол байгаа.

Худалдан авалт дээр бол мөн нөгөө талдаа бол тендерээрээ зарлаад л тэрийг нь нөгөө хянадаг журмаараа яваад хянагдаад, холбогдох байгууллагууд нь хянаад явчихдаг. Жил болгон аудит ордог ийм байдалтай байгаа. Сая Засгийн газраас чиглэл болгосны дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн бүхий л үйл ажиллагаанд нь олон улсад нэр хүнд бүхий аудит оруулахаар бид Засгийн газраас чиглэл өгсний дагуу сонгон шалгаруулалтаа зарлачихсан байгаа. Ойрын үед энэ аудитыг хийлгэнэ.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Одоо иргэдийн төлөөлөл асуулт асууна. Л.Энхболд? Л.Энхболд Улсын Их Хурлын гишүүн асан. Л.Энхболд байхгүй байна уу? Нэр өгсөн байна. Байхгүй байна. Б.Батсайхан Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн?

Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн Б.Батсайхан: Байна. Энэ микрофоноо өгчих үү? Нийгэм энэ сонсголд их ач холбогдол өгч байгаа юм. Учир нь энэ асар том хулгайны цаана энэ агуу үндэстний, энэ улсын хувь заяаны асуудал яригдаад байгаа юм л даа. Сүүлийн 30 жил Монгол Ардын нам, Ардчилсан нам 2 хамтарч тус тусдаа төр бариад, Монголын хувь заяаг өөдүүлээд, сэхээнд авааччихсан.

Асуулт иргэдээс: Монголын хувь заяа сэхээд очсон уу? Эрх баригчдаас асууж байгаа юм. Монголын хувь заяа сэхээнд очсон уу? Би асууж байгаа юм. За ингээд дуугүй байна.

Тэгэхдээ баримт дээр ярья. Өөрөөр хэлбэл энэ улсын хувь заяа буюу улс оршихуйн үндэс, үнэт зүйл, тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын үндсэн бүрэлдэхүүн хэсэг аюулд орсныг баталгаагаар ярья.

Нэгд, бид нарын өвөг дээдсээс үлдээсэн газар нутгийн бүрэн бүтэн байдал, экосистем аюулд орчихсон. Байхгүй. Хамгийн сүүлийн зургаар энэ байна. Нүүрс цаашаа шүү. Хамгийн сүүлийн зургаар Дорнодоос авхуулаад Увс, Ховд хүртэл энэ цэнхэртээд байгаа газар нутгийг газрын тосны хайгуулын лиценз өгчихсөн. Өнөөдөр 4000 гаран гол, мөрөн ширгэчихсэн байгаа. Өнөөдөр Өмнөговьд ухчихсан тэр 300 гаран сая тонн нүүрс ухчихсан газрыг ахиад нөхөн сэргээлт хийх ямар ч боломж байхгүй. Иймд экосистем бүрэн сүйрсэн. Ийм газар нутгаар бид яах юм? Ингээд бүрэн экосистем алдагдчихаж байгаа юм.

Хоёрт, бидний өвөг дээдсээс үлдээсэн агуу том нүүдлийн соёл өнөөдөр шахагдаж байна. Уурхайд. Усгүй болчихсон. Бэлчээр, Газрын тухай ерөнхий хууль ороод ирсэн. Хамгийн аюултай нь. Эко хүнсний тухай хууль орж ирэх гэж байна.

Гурав.Монгол хүний эзэн эрх байхгүй болсон. Эх орондоо эзэн байх эрх, эрүүл мэнд, элэг бүтэн амьдрах амьдрал мөн үү? Бүгд хулгайлагдсан. Хэн ч биш болсон.

Дөрөв.Эдийн засгийн тусгаар тогтнол бүрэн алдагдсан. Бүх үндэсний том компани, банк дампуурсан. Үндэсний компаниуд юу болсон бэ? Үйлдвэрлэж байгаа нэг юм ч байхгүй.

Тав.Энэ бүхнийг хамгаалж, элгэндээ тэвэрч байх ёстой төр өнөөдөр ямар ч чадамжгүй болчихлоо. Энийг өөрөөр хэлбэл энэ 30 жил төр барьсан, өнөөдөр байгаа та бүхэн ийм байдалд аваачсан.

Гэтэл өнөөдөр бид нарыг хар даа. Улс орны маань хувь заяаг ийм байдалд авааччихсан улсуудаас дахиад хувь заяаг гуйгаад сууж байгаа байхгүй юу. Одоо энийг ахиад яах вэ гээд бид нартай. Энэ бол арай Монголчууд яг үнэнийг хэлэхэд бид нар дэндүү арчаагүй, дэндүү ямар ч агуу сэтгэлтэй юм тийм ээ? Тэвчсэний хар гай. Нэг үг байдаг шүү дээ. Хаан хүнийг шинжих 35 эрдэм байдаг. Хамгийн дээд эх нь нигүүлсэл. Ард түмнээ алагчилдаггүй, эх нутагтаа, газар нутагтаа, зүрхэндээ багтаагаад явж байх эрдэм энэ улсуудаас байна уу? Харц хүний 3-хан эрдэм байдаг гэж байгаа юм. Хамгийн дээд тал нь арилжаалах эрдэм. Бүгдийг зардаг. Өнөөдөр зарж болдог, болдоггүй юмаа ч мэдэхгүй эх орноо зарж байгаа байхгүй юу. Ийм улсуудаар бид нар төр бариулчхаад одоо эд нараас бид нар хувь заяагаа шийдүүлэхээр асууж байгаа байхгүй юу. Юу хүсэх юм бэ? Нэг шийдэл хэлье. Бид уг нь хуультай орон. Үндсэн хуультай. Одоо больё. Монголын оюун санаа огт дуусаагүй.

Бид маргаашаас эхлээд Монголын хувь заяаг өөрсдөө авч явах тийм Монголын иргэд байна уу, үгүй юу? Энийг хайцгаая. Эд нарт биш. Уг нь хууль дээр байгаа юм. Үндсэн хуулийн 3.1 дээр Засгийн эрх мэдэл ард түмний гарт байна. Энэ эрхийг шууд буюу сонгож байгуулсан төлөөлөгчдийн байгууллагаараа эдэлнэ гээд. Монголын ард түмэн дараах эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ гэж байдаг шүү дээ. Төрийн хэрэгт шууд оролцоно гээд. Энэ эрхээ эдлэх цаг болжээ. Одоо энэ зурагт үзээд байж байгаа учир мэдэх хүмүүс өнөөдөр ил гарч ирэх цаг болсон. Бид Монголынхоо хувь заяаг нуруундаа үүрэхгүй бол энэ хүмүүс лаахайдаад байвал тун удахгүй саяын үзүүлсэн зураг. Бид эх оронгүй болно. Тийм учраас хариуцлагаа өөртөө үлдээе.

Мөн гадаадад байгаа олон улсуудыг хэлье. Нэгдсэн Үндэстний Байгууллагын анхны хууль 61 онд ороод хүн төрөлхтний гишүүн болоод анхны хүлээж авсан баримт бичиг Хүний эрхийн түгээмэл тунхаглал байгаа. Аливаа ард түмнийг ямар ч тохиолдолд оршин тогтнох хэрэглүүрээс нь хагацааж үл болно.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Үг хэллээ. Б.Найдалаа.

Найдалаа Хөдөлмөрийн үндэсний намын төлөөлөл. Хүн гэнэ.

ХҮН намын төлөөлөл Б.Найдалаа: Баярлалаа. Хүн нам шүү. Баярлалаа. Би маш товчхон ярья. Асуулт асуухгүй. Асуулт асуугаад олигтой ч хариулт энд байхгүй, тохиромжгүй юм байна. Шийдэл ярья. Хоёр зүйл байгаа юм л даа.

Нэгдүгээрт, мэдээжийн хэрэг хулгайчаа олж, яллах, шийтгэлийг нь хүлээх, хариуцлагыг хүлээлгэх.

Хоёр дахь нь дахиж яаж энэ хулгайчийг гаргахгүй байх вэ? Яаж хулгайчийн замыг таслах вэ? Та бүхэн санаж байна уу? 2018 онд ЖДҮ ярьж байхад, яг ингээд ярьж байгаад л хулгайчийг шийтгэе шийтгэе гэж байгаад тэгээд яасан мэдэхгүй. Хулгайч нар дахиад гараад ирсэн. Тэгэхээр яг энэ алдааг дахиж давтахгүйн тулд хэдүүлээ яг одоо энэ олон хүн сонсож байна, иргэд жагсаж байна, бид бүгдийн энэ Монголчуудын хүсэл, тэмүүлэл энийг өөрчлөх ёстой байгаа юм. Хулгайч үрждэггүй, хулгайч гардаггүй, тэрийг нь, замыг нь таслах ёстой юм. Та бүхэн санаж байгаа. 2008 оны 7 сарын 1-нд юу боллоо. Одоо ажиглах юм бол гадуур болж байгаа жагсаал өдрөөс өдөрт томорсоор, хүмүүс нь олширсоор байгаа. Залуучууд, иргэд янз янзаар өөрийнхөөрөө тэр асуудлыг бухимдаад илэрхийлж байгаа боловч шийдэл нь 7 сарын 1-тэй адилхан шүү. Өөрөөр хэлбэл одоо гадаа болж байгаа жагсаал, энд сууж байгаа хүмүүсийн бухимдал 7 сарын 1-ний жагсаал хоёрын сүнс нь яг адилхан. Тэр үед, тэр үед яг эрх барьж байсан Ардын нам, Ардчилсан намын гишүүд, дарга нар, лидерүүд цаг үеэ мэдрэхгүй, иргэдээ хуураад, нийгмийн хүсэж байгаа тэр өөрчлөлтийг хийж чадаагүй болохоор энэ чинь бугшсаар байгаад өнөөдөр ингээд тулчхаж байгаа юм.

Тэр шинэчлэл нь юу юм? Яг тодорхой ярья. Олон хууль байгаа. Хамгийн тодорхой, яаралтай хийх зүйл бол нэгдүгээрт Сонгуулийн тухай хууль, Сонгуулийн тухай хуулийг өөрчлөх тухай биш, өнгөрсөн 30 жилээс эрс шинээр хийх, сонгуулийг өөрөөр хийдэг больё гэж байгаа юм. Боов шоов тараадаг чинь хулгайн мөнгө шүү Монголчуудаа! Амралтад явуулаад байгаа чинь хулгайн мөнгө шүү! Тэгээд энийгээ бүгдээр нь, орвонгоор нь больё гэж байгаа юм. Сонгуулийг маргааш явуулах юм бол яг одоогийн тогтолцоо, сонгуулийн хуулиар юу ч өөрчлөгдөхгүй. Энийг хэдүүлээ ойлгоё.

Хоёр дахь нь хулгайч хаанаас төрөөд байгаа юм, хаана орогночхоод байгаа юм? Улс төрийн нам шүү дээ. Яг нам дээр чинь очиж шигдсэн, үржээд, биежээд, бие биеэсээ сураад ингээд байна. Тэгэхээр Улс төрийн намын тухай хуулийг эрс өөрчлөх, цоо шинээр хийх. 1992 онд хийсэн тэр концепцтоос шал өөр. Улс төрийн нам бол өөр зорилготой, өөр амьтай байх ёстой. Социализмын үед коммунист нам байх ёсгүй.

Гурав дахь нь Улс төрийн намын санхүүжилтийн тухай хууль. Хулгайн мөнгө хаана байгаа юм гээд байгаа юм. Хулгайн мөнгө чинь намууд дээр оччихсон. Тэнд шигдчихсэн, тэд нарыг санхүүжүүлээд, сонгуулийг санхүүжүүлээд, боорцог болоод, тэр байтугай цаашлаад начны бөхийн найраа ороод явж байгаа байхгүй юу. Үүнийг өөрчлөхийн тулд Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулиа өөрчлөх ёстой.

Би тэгээд эцэст нь дүгнээд хэлэхэд энэ шинэчлэлийг эсэргүүцэж байгаа улс төрийн Улсын Их Хурлын гишүүн улс төрч байх юм бол тэр хулгайч гэсэн үг. Би энийг шулуухан хэлчихье. Хулгайчийн тал гэсэн үг. Шинэчлэлийг эсэргүүцэж байгаа гэсэн үг. Ийм болохоор бид нар дахиж хулгайчийн замыг хаахын тулд шийдэл дээр бас анхаарах хэрэгтэй юм байна шүү. Тэгээд одоо Их Хурлын гишүүд ямар хэрэг мөрдөөд шалгах юм биш. Завтай байгаа. Саяын хуулийн шинэчлэлүүдээ, тогтолцооны шинэчлэлүүдээ, нийгмийн хүсээд байгаа, залуучуудын хүсээд байгаа заримдаа хэлж чадахгүй байгаа тэр шинэчлэлүүдээ яаралтай, шуурхай хийх хэрэгтэй. Хийхгүй бол одоо ялангуяа эрх барьж байгаа Ардын нам бол

өөрсдөө арчуулна шүү. Нийгмийн хүчийг хэн ч дийлдэггүй. Баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Санал хэллээ. Одоо Н.Өнөрцэцэг Zarig.mn сайт. Н.Өнөрцэцэг байгаа юм уу? Нэр өгсөн юм байна. Zarig.mn сайтын Н.Өнөрцэцэг байхгүй юм байна. Дараагийн хүн Х.Сугир Өмнөговь аймгийн төлөөлөл. Өмнөговь аймгийн иргэн Х.Сугир, Хуучин хурлын дарга байсан мөн үү? Сугар гуай алга уу? Хэлсэнд тооцлоо. Т.Батцогт Баянзүрх дүүрэг, 17 дугаар хорооны иргэн гэсэн байна. Т.Батцогт.

Сонсголд оролцогч, иргэн Т.Батцогт: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Хурал даргалж байгаа Чинзориг гишүүнийг бас сайн хараад аваарай. Хаяагаа хадардаг, хажууд байгаа эмэгтэй рүүгээ буруугаа бухдаг. Тэгж ярих юм бол энэ сонсголыг, өнөөдрийн энэ сонсголыг 12 сарын 15-ний өдөр албан бичгээр Соёлын төв өргөөнд зохион байгуулъя гээд санаачлаад явсан шүү дээ. Тэгээд би буруугүй, миний хажууд сууж байгаа энэ хүн буруутай гээд ингээд яриад байдаг. Тэгээд таны яг энэ гаргаж байгаа үйлдэл, танай намын үйлдэл 2016 оны Улсын Их Хурлын сонгуулийг төрийн эрхийг хууль бусаар авах гэж схем гаргасан. 60 тэрбумын схем гаргасан. Схем гаргасан улсуудаа ялласан. Гэхдээ тэр схем үргэлжлээд өнөөдрийг хүртэл явж байгаа. Тэрний илрэл нь юу вэ? ЖДҮ-ийн хулгайд 40 гишүүн холбогдсон. Хөгжлийн банк бас адилхан эрх мэдэлтэй албан тушаалтнууд холбогдсон.

Өнөөдрийн нүүрсний хулгай яг л энэ схемээр ингээд явж байгаа. Энэ бүгд. Гол асуудал юу байна вэ гэхлээр төрийн өмчит компаниуд өнөөдөр мэдээллийн сайтаас, төрийн мэдээллийн сайтаас хэд хэдэн тоонуудыг харлаа. Б.Жавхлан сайд байна. Гайхуулаад өндөр өндөр тоо яриад байна. Танаас тоо асууна. Сангийн яам, Сангийн яамны мэдээллээс харж болно. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд, 339 аж ахуйн нэгж байгууллага, Сангийн яамны тоо шүү. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын мэдээллийн сайтаас харсан. 467 төрийн өмчит үйлдвэрийн газар, Үндэсний аудитын газар 537 төрийн өмчит үйлдвэрийн газар. Гурван байгууллагын тоо гурвуулаа өөр өөр байгаа биз?

Тав дахь нь хамгийн чухал байгууллага Монгол Улсын Үндэсний статистикийн газар. Нийтдээ 5393 нэгж гэж байгаа юм. Тэгээд энэ хулгайч нь яг эндээс л эхэлж байгаа юм. Төрийн өмчит үйлдвэрийн газрууд хэдэн мянга байгааг нь та бүхэн сая харж байна, сонсож байна. Тоогоо мэдэхгүй болтлоо хулгайд алдсан.

Тэгээд энэ олон төрийн өмчит үйлдвэрийн газрууд 2022 онд хэдэн төгрөгийн төсөв баталсан бэ? УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан хариулаарай. 2023 онд энэ олон төрийн өмчит үйлдвэрийн газрууд хэдэн төгрөгийн төсөв баталсан бэ? Монгол Улсын хэмжээнд? Эндээс бүх хулгай эхэлж байгаа юм. Энэ тоо, энэ өмчит үйлдвэрийн газрууд өнөөдөр бизнес эрхэлж байгаа хувийн хэвшлийнхний бүх боломжийг хулгайлж байгаа. Арай л нөгөө төрийн ТҮЦ гэж байхгүй. Бараг бусдыг нь бүгдийг нь төрийн өмч нэрээр байгуулж, өөрсдийн нөхдөдөө энүүгээр дамжуулж хулгай хийдэг, мөнгө угаадаг ийм л хэрэгсэл болгосон байна. Тэгэхлээр энэ тоонуудыг авахыг хүсэж байна. Баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Б.Жавхлан сайд хариулах уу? Манай Ардчилсан намын гишүүд ард түмний Ерөнхий хяналтын сонсголыг намын тайз болгохгүй шүү. Анхааруулъя. Намын тайз болгохгүй шүү. Би тэгвэл иргэдийн төлөөллөөс бүгдийг чинь намын төлөөлөл гэдгийг нь уншина шүү. Надад нэр нь байгаа шүү. За Жавхлан сайд хариул.

УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан: Асуултад хариулъя. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл дарга байна уу? Засгийн газрын бүтцийн

байгууллагууд хариуцдаг хариуцаг зүйл дээрээ хариулт өгнө. Төрийн өмчийн болон зохицуулалтын газар гээд бүхэл бүтэн институт байна. Төрийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой, орон нутгийн өмчийн, хамтарсан гээд олон статустай төрийн оролцоотой аж ахуйн нэгжүүд байгаа. Бүх статистик, бүх тоон мэдээнүүд нь тэр байгууллага дээр нэгтгэгддэг. Та манай дээрээс буруу л тоо харсан юм шиг байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хүн байна уу? Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргыг дуудчихъя. Тэндээс асуултыг.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Хэнийг, Б.Цэнгэл даргыг уу?

УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан: Тийм.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Б.Цэнгэл даргыг дууд л даа.

УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан: Хариуцдаг, хариуцдаг юмаа хариулна.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Б.Цэнгэл даргыгаа дууд. Шадар сайдаа, Шадар сайд байгаа юм байна. С.Амарсайхан сайд та Б.Цэнгэл даргыг дуудаач. Төрийн өмчийн хорооны даргыг. Дараагийн төлөөлөл М.Самбууням 33 нэгдлийн төлөөлөл. М.Самбууням 33 нэгдлийн төлөөлөл.

Модун 33 нэгдэлийн төлөөлөл М.Самбууням: Хүйтэн байна. Сонсогдож байна уу? 18 өдөр болсон байна. Монголын залуучууд гадаа цементэн дээр. Хөлдөөд үхвэл та нар хариуцлагаа хүлээгээрэй. Гэр барьж өгсөн, буцаагаад хураагаад байгаа. Би бүр маш товч ярья та нарт. Энд бас намынхан их байгаа шүү. Та нарын хэрэг. Энэ нам бид нарт ерөөсөө ямар ч шаардлагагүй. Зүгээр энгийн ард түмэн бид нар. Намаа тараацгаа та нар. Ерөөсөө л иймэрхүү л шаардлага тавина.

Нэг.Монголд ерөөсөө нам хэрэггүй юм байна. Асуулт маш товч, тодорхой болно. Нүүрсний хулгайчийн нэрсийг зарла гэсэн. Энэ оффтэйк гэрээн дээр одоо энэ дээр Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар мөн үү? Энэ гол улсуудаа, Засгийн газар яагаад авчраагүй юм бэ? Засгийн газрын тэргүүн чинь байж байх ёстой. Энэ алга. Энийг одоо яг хариултыг нь хэл. Энэ том том ацулуудаа зарла гээд байгаа юм. Энэ ацулууд чинь хаана байгаа юм? Нийгэм тэгж хүлээж байгаа. Нийгмийг та нар мэдээ, мэдээлэлгүй хэдэн өдөр болгодог юм? Энэ Монголын үндэсний радио телевиз хаана ажиллаж байгаа юм? Энэ талбай дээр аль ... /*бичлэг сонсогдоогүй*/ чимээг нь намжаах, энэ хуулиа чангалчихсан бол та нар ямар ч асуудалгүй. Өнөөдөр энэ чинь бүр усны үеэр, далайн давлагаа, цунами болж байна. Монголын бүхэл бүтэн хувь заяаны асуудлыг ярьж байхад та нар энэ хэвлэл, мэдээллээ та нар яагаад байлгаж болдоггүй юм? Одоо энэ хаалтын гэрээ.

Хоёр. 22.1 Авлига, албан тушаалын хууль та нар бүгд мэдэж байгаа энэ жишээлбэл, Улсын Их Хурал, Засгийн газар энэ бодитой энэ үр дүнг нь хэлээч дээ та нар. 20-25 жил ял өг, төрийн албанд насаар нь ажиллуулахгүй, хөрөнгийг нь хураа. Энэ хөрөнгийг нь хураагаад ард түмэнд хэрэгтэй аж үйлдвэр, хүн амьтны ажлын байртай болох тэрийг нь байгуул.

Гурав. Одоо энэ ард түмний тухай энэ хянан шалгах хороо байгуулмаар байна. Энэ ерөөсөө бүх юмыг эд нар, нам, улс төрийн зорилготойгоор та нар нэг нэгнийгээ, хулгайч хулгайчийгаа барьдаггүй гэж ард түмэн. Монголчууд ер нь хэзээнээсээ худалч, хулгаач юм? Хэзээнээсээ мэддэггүй, үздэггүй. Ийм учраас энэ ард түмнийг бүх юмандаа ард түмний төлөөллийг оруул. Магадгүй энэ цаашаа ард түмний тэр хуралдай ч зарлах түвшинд

хүрчихсэн байна. Энэ одоо тэнд байгаа төлөөллүүд бас ингэж ... /бичлэг сонсогдоогүй/ байна. Одоо энэ сая миний энэ асуудлыг ард түмний хянан шалгах хороо гэдэг бол бүх энэ байгууллага бол ард түмний цэвэр нийгэмд ямар ч нам биш, үзэл бодлоороо Монголын төлөө явсан энэ Модун 33 би сая талбай дээр 18 хонохдоо тэр гэр дотор, энд ирсэн улсуудаас санал асуулгын судлаад явж байгаа. Тэр солигдож болно. Модун 33 говийг Модун хаан 2200 жилийн тэртээ Хятадад алдаагүй. Тухайн үед. Тэгэхэд өнөөдөр бид нар 2000 жилийн дараа та нар хулгай хийж идэж байна.

Дөрөв. Энэ саяынхыг энэ У.Хүрэлсүх Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн 3 өндөрлөг, Улсын Их Хурлын гишүүн Г.Занданшатар, Л.Оюун-Эрдэнэ танаа Одоо Монголд энэ хүний эрхийн байгууллага ерөөсөө алдагдчихсан байна. Жишээлбэл энэ хүний эрхийг энэ хуульдаа хамгийн сайхнаар .../бичлэг сонсогдоогүй/ явж байснаа 22.2 гэдэг юм байдгийн байна. Энэ хуулийг өөрчил. Бүх юм, хүний гомдол ямар ч юман дээр энэ байгууллагад бүгд ерөөсөө хүнийг харлуулдаг. Монголд ер нь амьд явахын баталгаа байгаа юм уу? Одоо төрийнхөө гадаа хэдэн арваараа залуучууд нүцгэлээд ингэж байхад шууд тийш нь аваачаад л цагдаж, хорьж байдаг. Эмнэлэгт аваачиж үзүүлээч. Энэ нийгмээ та нар талцуулж байна шүү дээ. Төрийн гурван өндөрлөгт, сайдад асуулт байдлаар.

Би ер нь дор дор нь Улсын Их Хурлын даргаа, саяын энэ хүний эрхийн асуудал дээр та нар энэ Монгол хүнээ амьд, өнөөдөр Монгол дэлхийд хамгийн цөөхөн. Одоо бараг мөхөж буй гэж олон улсад яригддаг шүү дээ. Ийм цөөхөн ард түмнийхээ. Ямар сайхан боломжийг хулгайлсан? Энэ 44 их наяд гэдэг үнэхээр Монголын хувь заяаг ер нь сүүлийн 30 жил хулгай хийснийг нь хулгайч Монголын хувь заяаг үнэхээр дэндүү байна. Та нар энэ гэр хороолол, хөдөө малчид ёстой үнэндээ нээрээ сандарч тэвдсэн байдалтай байна. Дэндүү миний Монголын ард түмнийг доош нь та нар хэдэн жил тархийг нь угаасан. Энэ нам гэдэг юм энэ хэнд хэрэгтэй юм? Та нар одоо боль. Тэгээд хулгайчдаа нэрсийг нь зарла, тэр ялыг нь оногдуул, хөрөнгийг нь хураа. Бүх ард түмэн ийм л юм хүсэж байгаа. Энэний төлөө явъя. Алгаа таш. Үнэн бол үнэн. Дараагийн хүндээ боломж өгье.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Сая эхэллээ дээ. 3. Дашдаваа дарга тэр нэр гээд байгаа юм та нар хэлэх юм байгаа юм уу? Акулууд гээд байх юм. Тийм юм хэлэх боломж байгаа юу? Акулуудыг зарла, ахул нь хаа байна гээд байх юм даа. Одоо тэгээд тийм боломж байдаг юм уу? 3. Дашдаваа дарга та нэг юу гэх юм, тийм боломж байдаг юм уу, байхгүй юм уу? Акулууд нь хаана байна л гээд байна. 2 дугаар индрийн микрофон. Заалны 2 номерын индрийн микрофон нээе.

Авлигатай тэмцэх газрын дарга 3. Дашдаваа: Иргэний асуултад хариулъя. Мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байна. Одоогоор 50 орчим хүн яллагдагчаар татагдсан, 20 орчим хүнийг цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авчихсан, мөрдөн шалгах ажиллагаа нэлээн өргөн цар хүрээтэй явж байгаа гэдгийг та бүхэндээ хэлье. Авлигатай тэмцэх байгууллагын даргын хувьд шалгалтын ажиллагаа дөнгөж эхлээд удаагүй байгаа учраас тодорхой мэдээлэл өгөх боломжгүй байна.

Гэхдээ энэ ганц зүйл хэлэхэд бид Авлигатай тэмцэх байгууллагын хамт олон бол энэ нүүрсний гэх хэрэг дээр ямар нэгэн этгээдэд ял завшуулахгүй. Бид бол бүх хүч чадлаараа ажиллаж байна. Ийм учраас тодорхой үр дүн гарна гэдэгт итгэлтэй байна. Ийм л юм хэлье дээ.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Одоо 1 иргэн асууж, үг хэлнэ. П.Мөнхтуул “Тавантолгой” ХК-ийн дэд захирал. Өмнөговийн л хүн л шиг байна даа.

“Тавантолгой” ХК-ийн Үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал П.Мөнхтуул: “Тавантолгой” компанийг төлөөлж энэ уулзалтад орж байна. УИХ-ын гишүүн, Сангийн сайдаас 1 асуулт байгаа. Түрүүн УИХ-ын гишүүн, Сангийн сайдын тавьсан илтгэл дээр нүүрсний хулгайн багц гэсэн 5 багц гаргаж ирсэн. Үүн дээр “Тавантолгой” хувьцаат компанитай холбоотой 340.000 тонн гэдэг нүүрсний тоо явж байгаа. Өнөөдрийг хүртэл яг энэ Тавантолгой нүүрсний уурхай гэдэг сэдвийн ард орон нутгийн Тавантолгой буюу жижиг Тавантолгой нэр үргэлж хавчуулагдаад, чирэгдээд явж байгаа. Тэгээд УИХ-ын гишүүн, Сангийн сайдын тайлбараас сонсоход үүссэн хэрэг, шалгагдсан хэрэг байхгүй гэж хэлсэн мөртөө нүүрсний хулгайтай холбоотой гээд энэ олон түмэнд яагаад энэ мэдээллийг тавьсан юм бэ? Энэ 340 гэдэг тоог уг нь төрийн байгууллага нь шалгаад, тогтоогоод ямар нэгэн гэмт хэргийн шинжгүй юм гэдгийг 21 оны 11 сарын 15-ний Нийслэлийн прокурорын тогтоолоор 255 гэсэн тогтоолоор уг нь танилцуулагдчихсан юм.

Энэ 340 гэдэг нүүрсний асуудал дээр 2018 оноос манай уурхай дээр тухайн үеийн УИХ-ын гишүүн, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар сайдаар ахлуулсан 10 агентлагийн шалгалт орсон байдаг юм. Энэ дээр нь одоо яг энд дурдагдаад байгаа Авлигатай тэмцэх газар, Эрүүгийн цагдаагийн газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар гээд 10 агентлаг, Мэргэжлийн хяналт, Ашигт малтмалын газар, Уул уурхай яам гээд шалгаж болох, буруутгаж болох бүх агентлагууд нь шалгалтаар 2 жилийн хугацаанд явсан байдаг юм. Ингээд шалгаад яг энэ 340 гэдэг тоог л шалгаад байгаа юм. Тэр тогоо ч сая бас энэ илтгэл дээрээ тавина лээ. Тэгэхээр энэ тоог үнэхээрийн хангалттай шалгасан. Тэгэхэд манайх яг энэ Тавантолгойн орд гээд бүлэг орд дээр 68000 Га талбайн дөнгөж өчүүхэн 0.4 га-д жилдээ 2 сая тонн нүүрсийг олборлоод, гадаадад экспортолж байгаа. Яг энэ Тавантолгойн бүлэг орд дээрх нүүрсний олборлолт, борлуулалт 3 хэсэг дээр үйл ажиллагаа нь явагддаг. Нэгдүгээрт нь олборлох борлуулалт. Энэ бол уурхайтай холбоотой. Хоёрдугаарт нь 258 километр буюу авто тээврийн ийм хэсэг байгаа. Энэ дээр бүхэл бүтэн институт ажилладаг. Авто тээврийн газар, бусад хяналт шалгалтын байгууллага.

Дараа нь хилийн 2 хил дээрх тээвэрлэлт буюу хилийн бүс энэ дээр 8 агентлаг, институт нь бас ажилладаг. Тэр тусмаа хүчний талдаа хамгийн диктатуртай, цэргийн зохион байгуулалттай ийм хяналт шалгалтын байгууллага нь ажилладаг. Манайх бол үнэхээр цөөхөн, жижиг уурхай. Өнөөдөр 200 гаруйхан ажилчинтай, 90 хувь нь орон нутгийн ажилчид ажилладаг. Бид үнэхээр авто тээврийн тэр 250 километр, дээрээс нь хилийн тэр зааг дээр ажиллах бидэнд тийм ажиллах хүчин, боловсон хүчин байхгүй. Бид нар зөвхөн уурхай дотроо нүүрсээ олборлоод түүнийгээ худалдаанд гаргаад, экспортод гаргах ажлыг л хариуцдаг.

Тэгээд бас мөн слайд дээр харагдаж байдаг “Тавантолгой” ХК-ийн нүүрс гээд учиргүй том тоо явж байна лээ. Сая тонн нүүрс, 500 мянган тонн нүүрс зөрсөн гээд. Бид нар 2 саяхан тонныг арай чамай гаргаж байна. Өнөөдрийн байдлаар. Бид нар тэр 5 сая, 1 сая тонныг хилээр гаргах тэр хүртэлх хариуцлагыг үнэхээрийн хүлээж чадахгүй. Бид нар 2 сая тооныхоо мэдээ, тайланг улсдаа тайлагнаад, төлөвлөгөөгөө батлуулаад өнөөдрийг хүртэл манай энэ яг одоо төр барьж байгаа та бүхэн шилдэг аж ахуйн нэгж, топ аж ахуйн нэгжийн 5-т шалгаруулаад жил болгон бид нарт цом гардуулдаг. Үүнийгээ бид өнөөдрийг хүртэл ажилласан ажлынхаа үр дүн гэж хардаг. Тэгээд энд прокурорын тогтоолыг би бүх хүнд бараг өдөр болгон шалгуулж байна. Одоо болтол Уул уурхайн яам гээд шалгалт оччихсон л байна. Сумын төв дээр 10 гаруй, 20-иод бүрэлдэхүүнтэй цагдаагийн байгууллага оччихсон шалгаж байна. Өдөр болгон би бараг унтахдаа өөртэйгөө яриад, өглөө босоод цагдаа юм уу, ирсэн шалгалт болгонд энэ тухайгаа мэдэгддэг, ярьдаг, одоо цээжилчихсэн. Бараг миний хажууд байгаа хүн болгон энэ сэдвээр маш сайн ойлголттой болчихсон.

Тэгээд хамгийн чухал нь, хамгийн чухал нь 350 гэдэг тоон дээр саяын 11 агентлагийн

4 удаагийн шинжээчийн баг орсон шүү дээ. 40, 50 инженер шалгасан шүү дээ. Энэ бүх хүмүүс энэ тоог нь гаргаад, тоо болгон нь өөр. Жилээс жилд өсдөг. Энэ өсөлт болгоны ард нүүрс явж байгаа. Нүүрс, болгоны ард доллар, мөнгө, төгрөг бүгд явж байгаа. Энэ бүх хохирлыг “Тавантолгой” ХК, орон нутагт үүрээд явж байна шүү дээ. Өнөөдөр 340 гэдэг тоон дээр бид маргаагүй. Төлж байгаа. 2 компани хамтын ажиллагааны гэрээ хийгээд, түүнийхээ үндсэн дээр өнөөдөр 70.000-ийг нь төлчихсөн явж байгаа. Дахиад тэр исэлдсэн нүүрс нь эрчим хүч, чанар нь сайжраад ороод ирсэн. Маш их тоо. Мэдээж энийг шахаж байгаад төлүүлнэ. Энэ болгон орон нутгийн төсөвт орох төсвөөс хасагдаж байгаа шүү гэдгийг энэ мэдлэгтэй хүмүүс бас ойлгоод сууж байгаа гэдгийг цагтаа багтаагаад ... /бичлэг сонсогдоогүй.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Б.Жавхлан сайд харуулах уу?

УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан: Энэ нүүрстэй холбоотой асуудлыг ингэж гаргаж тавиад манай Засгийн газрын хувьд ер нь нэг эцэслэх гээд ингээд явж байгаа. Тэр ч үүднээс энэ жижиг Тавантолгойн энэ нүүрс, тэр хувьцааны эдийн засгийн үнэ цэнийг хамгаалж, олон нийтийн өмнөөс төрийг төлөөлж, тэнд бүрэн эрхт төлөөлөгч томилогдож байгаа асуудал шүү. Өөрийн биш талбайгаас ороод 340.000 тонн нүүрс аваад экспортолсныг таныг л одоо сайн үйлс, буяны ажил хийчихсэн юм шиг ийм өнцгөөр ойлгуулах юм. Сая энд алга ташиж байгаа хүмүүсийг би ойлгосонгүй. Юунд алга ташиж байгаа юм? Энэ 1072 хувьцаа эзэмшигчдийн олон нийтийн энэ компаниас, тэр эзэмшлийн талбайгаас нь нүүрс аваад явчихсаныг баяр хүргэж байгаа юм уу? Миний хэлсэн асуудал бүгд үнэн. Таны хэлсэн зүйлүүд чинь үнэн. Тэгэхдээ та 1 зүйл дутуу хэлж байна. Би танд хэлээд өгье. Юу вэ гэвэл хуулийн байгууллага одоо ч гэсэн шалгаж байгаа. Тэр мэдээллийн үндсэн дээр тэр 5 бүлэг асуудлын 1 нь болгож оруулсан байгаа юм. Тэр 340.000 тонн нүүрс байхгүй болчихсоныг 2 компани хоорондоо ойлголцсон гэсэн тийм акт үйлдээд, би танайхаас ороод нүүрс авчихсан юм. Нөгөөдөх нь танайх манайхаас зөвшөөрөлгүй нүүрс аваад явчихсан байна. 340.000 тонн шүү дээ. 34 килограмм биш. Тэгээд хоорондоо энийг хүлээн зөвшөөрөөд, акт үйлдээд, ингээд төлөөд явж байгаа юм байна лээ. Тэгээд 70.000-ийг нь тушаачихсан. Одоо 260.000 нь өглөг, авлага аль алиных нь баланс дээр нь ингээд байж байгаа юм. Энийг одоо хуулийн байгууллага, одоо мэдэхгүй сэргээж байгаа юм уу? Эсвэл шалгаж байсан, үргэлжлүүлж шалгаж байгаа юм уу? Одоо илүү хуулийн байгууллага илүү мэдээлэл өгөх байх. Тийм учраас яг тэр шалгаж байгаа бүлэг 5 асуудлын 1 нь болж орсон байгаа шүү. Энд өөр илүү, дутуу юм байхгүй.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: 2 дугаар микрофон дээр прокурорын тайлбарыг сонсоодохъё. 2 дугаар микрофоныг нээх үү.

... : “Тавантолгой” ХК-ийн төлөөлөл болсон Мөнхтуулын саяын ярьсан “Тавантолгой” ХК-ийн мөргөцөгтэй холбоотой хэрэг өмнө нь прокуророос хаахаар шийдсэн байсан. Сая энэ ажлын хэсгийн хүрээнд бол дээрх хэргийг сэргээж шалгаж байгаа. Үндсэндээ энэ нүүрс тойрсон холбоотой хэргүүдийг уялдаа холбоотой нь хамтарсан ажлын хэсэг шалгаж байгаа. Мэдээлэл жоохон дутуу авагдсан юм шиг байна.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Одоо дэгээрээ явна. Одоо 1 Их Хурлын гишүүн үг хэлнэ. Улсын Их Хурлын Ганибал гишүүн асуултаа асууж, үгээ хэлнэ. Дэгээрээ явж байгаа шүү дээ. 4 иргэн, тэгээд дараа нь 1 Улсын Их Хурлын гишүүн гээд явж байгаа шүү дээ. Дэгээрээ л явъя.

УИХ-ын гишүүн Н.Ганибал: Өнөөдрийн нээлттэй сонсголд оролцож байгаа Та бүхэндээ баяр хүргэе. Ер нь ард түмний мэдэх эрхийн төлөө сөрөг хүчнээс өнөөдрийн нээлттэй сонсголыг хийхийг шаардсан. Асуулт асуухаасаа өмнө Сүхбаатар аймгийн

Эрдэнэцагаан сумаас хэдэн буурлууд, буурай нар 1 асуултыг заавал асуугаарай гэсэн юм. Яагаад Сүхбаатарын талбай дээр барьсан 4 гэрийг буулгачихсан бэ? Монголын ард түмэн, Монгол иргэн үнэ цэнгүй болчихсон уу? Талбай дээр байгаа тэр ёлк-ны модноос чинь үнэ цэнгүй болчихсон юм уу даа гэдэг энэ асуултыг заавал асуугаарай гэж иргэн, өндөр настан Ичинхорлоо гэдэг хүн хэлүүлсэн юм. Үүнийг би асуучихъя.

Нүүрсний хулгай өөрөө ийм 4 янз байна. Хэрвээ эрх баригч нар хүсэж байгаа бол өнөөдөр ч гэсэн 1 урсгалыг нь зогсоох ийм боломж байгаа. Монголын ард түмэн бүгдээрээ Цагаан хаднаас тэр хил рүү явдаг богинын тээвэр гэдэг асуудлыг ойлгодог болсон. Энэ өнөөдрийн ханш нь гэхэд 1 тонн нүүрсийг 70 ам.доллаароор зөөж байна. Өнөөдөр “Эрдэнэс Тавантолгой” ХК гээд Монголын ард түмний өмч гээд байгаа төрийн хэдэн дарга нар удирдаж байгаа. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс чинь аман дээрээсээ 100 ам.доллаароор зарагдаж байгаа. Тэгэхэд тэнд зөвхөн тээвэр нь 70 ам.доллар байна. Тэр тээврийг хэн хийгээд байгаа юм бэ гэхээр энэ эрх баригч нарын гар, хөл болсон тээврийн компаниуд хийгээд байна гэдгийг ард түмэн зарлаад байгаа юм. Өчигдөр Улаанбал нэвтрүүлгээр бас тодорхой хүмүүсийн нэрийг хүртэл хэлж байна лээ. Энэ асуудлаа өнөөдөр зогсоох боломжтой.

Яагаад Монголын ард түмэн өөрсдийнхөө баялгийг хэзээ хилээр гарах нь тодорхойгүй, хилээр гарах үгүй нь мэдэгдэхгүй ийм байдлаар нүүрсээ зарж, бусдын эрхэнд аваачиж өгөөд байгаа юм бэ?. Энэ асуултыг би Зам, тээврийн сайдаас асуумаар байна. Ер нь тэгээд бид бүтээгдэхүүнээ үнэ цэнгүй болгож байгаа асуудал дээр энэ хамгийн чухал байгаа юм. Өнөөдөр “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн олборлолтын зардал гээд 30 ам.доллар, 40 ам.доллар гардаг байх, олж байгаа ашиг нь гээд 70 ам.доллар байдаг байх. Яг тэрэнтэй адилхан хэмжээний хийдлийг тэр богинын тээвэр дээр хийгээд байгаа юм. Ер нь уртын тээвэр гээд 200 гаруй километр замаар тээвэрлэлт хийж, дөнгөж 17 ам.доллаароор тээврийн хөлсийг тооцоож, өнөөдөр хүртэл бүх компаниуд хийж байгаа. Энэ тээврийн компаниуд. Энэ дээр би тодорхой хариулт авмаар байна.

Хоёрт нь оффтэйк гэрээнүүдийг ил болгож байна. Энэ бол сайн. Иргэдийн мэдэх эрхийг хангалаа. Дээрээс нь өнөөдөр хэлэлцүүлгүүд явж байна. Энэ зөв үү, буруу юу, энд одоо но-нууд нь байна уу, үгүй юу?. Оролцогч талууд энэ тайлбараа хэлээд эхэлчихсэн. Тэгэхдээ энэ өнөөдрийн мэдээлэл дотор, ялангуяа “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн мэдээлэл дотор энэ Чалкогийн 274 сая ам.долларын гэрээ гэж байна. Глори таун гээд 100 сая ам.доллар, Жасин интернешнл гээд 63 сая ам.доллар, “Шинхуа Энержи” гээд 33 сая ам.доллар, бусад худалдан авагчдын гэрээний дүн гээд 134 сая ам.доллар, нийтдээ 603 сая ам.долларын гэрээ хийгдсэн байна. Энэ гэрээнүүд бас оффтэйк гэрээнүүд мөн үү? Эдгээр гэрээнүүд яагаад нууцаар хийгдчихсэн вэ?

Ер нь 2011 онд нүүрс хамгийн үнэ цэнтэй болоод, дэлхийн зах зээл дээр хамгийн үнэтэй болсон. Яг энэ үед нь Монголын ард түмний өмчийг хамгийн хямдхан үнэтэйгээр ийм оффтэйк гэрээнүүд хийсэн асуудалд хэн хариуцлага үүрэх юм бэ? Энийг асууж байна.

Дараа нь энэ бас тодорхой. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам, Тавантолгойн нүүрс ачих ложистикийн төв, нүүрс баяжуулах үйлдвэр, Тавантолгойн дулааны цахилгаан станц, газрын тос дамжуулах хоолой энэ гэрээнүүд оффтэйк гэрээнүүд мөн үү? Энэ нууцаасаа гарсан юм уу? Яагаад энэ гэрээнүүд харилцан адилгүй байгаад байгаа юм бэ? Зарим нь нууцаас гардаг, зарим нь нууцаас гардаггүй. Тэгээд энэ мэдээлэл дотроо зүгээр л томоохон төсөл, хөтөлбөрүүд гэсэн байдлаар оруулчихсан. Энэ талаар би тодорхой нийт ард түмний өмнө бас асуумаар байна.

Ер нь тэгээд эрх баригч нар минь та нар одоо танай нам тийм шударга, асуудлыг

гаргаад тавьчих тийм боловсон хүчин байхгүй болчихсон юм уу? Тэр Тавантолгой дээр “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр, орон нутгийн Тавантолгой дээр бүрэн эрхт төлөөлөгч томиллоо гэх юм. Төрийн албаны хуулийг зөрчин зөрчин Төсвийн шууд зарцуулагч нарыг томилоод байгаа нь ямар ашиг.../минут дуусав./

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Цагдаагийн байгууллагаас дарга, төлөөлөгч байна уу? Тэр талбай дээрх гэрүүдийг яагаад буулгачихсан бэ? Түрүү ч хариулчих шиг л болсон. Яах вэ, дахиад хариулъя. Дараа нь тэр Ж.Ганбат дарга асуултад бэлдэх үү? Хэн хариулах уу? Жавхлан сайд хариулах юм уу? Ж.Ганбат дарга хариулах юм уу? Тэр богинын тээврийн өртөг өндөртэй холбоотой, Чалко болон бусад 4 компанитай гэрээ байгуулсан асуудал, бүрэн эрхт төлөөлөгч томилсон асуудлуудын талаар асууж байна. Хэдэн номер? Заалны 2 номер.

... : Гэр буулгасан асуудалтай холбоотой асуудлаар хариулт хэлье. Гэр яагаад буруулсан гэхээр гэр буулгах, мөн барих тухай асуудлыг цагдаагийн байгууллага нь хариуцдаггүй. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зөвшөөрлөөр гэрүүдийг барьсан. Барьж байх хугацаанд жагсаагчдын төлөөлөлтэй Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, мөн цагдаагийн байгууллагын зохих албан тушаалтнуудтай уулзаад энэ гадаа хүйтэнд олон хоногоор байхад ер нь эрүүл мэндэд туйлын таагүй байна, хүний амь нас эрсдэх аюул үүснэ, мөн хүний эрхийн байгууллагаас ийм шаардлага тавьсантай холбогдуулаад, зөвшилцөлд хүрээд Соёлын төв өргөөнд тодорхой өрөөнүүдийг гаргаж өгсөн байгаа. Сая миний авсан мэдээллээр одоогийн байдлаар Соёлын төв өргөөнд 27 иргэн, жагсаагчдын төлөөлөл байгаа, гадаа 150 гаруй хүн байгаа байдалтай байна.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: “Эрдэнэс Тавантолгой” ХК дахь Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат дарга хариулах уу? Тэр тээвэртэй холбоотой богинын тээвэр, мөн тэр Чалко болон нэмж гурван ч компанийн нэр хэллээ шүү дээ. 4 гэрээ нууц байна уу, үгүй юу гээд эдгээртэй холбоотой юм хариулах уу.

“Эрдэнэс Тавантолгой” ХК дахь Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат: Тэр нууцын зэрэглэлтэй байсан 7 гэрээг ил болгосон. Эдгээрээс өөр нууц гэрээ байхгүй. Энэ урьдчилгаа төлбөрийг нь урьдчилж аваад дараа нь нүүрсээр төлөх, нүүрсээр өгөх нөхцөлтэй ийм гэрээнүүд байгаа. Эдгээр гэрээнүүд бол нууцын зэрэглэлтэй биш. Ингээд энэ хугацаа нь бол Чалкотой байгуулсан гэрээ нь 2011 оны 07 дугаар сарын 26-ны өдөр эхэлж хийгдээд, өнөөдрийг хүртэл үргэлжилж байгаа ийм гэрээ байгаа юм. Нөгөө Глори таун гэдэг нь бол 2021 оны 6 дугаар сарын 9-ны өдөр байгуулагдсан гэрээ. дараагийнх нь тэр ... гэдэг нь 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдөр. ... гэдэг нь 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдөр гэрээ байгуулсан байна. Энэ бусад худалдан авагч нарын гэрээ гээд тэнд байгаа. Энэ дээр бол нийтдээ 603 сая ам.долларыг урьдчилж авсан. Урьдчилсан төлбөрийг нь аваад, тэгээд төлбөрт олгох нүүрсийг нь ачуулаад явж байгаа. Эдгээр гэрээнүүд нь нууц биш.

2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр гэрээнүүдийн талаарх мэдээллийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн вебсайтад 178 гэрээг байргуулж, ил болгосон. Гэхдээ нөгөө энэ гэрээний нөгөө тал болох харилцагч, энэ худалдан авах тал энэ дээр асуудлаа бол тавьсан. Гэрээ дээр нэг заалт бол байна. Энэ гэрээг ил болгохдоо нөгөө талаасаа заавал зөвшөөрөл ав гэдэг заалт байна. Ялангуяа энэ томоохон худалдан авагч нь төрийн өмчит ААН, энэ Хятадын худалдан авагч нар бол энэ манай талын саналгүйгээр ил болгохгүй ийм асуудал бол тавьж байгаа. Энэ дээр бол бид нар нөгөө талдаа бол энийг манайхаас бол ил болгоё гэдэг хүсэлтийг нь бол ингээд тавьчихсан. Одоо бол яг энэ тал дээрээ бол ажиллаж байгаа.

Нөгөө талдаа энэ дахиад нэг 6 томоохон төслийн гэрээнүүд бол нууц биш, нууцын зэрэглэлтэй гэрээ биш. Төслийг санхүүжүүлэх гэдэг ийм гэрээ хийгдчихсэн. Үүнд

Тавантолгой-Зүүн баян чиглэлийн төмөр зам, Тавантолгой-Гашуун сухайт, Тавантолгой-Зүүн баян төмөр замуудыг холбох төмөр зам, тэгээд Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв, нүүрс баяжуулах үйлдвэр, Тавантолгойн дулааны станц, газрын тос дамжуулах хоолой зэрэг төслийн гэрээнүүд бол нууцын зэрэглэлтэйгээр биш, ил байгуулагдаад, санхүүжилт нь мөнгөөр болон нүүрсээр хийх нөхцөлтэйгөөр хийгдээд явж байгаа. Эдгээртэй холбоотой мэдээллийг мөн 2022 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр компанийн вебсайт дээр нь байрлуулчихсан. Үүнээс бол Тавантолгой-Зүүн баян чиглэлийн төмөр замын ажил нь энэ дээр захиалагч нь бол Монголын төмөр зам, гүйцэтгэгч нь Улаанбаатар төмөр зам, Зэвсэг хүчний Жанжин штаб гэдэг ийм байгууллагууд байгаа юм. Ингээд нийтдээ саяын асуусан нийт 178 гэрээнээс коксжих нүүрсний гэрээ 31, исэлдэн нүүрсний гэрээ нь 109, төслийн санхүүжилтийг нүүрсээр барагдуулах 38 гэрээнүүд байна. Эдгээр 178 гэрээг компанийн вебсайт дээр 2022 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр байршуулж, үндсэн мэдээллүүдийг ил болгочихсон. Гэрээг бүтэн эхээр нь байршуулаагүй, нөгөө гэрээний нөгөө талаасаа зөвшөөрөл авах ажил хийгдээд явж байгаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Шадар сайд хариулах уу? Та тэр “Эрдэнэс Тавантолгой” ХК болоод орон нутгийн Тавантолгой компани дээр бүрэн эрхт төлөөлөгч томилсонтой холбоотой асуудал. Яагаад бүрэн эрхт төлөөлөгч томилсон юм бэ? Ялангуяа жижиг Тавантолгойг л хэлээд байгаа юм даа. Та нэг хариулах уу?

УИХ-ын гишүүн, Шадар сайд С.Амарсайхан: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Монгол улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 450 дугаар тогтоолоор орон нутгийн буюу “Тавантолгой” ХК дээр бүрэн эрхт төлөөлөгчийг 6 сарын хугацаатайгаар томилох шийдвэр гарсныг та бүхэн мэдэж байгаа. Энэ бол ерөөсөө энэ олон жил яригдсан, ялангуяа 2011 оноос хойш өнөөдрийг хүртэл буюу 11 жилийн хугацаанд яригдаж байгаа тэр мөргөцөгтэй холбоотой асуудал гэж яриад байгаа. Сүүлд тэр 2 ААН хоорондоо бие биеийнхээ талбай руу орж олборлолт хийсэн, хийлгэсэн гэдэг энэ асуудлуудыг эцэслэж нэг мөр ялгаж салгах ийм ажлыг хийх, нөгөө талаараа “Эрдэнэс Тавантолгой” ХК нь “Тавантолгой” ХК-тай хамтарч зарим мэдээллүүдээ тулгах, дээрээс нь Засгийн газрын энэ тогтоол шийдвэрийн хүрээнд хэд хэдэн үүрэг даалгавар өгчихсөн байгаа юм.

Нэгдүгээрт, ерөөсөө цаг аваад байх асуудал байхгүй. Та нарын асуусан асуултад хариулж байна, тийм. Тэгээд энэ дээр тэр мэдэж байгаа. Энэ, тэгээд та бүхэн зөв буруугаа ялгах гэж орж ирсэн хүмүүс шүү дээ.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Тэр бүрэн эрхт төлөөлөгчтэй холбоотой юмыг яагаад томилсон юм бэ гэж асуусан учраас хариулж байна шүү дээ. Өөрсдөө асуучхаад асуултдаа хариулт ав л даа. Та сонирхохгүй байсан ч тэр асуусан хүн нь хариугаа сонирхож байгаа шүү дээ.

УИХ-ын гишүүн, Шадар сайд С.Амарсайхан: Хулгай хийчихсэн юм бол хулгайг нь хийчихсэн гэдгийг нь тогтооё гэж байгаа юм, хариуцлагыг нь хүлээлгэе гэж байгаа юм, хийгээгүй юм бол хийгээгүй юм байна гэдгийг нь ялгая гэж байгаа юм. Олон жилийн хугацаанд ингэж одоо бие биеийгээ буруу, хийгээгүй хэрэгт нь хардаад байгаа юм уу, эсхүл хийчихсэн хэргийг нь нуугаад байгаа юм уу гэдгийг нэг мөр цэгцэлье гэдэг ийм асуудлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Тавантолгой” хувьцаат компани хоёрын аль алин дээр нь бүрэн эрхт төлөөлөгч томилсон юм. Нөгөө талаар аль, аль хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс орж байгаа юм. Орон нутгийн буюу төрийн мэдлийн 51 хувь, 49 хувийн хувьцаа эзэмшигч буюу тэр гадна, дотнын хувьцаа эзэмшигчид хүртэл ингээд худлаа юм бол энэ худлаа гэдэг мэдээллийг нь тодорхой болгож өгье. Үнэн юм бол үнэн гээд тэрийг нь тогтоож хариуцлагыг нь хүлээлгэе гэж байгаа юм. Ийм л асуудал, тийм.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Одоо О.Отгонбаатар талбайгаас ирсэн нэр байна, жагсагчдын төлөөлөл гэж байна. О.Отгонбаатар. О.Отгонбаатар байна уу?.

Сонсголд оролцогч, жагсагчдын төлөөлөл О.Отгонбаатар: Мөн байна. Энэ хулгайч нартай тэмцэж байгаа 2 дахь сонсголд орж байна. Энэ төр гэдэг чинь одоо Улсын Их Хурал. Улсын Их Хурлын та нар, ажлын хэсгийнхэн та нар одоо жоохон бядтай бай, төр шиг бай. Улсын Их Хурлын бүхэл бүтэн дэд дарга нь байна, том заалаа онгойлго, ингээд шийдье, ингэе, ингэе гээд л ярьчих юман дээр бүлэглэл зохион байгуулалттай орж ирсэн хэдэн нөхдүүдийн өмнө гөлөлзөөд дуугарч чадахгүй л суугаад байх юм. Ингэвэл бид нар асуудлаа яаж шийдэх юм бэ? Та нар жоохон зарчимч бай л даа, тохиролцоод ороод ирчихсэн хэдэн хүн дайрахаар нь гөлөлзөөд зогсоод байх юм. Энэ янзаараа бол энэ хулгайг чинь шийдэхгүй шүү дээ.

Одоо би 2 дахь юмаа хэлье. Засаг нь иргэддээ шахуулаад, Засаг иргэд 2 нийлээд шүүх, прокурор руу энэ хулгайчуудыг чинь үргээлээ. Үргээлгэ хийлээ. Одоо шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газраа жагсаал цуглаан, тайван замын тэмцэл та нар руу чиглэнэ шүү. Та нар руу чиглэнэ шүү. Хөгжлийн банкны эхний шүүх хурал хаачихсан юм бэ? 4 сарын өмнө сонсгол хийгээд би энд бас орилоод зогсож байсан. Авлигатай тэмцэх газрын дарга аа, гишүүндээ итгэх үү, төлөөлж явуулсан гишүүндээ итгэх үү, танд итгэх үү? Энэ Женко оргоод алга болчихсон гээд гишүүн маань дэвхцээд байдаг. Та үгүй ээ гээд байдаг. Нэг цонхоор мэдээлэл өгөөч. Гадаа байгаа жагсагчид чинь нэг цонхоор мэдээлэл авахгүй болохоор ойлголт байхгүй болчихоод байна.

Хоёрт нь Авлигатай тэмцэх газрын даргаа та нэг хариулж өгөөрэй. Хэзээ тэр хэрэг гэж үзээд хэрэг нь үүсэх юм бэ? Хэрэг нь үүсвэл энэ хулгайчуудаа хилийн хоригийг нь тавих юм уу? Танай, манай нам гээд байх юм байхгүй, холбогдсон бүх хүнийг айлгаж гэж байгаа шүү дээ. Ийм асуулт байна шүү.

Хоёрт нь би ингэе. Доржханд гишүүнээ, зовсон ард түмэн, ядарсан ард түмнээ битгий туйлдуул. Зуд болоход нохой зоолно гэгчээр Та тэр 40 их наяд төгрөгийн тооцоогоо тайлбарла. Тэрийг чинь 3.2 сая иргэндээ хуваачихад нэг иргэн 125 сая төгрөг авна гэсэн Монголоор нэг хүн байна. Энийгээ та тайлбарла, алдагдсан боломж нь хэд юм бэ? Жинхэнээсээ ухаад хулгай хийгээд аваад явчихсан нь хэд юм бэ, баримт байна уу, санхүүгийн баримт нь байна уу? Хэдэн сарын хэдэнд гаргачихсан юм бэ? Алдагдсан боломжоос нь хэдийг нь бид нар алдчихаад байгаа юм бэ? Иргэд чинь ингээд нэг цонхоор мэдээлэл байхгүй туйлдаад байна.

Хоёрт нь тэр Улсын Их Хурлын 7 гишүүний нэрс нь зарлагдсан байна лээ. Зарим нэг нь баавгай сэрж байна гээд шалгуулья, барья нэрээ цэвэрлэнэ гэж байна лээ. Одоо энэ гадаа сонсгол болж байхад гадаа хэвлэлийн хурал хийгээд байгаа гишүүд ичээч, Адьяасүрэн та ичээч, би хэдэн мянган жолоочтой хулгай хийгээгүй гээд. Та шалгуулах уу? Би танаас асууж байна. Бат-Эрдэнэ та шалгуулах уу? Би танаас асууж байна. Баахан Өмнөговийн нөхдүүд авчирчхаад л ийшээ дайраад байх юм.

Залуучууддаа ганц юм хэлчихье. Хүний нэр ярьж энд үг хэлж болдоггүй юм шүү. Би хүн гүтгэсэнгүй. Хүн гүтгэж болдоггүй, 2022 оны 4 дүгээр сард зохион байгуулсан Хөгжлийн банкны ерөнхий хяналтын сонсгол дээр Алтанхуяг гэдэг хүнийг Та бондын зөвлөл байгуулж байгаад Монголыг тонох хонгилыг угсарсан гээд хэлчихсэн чинь энэ зуслангаа шүүхээр явсан. Алтанхуяг гуай би танаас өмнөх сонсгол дээр таны нэр хүндийг гутаасан бол энэ сонсгол дээр уучлалт гуйя. Та харин шалгуулаад ялтай бол ялаа аваарай,

ялгүй бол цагаадаарай. Залуучууд тэгэхээр хамаагүй хүнийг бас тонуулч гэж хэлж болдоггүй юм. Наадуул чинь жагсаал мөнх биш учраас маргааш, нөгөөдөр та нарыг агнаад эхэлнэ. Алтанхуяг бол ингэдэг л хүн байна лээ. Үгүй ээ, ер нь ийм л байна шүү дээ, энэ залуучууд байнга жагсахгүй шүү дээ.

Дараад нь ингээд энэ уянгалахаа боль Их Хурлын гишүүд ээ. Одоо Засаг нь ажлаа шахаад эхэллээ. Та нар уянгалахаа бүлэг, бүлэг дээрээ ганц муу эмэгтэй рүүгээ дайраад байна. Эмэгтэй хүн хулгай хийсэн байж болдоггүй юм уу? Одоо наад уянга чинь хэтэрлээ. Шалгуулаад, шалгуулаад явчих. Та нарыг хулгайч гээгүй шүү дээ. Нэр нь холбогдсон бол шалгуулчих. Шалгуулаад янз бүрийн асуудал байхгүй бол би асуудалгүй гээд ороод ирэхэд чинь хүлээгээд л авъя, тэврээд л авна. Иймэрхүү юмнууд байна.

Авлигатай тэмцэх газрын дарга, шүүх, прокурор, прокурорын даргаас асууя. Энэ эрэн сурвалжлагдаж байгаа улсууд чинь хэзээ ирэх юм бэ? Одоо хамгийн түрүүчийнх нь Сайханбилэг чинь хэзээ ирэх юм бэ? Араас нь хэдэн хүн алга болчхоод байгаа юм бэ? Хоёрт нь 2013 онд тэр нэг 390 мянган тонн нүүрсний хэрэг цайрсан гээд ард түмэн ам дамжин яриад байна. Энэ хэн, хэн холбогдож байгаад прокурор дээр хэрэгсэхгүй болгочихсон юм бэ? Ийм, ийм асуудлуудыг асуумаар байна. Тэгээд энэ одоо яг миний нэр зааж хэлсэн улсууд асуултад нь хариулаад өг, тэр 2013 оны тэр нүүрсний хулгайн хэрэг яагаад прокурор дээр цайчихсан юм бэ? Тэр АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР эрэн сурвалжилж байгаа прокурор, эрэн сурвалжилж байгаа хүмүүс Сайханбилэгээс чинь өгсүүлээд түрүүч нь хэзээ ирэх юм бэ? Иргэддээ нэг цонхоор мэдээлэл өгөх гишүүн нь ч нэг юм яриад л, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР нь ч нэг юм яриад байх юм. Одоо ийм.../минут дуусав/

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Дашдаваа дарга хариулах уу? Үгүй ээ, дэгээрээ явж байна шүү дээ. Нэрээрээ л, дарааллаараа явж байна шүү дээ. Дэгээрээ явж байна, нэрээрээ явж байна. Та хэн гэж хүн юм бэ? Нэрсийн жагсаалт дотор нэр нь байгаа юм уу? Дашдаваа дарга хариулт авъя.

Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа: Иргэний асуултад хариулья. Нүүрсний гэх тодотголтой мөрдөн шалгах хэргийн мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байна. Мөрдөн шалгах ажиллагаа бол нэлээн өргөн цар хүрээтэй, бас олон жилийг хамарсан, 10 жилийн.../үг тасрав/

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Хэн гэж хүн юм бэ, нэр нь байгаа юм уу? Дашдаваа дарга хариулах уу.

Авлигатай тэмцэх газрын З.Дашдаваа: 10 орчим жилээр хамарсан, бас нэлээн өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа явагдаж байгаа. Энэ нэр дурдагдсан нүүрсний хулгайн хэрэгт нэр дутагдсан хүмүүстэй бол хэрэг бүртгэлийн хэрэг нээгээд шалгаж байгаа. Хэрэг бүртгэлийн хэрэг нээгээд шалгах явцад цугласан нотлох баримтын хүрээнд бид хүмүүсийн яллагчаар татах саналаа прокурорт гаргадаг хуулиараа. Прокурор яллагчаар татсан тогтоолыг баталснаар тэр хүнд бид таслан сэргийлэх арга хэмжээгээ авч хэрэгжүүлж эхэлнэ.

Дараагийн асуудал бид Хөгжлийн банкны асуудлыг 8-9 сар орчим шалгасан. Нийт 94 холбогдогчтой 470 орчим хавтаст хэргийг прокурорт шилжүүлчихсэн байна. Энэ ажлын хүрээнд 809 орчим тэрбум төгрөг төлөгдсөн. Тийм учраас 10 жилийн хугацааны хэргийг бид аль болохоор шуурхай шалгаж шийдэхийн төлөө цагдаагийн байгууллага болон прокурорын байгууллагын хамтарсан ажлын хэсэг шуурхай ажиллаж, цаашид ажиллахын төлөө хичээж байна.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Прокурор хариулах уу, түүрүүн тэр 370-ыг сэргээсэн тухай ярьчихсан даа. Хариулах уу дахиад. Байж байгаарай, дараа нь.

Улсын Ерөнхий Прокурорын газрын Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын ажилд хяналт тавих хэлтсийн дарга Д.Баянжаргал:

Ч.Сайханбилэгийг эрэн сурвалжлах асуудал бол Интерполын шугамаар хайх асуудал тавигдсан байгаа. Хариу ирээгүй байгаа. Энэ бол бид нараас шалтгаалах асуудал биш юм. Өмнө нь 2013 онд хаасан хэргүүд байж байгаа. Тухайн үедээ бас прокурор хавтаст хэрэгт авагдсан, нотлох баримтад тулгуурлаад хэргийг хааж шийдсэн байгаа юм. Түүрүүн би мэдээлэлдээ хэлсэн. Нийтдээ энэ хамтарсан ажлын хэсгийн хүрээнд 15 хэрэг материалыг хаасан, хэрэгсэхгүй болгосон, татгалзсан материалыг прокурор хянаад дахин нягталж шаардах шаардлагатай юм байна. Ажлын хэсгийн хэмжээнд хооронд нь уялдаа холбоотой юмнууд бас нэлээн бий. Шалгалтын цар хүрээ нэлээн өргөн байгаа. Цаг хугацаа нэлээн зарцуулна. Одоо бид нар яг тодорхой тэдийг нь шийднэ гэж хэлэх боломж байхгүй байна. Энэ бол мөрдөн шалгах ажиллагааны үр дүнгээр эцсийн үр дүн нь харагдах асуудал юм. Тэрийг та бүхэн ойлгоорой гэж хэлмээр байна.

Хөгжлийн банкны хэргийн тухайд бол сая Авлигатай тэмцэх газрын дарга хэлсэн. 10 сарын 25-нд Нийслэлийн прокурорын газарт шүүхэд шилжүүлэх саналтай хүрч ирсэн байж байгаа. Прокурорын байгууллага хянаж байна энэ хэргүүдийг.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. О.Батхүү ХҮН намын төлөөлөл гэсэн байна. Байна уу? О.Батхүү алга байна. А.Отгонбаатар Үнэн ба зөв намын төлөөлөл. А.Отгонбаатар. Байхгүй байна. М.Чимэддорж Хан-Уул дүүрэг 2 дугаар хороо.

Сонсголд оролцогч, иргэн М.Чимэддорж: Баярлалаа. Хамгийн эхний асуудал сэтгүүлч нарыг нэлээн анхаарал хандуулаарай гэж хүсэж байна. Үйлдвэр аж ахуйн газарт онцгой дэглэм тогтоох, нөгөөдөх нь бүрэн эрхт төлөөлөгч, төлөөлөгч томилох гэдэг Монгол Улсын өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн тогтолцоонд байхгүй ойлголт юм. Үйлдвэр аж ахуйн газарт онцгой дэглэмийг тогтооно гэдэг нь тухайн үйлдвэрийн газарт гарч байгаа аливаа шийдвэрт Монгол Улсын зарим хуулиуд нь үйлчлэхгүй болгож байгаа энэ хууль үйлчилдэггүй орчныг зохиомлоор бий болгож байгаа юм эрх баригчид.

Хоёрдугаарт нь бүрэн эрхт төлөөлөгч томилно гэдэг нь хуулиар хариуцлага хүлээх боломжгүй ийм субъектийг гаргаж ирээд, дуртай юмаа хийлгүүлж байна. Хэд хэдэн үйлдвэрийн газрыг дурдъя. Нэгдүгээрт, Эрдэнэт үйлдвэр. Эрдэнэт үйлдвэрт бүрэн эрхт төлөөлөгч томилсон, онцгой дэглэм тогтоосон. Эрдэнэт үйлдвэрийг одоо бараг цөлмөөд дуусаж байна гэж ойлгож байна. Яагаад вэ гэхээр өнгөрсөн сард Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрээс ирсэн инженерүүд бараг өдрийн хоолны мөнгөгүй, томилолтын мөнгө нь багассан гэж байна шүү дээ. Эрдэнэтийн үйлдвэрийн санхүүгийн байдлыг өнөөдөр шалгах юм бол Тавантолгойгоос дор болчихсон байгаа байх.

Хоёр дахь онцгой дэглэм тогтоогоод бүрэн эрх төлөөлөгч томилсон байгууллага Салхитын мөнгөний орд. Одоо бараг нөөц нь дуусаж байгаа байх. Тэгээд Монголын төмөр зам, “Эрдэнэс Тавантолгой” ХК, хамгийн сүүлд орон нутгийн Тавантолгой дээр бүрэн эрхт төлөөлөгч томиллоо. Энэний ард Монгол Улсад өмчийн хамгаалалт гэдэг ойлголт эрх зүйн хувьд байхгүй болж байна. Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй байгаа компанийн өмч эзэмшигчийн эрхийг шууд төр авчаж байгаа нь ерөнхийдөө Монгол Улсад дахиад цаашаа зах зээлийн эдийн засаг, хөрөнгө оруулалт татах бүх орчныг эрсдэлд оруулж, бүх зах зээлийн эдийн засгийг уналтад оруулах ийм шийдвэр болчихлоо. Энэний араас “Энержи ресурс”-ийг төрд авч болох нөхцөл бүрдээд байна. Загсийн газрын Хэрэг эрхлэх газрын

дарга Д.Амарбаясгалан нэг ноцтой мэдэгдэл хийсэн. Тэр бол Хармагтай ордыг төрд авна гэж байгаа. Австралийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй байгаа компанийг төрд авах хаалгыг нээж байна. Энэ бол хөрөнгө оруулагч нар, ялангуяа гадаадын хөрөнгө оруулагчид маш ноцтой сонсогдож байгаа шүү. Монголд байж байгаа бүх төслүүдийг нийгэмчилж болдог юм байна, төр дээрэмдээд авч болдог юм байна гэдэг сигналыг өгч байгаа юм. Энэ бүхний эцэст Оюутолгойг төрд авч болно гэсэн үг. Тэгэхээр энэ асуудлыг манай энэ Хууль зүйн Байнгын хорооныхон яаж харж байдаг юм бэ?

Өөр нэг ноцтой асуудал бол ер нь манай энэ парламент Монгол Улсын эрх зүйн тогтолцоог хамгаалж чадаж байна уу? Засгийн газар дураараа авирлаад байна, эрх зүйн тогтолцоог чинь устгаад байна. Ялангуяа эрх баригч намын одоогийн Засгийн газрын гар хөл болсон ХҮН намын Т.Доржхандаа өөрт чинь хандаад хэлчихье. Энэ эрх баригчдын гар хөл битгий болооч та нар, ХҮН намынхныг дахиад хэлчихье. Бүх үгэндээ АН-ын нэрийг хавчуулж явж байгаа ХҮН намынханд хэлчихье. Та нар та нарын гараар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийгээд Засгийн газрыг Улсын Их Хурлын дээр гаргаад тавьчихлаа. Одоо Улсын Их Хурал, Засгийн газарт хяналт тавьж чадахаа больчихоод, өнөөдрийн энэ бүх хулгай зэлгий чинь явж байгаа шүү. Цаашдаа ер нь Монгол Улсад парламент орших юм уу, үгүй юм уу гэдэг асуултыг бид нар өнөөдөр асуух ёстой шүү дээ. Өнөөдрийн Засгийн газартай холбоотой энэ дураараа авирлаж байгаа юм чинь ер нь таны гараар хийгдсэн, танай намынхны гараар хийгдсэн Монголын төрийн хутгуур болж байгаа шүү. Энийг бас эргэж бодоорой.

Хоёр дахь асуудал нь уучлаарай, 1 минут нэмээд өгөхийг бодоорой. Өнөөдөр нүүрсний хулгай хийгдсэн байна. Оффтэйк гэрээгээр нууцад хамруулаагүй хэд хэдэн том нүүрсний гэрээ байна. Авлигатай тэмцэх газрын веб сайт дээр тавьснаар бол Норинко Интернейшнл гэдэг компанитай нийтдээ 6 сая тонн нүүрсний бартерын гэрээ байгуулчихсан явж байна. 6 сая тонн нүүрс шүү. Энэ 6 сая тонн нүүрсний ард нь миний ойлгож байгаагаар 2 том бартерын гэрээ байгаа. Тэгээд энэ компанийг шалгаад үзэхээр ард нь Норинко интернейшнл гэдэг компанийн хувьцаа эзэмшигч нь Хятадын Норинко гэдэг компани байна. Хамгийн том хувьцаа эзэмшигч нь 1998 онд Шинжааны хөрөнгийн бирж дээр гарсан компани. Цаад талдаа хамгийн том хувьцаа эзэмшигч компани нь өнгөрсөн сард Иран Улсад зэвсгийн технологи нийлүүлсэн гээд АНУ-ын хоригт орчихсон компани явж байна.

Дахиад яг энэ компанитай нэг хаяг дээр байгаа 2 компани байна. Нэг нь GGCAT гэдэг компани байна. Нэг нь Тахилт хайрхан транс гээд компани байна. Нэг хаяг дээр байгаа компаниуд шүү. Уучлаарай 1 минутаа авчихья тэгэх үү.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Нэг минут гэж байхгүй шүү дээ, таван минут л гэсэн шүү дээ. Ж.Ганбат дарга хариулах уу тэр Чалко, тэр 2 гэрээтэй холбоотой асуудлаар БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ хариулах уу?

“Эрдэнэс Тавантолгой” ХК дахь Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат: Норинко интернейшнл гээд энэ компани бол Хятадын 100 хувь хөрөнгө оруулалттай төрийн өмчийн компани юм байна лээ. Энэ бол төрийн өмчийн компани, ямар нэгэн хувийн өмчлөлийн юм байхгүй. Ийм байдлаар Тавантолгой дээр “Эрдэнэс Тавантолгой” ХК компани дээр олборлолт талд нь явж байна, мөн баяжуулах үйлдвэрийн төсөл дээр нь бас Норинко компани оролцоод явж байгаа. Мөн урьдчилгаа төлбөрийг авч ашигласан гэрээ гэдэг дээр Норинко компани бас байгаа. 2020 оны 6 сарын 9-нд 100 сая ам.долларын урьдчилгаа аваад хэрэглэчихсэн, одоо 12 сарын 20-ны байдлаар бол 86.6 сая ам.долларын үлдэгдэлтэй байгаа. Энэ бол нууцын зэрэглэлтэй биш, ил гэрээ. Норинкотой хийсэн гэрээнүүд бол нууцын зэрэглэлгүй. Зарим дээр нь энэ төлбөрийг нь бэлнээр, зарим дээр нь нүүрсээр гэдэг ийм байдалтайгаар 3 олборлолт дээр явж байгаа. Саяын хэлдэг

мөнгийг нь урьдчилаад авчихсан гэрээ байгаа. Тэгээд Баяжуулах үйлдвэрийн төсөл дээр байгаа юм.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Хариулт хангалттай юу? За. Одоо Ц.Дуламсүрэн, Ц.Дуламсүрэн жагсагчдын төлөөлөл. Ц.Дуламсүрэн гэж байхгүй байна. Д.Гантулга Сүхбаатар дүүрэг 1-р хороо гэсэн байна. Д.Гантулга.

Сонсголд оролцогч, иргэн Д.Гантулга: Нэгдүгээрт, ийм нээлттэй сонсгол явагдаж Авлигатай тэмцэх газрын даргаас миний бие асуух эрхтэй болж байна. Хэзээ бид нар Авлигатай тэмцэх газрын даргаас асууж байцааж байсан юм бэ? Энэ боломжийг олгосон, энэ санаачилгыг гаргасан сөрөг хүчний хоёрыгоо жоохон юм эвгүй болонгуут л та нарын буруу, энэ иргэд ингэлээ, тэглээ гэх биш. Энэ бол том боломж шүү. Тэгэхээр оролцож байгаа хэн ч гэсэн, аль ч нам байсан хамаагүй асуултаа сайн асууж аваарай. Чимэдээ АН-ынхан одоо та нар больё, энэ хэдэн залуучууд байна. Бүгдээрээ биш шүү дээ. Энэ нам дотор чинь зөндөө том, хамгийн том хулгайч чинь бараг энд явж байна шүү дээ. Хулгайчид ямар ч нам хамаагүй байхгүй юу даа. Хулгайч бол хулгайч. Ардчилсан намын хулгайч, МАН-ын хулгайч гэж байхгүй. Та нар зүгээр больцгоо, худлаа нэг нь нэг жоохон юм хийе гэхээр зүгээр. Хүнээ зөв онилолдоо.

Нэг асуултыг Б.Жавхлан сайдаас асууя. Б.Жавхлан сайдаа та яагаад худлаа яриад байгаа юм бэ? Энэ АМНАТ-ыг байна шүү дээ тэнд нэг хүн бас асууж байна. 40 их наяд бол хулгай, 10 их наяд бол хулгай биш болчдог юм уу. Засгийн газар нь гарч ирээд 10 их наяд байсан юм Т.Доржханд худлаа яриад байна гээд. Тэгээд тэр 40-ийг 10 болгож байгаа нь их инээдтэй. АМНАТ дандаа жишиг үнээр авдаг, гэрээний үнээр авдаггүй гээд худлаа яриад байгаарай. 2010 оны 12 оны 10 сарын 09-ний 74 дүгээр тогтоол байна Засгийн газрын. Энэ тогтоолоор АМНАТ-ыг жишиг үнээс биш гэрээний үнээр авдаг болсон. Ингээд энэ хугацаанд 8 удаа энэ тогтоол чинь өөрчлөгдсөн байна. Яг одоо бол мэдээж жишиг үнээр авч байгаа. Энэ хэзээ вэ гэхээр 2019 оны 9 сарын 4-нд гэрээний үнээр авдаг болсон байсныг сая 2021 онд өөрчилсөн шүү дээ. Жишиг үнэ, гэрээний үнээс ялгаатай байвал 30 хувиас ялгаатай байвал жишиг үнээр авдаг гээд тогтоол байна. Гэтэл яагаад энийг АМНАТ-ыг жишиг үнээс авдаг гэж худал хэлэв ээ? Тэр зөрүүгээр яах гээд байна. Хүмүүсийг битгий төөрөгдүүлээд байгаачээ. Нэг цонхоор байх хэрэгтэй шүү дээ. Тэгэхээр энэ дээрээ тайлбар өгөөч? Энэ жишиг үнээр ерөөсөө сүүлийн 10 жил, ерөөсөө ч гэрээний үнээр аваагүй юм уу АМНАТ-ыг. “Эрдэнэс Тавантолгой” ХК жишээлбэл өмнөх гэрээ рүү орохгүй шүү дээ. Яагаад гэвэл “Эрдэнэс Тавантолгой” ХК маш бага хямдхан зардаг байхгүй юу. 30 хувь руу орохгүй юм чинь мэдээж АМНАТ-ыг жишиг үнээр төлнө шүү дээ. Энэ дээрээ тайлбар өгнө үү.

Авлигатай тэмцэх газрын даргаас, нүүрсний хулгай гэдэг чинь цагаан захтнуудын хэрэг яваад байгаа Схем аваад үзвэл өнгөрсөн 2 жилийн хугацаанд тооцоог нь гаргаад үзэхээр амны үнэ 2020 оны 2 дугаар улирлын байдлаарх зардал бол 45 доллар байсан, Ковидын өмнөх үед. Энэ хугацаанд чинь амны чинь үнэ ерөөсөө олигтой өсөж чадаагүй байна. Гэтэл хилийн цаана хамаагүй өссөн. Тэгвэл ойролцоогоор нэг тонн нүүрсэн дээр 60 ам.доллар нэмээд түүнийг гэнэтийн ашиг гэдэг шиг тэврээр дамжуулаад хилийн үнэ гээд энэ эрх баригчид чинь аваад байна. Өөрөөр хэлбэл нүүрсний үнэ өсөхөөр энэ ашгийг чинь Монголчууд авч чадахгүй байна шүү дээ, иргэд авч чадахгүй байна, татвар авч чадахгүй байна. Энэ ашгийг чинь тэврээр дамжуулаад аваад байна, Хятадуудаас аваад байна. Ихэнх тэврийг бас Хятадууд хийж байгаа шүү дээ. Энэ асуудлыг шалгаж байгаа юу? Энэ чинь жинхэнэ нүүрсний хулгайн цөм нь явж байгаа юм. Тэгэхээр АТГ энэ дээр хариу өгөөч.

Хоёрдугаарт “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас квот авахаар 1 ам.доллар 50 цент авдаг. Энийг энэ салбарынхан бүгд ярьж байна. Энэ дээр ямар, ямар хүмүүсийг шалгаж байгаа вэ

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР? Одоо надад олгосон ийм боломж байна Авлигатай тэмцэх газрын даргыг байцаах. Ийм 2 асуулт дээр тодорхой хариулт өгөөч. Ингээд эд нарыг чинь хэрэг биш гээд үзчихээр нүүрсний 40 их наяд төгрөгийн хэрэг алга болчих гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр тодорхой хариулт өгөөч. Баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Б.Жавхлан сайд АМНАТ-тай холбоотой асуултад хариулт өгнө үү.

УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан: Д.Гантулга найз минь больж үз дээ. Одоо олон нийт юм уншдаг, мэддэг болчихсон байгаа шүү дээ. Одоо веб сайт дээр наадхыг чинь ороод уншихад АМНАТ-ыг ингэж авч ирж байсан аргачлалыг нь харах юм бол 2 түүх байгаа юм. Таны хэлсэн үнэн 2021 оны 6 сарын 03 хүртэл гэрээний үнэ, 2021 оны 6 сарын 03-наас манай Засгийн газраас нэлээн томоохон 2 реформ өөрчлөлтийг хийсэн юм. Тэр нь одоо жишиг үнэ гадна талд байгаа үнэлгээнээс ил нөхцөлөөр нь авдаг болчихсон байгаа. Тэр гэрээний үнэ гэдэг дээр та буруу тайлбарлаад байна. Танд уг нь өгсөн, та одоо өөрөө яг барьчихсан сууж байгаа даа, уншихаараа өөр уншаад байдаг юм уу, хаашаа юм. Энэ үнэлгээ дээр ингэсэн байгаа юм. Засгийн газрын 2014 оны 220, 2019 онд 342 дугаар тогтоолоор батлагдсан гадаадын зах зээлд борлуулсан нүүрсэнд АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох аргачлал, энэ аргачлалын 2.3 дээр ААН-ийн нүүрс борлуулах гэрээний үнэд үндэслэн АМНАТ ногдуулах борлуулалтын үнэлгээг Монгол Улсын хилийн өртөө хүртэл бараа нийлүүлэх нөхцөлөөр тодорхойлно гэж байгаа юм.

Тэрийгээ тодорхойлохдоо аргачлалын 2.4 дээр нүүрсийг Монгол Улсын хилийн өртөө хүртэл хүргэхэд дараах зардал төлбөр ороогүй бол түүнийг нэмж тооцно. 2.4.1 дээр тээврийн зардал, тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой тээврийн болон экспортын бичиг баримт бүрдүүлэлтийн хураамж, даатгалын шимтгэл, түүнчлэн барааг ачих, буулгах, хадгалах, шилжүүлэн ачихад гарсан зардал. Энэ бүх өртгийг нь гэрээний үнэ дээр нь нэмж байгаад тэр үнэлгээнээс нь АМНАТ-ыг авч ирсэн байгаа байхгүй юу. 2021 оны 6 сараас харин ямар болсон бэ гэхээр гадна талд байгаа биржийн үнээс нь бид нар түүн дээр Хятадын гаалийн нөөц, Хятадын гаальтай холбоотой импорттой холбоотой татваруудыг нь мөн бусад гаальтай холбоотой бичиг хэргийн зардлууд гээд жижиг зардлууд байдаг. Тэд нарыг бүгдийг нь хасаж байгаад яг ил нөхцөлөөр нь авдаг болсон байгаа.

Тэр нь бол өмнөх, харин тэр гэрээ дээр нэмэх нь өртөг, тэр үнэлгээнээс бол хавьгүй жоохон өндөр байдаг. Өөрөөр хэлбэл бид нар АМНАТ-ыг илүү авдаг болсон гэсэн үг харин ч. Тэрнээс биш амны гэрээний үнэ гэж та уг нь бол нюансыг нь өөрөө зөв ойлгож байгаа, тийм боловсролтой хүн гэж би таныг боддог. Тэгээд тайлбарлахдаа яагаад эхлээд нэг тийм тоо гаргачихсан, тэрэндээ бантаад л тайлбарлах гээд л тал талаас нөгөө эвэнгийн онигоо шиг л юм болоод давхиад байх юм.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: З.Дашдаваа дарга хариулах уу? 2 дугаар микрофоныг нээе, 2 боломж алдаад байгаа тухай л ярьсан даа.

Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа: Д.Гантулгын асуултад хариулъя. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааг ер нь бүхэлд нь шалгаж байгаа. 10 жилийн хугацаатай үйл ажиллагааг шалгаж байна. Эхний ээлжинд 2018-22 оны 633 тонн нүүрс худалдах, худалдан борлуулах гэрээг нэг бүрчлэн шалгаж байгаа. Энэ дээр бас бид нар тодорхой хэмжээгээр гэрээн дээр тодорхой үнийн асуудал нэмэгддэг байдаг гэсэн мэдээллүүд байгаа. Энэ талаар ажлын хэсэг шалгаж байгаа. Мөн 7.5 их наядын “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ажил гүйцэтгэх 587 орчим гэрээг нэг бүрчлэн шалгаж байна. Ингээд энэ гэрээнүүдийг шалгаад тодорхой үр дүнгүүд гарах байх. Бид нарт тодорхой мэдээллүүд байна. Гэрээ болгон дээрээ бид нар шинжээчийн баг томилоод ажиллаж байна. Тийм учраас

томилсон шинжээчийн багийн дүн гарсны дараа тээврийн компани нүүрсний гэрээг авсан компаниуд хэдэн төгрөгийн орлого орсон гээд бид нар цаашаа хөөгөөд явна. Тэгэхээр эндээс ямар нэгэн байдлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн удирдлагууд болон гэрээ байгуулсан хүмүүс тэр нэмсэн асуудал, илэрнэ ямар ч байсан. ААН-ийг бол бид нар шалгаж байна.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Д.Гантулгатай санал нэг байна. Энэ нээлттэй ерөнхий хяналтын сонсгол явуулж, төрийн холбогдох албан тушаалтнуудыг ирүүлж бас мэдээлэл авч, тайлбар авч, хариулт авна гэдэг бол бас нэг алхам гэдэгтэй санал нэг байна. Тэгэхээр энэ нээлттэй хяналт, ерөнхий хяналтын сонсгол явуулах санал санаачилга гаргасан Их Хурлын гишүүддээ дахиад нэг нэрийг нь хэлээдэхье. Энэ ганцхан Т.Доржхандын нэрийг хэлээд нарын гээд явчихсан. Нийт гишүүдийн нэрийг нэг хэлье. Т.Доржханд, А.Адъяа, Ж.Батсуурь, Д.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Д.Ганбат, Н.Ганибал, С.Одонтуяа, О.Цогтгэрэл, Ж.Батжаргал, Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Г.Ганболд, М.Оюунчимэг, Д.Тогтохсүрэн, Б.Энхбаяр, Т.Энхтүвшин нарын 17 гишүүн энэ ерөнхий хяналтын сонсгол явуулах санал гаргаж Их Хурлын даргад өргөн барьсан учраас энэ сонсгол явагдаж байгаа гэдгийг. Дараагийн иргэн Т.Баярхүү, Баян зам тээвэрчдийн холбоо. Т.Баярхүү байна уу? Алга. Т.Төрболд Үндэсний батлан хамгаалах их сургуулийн аюулгүй байдлын доктор Т.Төрболд. 2 дугаар микрофон уу?

Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн доктор Т.Төрболд: Өнөөдрийн энэ хэлэлцүүлгийг зохион байгуулж байгаа болон энэ хэлэлцүүлэгт оролцож байгаа та бүхэндээ оройн мэнд хүргэе. Тэгээд өнөөдрийн энэ хэлэлцүүлгийн туршид өглөөнөөс хойш байлаа. Тэгээд их л юм бодлоо. Зохион байгуулалтын хувьд өнөөдрийн хэлэлцүүлгийг бас нэлээн бужигнууллаа. Тэгэхдээ ямар ч байсан тодорхой мэдээллүүдээ авлаа. Би энэ аюулгүй байдал судлаач хүний хувьд бол Монгол Улсын тусгаар тогтнол, ялангуяа төр засгийн тусгаар тогтнол, эдийн засгийн аюулгүй байдал зэрэгт голчлон анхаарал хандуулж, санаа зовж байгаа юм. Тэгэхээр энэ сүүлийн 1990 оноос хойш Монгол Улсад томоохон хэмжээний ийм хулгай, гэмт хэргийн чанартай үйлдлүүд илэрсэн юм уу гээд та бүхэн нэг асуугаад үзээрэй өөрсдөөсөө. Яг энэтэй адилхан өнөөдөр энэ нүүрстэй холбоотой, ялангуяа Монголын эдийн засгийн ганц түшиц болж байгаа энэ томоохон нүүрсний салбар дээр энэ томоохон хулгай гарчээ гэж байгаа юм.

Тэгэхээр энэ 2013 онд жишээлбэл үүссэн байсан тэр хэрэг өнөөдөр хүртэл илрэхгүй байгаа нь Улсын ерөнхий прокурортой холбоотой асуудал. Нөгөө талаасаа 90 оноос хойш одоо алт дилерийн хэрэг, өмч хувьчлалын асуудлууд, хадгаламж зээлийн хоршооны хэрэг, үүнтэй холбогдуулаад цаашаа ярих юм бол Хөгжлийн банк, Хөгжлийн банктай холбоотой олон бондуудын асуудал гээд маш олон асуудлууд байгаа. Энэ хэргүүд өнөөдөр хүртэл илрээгүй. Тэгэхээр мөрдөх алба, шүүх хоёрын дунд байгаа прокурорын байгууллага яагаад одоо болтол ажлаа хийдэггүй юм бэ? Дээрээс нь энэ хулгайг анхнаас нь төмөр замыг барихаас авхуулаад гацаасан, тэвэр явуулдаг бүх зүйлийг чинь анх энэ схемийг зохиосон хүнээ өнөөдөр гадагшаага та нар алдчихаад сууж байна шүү дээ. Улсын ерөнхий прокурор өнөөдөр нэг ч гарч ирсэнгүй. Тэгэхээр энэ асуудлыг Улсын ерөнхий прокурор өнөөдөр энэ гэмт хэргийн асуудал ярьж байгаа учраас Улсын ерөнхий прокурор энд байх ёстой. Тэрнээс намууд, ХҮН нам, АН, МАН гэж талцах гэж энд ирээгүй. Энэ хулгайг хэн хийсэн юм, хэрэгтэнтэй хариуцлага тооцохыг л энд жагсаж байгаа ард иргэд, энд ирсэн хүмүүс шаардаж байгаа шүү дээ.

Тийм учраас Улсын ерөнхий прокурор тодорхой байр сууриа хэл. Гучин хоёрхон нэр төрлийн үгүй ээ гучин хоёрхон төрлийн гэмт хэрэг дээр хүмүүс шалгаж байна гэж байгаа. Тэгэхээр энийгээ яг тодорхой болго, мөрдөн байцаах болон хяналт тавих бусад хуулийн зарим нэгэн заалтыг барьж халхавчилж, энэ гэмт хэргүүдийг хаацайлахаа одоо боль. Улсын Их Хурлын гишүүд өнөөдөр энэ асуудал дээр онцгой горимоор хуралдаж, зарим асуудлыг

шийдэхгүй бол аягүй бол энэ иргэд төрдөө итгэхээ болих, больсноос үүдсэн эмх замбараагүй байдал өнгөт хувьсгал руу ч явах нөхцөл байдал үүсчхээд байна.

Нөгөө талаасаа эдийн засгаа авч явж байгаа энэ салбарыг татаж унагахад маш ойрхон болчихлоо. Гаднын худалдан авагч нар нь ч тэр, дотоодын ААН нь ч тэр шударгаар ажиллаж байгаа маш олон компани, хувь хүмүүс байгаа. Гэхдээ харамсалтай нь юун дээр очиж гацаад байна вэ гэхээр энэ бүлэг мафийнханд очиж гацаад байгаа юм. Тэгээд энэ мафийг илрүүлэхээр өнөөдөр зарлаад явж байгаа Засгийн газар бол сайн байна. Гэхдээ одоо хүч жоохон дутуу байна. Засгийн газрын үйл ажиллагаа дээр дэмжлэг үзүүлбэ, Засгийн газрын үйл ажиллагааг тогтвортой байлгах нь маш чухал. Зарим нэгэн хүмүүс ярьж байгаа юм, ерөөсөө намууд бараг энэ Засгийн газар тар, парламент тар гэж байгаа юм. Энэ гэмт хэрэг чинь илрэхгүй, бүр нохойн замаар ороод дуусна. Тийм учраас Улсын Их Хурал дээр энэ тогтолцооны өөрчлөлт, системийнхээ агуулгыг өөрчлөхгүйгээр бид нар цаашаа ахиад 30 жил явна гэсэн ойлголт байхгүй. Тийм учраас Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах, парламентын тогтолцоог сайжруулах, Монголчуудын үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, эд хөрөнгөтэй байх, зах зээл, чөлөөт зах зээлийн нийгэмд ажиллаж амьдрах боломжийг олгосон шинэ Үндсэн хуулиар ардчилсан парламентын засаглалыг сонгосон. Энэ тогтолцоогоо бид нар илүү төгөлдөржүүлж, энэ хулгай луйврыг багасгах тогтолцоогоо бүрдүүлэхгүйгээр цаашаа алхах боломжгүй.

Тийм учраас Үндсэн хуульдаа яаралтай бид нар энэ өөрчлөлтүүдийг оруулах ёстой. Түрүүний ярьсан мөрдөх алба, шүүх хоёрын дунд байгаа прокурорын байгууллагын удирдлагууд, үе үеийн удирдлагууд, бизнесменүүдийг дарамталж шоронд хийж хэдэн сая доллароор нь дээрэмддэг байсан хэргүүдийг одоо та нар мартчихсан шүү дээ. Хаана байгаа юм бэ, илэрсэн нь хаана байгаа юм бэ? Гэмт хэргийн хохирогч нь өөрөө ингэж шилжүүлгийн баримтаа үзүүлээд өнөөдөр хүртэл ярьсан. Тэр Дорлигжав гээд нөхөр одоо хүртэл хэдэн, хэдэн арван сая доллароор нь идчихээд л зүгээр явж байна шүү дээ. Энэ мэтчилэн гэмт хэргүүдтэйгээ тэмцэнэ шүү дээ. Тэмцэж байгаа улсууд руу, харин зохион байгуулалттай юм хийж байгаа улсууд байх юм бол Монголын ард түмэн тэр хүмүүсийг хулгайч гэж бодоорой. Баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Ерөнхий прокурор өглөөнөөс хойш суугаад байгаа шүү дээ. Хариулт өгөөд, өөрөө сууж байгаа даа. Одоо Б.Батбаатар Иргэний зориг ногоон намын дэд дарга. Б.Батбаатар байна уу? Б.Батбаатар гэхээр Х.Бат-Ялалт босоод ирдэг чинь яаж байгаа билээ? Үгүй ээ, үгүй хүн чинь байхгүй байна шүү дээ одоо Х.Бат-Ялалтаа. Дэгээрээ явъя. Чи өглөө зөндөө ярьсан даа Х.Бат-Ялалт. Хүний оронд ярих, наад улсууд чинь үг хэлбэ. Б.Жаргалан Хан-Уул дүүрэг.

Сонсголд оролцогч, иргэн Б.Жаргалан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өглөө 9 цагаас хойш хамт байлаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: С.Батбаатар байна. Ерөнхий нарийн бичгийн дарга.

Сонсголд оролцогч, иргэн Б.Жаргалан: Тэгээд үнэхээр гунигтай байна. 33 жилийн өмнө ардчилсан хувьсгал яг энэ талбай дээр өвлийн хөхөө хар хүйтэнд болсон. Тэгээд тэр үед Монголын ард түмэн юу хүссэн юм, өнөөдөр 33 жилийн дараа бид Төрийн ордондоо суучхаад нэг нэгэн рүүгээ хашхичаад хэн хулгай хийсэн бэ гээд төрийн хулгайгаа Төрийн ордондоо хэлэлцээд сууж байхыг бол хүсээгүй юм. Тэр үед бид нар илүү гэгээн мөрөөдөлтэй байлаа. Монгол Улс хөгжинө гэдэг хөгжих бүрэн боломжтой байлаа. Дотоод, гадаадын зах зээлийн нөхцөл байлаа, хүний нөөц байлаа. Гол нь бид нарт мөрөөдөл байлаа. Гэтэл одоо бид нар мөрөөдөл ярьж чадахаа байчихсан байна, бид нар зөвхөн хулгай ярьж байна.

Хулгайгаа ярих, ярихдаа бүр бүрэн хэмжээгээр нь ч ярьж чадахгүй байна. Хязгаарлагдмал мэдээллийн хүрээнд зөвхөн эрх баригчдын бид нарт өгч байгаа тэр цаасных нь хүрээнд л ярьж чадаж байна шүү дээ. Тэгэхээр үнэхээр гунигтай байна, бид нар ийм зүйл хүсээгүй.

Тийм ч учраас гадаа жагсагчид зогсож байгаа. Өнөөдөр гадаа зогсож байгаа бүх залуучуудыг энэ танхимд оруулаад ирэхэд яах вэ дээ. Өнөөдрийн эрх баригч МАН 1990 оны МАХН-аас илүү коммунист арга барилтай байна. Бид нар ардчилсан улсад амьдарч байгаа биз дээ. Яагаад иргэдийнхээ эрхийг хангахгүй байгаа юм бэ? Яагаад 1991 онд батлагдсан ардчилсан Үндсэн хуулиас өмнө батлагдсан хуулийн дагуу хувийн ААН дээр бүрэн эрхт төлөөлөгч томилж байгаа юм бэ? Бид нар яагаад коммунизм руу ухраад байгаа юм бэ? Бидний мөрөөдөл хаачсан юм бэ? Тэгээд энэ бүх зүйлийг ярих гэхээр та нар улс төржлөө гэх юм. Үгүй, энэ чинь бүх ард түмэн, ард түмний зүрх сэтгэлд ойрхон болчихоод, бүгдээрээ гадаа гарчхаад байхад та нар улс төржлөө гэж нэг нэгэн рүүгээ дайрч болохгүй. Эцсийн бүлэгт өнгөрсөн 33 жилийн 29-д нь МАН дангаараа, эсвэл эвслийн хүрээнд засагласан байдаг. Өнгөрсөн 7 жил МАН үнэмлэхүй олонхоор парламентад засаг бариад сууж байна. Өнгөрсөн 7 жилийн хугацаанд Монгол Улс 18.5 тэрбум ам.долларын нүүрс экспортлсон. Энд хэн байсан юм бэ, эрх баригчдаа та нар л байсан шүү дээ. Хулгайчийг хаанаас хайгаад байгаа юм бэ? Тусгаар тогтнолынхоо ордноос хай л даа.

Тэгээд түрүүн УИХ-ын гишүүн, Сангийн сайдаас нэг асуулт асуусан. Тэр асуултад УИХ-ын гишүүн, Сангийн сайд хариулж чадсангүй. Өнгөрсөн хугацаанд зөвхөн энэ нүүрсний хулгай биш, төсвийн хулгай, Ковидын хуулиар далимдуулсан хулгай, мөн энэ ТӨК-иудын зарцуулалт тайлан дээр тусгагдсан энэ бүх хулгай явж байна. Энэ дээр бид нарт мэдээлэл алга байна. Холбогдох хүмүүс нь энд байхгүй байна, аль эсвэл мэдээллээ өгөхгүй байна. Тэгээд сая Авлигатай тэмцэх газрын дарга бүх асуулт дээр шалгаж байна, шалгаж байна л гэж хэлж байна. Тэгэхээр нэг ийм горимын санал байна. Энэ нээлттэй сонсгол, энэ нийтийн сонсгол бол маш чухал, энийг ард түмэн хүсэж байгаа, энийг бүх улс төрийн намууд, иргэний нийгмийн төлөөлөл бүгдээрээ ширээний ард суугаад энэ асуудлуудаа хэлэлцээд, цаашид Монгол Улс ер нь хаашаа явах юм бэ гэдгээ ярих нь чухал байна.

Тэгэхээр өнөөдрийн хувьд энийг зүгээр ингэж оромдоод, нийтийн сонсгол хийсэн нэр зүүгээд, Т.Доржханд гишүүн сөрөг хүчний гишүүдийн дагуу хийж байна шүү гэж ам хаагаад энэ сонсголыг үнэгүйдүүлмээргүй байна. Тэгэхээр ямар горимын санал байгаа вэ гэхээр одоо энэ сонсголыг завсарлуулаад, дараачийн удаад ямар, ямар мэдээллүүдийг нээлттэй болгох юм, түрүүний яригдаад байгаа оффтэйк гэрээнүүдийн зөвхөн 7 нь нээлттэй болсон байгаа, бусдыг нь нээлттэй болгоод, энд өнөөдөр үг хэлсэн хүмүүсийн тавьсан шаардлагын дагуу баримт бичгүүдийг, мэдээллүүдийг ил тод болгоод, холбогдох ажил хариуцсан үе үеийн албан тушаалтнуудыг байлцуулаад, дараагийн бас дахин нэг өдөр маргааш байж болно, нөгөөдөр байж болно нэг өдөр товлоод дахиад нэг сонсголоо үргэлжлүүлэе. Хурал даргалагчаа тийм горимын санал дээр саналаа хэлнэ үү? Баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Б.Цэнгэл дарга ирсэн байна, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга. Төрийн өмчийн болоод төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн төсөвтэй холбоотой асуудал түрүүн ярьсан юм. Жилд ер нь энэ төрийн өмчийн байгууллагууд, компаниуд дээр ямар хэмжээний төсөв баталж өгдөг юм, үр ашиг нь ямар байдаг юм гэсэн асуулт гарсан юм. Тэгээд сая ч бас энэ Б.Жаргалан дурсаад байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Цэнгэл. Монгол Улсад төрийн болон төрийн өмчийн оролцоотой 105 ААН, орон нутагт 267 ААН үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ төрийн өмчийн 105 ААН-д нийт 53 гаруй мянган ажиллагсад ажиллаж байна. Энэ ТӨК-иудын

авлага 1.8 их наяд, өр төлбөр 18.1 их наяд. Эдгээр компани нийт 53.4 их наядын хөрөнгөтэй. 2021 оны байдлаар 10.6 наядын орлого олж, зардал нь 9.1 их наяд гарсан. Төсвийн төлбөрт 1.8 их наяд, ногдол ашигт 2021 оны байдлаар 207.2 тэрбум, цэвэр ашиг нэг их наяд гаруй төгрөгийн цэвэр ашигтай ажилласан дүн байж байгаа. Энэ ТӨК-иудыг дотор нь ангилж үзэх юм бол ТӨҮГ 21, ТӨХК 51, ТӨХХК 21, Төрийн өмчийн оролцоотой компани 12 байх жишээтэй. Энэ дээр нэг зүйлийг онцолж хэлэхэд эдгээр ТӨК-иудын хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэгч нь янз, янз байдаг.

Тухайлбал, манай олон нийтэд ийм ойлголт байдаг. Ер нь бүх ТӨК-иудыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын харьяанд байдаг гэж ойлгодог. Яг манай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын харьяанд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр нь авч үзэх юм бол 49 компани байж байгаа. Бусад нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 17, Сангийн яаманд 7, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2, Зам тээврийн, хөгжлийн яаманд 2, Эрчим хүчний яаманд 26 удаа гэх зэргээр ангилагдаж явдаг. Түрүүн худалдан авалттай холбоотой асуулт гарсан байна лээ. Ингэхээр ерөнхийдөө энэ төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниуд дээр 2021 оны байдлаар 7 их наяд 675 тэрбум төгрөгийн худалдан авалтууд хийгдсэн байж байгаа. Үүнээс мэдээж төр хувийн хэвшлийн түншлэл гэдэг агуулгаар нь тодорхой хэмжээний худалдан авалт тийшээ явдаг. Эндээс нийт төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын хөрөнгө оруулалт 2021 онд 4.1 их наядын хөрөнгө оруулалт бол орсон байж байгаа. Саяын миний хэлсэн худалдан авалтуудын ерөөсөө 89 орчим хувь нь нэр бүхий нэг 4-5 компани дээр оногдож байгаа. Баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Одоо нэг иргэн асууж, үг хэлнэ. П.Ганболд, иргэн П.Ганболд байна уу? П.Ганболд гэж. П.Ганболд мөн үү?

Сонсголд оролцогч, иргэн П.Ганболд: Мөн. Намайг П.Ганболд гэдэг би Сэлэнгэ аймгийн Сайхан сумаас ирсэн. Энэ дотор байгаа хулгайчуудаа яагаад зарлахгүй байгаа юм бэ? Энэ дотор чинь зөндөө хулгайчууд байна шүү дээ, одоо ингээд УИХ-ын гишүүн, Сангийн сайд нараас нь авхуулаад. Та нар энийгээ хийгээч. Энэ дотор зөндөө хулгайчууд байна шүү дээ. Энэ юу нь хаачсан юм бэ? Тийм Ерөнхий сайд нь хаачихсан юм бэ? Л.Оюун-Эрдэнэ хаачихсан юм бэ? Энэ Л.Оюун-Эрдэнэ энэ хулгайчийг бас шалгамаар байна, Д.Сумъяабазарыг шалгамаар байна. Энэ хүмүүс хаачихсан юм бэ? Энэ хүмүүсийг яагаад шалгахгүй байгаа юм бэ та нар? Баяртай.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Маш товчхон санал хэлж байна. Одоо нэг гишүүн үг хэлнэ. Д.Өнөрболор гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Нэгдүгээр микрофоныг нээе, нэгдүгээр микрофон.

УИХ-ын гишүүн Д.Өнөрболор: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Миний бие Улсын Их Хурлын 12 сарын 12 дугаар 02-ны өдрийн.../үг тасрав/

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Дэгээрээ явъя, яагаад үймүүлээд байна вэ? Д.Өнөрболор гишүүн асуултаа асууя. Чи хэн юу гараад ирэв? Үгүй ээ, чи түрүүн Ч.Гэрэлт-Од гээд чи бүр эхээр үг хэлчхээд гарсан шүү дээ. Үгүй ээ, үгүй одоо дэгээрээ явъя Даваадорж. Д.Өнөрболор гишүүн үг хэлж байна шүү дээ. Дэгээрээ явъя л даа, ямар сонин та нар тэгээд. Чи түрүүн эхэнд нь зөндөө ярьсан шүү дээ энэ чинь. Нэгдүгээр микрофонд хүлээчихдээ. Чи түрүүн зөндөө л ярьсан шүү дээ.

Үгүй ээ, үгүй би чинь анхны, танд шаардлага өгсөн биз дээ? Гадаа байгаа залуучуудыг маань цагдаа хүчний байгууллагууд хүчээр тараах, хашлага албадлага хийгээд байна, хийх гээд байна. Үүн дээр цагдаа хүчнийхэн болиоч. Бид нар нь энд зүгээр тайван

жагсаал шүү дээ. Яагаад заримыг нь энд оруулж ирчхээд, заримыг нь гадаа оруулж ирэхгүй ингээд тараах гээд.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Хаана байгаа хүмүүс юм бол?

Энэ гадаа талбай дээр байгаа. Талбай дээр тайван суулт хийж байгаа хүмүүсийг цагдаа хүчний байгууллага нь өнөөдөр одоо яг одоо шүү, тараах гээд албадлага хийх гээд, баривчлаад явах гээд байна. Үүн дээр анхаарлаа хандуулаач. Тэгээд бид өнөөдөр 19 хонолоо. Өнөөдөр та бүхэн, та бүхэн өнөөдөр бид нарын хүчээр харин тийм ээ, залуучууд энэ хүмүүсийн төлөөлөл ирж, энд яг нүүрсний асуудлаар ярилцаж байна. Тэгэхээр тэнд байгаа баатруудаа өнөөдөр аччихаад, өнөөдөр энд суумааргүй байна. Та нэг хэлээд өгөөч цааш нь.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Ойлголоо. Ард чинь, хойд талд цагдаагийн дэд дарга сууж байна, та нэг асуугаад тодруулаад дараа нь нэг тайлбар хариу гээд өгч байгаач. Юу болоод явчхав.

Гадаах нөхцөл байдлаа дүгнээч та нар. Хүн үхэх гээд байж байхад та нар одоо юун дэг яриад байгаа юм бэ.

Орилж хашхирахаа больчхооч.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Нэг номерын микрофоныг өгье. Цагдаагийн дэд дарга.

Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагий хурандаа П.Оростогоо: Яг одоо цагийн байдлаар энэ талбай дээр байж байгаа хүмүүсийн эрүүл мэндийг үзэх гээд Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн төвийн дарга П.Бат-Ирээдүй гэдэг эмч ирчхээд эмнэлгийн үзлэг хийе гэсэн шаардлага тавиад байж байгаа юм байна. Цагдаагийн оролцоо ямар ч байхгүй. Энэ худлаа мэдээлэл битгий тараагаад, та нар дэг эвдээд байгаач. Одоо цагдаагийн байгууллагын зүгээс тараах чиглэлийн үүрэг чиглэл өгөгдсөн юм байхгүй гэсэн мэдээ сая надад ирлээ. Битгий та нар энд санаатайгаар үймүүлээд байгаач. Энэ чинь зохион байгуулалттай арга хэмжээ болж байна, битгий дэг эвдээд байгаач та нар.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Цагдаа ямар ч хамаагүй байна гэсэн. Д.Өнөрболор гишүүн асуултаа асууя. Та энэ урд талын Д.Өнөрболор гишүүн наад микрофоноосоо асууя. Дэлгэцийн урд талын микрофоныг нээгээд өгчих. Тэгвэл нэгдүгээр микрофон дээр оч.

УИХ-ын гишүүн Д.Өнөрболор: Миний бие Улсын Их Хурлын 12 дугаар 12 сарын 02-ны өдрийн нэгдсэн чуулган дээр энэ нүүрстэй холбоотой эдийн засгийн гэмт хэргүүдтэй холбоотой асуудлаар ийм нээлттэй сонсгол явуулах талаар шаардаж байсан. Энэ ажил бодит ажил одоо болж байна өнөөдөр. Тэгээд иргэд ер нь их маш их бухимдалтай байна. Үнэхээр төр засагтаа итгэх итгэлгүй болж байгааг бид нар харж байна. Гэхдээ улс төрч болгон өнөөдөр энэ худал хулгай руу бас ороогүй. Нэр цэвэр, өмнөх ажлаа хийж яваа гишүүд, Засгийн газрын гишүүд, төрийн албан хаагч нар байгаа шүү. Тухайлбал, жижиг, дунд үйлдвэрлэл ЖДҮ аваагүй, нүүрсний луйвар хийгээгүй, Хөгжлийн банкнаас зээл аваагүй ийм хүмүүс бас бий шүү. Тэднийг төлөөлөөд нөгөөтээгүүр би Сэлэнгэ аймгаас сонгогдсон гишүүний хувиар Сэлэнгэ аймгийнхаа иргэд олноос ирүүлсэн асуудлыг бас цэгцлээд хамтатгаад, хэд хэдэн зүйлийг тодруулья гэж бодож байгаа юм.

Нүүрс ер нь энэ дэлхийн эдийн засгаас арчигдах цаг ойртсоор байна. 2060 он гэхэд түүхий нүүрсний хэрэглээг БНХАУ бүрэн халахаа зарласан. Тэгэхээр 2025 оноос хойшоо 5

жилийн дотор нүүрсний хэрэглээг хязгаарлахаар бодлого одоо явж байна. Гэтэл би яг гол юмаа ярих гэж байна. Гэтэл бидний яг энэ нүүрс бол Монгол Улсын эдийн засгийг тэтгэгч тийм ээ, энэ экспорт голдиролдоо ороогүй байна. Авлига хахуулиасаа өнөөдөр салсангүй бид нар. Холбогдох албан тушаалтнуудын ёс зүйн асуудал улам бүр гэмт хэргийн, бүлэг дээрмийн шинжтэй болсон байгаа нь үнэхээр эмгэнэлтэй байна. Тэгэхээр энэ хууль хяналтынхан, мөн Ерөнхий прокурорт хандаж би нэг зүйлийг хэлмээр байна. Энэ цаг хугацаа бол та бүхнээс өндөр ёс зүй, хариуцлага, шударга байхыг шаардаж байна. Тэгэхээр Ерөнхий прокурор одоо энэ төрийн нэрийн өмнөөс хяналт тавьж, үйл ажиллагаа явуулдаг хүн байгаа. Тэгэхээр төр бол ард түмэн. Тэгэхээр ард түмэн, олон улс та бүгдийг бас харж хүлээж байгаа гэдгийг би танд онцлон тэмдэглэе.

Тэгээд ард олныг бухимдуулаад байгаа энэ нүүрсний олборлолт, тээвэрлэлт, экспорттой холбоотой энэ асуудлууд дээр голдуу ийм зөрүүтэй мэдээлэл газар авч байгаа учраас ард түмнийг нэлээн их бухимдал, төөрөгдөлд оруулаад байна. Тэгээд миний ойлгож байгаагаар энэ 21 компани гэрээнд заасан хэмжээнээсээ сая тонн нүүрс илүү экспортолсон 12 компани эх үүсвэр нь тодорхойгүй байна. Гэрээгүй 515,000 тонн нүүрс экспортолсон байна. Гашуун сухайт боомтоор 86 компанийн 2527 тээврийн хэрэгсэл олон удаагийн давтамжтайгаар ачаагүй гэсэн бүртгэлээр гарсан байна. 3700 гаруй тээврийн хэрэгслээр 379,000 тонн нүүрс экспортолсон гаалийн мэдүүлэг олдоогүй зэрэг, бас 17,000 давтан удаагийн давтамжтайгаар хилээр ачаагүй хоосон гарсан байна. Тэгэхээр нэг юм уу, эсвэл нэг, хоёр сая тонноор тогтохгүй ийм нүүрсний хулгай хийгдэж байгаа гэсэн ойлголт байгаад байна л даа. Тэгэхээр энэ тал дээр холбогдох байгууллагаас яг одоо тодорхой хариулт авмаар байна? Өнөөдрийн байдлаар яг хэдий хэмжээний нүүрс одоо хууль бусаар гадагшаа гарчихсан юм бэ? Тэгээд хэдийг нь тогтоогоод байгаа юм бэ? Энэ олон нийтэд тодорхой мэдээлэл өгч, яг нэг мөр одоо болгож, одоо нэг тоотой болохгүй бол болохгүй асуудал бас үүсээд байна гэж бол хэлж байна. Авлигатай тэмцэх газраас одоо зарласан нүүрс нийлүүлэлтийн 633 гэрээний 259 нь тоо хэмжээтэй байна. 6 гэрээ нь бол ам.доллараар хийгдсэн байна, үлдсэн 368 гэрээний нийт нүүрсний хэмжээ нь ер нь хэд байгаа юм бэ? Энэ нүүрсний хэмжээтэй гэрээний дүнг нэгтгээд үзэхээр бол 130.7 сая тонн болоод байх юм. Гэтэл Засгийн газар одоо танилцуулахаар 86 сая тонн гээд байна. Тэгэхээр “Эрдэнэс Тавантолгой”ХК экспортолсон гэдэг одоо энэ зөрүүгээ бас одоо тайлбарлаж хэлж өгөөч?

Энэ компанийн 85 хувь нь бол төрийн мэдэлд байгаа. 15 орчим хувь нь бол иргэдийн нөгөө 1072 хувьцаа байгаа. 0.06 хувь нь бол ААН байгаад байгаа. Тэгэхээр даруй 10 жил одоо өнгөрсөн байна. Тэгэхээр 1072 ширхэг энэ хувьцаа иргэн бүрд нэг сая төгрөгтэй тэнцэх хэмжээний үнэлгээтэй байсан. Тэгэхээр ард иргэдэд хуваарилсан энэ хувьцааны үнэ одоо яг өнөөгийн үнэ цэнийг бас одоо тайлбарлаж хэлж өгөөч гэж.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Хэн хариулах вэ? Тэр хичнээн тонн нүүрс хилээр гарчихсан юм, хэдийг нь одоо тогтоочихсон юм, хэдийг нь тогтоож чадаагүй байгаа юм гээд л байна даа. Манай хууль хяналтын байгууллагууд хариулах юм уу, УИХ-ын гишүүн, Сангийн сайд хариулах юм уу? Дашдаваа даргад хариулах юм байгаа юм уу? Хичнээн тонн нүүрс гарчихсан юм, хэдийг нь тогтоочихсон юм бэ гээд байх юм. Хариулах хүн байна уу? УИХ-ын гишүүн, Сангийн сайд хариулах юм уу? Ганбат дарга хариулах уу? Жавхлан сайд. Цагдаагийн дэд дарга наана чинь байгаа, гайгүй байх сая ярьсан шүү дээ.

УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан: Түрүүн тэр 340000 тонн ярихад алга ташаад байсан хүмүүс одоо алга ташилтандаа итгэлтэй байна уу? Та нар дахиад нэг алгаа ташчихдаа харъя даа. Алга ташчихдаа харъя даа. Бүх камерууд ийшээ харуулчихаарай. Энэ хүмүүсийг бүгдийг нь сайн хараад аваарай. Сайн бүгдийг нь хараад аваарай. Та нар босож зогсож байгаад алга ташаарай за юу. Засгийн газар хийсэн ажил дээрээ бид итгэлтэй байна.

Энэ жижиг Тавантолгой, “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр онцгой дэглэм тогтоож, бүрэн эрхт төлөөлөгч томилсон. Нүүрсний хулгай гарсан учраас. Энэ 2 компани дээр чинь Монголын ард түмний баялаг байгаа юм. Тэрийг ухаж байгаа юм. Энэний өмнөөс Монголын төр тэрийг хамгаалалтдаа авч байна, бүрэн хяналтдаа авсан. Хэрэв асуудал байхгүй бол тэгээд л энэ 6 сарын хугацаанд тэр үнэн мөн нь тавигдаад л, харин ч тэр одоо хувьцаа нь улам амилаад, тэгээд цаашаагаа харин алдаа мадаггүй цэвэр болоод явах нь зөв биз дээ? Тэрийг одоо энд буруушаагаад яваад байгаа нь маш харамсалтай, маш харамсалтай нь өнөөдөр зохион байгуулалттай хэдэн хүн энд орж ирсэн байна. Өнөөдрийн энэ сонсголыг үр дүнгүй болгох гэж, сарниулах гэж ийм зорилготой орж ирсэн шүү дээ та нар. Камер бүгдээрээ ийшээ хараа, энэ оролцож байгаа хүмүүсийг сайн харуулж аваарай.

Гишүүний асуултад хариульа, энэ тоонууд бол манай гаалийн статистик тоо шүү, гаалийн дотоод хяналтаар 2018, 2019 он хүртэл удаа дараагийн шалгалтаар ил болсон тухайн үед нь хуулийн байгууллага руу Асралт дарга өөрөө шилжүүлсэн. Ийм тоон материалууд байгаа шүү, 3 бүлэг хэсэг байгаа юм.

Нэгдүгээрт, гэрээгүй болон гэрээнээс илүү тоо хэмжээгээр экспортыг бүрдүүлэлт хийсэн гэж. Энэ бүр нэр бүхий 21 компани гэрээнд заасан хэмжээнээс 1 сая тонн нүүрс илүү экспорт хийсэн байсан, 12 компани эх үүсвэр нь тодорхойгүй, гэрээгүй 515.000 тонн нүүрс экспортсон гэж байгаа.

Хоёрдугаар асуудал нь улсын хилээр хоосон гэж бүртгэгдэж гарсан тээврийн хэрэгсэл Гашуун сухайт боомтоор 86 компанийн 2527 тээврийн хэрэгсэл олон удаагийн давтамжтай Гашуун сухайт боомтоор ачаагүй гэсэн бүртгэлээр гарсан. Энэ одоо гаалийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүд шүү.

Гуравдугаарт, экспортын гаалийн бүрдүүлэлтгүй улсын хилээр гарсан байж болзошгүй бас энэ зөрчлийг илрүүлээд хуулийн байгууллага руу шилжүүлсэн. Энэ нь 3758 тээврийн хэрэгсэл нийт 379000 тонн нүүрс экспортсон, гаалийн мэдүүлэг олдоогүй гэсэн.

Энэ бол яг албан ёсны, одоо хяналт шалгалтаар баталгаажсан ийм статистик мэдээ шүү, бусад өөр олон тоонууд байгаа, тэр нь одоо шалгагдаж байгаа. Одоо ийм тоон мэдээ баримтууд байгаа. Хамгийн тодорхой, албан ёсны төрийн өөрийн институцийн шалгалтаар илэрсэн зөрчлүүд нь бол энэ байгаа юм.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Одоо Шинжээравдан “Босоо Монгол ТББ”-ын төлөөлөл.

Сонсголд оролцогч, “Босоо Монгол ТББ”-ын төлөөлөл П.Шинжээравдан: Бид нар эндээс нэг шийдэл гаргачихъя гэж бодсон чинь нэлээн хэрүүл болоод жаахан тийм болчихлоо тийм ээ, уул нь эндээс бид нар яаж гарах юм бэ? яаж цаашдаа явах юм бэ? яавал бид нар энэ хулгай луйваргүй, ийм улс төртэй, ард иргэддээ хууль хяналттай, чанга хатуу болох юм бэ гэж тийм юм горьдож бодож байсан юм.

Тэгсэн чинь одоо чи, би-дээ тулаад, нам эвсэлээрээ ингээд л маргалдаад л нэг иймэрхүү болоод байна. Ингэмээргүй байна. Бид нар энд гадаа байгаа улсууд дотроос маш олон улсууд, маш олон сэхээтэн, маш олон үндсэн хууль судлаач, тэр эдийн засагч, эрдэмтэд энд одоо зарим нь ороод ирчихсэн сууж байна. Энэ улсууд бол ярьж байгаа юм, за бид нар эд нараас бол ерөөсөө хулгайгаа илрүүл гэж энэ хулгайчаас нэхээд бол нэмэргүй юм байна, хууль хяналтын байгууллагууд нь хүртэл өнөөдөр халдашгүй дархан эрхтэй болохоор хөдөлж чадахгүй байна гээд одоо Дашдаваа дарга сая гарч ирээд л хэлээд байна шүү дээ. За эд нарыг шалгаж байгаа нэрийг хэлэх боломжгүй байна, манайх хуулийнхаа хэмжээнд байж

болно, гэхдээ эд нар ч өөрсдийг нь томилоод байгаа улсуудыг өөрсдөд нь яаж барих юм бэ гэдэг энэ улсууд гадаа зөндөө яриад байна, энэ тогтолцоо системийг өөрчлөх юм байна.

Тогтолцоо системээ өөрчлөхгүй гээд бид нар өнөөдөр энд Төрийн ордонд хулгай яриад гүйж байдаг, энийг чинь шүүхийн танхимд ярьдаг шүү дээ уул нь. Шүүхийн танхимд энэ хулгайчдаас болж, уул уурхайн хулгайчдаас болж шүүхээр зөндөө явсан. Дандаа улс төрчид оролцчихсон байдаг байхгүй юу даа энэ чинь, аль аль нам нь ерөөсөө тэр та нар бүгдээрээ сонсож бай, намаараа талцаж байгаа улсууд сонс. Өнөөдөр Монголд энэ олон нам байгаад байна бид нар одоо хагацал талцал болоод бусдын өгөөш болж дуусаж байгаа юм.

Өнөөдөр жалга довынхоо үзлээс салаагүй, жалга довоороо морь, бөхөөрөө талцаж байгаа улсууд юуных нь энэ олон нам болоод талцах юм бэ? Хэрэггүй шүү дээ. Ерөөсөө бид нар энэ Үндсэн хууль тогтолцоогоо өөрчлөх нь зөв юм байна. Өнөөдөр энэ улс Улсын Их Хурлын гишүүдийг халдашгүй дархан эрх нь байхгүй болгож байж хууль, шүүхийн байгууллагын цагдаагийн хурандаа нарыг хараад чадахгүй байна шүү дээ.

Өнөөдөр хулгай хийсэн луйварчдыг цагдаа, хүчний байгууллага, авлигатай тэмцэхийн дарга Дашдаваа гуай цэргүүдтэйгээ орж ирээд аваад гардаг тийм нийгмийг хүсээд байгаа шүү дээ, тогтолцоо өөрчлөх гээд байгаа чинь энэ. Улаанбаатар хотын 1 сая 600 мянган шахуу иргэн чинь өнөөдөр хотынхоо даргыг томилох эрх байхгүй, эргүүлэн татах ч эрх байхгүй сууж байгаа нь үнэн биз дээ? Утаа, хөгжил, тэр хүн нь буруугаа чихэх гээд бүх хүн рүү дайраад байдаг, энэ чинь тогтолцоо нь буруу байгаад байгаа юм. Өнөөдөр байхгүй байгаад байна шүү дээ. Ерөөсөө бүх улсууд чинь энд яг байх ёстой хэд нь алга байна гэж хэлж байна? Их Хурлын дарга нь нэг тийшээ хараад суучихдаг, Засгийн газар нь нэг тийшээ, Ерөнхийлөгчийн Тамгын газар гээд 3 тийш ээ, дунд нь ард түмэн чинь үгүй болж байна. Баялаг чинь үгүй болж байна. Доржханд гишүүн ээ, яах вэ? энэ 44 их наядыг гаргажээ, за үүнээс их байж ч магадгүй.

Бид нар өнөөдөр төр, Үндсэн хуулийн 22.1 гэж хүмүүс яриад байгаа юм. Зөвхөн нүүрсний асуудал яриад байгаа байхгүй юу даа. Тэр Оюу Толгойн асуудал яагаад чимээгүй болчихож байгаа юм бэ? Энэ Тамсагийн нефтийг мэддэг гишүүн бас байдаггүй юм байна шүү дээ.

Бүтээгдэхүүн хуваах гэрээ гэж юу юм бэ? Монгол хэдэн хувийг нь авдаг юм, хэдэн баррель нь яадаг юм бэ? Энэ 2023 онд яах вэ, юу ч мэдэхгүйгээр өнөөдөр бид нар зүгээр гадны хоол болоод 3-хан сая гаран гэдэг. Энэ том газар нутагтай тийм үү? 1000564 километр квадрат уудам нутагтай, 70 сая малтай, газрын доор нь байхгүй элемент байхгүй Менделеевийн 108 элемент бүгд байхад яагаад ядуу байгаа юм? Яагаад Монголд ийм өргүй байх боломжтой энэ баян байгууламж өнөөдөр 34 меллард долларын өрөнд орсон эдийн засгийн тушаалуудаар гаднын орнуудад алдчихаад байгаа юм бэ? Алдчихаад л суугаад байна шүү дээ тийм үү? Ард иргэдийн дунд баян хүн байна уу? Та нар гишүүдээ сайд нараа энэ талбайгаас хойш сангууд гэр хороолол гэж одоо үлгэр яриад байх юм. Талбайгаас хойш яахав? зүгээр энэ орон сууцны амьдрал нь байна уу? Та нар дотроо бараг нүүрсээ барьж үзээгүй гэж яриад байна шүү дээ. Тавантолгой хаа байдаг аа мэдэхгүй улсууд байна. Яах вэ би заагаад өгөө. За ийм амьдралаас тасарчихсан улсууд ард түмний төлөө сууж болохгүй ээ, Ард түмний төлөөлөл, тэр малчин эрдэмтэн, инженер, сэхээтэн, эдийн засагч, хуульч жинхэнэ сэхээтнүүдийн хувьд төрд орох боломж гарга. Энэ Улсын Их Хурал өнөөдөр байна шүү дээ ахиад та нар сайн бодоорой. Ашигт малтмалын тухай шинэчилсэн найруулгаар өнөөдөр дахиад хуулийн төсөл оруулж хаалттай хэлцэл хийж байна, та нар ахиад ямар юм хулгайлах гээд байгаад байна аа?

Газрын тухай багц хууль гэж байна, газар нутаг, бэлчээр дээр юу оруулах гэж байна?

Та нар тэр 68 хуулийг батлах гээд өнөөдөр намрын чуулганаар зун батална гэж яригдаж байна гэж байна, тийм үү? Парламент вэб сайт дээр өнөөдөр тавьчихсан юм байна. Би тэрийг худлаа хэлээгүй, парламент веб сайт дээр чинь байгаа. Та нар өнөөдөр хулгай луйвартай холилдсон улсууд. Ах дүү нараа, та нар, бид нар адилхан монголчууд АН, МАН хүн ч бай ах дүү нар шүү дээ. Бид нар нэгхэн үндэстэн шүү дээ, 2 том гүрний дунд байгаа энэ жижигхэн үндэстэн дэлхийгээс ичих хэрэгтэй байхгүй юу.

Та нар өнөөдөр энэ хулгай луйвраа ил болгоогүй цагт ахиж хууль батлах эрх зүй байхгүй, ёс юу ч байхгүй үнэн биз дээ? Бат-Ялалтаа Үндсэн хуулиар оролддог хэн юм бэ? Эд нар та нар хичнээн удаа Үндсэн хуулиар оролдсон юм бэ? Үндсэн хууль гэдэг бол энэ үндэстэн оршихуйн төлөө, тэр Монгол Улс оршин тогтнох уу, үгүй юу? Ард түмэн, төр хоёрын хоорондхо том гэрээ байх гэж боддог би бол мунхаг, гэтэл та нар олонхоороо тэрийг өөрчилдөг, олонхоороо та нар авлигатай тэмцэх, цагдаа, цэргийн дурынхаа хүмүүсийг тавьдаг, тэрийг түлхүүрддэг, баадууддаг. Шударга ёс нэхсэн улсууд нь өнөөдөр талбай дээр байж байхад тэр тагнуул, цагдаа өнөөдөр тэр хил дээр гараад алга болоод байгаа юмыг аль хэдийн барьж байхгүй юу хийсэн юм бэ? Бид нар юу хийж байсан юм? Одоо ингээд хөтөлбөр дээр маргана, энэ хэлэлцүүлэг ямар ч үр дүнд хүрэх шинж алга байна.

Та нар Монгол хүн л юм бол Монгол хүний төлөө цохилох зүрхтэй бай гэж Хатанбаатарын хэлсэн үг байдаг. Тэгвэл та нар энэ хулгай луйврын Улсын Их Хурлаа тараагаад халдашгүй дархан эрхээ байхгүй болгож байгаад хууль, шүүхийн өмнө оччих, тэгээд бид нар яах юм? тэгээд дараагаа цаашаа яах вэ? гээд улсууд асуудаг.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За баярлалаа, үг хэллээ. За П.Ганзориг Хан-Уул дүүрэг, 17 дугаар хорооны иргэн.

Сонсголд оролцогч, иргэн П.Ганзориг: Баярлалаа. Сангийн сайдын түрүүн танилцуулсан 5 төрлийн хулгайн 5 дахь хулгай дээр бас асуудал ярьмаар байна. Тэгээд 5 дахь хулгай нь бол энэ хэт өндөр төсөвтэй, бодит улсын төсвөөр “Эрдэнэс Тавантолгой” ХК одоо хохироосон ийм асуудлыг бол танилцуулсан. Энэ дээр тухайлбал, Тавантолгойгоос Гашуун сухайт хүртэлх 1 тэрбум долларын гэрээ бүхий төмөр замын ажлын гэрээ байгуулаад улсын нууцад аваад 1 компаниар гүйцэтгүүлж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр хувийн хэвшил яг шударгаар өрсөлдөж байгаа, хууль, намынхаа дагуу үйл ажиллагаа явуулж байгаа хувь хэвшлүүдээ бол хамгаална, харин хувийн хэвшлийн нэрийн дор халхавчилж нууцаар гэрээ байгуулж, энэ их хэмжээний хохирол учруулж байгаа зүйлтэй бол хатуу тэмцэх ёстой. Зам тээврийн яам Тавантолгой төмөр зам компаниудаас энэ байгууллагуудаас төмөр замын нэг километрийн өртгийг 3.1 сая доллар гэж гаргаж ирсэн тооцоо. Гэтэл Бодь интернэйшнлийн захирал Баясгалан өнгөрсөн 7 хоногийн 1 дэх өдөр танилцуулахдаа 1.4 сая доллар гээд шал худлаа мэдээлэл өгч байгаа нь бодит бус мэдээлэл, төрийн байгууллагууд нь ингээд бодитой тооцоогоо гаргаад танилцуулаад байх юм.

Яагаад ингээд ард иргэдэд ийм ойлгомжтой зүйл дээр ингэж худлаа мэдээлэл өгөөд байгаа юм, тэгэхээр энэ гэрээнд чинь асуудал байна гэсэн үг, бусад зүйлд нь яаж ард түмэн итгэх юм, тэр зам чинь өнгөрсөн хугацаанд бүтээн байгуулалт, суурь дэд бүтэц нь хийгдчихсэн 276 сая доллароор далангийн ажил хийгдсэн, энэ дээр баригдсан юм байгаа биз дээ, эсвэл агаар дээр барьчихсан зам юм уу. Тэгэхээр ийм байдлаар маш том, одоо 1 тэрбум доллар гэдэг бол 3.7 их наяд төгрөг.

Манай Монгол Улсын 2023 онд төсвийн хөрөнгөөр хийгдэх нийт хөрөнгө оруулалтын арга хэмжээний нийт 3 их наяд төгрөг хүрэхгүй шүү дээ. Тэрийг хэдэн мянган

аж ахуй нэгжүүд тендер зарлаад маш өндөр шалгууруудыг давж орж өрсөлдөж байж авдаг. Борлуулалтын орлого, татварын өргүй байх, гүйцэтгэлийн баталгаа, техник тоног төхөөрөмж, хүн хүчний шаардлага гээд. Гэтэл энэ бүхэл бүтэн улсын төсвөөр жилээс жилд хийгддэг ажлаас том дүнтэй гэрээг хэн нэг компани байгуулаад нууцад авчихсан, тэгээд тайлбарлаж байгаа мэдээллүүд нь зөрүүтэй, эргэлзээтэй.

Тэгэхээр нэгдүгээрт, төмөр замынхаа 1 километрийн бодит өртгийг нь зам тээврийн агуулгыг нь Тавантолгой төмөр замын төлөөллүүд гарч ирээд яг бодит байдлаар нь хэлээч ээ. Яг 3.1 сая ам.доллар гээд түрүүнд танилцууллаа шүү дээ. Яагаад ингээд гүйцэтгэгч компани худлаа яриад байгаа юм бэ, Хоёрдугаарт, энэ сонгон шалгаруулалт явагдахдаа яагаад шууд гэрээ байгуулсан ч гэсэн холбогдох хуулийн дагуу шаардлагууд тавигддаг, 1 тэрбум долларын гэрээ байгуулсан бол 50 сая долларын гүйцэтгэлийн баталгаа гаргасан байх ёстой, энэ ажлыг гүйцэтгүүлэх туршлагатай, техник тоног төхөөрөмж, мөнгөтэй байх ёстой, тэрийгээ нотолсон бүх бичиг баримтуудыг дүгнэсэн дүгнэлтүүдийг олон нийтэд ил гаргаж тавих хэрэгтэй. Энийг яг тухайн компанийг үнэлж шалгаруулсан нөхдүүд нь энийг ил гаргаж тавих хэрэгтэй.

Мөн Бодийн Баясгалан захирал танилцуулахдаа 800 орчим сая долларын ажил гүйцэтгэсэн гэж байна лээ, 800 орчим сая долларын ажил гүйцэтгэсэн бол тэр хэмжээний 80 орчим сая долларын НӨАТ-ын татвар төлсөн байх ёстой улсад, 1 тэрбум долларын өртөг бүхий төслийг нормчлогдсон, ер нь бол тооцдог стандарт ашиглан 15 хувь байдаг 150 сая доллар ашиг олсон байх ёстой, тэрнийхээ 10 хувийн ААНОАТ-ыг улсад төлсөн юм уу? энийг бас Жавхлан сайд маш тодорхой хариулмаар байна, энэ татваруудаа энэ компани төлсөн үү, төлөөгүй бол хэзээ төлүүлэх вэ?

Гуравдугаарт, энэ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн, бас бүх данс Голомт банк дээр байршдаг гэсэн мэдээлэл байна? Голомт банкны эцсийн эзэмшигч нь Баясгалан гэж хүн өөрөө, Бодь интернэйшнлийн, бас үүсгэн байгуулагч нь Баясгалан гээд хүн байгаа, энэ бас үнэн үү? Энийг бас “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн бүрэн эрх төлөөлөгч Ганбатаас хариулахыг бас хүсье. Ингээд энэ мэдээллүүдэд маш тодорхой хариулт авахыг хүсэж байна. Тэгээд ер нь бол энэ 1 тэрбум долларын гэрээ дээр, 3.7 их наядын гэрээн дээр олон улсын аудитын байгууллагууд, татварын байгууллагуудыг оруулж шалгаад олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх хэрэгтэй. За баярлалаа.

Сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг: Тэр төмөр зам, Бодьтой холбоотой, татвартай холбоотой асуудал Сангийн сайд хариулах уу. Татварын ерөнхий газрын дарга хариулах юм уу? За Заяабал дарга. Тэгээд 108 сая долларын ханшийг олсон байх ёстой, тэрнээсээ татвар төлсөн юм уу л гээд байна шүү дээ. За.

Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал: Энэ гүйцэтгэгч компаниудтай холбоотой гэрээ ил болж байгаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Цагдаагийн дэд дарга та нар тайлбар өг дөө, яагаад дахин дахин сонсгол үймүүлээд байгаа юм бэ?

Цагдаагийн дэд дарга, хурандаа П.Оростогоо: Би одоо яг энэ хэлэлцүүлэгт анхнаасаа та бүхэнтэй хамт байгаа шүү дээ, танхим дотроо, тэгээд авсан мэдээллийнхээ хүрээнд ярьж байна. Мэдээлэл өгсөн Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга Бат-Ирээдүй тэргүүтэй эмч нар ирээд яг өөрийнхөө дүүрэг дээр болж байгаа жагсагчдын биеийн эрүүл мэндийн байдалд үзлэг шинжилгээ хийе гэсэн хүсэлт тавьсан юм байна, Ингээд хийлгэхгүй тухай асуудал ярьсан, энэнтэй холбогдуулаад цагдаагийн байгууллагаас бас дэмжлэг авсан, ийм л асуудал болж байгаа юм байна шүү дээ, ямар ч баривчилгаа

хийгдээгүй, саатуулагдсан хүн нэг ч байхгүй.

Битгий та нар үймүүлээд байгаа ч, өө тийм байхгүй наадах чинь дандаа эмнэлгийн машинууд байгаа биз дээ? Цагдаагийн байгууллага чинь өөрөө тусдаа “police” гэсэн машинтай шүү дээ, энэ арга хэмжээнд байгаа хүмүүс хэдүүлээ гараад уулзаадахья за юу? Та нар зохион байгуулалттай байна шүү дээ, бүгдээрээ гараад уулзаадахья. За ойлголоо.

Сонсголд оролцогч /нэрээ хэлээгүй/: Залуучууд өнөөдөр тайван замаар энд нүүрсний хулгайч нартай, 17 хүний нэр зарласан. Дашдаваа дарга, танай 50 хүний нэр очсон тийм ээ, Нямбаатар сайд 17 хүний нэр зарласан, үлдсэн 30, тэр 33 хүний нэр хаачихсан юм бэ? Би Сү.Батболд, Сумъяабазар, Чимэдийн Хүрэлбаатар нар.

Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал: Ил болсон 3 гэрээ байгаа. Тавантолгой төмөр замын гэрээ “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай байгуулсан гэрээ, энэ 3 гэрээ байгаа нүүрс нийлүүлэх гэрээ, ажил гүйцэтгэх 2 гэрээ байдаг Бодь интернейшнл компанитай байгуулсан 3 гэрээ байгаа. Бид нар мэдээллийг бэлтгэх шатанд ажиллаж байгаа юм, тоон мэдээллийг нэгтгэж, над дээр бол байхгүй байгаад байна, тэрийг би дараа нь албан ёсоор ил тод мэдээлье.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За Ганбат дарга, “Эрдэнэс Тавантолгой” ХК данс чинь Голомт банк дээр байдаг юм уу? Хаана байдаг юм гээд байх шиг байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК дахь Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат: “Эрдэнэс Тавантолгой” ХК Голомт, Төрийн банк, Худалдаа хөгжил гэсэн банкнууд дээр данстай ер нь орлого болон гүйлгээнүүд энэ 3 банкаар дамжаад явуулдаг, ийм байдалтай байгаа юм байна. За за боллоо, баярлалаа,

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За дараагийн хүн С.Батбаатар Иргэний зориг Ногоон намын ерөнхий нарийн бичгийн дарга.

Иргэний зориг Ногоон намын Ерөнхий нарийн бичгийн дарга С.Батбаатар: Баярлалаа, өнөөдөр энд ирсэн хүмүүст өдрийн мэндийг хүргэе. Би нэг юман дээр тодруулмаар байна. Доржханд гишүүнээс, 40 их наяд, бол 12 тэрбум гаран доллар, үнэхээр энэ яг ямар баримттай хаанаас гарч ирсэн тоо юм. Сангийн сайдын ярьж байгаагаар бол ер нь 300 хэдэн мянган тонн зүгээр, бүртгэлгүйгээр 1 сая тонн гээд. Ингээд 200 сая долларын хулгайны асуудал яригдаж байна. Таныхаар бол 12 тэрбум долларын хулгай яригдаж байгаа, энэ дээр нэг тодруулга авмаар, яг аль нь бодит тоо хэдий хэмжээний хөрөнгө бид нар хулгайд алдчихаад байгаа бэ гэдгээ тодорхой хариулаагүй шүү дээ.

Доржханд гишүүнээс энэ асуултыг асууж байгаа юм. 2-т нь 45 их наяд төгрөгийн жишээ нь борлуулалт хийчхээд 5 их наяд орчим төгрөгийн татвар авсан юм уу. Нэг, 200 хэдэн тэрбум, жилд 300, 400, 500 гээд 10-аад үлдсэн 30 хэдэн их наяд төгрөг нь олборлолтын зардал нь хэд байсан юм, тээвэрлэлтийн зардал нь хэд байсан юм. Тавантолгой ХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК ХК бараа үйлчилгээ, ажил, бараа үйлчилгээ нийлүүлсэн аж ахуй нэгжүүдийн нэрийг нээлттэй зарламаар байна.

Энэ ганцхан “Эрдэнэс Тавантолгой” ХК ч биш төрийн өмч, төрийн өмчийн оролцоотой нийт 105 аж ахуй нэгжийн бүх бараа үйлчилгээ үзүүлдэг аж ахуй нэгжүүд дээр зарламаар байгаа юм. Ямар өртөгтэйгөөр, ямар үнэтэйгээр ажил бараа үйлчилгээ нийлүүлж байгаа юм.

Нэг их наяд төгрөгийн ашигтай ажилласан гэж ярьсан. Үндсэндээ “Эрдэнэс Тавантолгой” ХК, Оюу Толгой гэсэн хэдэн компанид ашигтай болохоос биш төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой бусад бүх аж ахуй нэгж нь алдагдалтай ажиллачихсан шүү дээ. Тэгээд энэ ашиг нь хаашаа орчхов гээд судалж үзсэн юм. Дандаа ажил, бараа үйлчилгээ маш өндөр өртгөөр нийлүүлдэг, 2016 онд төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжүүд 10.8 их наяд төгрөгийн өр зээл алдангитай байсан бол өнөөдөр 18 их наяд гаран төгрөгийн өр зээл алдангитай байна. Энийг нээлттэй тавих боломжтой юу гэж Шадар сайд, Сангийн сайд 2-оос асуумаар байна.

Төрийн өмчит болон Төрийн өмчит хувьцаат компаниуд аж ахуй нэгжүүд бараа үнэгүйдүүлдэг бүх аж ахуй нэгжүүдийг нээлттэй тавих, ямар үнээр, ямар өртгөөр бараа үйлчилгээ нийлүүлсэн, энэ хугацаанд ямар хүн, цаана нь ямар эзэд байдаг юм, энийг яагаад асууж байгаа юм гэхээр өнөөдөр Монгол Улс бол бүх өмчөө төрийн өмч гээд өгчихсөн, тэгээд бодоод үзэхээр төр гэж яг хэн юм бэ гээд бодохоор үндсэндээ бол ялсан нам. Та нар сайн бодоод үзээрэй, Улсын Их Хуралд олонх болсон нам Засгийн газраа байгуулдаг, сайд, дарга газар, хэлтсийн даргаар томилдог, дээр нь төрийн өмчит аж ахуй нэгжүүдийн захирлуудыг томилдог, төрийн өмчийн болон аудит, бүх байгууллагын удирдлагуудыг Улсын Их Хуралд томилдог гэдгийг бид нар бүгд мэдэж байгаа. Одоо иргэдэд 100 мянга төгрөгийн, сонгуулийн саналыг нь худалдаж авах, мөнгө тараад 200000 төгрөг тараадаг гээд бодохоор дунджаар 5-10000 хүнд тараахад сонгуульд ойролцоогоор 1-2 тэрбум төгрөгийн зардал гаргадаг, ийм их хэмжээний зардал гаргачхаад 1 сая гаранхан төгрөгийн цалин аваад, шударгаар хууль батлаад суучихъя гэж бодож байна уу? ёстой тийм хайр гэж байдаггүй байхгүй юу. Энэ мөнгийг яаж олж авдаг юм гэхээр нөгөө эзэн биегүй зүйлдээ бид нар бүх өмчөө өгчихсөн, тэр өмчид ерөөсөө бараа үйлчилгээ, ажил үйлчилгээ нийлүүлэх замаар энэ мөнгийг олж авдаг, тэрнээс биш тэр их мөнгийг зарлаж байгаад л сард сая гаран төгрөгийн цалин авчихаад суучихсан, тийм учраас энэ төрийн өмч болон төрийн өмчийн оролцоотой бүх аж ахуй нэгж дээр шалгалт оруулахыг бид 2017, 2018 ондуудад удаа дараа шаардаж шаардлага өгч байсан Иргэний зориг намаас. Энэ “Эрдэнэс Тавантолгой” ХК бол өчүүхэн хэсэг нь цааш нь энэ бүх төрийн өмчит аж ахуйн нэгж дээр шалгалт хийгээд үз. Яагаад алдагдалтай ажиллаад байгаа юм, асар их тоо гарч ирж байгаа. Бидний гадаадад байгаа гучин хэдэн тэрбум долларын өр бол цаашаа. Тийм учраас энэ дээр шалгалт хийхээр энэ ажлын хэсгийг яаралтай байгуулаад, мэдээллийг нь нээлттэй тавиад өгөөч, хэн гэдэг ямар хүнийг, ямар компаниуд мөнгө угаагаад байгаа юм гэдгийг нь нээлттэй тавимаар байна. За баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Ганбат дарга хариулах уу? Бараа бүтээгдэхүүн худалдаж авсан аж ахуй нэгж байгууллагуудыг ил тод болгох тийм боломж байна уу. Бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ худалдан авалтын ажлын хэсгийн байгуул, ил тод болго, худалдан авах ажиллагааны талаар.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн худалдан авах ажиллагааны газрын дарга Н.Цэрэнсамбуу:

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн худалдан авах ажиллагааны талаар мэдээлэл өгье. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар зохион байгуулагдаж байгаа бүх тендер, шалгалтуудын урилга, үр дүн, гэрээний мэдээллийг худалдан авах ажиллагааны цахим систем, tender.gov.mn цахим систем дээр бол байршуулдаг, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьд бол мөн хуулийн дагуу зохион байгуулагдаж байгаа тендерүүдээ бүх гэрээ, гэрээ дүгнэсэн актын мэдээллүүдийг эх хувиар нь оруулчихсан байгаа. Энэ мэдээллүүдийг иргэд олон нийт бүгдээрээ орж үзээд нэгжийн үнэ нь ямар байна, зах зээлийн бодит үнээс өндөр байна уу, үгүй байна уу гэдгийг хянах бололцоог нь бол бас бүрдүүлчихсэн байгаа, бүгдээрээ орж үзээрэй гэж хэлмээр байна. За

товчхондоо бол өнгөрсөн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд бол 3.4 их наядын 686 ажил байсан, гэрээний үнийн дүн бол 2.5 тэрбум, гол эзэлж байгаа үнийн дүнг бол гэрээт олборлогчдын зардал дээр яг энэ төслүүд явж байгаа юм байна гэдгийг бас та бүхэн өөрсдөө ороод үзэх боломжтой, бүх гэрээ нь ил байгаа гэж хэлье.

УИХ-ын гишүүн С.Доржханд: За баярлалаа болох уу? За би маш товчхон хэлье, маш олон хүмүүс асуугаад байна, 40 их наядын тоо бодитой юм уу, өөрөөс чинь болоод маш олон хүмүүс талбай дээр гараад ирлээ гээд. Үнэн, үнэн. Гарч ирсэн нь сайн, гарч ирсэн болохоороо өнөөдөр бүгдээрээ хуралдаж байгаа, гарч ирсэн болохоор энэ оффтэйк гэрээнүүд нууцаас гарсан шүү. Тийм болохлоор энэ бол үнэн, 2 дахь нь 125 сая төгрөг хүн болгонд өгнө, 40 их наяд чинь та гаргаж ирснээс боллоо гээд яриад байх шиг байна. Тоогоо бодоод сурчих л даа. 40 их наядыг чинь 3.4 сая хүндээ хуваах юм бол 11.7 сая төгрөг юм. 440 их наяд гээд хүмүүс хөөсрүүлээд санаатай, санамсаргүйгээр тоог нь өсгөчихсөн шүү. 440 их наядыг 3.4 сая хүнтэй хуваах юм бол 125 сая төгрөг шүү. Тэр эзнээ та нар олоорой харин. Одоо энэ бодитой юм уу, бодьгүй юм уу гэдгийг хэлье. Бид нар тооцооллоо гаргаад мэргэжилтнүүд нь шүү дээ, би чинь бас санхүүч шүү дээ. Монгол Улсын Сангийн яаманд 15 жил ажилласан юм. Олон улсын санхүүгийн байгууллагад 5 жил ажилласан мэргэжилтэн хүн. 40 их наяд төгрөгийн орлогоо бид нар алдчихсан шүү. 40 их наяд төгрөгийн орлого алдсан ганцхан жишээ хэлье.

Сүүлийн 10 жилийн хугацаанд нүүрснээс, нүүрсний салбараас, Монголын нүүрснээс урд хөршид долларын тэрбумтан 7 төрчихсөн байгаа юм байна, бодитой шүү. Зөвхөн нүүрснээс нэг хятад хүн, тэрбум доллар хамгийн бага мөнгө олсон гэдэг чинь энэ чинь өөрөө хорь гаруй их наяд төгрөг шүү, энгийн жишээ. За тэгэхлээр бид нар ийм хэмжээний мөнгөө алдчихсан. 40 их наядын орлогоо бид нар алдчихсан, энэ мөнгө чинь доллароор орж орж ирэх ёстой байсан алдчихсан, яагаад гэвэл ам нөхцөлөөр бид нар хямдхан зараад байгаа байхгүй юу. Гэтэл хувийн сектор нь болохоороо цаашаа хилрүү гарч зараад байдаг “Эрдэнэс Тавантолгой” ХК болохоороо амнаасаа хямдхан нүүрс өгөөд байдаг хятадууд л тэгж авдаг юм чинь гэсэн ийм буруу тогтолцооноос чинь болоод алдчихаад байгаа юм. Харин үүнд ногдох бид нарын мөнгө энэ бол татварын мөнгө юм. АМНАТ буюу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, нэмэх нь аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татвар буюу үүнд ногдох нь 10.8 их наяд төгрөг бол бид нар төсөвтэй авах ёстой байсан мөнгө юм.

Харин 40 их наядтай тэнцэх доллар чинь өнөөдөр Монголын нутаг дэвсгэрт орж ирчихсэн байх ёстой, тэгсэн бол бид нар ханшаа алдахгүй байсан юм, тэгсэн бол өнөөдөр инфляцаа бас барих байсан юм. Тухайлбал баталгаажуулаад 2 хүн хэлсэн шүү. Нэг нь бол Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ гэдэг нэг хүн 4 сарын 6-нд бүх хэвлэлүүдийг суулгаж байгаад сүүлийн 10 жилийн хугацаанд бид нар нийт эдийн засагтай тэмцэх хэмжээнийхээ орлогыг алдчихаад байна. Сүүдрийн эдийн засаг, Сангийн сайд, Засгийн газрууд нь баталгаажуулаарай, дөнгөж саяхан долоохон хоногийн өмнө Сангийн сайд таны өгсөн мэдээлэл бол хилийн цаана бид нар нэг жилдээ 1.1-ээс 1.5 тэрбум доллар алдчихаад байгаа юм гээд. Энэ бол алдагдсан боломж биш шүү. Төмөр замаа тавьсан бол бид нар 8 доллараар хийх байсан, хамгийн муу шийдвэрээс болоод бид нар тэр боломжоо алдчихсан юм. Үнэн. Ковидын үеэр бид нар Австралийн нүүрс хаалттай, Орос хаалттай. Яг ийм үед ганцхан Монгол байсан. Индонез хаалттай энэ үед бид нар нүүрсээ төмөр зам тавьчихсан бол бүр асар их мөнгө олох байсан юм, алдчихсан юм 10 жил алдчихсан юм тэр шийдвэрийг гаргасан, өнөөдөр зугтаачихсан байгаа үнэн. Харин өнөөдрийн миний яриад байгаа юм бол алдагдсан боломж өртэй биш өнөөдрийн тогтолцоогоор бид нар ийм хэмжээний орлого алдчихсан байгаа юм. Энэ бол зөвхөн нүүрсэн дээр шүү. Одоо бүгдээрээ зөвхөн нүүрсэн дээрээ төвлөрч байгаа энэ хулгайныхаа асуудлын ард нь гарья. Тэгсний дараа өөр асуудлууд бас байгаа гэдгийг хэлчихье. Тэгээд сонирхсон хүмүүс бол ХҮН НАМ.mn гэсэн пэйж дээрээс бүх мэдээлэл, тооцоолол байгаа шүү. Баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За баярлалаа За одоо П.Өлзийнаран. “Мон Эн Ко” ХХК-ийн төслийн инженер. За алга. Тэгвэл Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хороо, Б.Батзориг за алга байна. Баянгол дүүргийн иргэн Ц.Одонтунгалаг байна уу.

Сонсголд оролцогч, иргэн Ц.Одонтунгалаг: За юуны өмнө хэлэлцүүлгийг зохион байгуулсан хүмүүст бас талархаж байгаагаа илэрхийлье. За тэвчээртэй өнөөдрийг одоо яг энэ цаг хүртэл хүлээцтэй суусан Улсын Их Хурлын гишүүд, иргэд, төрийн албан хаагчдаа бас иргэдээ хүндэлж байгаад нь бас талархаж байна. За өнөөдрийн энэ хэлэлцүүлгээс олигтой үр дүн гарахгүй гэдгийг маш олон хүн хэллээ. Үнэхээр нөхцөл байдлыг харж байхад тийм байна ямар ч байсан хуулийн хүний хувьд хэлэлцүүлэгтэй холбоотой гараад байгаа хулгай дээрэм, булхай бүхнийг одоо хуулийн байгууллага нь шалгаж байгаа юм байна. Хуулийн дагуу шалгаж байгаа юм байна. Мэдээж хуулийн дагуу шалгахад тодорхой хугацаа шаардагдаж байгаа юм байна гэдгийг нь ойлголоо. За ингэснээр энэ асуудал яг хуулийн байгууллагаас шалгаснаар шийдэгдэнэ гэж бас итгэл төрөхгүй байна.

Өнөөдрийн энэ хэлэлцүүлэгт иргэд гадаа жагсаж байгаа их хулгайг одоо эсэргүүцсэн ард түмэн нь нийлээд гадаа жагсаж байгаа. Гэтэл энэ ард түмнийг төлөөлж бүгдийг нь чиний өмнөөс төр энэ Монгол төрийг удирдана, та нарыг төлөөлж удирдана гэсэн УИХ-ын гишүүд, дүүрэг, Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгчид нэг ч хүний талбай дээр гарч ирэхгүй байна, энэ хүмүүс ард түмнийг төлөөлж энэ төрийн үйл хэрэгт оролцох ёстой, гэтэл өнөөдөр нэг ч хүн байхгүй, энд хэдхэн Улсын Их Хурлын гишүүн сууж байна. Тэгэхээр юуны өмнө энэ Улсын Их Хурлын гишүүд нь төрийг төлөөлж байгаа иргэдийг төлөөлж байгаа, төлөөлж төрд сууж байгаа хүмүүсээ үйл хэрэгтээ идэвхтэй оролцооч, ирж гарч ирж, ард түмнийхээ байгаа байдлыг одоо төрдөө дамжуулж өгөөч гэж хэлмээр байна. Хүмүүс чинь та нараар дамжуулна гэж сонгож гаргасан юм байгаа шүү дээ. За дээрээс нь ҮАБЗ-тэй холбоотой гэрээнүүд яриад байх юм. Энэ гэрээ оффтэйк гэрээнүүдээс хэд нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжтэй гэдгийг асуумаар байна, хэдэн зүгээр энгийн гэрээ вэ, ер нь бол энгийн гэрээ ч оффтэйк гэрээ байж болдог гэж би сонссон.

Бүх гэрээнүүд Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжтэй юм уу, үгүй юм уу гэдгийг асуугаад асуух хэрэгтэй байна. За ганцхан нүүрсний гэрээнээс гадна маш олон гэрээ тендерүүд байгаа, төсвийн хулгай байгаа ЖДҮ хулгай, Хөгжлийн банк, дээрээс нь төсвөөс хийгдэж байгаа бүхий л тендерээр хийгдэж байгаа ажил бол хулгай байгааг мэдэж байгаа, тэгэхээр нефть, зэс юу байдаг юм, бүх юман дээрээ хяналт тавьж ажилламаар байна УИХ-ын гишүүд ээ, та бүхэн энд хууль хэрэгжүүлж, хуулийнхаа дагуу бүх үйл ажиллагааг явуулж, Монгол Улсыг хөгжүүлэх бодлогыг гаргаж, ингэж ажиллах үүрэгтэй хүмүүс. Гэтэл ордон дотроос дандаа буруу болохгүй бүх юмыг эндээс бид нар сонсох юм. Энэ байдлаа засаач, эр эмгүй Улсын Их Хурлын гишүүн болохоороо нөхөр, хүүхдээсээ салаад явчих юм, дандаа болохгүй бүх асуудлыг Улсын Их Хурлын гишүүд маань гаргах юм. Бид нар яаж та нарт итгэх юм бэ. Тийм учраас эндээсээ өөрсдийгөө өөрчилж, засаж эхлээч гэж хэлмээр байна.

Үндэсний аюулгүй байдлын гишүүн, Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ УИХ гишүүн Сү.Батболд, нарыг ард түмнээ төлөөлсөн том сонсголд оролцохгүй байгаад үнэхээр харамсаж байна. Энэ хүмүүсийг байсан бол сонсгол бас шал өөр болох байсан. Яг шийдвэр гаргаад асуудлыг шийдэх хэмжээний хүмүүс нь байхгүй байна, тийм учраас энэ сонсгол үр дүнгүй болох нь тодорхой харагдаж байна.

Өнөөдрийн хулгай бол яалт ч үгүй МАН-тай холбоотой, яагаад гэхээр төр барьж

байгаа бол хариуцлагаа хүлээх хэрэгтэй. Ардын нам, Ардчилсан Нам гээд хэн нэгэн хүн рүү зүтгүүлээд байж болохгүй ээ, дотроосоо нэг хүн буруутай байх юм бол нам дангаараа хариуцлагаа хүлээгээд явах хэрэгтэй, иргэд хэлж байна, 17 хүний нэр зарлаж байгаа бол зүгээр л нэг жараахай гэдэг шиг юмыг хаах гэсэн ийм байдал харагдаж байна. 50 хэдэн нэрс ирсэн бол АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР нь зарлаач, хуулийн дагуу шалгана гэдгээ бас хэлээч гэж хэлмээр байна. За би ингэж сонссон байгаа, хариулт авмаар байна. Монгол Улсад ганцхан оффтэйк гэрээ, “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас гадна маш олон уурхай байдаг гэж байгаа юм. Уурхайнуудын баялгийг хэн идээд байгаа юм бэ. Хэдхэн гэр бүл баяжаад суудаг Монгол баялагтай байгаад яах юм бэ. Бид нар баялгийнхаа эзэн болмоор байна шүү дээ. Тийм учраас уурхай дээр 2 улсын үйлдвэр дээр улсын уурхай дээр тавьж байгаа шиг шаардлага тавиач хяналт тавиач. Нэг гэр бүлд нэг уурхайг авчхаад, насаараа баян тансаг, Монголд ч байхгүй амьдралтай байх ёстой юм бэ. Бид нар яахаараа ядуу тарчиг, өр зээлэндээ баригдаж байх ёстой юм бэ. зохицуулаагүй учраас та нар буруутаад байгаа юм шүү гэдгийг хэлмээр байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай холбоотой хүн хэлж байсан нүүрсний хулгай чинь ерөөсөө хил гааль дээр байдаг юм гэж. Гаалийн татвар төлөхгүй, гаалийн бүрдүүлэлт хийхгүй гардаг, энд хулгай явагддаг юм. гаалийн байцаагч нар 20 мянган тонн байвал 2 мянган тонн гэж бичиж байгаад, өөрсдөө хахууль аваад гаргаад байгаа, энд чинь л зөрүү мөнгө харагдаад байдаг юм.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За Ганбат дарга хариулах уу? гэрээнүүд чинь хэд нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжтэй юм гээд байх юм. Хэн хариулах вэ? Жавхлан сайд уу, УАБЗ-ийн зөвлөмжтэй хэдэн гэрээ байгаа хэдэн зөвлөмжгүйгээр байгуулсан гэрээ байх юм гээд байна шүү дээ.

УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан: За би өөрийнхөө мэдээллийн хүрээнд хариулья. “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр бол байхгүй юм байна. Засгийн газрын хуралдаанаар оруулаад нууцалж байсан оффтэйк гэрээнүүдийг ил болгоход энэ асуудал бол яригдсан байгаа. Тавантолгой - Гашуун сухайт, Богдхан төмөр зам, 2 гэрээ, сүүлийнх нь 3 гэрээ байгаа. мэдээж зөвлөмж байгаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За баярлалаа. Сонгинохайрхан дүүргийн 27 дугаар хорооны иргэн Ц.Баттулга гэж байна уу. та нэгдүгээр микрофон дээр.

Сонсголд оролцогч, иргэн Ц.Баттулга: За оройн мэндийг хүргэе. хууль баталдаг Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэг, Хяналтын хороо гэж юм байна. хуульд нэг л юм байна, илрэхгүй ба авсан өгсөн хоёуланг нь шийтгэдэг юм байна. Шинэ хуулиар 12 жилийн ял авахаар оруулчихсан юм байна. Жишээлбэл: Би хүнээс авлига авсан, бол тэр хүн хэлэхэд би 12 жилийн ял авах юм байна шүү дээ. Ийм хууль гэж хаашаа юм байдаг юм бэ, эсвэл тэр өгсөн хүнээ шийтгэдэггүй болгож өгөө. Тэгж байж авлигын чинь эзэн тодордог баримт тодордог байхгүй юу. Хоёуланг хийчихээр чинь хэн хэнийгээ хэлэх юм бэ. Засгийн газар гараад явчих гээд хэлээд зохион байгуулаад байгаа. Улсын валютын сан 2021 оны 9 сард бүх юмыг нь гаргаж ирчхээд энэ хулгай байна гээд хэлээд явчихсан шүү дээ, дүгнэлт байна шүү дээ. Тэгээд өнгөрсөн жил өгөөд Зам, тээврийн сайдын хэлснээр 280 сая тонн нүүрс гаргачаж байгаа юм байна, Би өөрөө барилгын төсөвчин хүн байхгүй юу. Ахмад уурхайчин болон тэтгэврийн хүн байна. Төсөв хөрөнгө бодоод үзсэн чинь 940 тэрбум төгрөг болж байгаа юм байна Өнөөдрийн байдлаар гаргасан нүүрс 940 тэрбум төгрөг. Гаалийн газрын тайлан дээр гарсан байна. би энэ 2 тоог нь ярих гэж байна шүү дээ. 186 мянган тонн нүүрс гаалийн бүрдүүлэлтгүй гарсан илтгэл дээр гарч байна. энийг бодоод үзлээ мэргэжлийн хүний хувьд. 37.9 их наяд төгрөг алга болчихсон байна. Томилдог дарга нар, томилдог нэр бусад нь хаа байна. Энэ тайлан дээр чинь хаа байлаа. Засаг барьж байгаа та нар чинь улсуудаа томилчихоод байна, тэр улсуудтайгаа хариуцлага тооцоо л доо. Угаасаа хар тамга та бүхэн дээр дарсан шүү дээ. Энэ хэдэн хүүхдүүдийг өрөвдөж байна. Бид нарын үеийн

улсууд ч хэдэн хүүхдүүдийнхээ эрүүл өсгөхөд л ажил амьдралаа зориулсан шүү дээ.

Түрүүчээс нь юу бодож байна. Тийм ээ, энэ хүүхдүүд чинь бидний хэнийх нь ч бай ялгаа байхгүй. Хүүхдүүдийг чинь бид эрүүл энх, эрүүл саруул хүүхэд болгоход чинь бид нар амьдралаа зориулсан шүү дээ. Тэгээд энэ дээр одоо тэр цагдаагийн газрын дарга улсууд бодох хэрэгтэй биз дээ. Энэ төр нь бодооч. Тэгээд л залуучуудаа 20-30 хоног, энэ хүйтэнд байлгаж л байдаг. Энэ төр хариуцдаг улсууд энийгээ хариуц. Хүний эрүүл мэнд, хүний эрх бүгдийг нь хүндээ ээлтэй болго. Түрүүний тэр асуултыг би асуугаад байгаа. Энэ 37 тэрбум 913 сая 760 мянган төгрөг хаягдсан байна. Энийг чинь сая гаалийн тайлан дээр хяналтгүй, бүрдүүлэлтгүй гарсан гэж бичсэн байна. Энэ жил 94 тэрбум 120 сая төгрөгийн нүүрс өгөхөөс энэ мөнгө нь орж ирсэн үү Сангийн сайд аа, би танаас л асуух гэсэн юм. Энэ тайлан дээр байна л даа 28 сая. Энэ нь 94 тэрбум 920 сая төгрөг, энэний хэдэн хувийнх нь мөнгө нь орж ирсэн юм. Одоо бид нар шиг тэтгэврийн хүн дээр хэд нь ирэх юм бэ. Тэр 37 тэрбум ямар компанид байгаа юм, гаалийнхан орж илрүүлсэн юм байна. Тэр 18 сая 614 мянган тонн нүүрс яриад л байна. Тэгээд хууль чинь авлигатай тэмцэнэ гэгчхээд авсан, өгсөн хоёуланд нь 12 жил өгнө гэж байгаа юм. Би л хүнд өгчхөөд дахиад 12 жилээр яллуулахгүй шүү дээ. Ийм балай юм хийчхээд тэгээд энэ чинь яаж илрэх юм. Хулгай чинь, хууль чинь хуудуутай юм их байна. Их Хурлын гишүүд ээ, энийгээ зас. Тэр хөөн хэлэлцэх хугацаа больчихсон гээд аягүй цэвэрхэн юм яриад байгаа. Худлаа хоёуланг нь шийтгэх юм байна. Үнэнийг хэлсний төлөө би 10 жилийн ял авах ёстой юм уу. Нөхөр тэр авлига авсан, би өгсөн гээд. Ийм балай хууль гаргаж байгаа боль л доо. Би иргэн хүний хувьд, ахмад хүний хувьд хэлж байна. Баярлалаа.

УИХ-ын гишүүн С.Одонтуяа: Б.Жавхлан сайд хариулчих уу, иргэн Ц.Баттулгын асуултад.

УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан: Саяын хүнд баярлалаа, наадахын чинь учрыг олох гээд бид нар ингээд ажиллаад байгаа шүү дээ, эцсийг нь хүртэл явна. Наад асуудлууд чинь өнөөдөр гарч ирж байгаа юм биш. 2019 он хүртэл гаалийн байгууллагын дотоод хяналтаар илэрсэн зөрчлүүд. Баримт факттай баримтжуулчихсан, эдгээрийг бүгдийг нь тухайн үед хуулийн байгууллагад өгсөн. Одоо шалгаж байгаа гэж би ойлгож байгаа. Удахгүй ил болох байх. Ил болохоор нь хоёулаа тэр тоог зэрэг мэдэж авах байх. Би ч бас тэр тоог бүгдийг нь хэлж мэдэхгүй байна. Та орж ирсэн үү, үгүй юу гээд тэр борлуулалтын орлогыг нь ярьж байна уу даа. Борлуулалтын орлогын хувьд бол амнаасаа зарсан бол ороод ирчихсэн байгаа. Тэр 45 их наяд гэдэг чинь бол яг амнаасаа зарсан 336 сая тонн нүүрс, Монгол Улсын экспортод орж ирсэн орлого нь тийм байгаа. Харин тээвэр дээр бол өөр шүү, тээвэр дээр нь ийм нюанс байгаа юм. Манай тээвэр хийж байгаа нийт компаниудын ер нь 10 хувь нь хятад эзэнтэй, монгол хүний нэр дээр бүртгэлтэй. Нүүрс худалдаж авч байгаа нь урд зүгийн иргэн, тээвэрлэж байгаа нь мөн урд хөрш.

Энэ хүмүүс хилийн цаана хоорондоо түлхүү тооцоо хийж байна. Тээврийнхэнтэй, тэгээд мөнгөө үүрж орж ирээд, Монголд бүртгүүлээд, татвараа төлье өө гэсэн тийм юм бол тэнд хэзээ ч явагдахгүй. Тэгэхээр үүний шийдэл нь юу вэ гэхээр ерөөсөө л бид нар бирж дээрээ бүх Монголын баялгийг хил үнээр хатуу борлуулах шийдлийг одоо бид нар Их Хурал дээр ярьж байгаа. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль гээд Улсын Их Хурал маань энийг маш сайн дэмжиж байгаа. Энэ харин нэлээн бас тийм эсэргүүцэлтэй тулгарах шинжтэй байна. Энэ зөв, зүгээр явахгүй л дээ. Гэхдээ нэг өдрийн дотор энэ рүү бид бүрэн шилжиж чадахгүй. Бидэнд бас тодорхой хугацаа хэрэгтэй. Өмнө нь хийгдчихсэн байгаа, хатуу олон улсын гэрээнүүдийг бид шууд цуцлаад дуусгаж чадахгүй. Бүгдийг нь гэрээнийхээ нөхцөлийг сайжруулах замаар гээд аятайхан дуусгачихыг хичээж ажиллаж байгаа. Ийм байдлаар л бид эдийн засгийн аргаар нь, өөрийнх нь зах зээлийнх нь аргаар, болохгүйг нь хуулийн байгууллага руу нь шилжүүлээд хамтдаа үр дүнг нь харна л гэж бодож

байгаа шүү.

УИХ-ын гишүүн С.Одонтуяа: Г.Уянгахишиг Хүн нам, Уянгахишиг байхгүй байна уу. Байхгүй юм байна. Гишүүдээс УИХ-ын гишүүн, Одонгийн Цогтгэрэл, АН-ын бүлгийн дарга.

УИХ-ын гишүүн, АН-ын бүлгийн дарга О.Цогтгэрэл: Үдэш болтол нээлттэй сонсголд идэвхтэй оролцож байгаа оролцогчдод талархлаа илэрхийлье. Монголчуудын сүүлийн үеийн түүхийн 30 жилийн идээ бээр бас энэ хүрээд задарч байна. Бид нар 30 жилийн өмнө иргэний эрх, иргэний бизнес, төвлөрсөн бус эдийн засаг руу гэдэг энэ тогтолцоо руу шилжсэн. 30 жилийн дараа эргээд харахад төржсөн эдийн засаг, халамжийн тогтолцоо, дарга анги ийм л зүйлтэй, эргээд бараг 30 жилийнхээ өмнөх нөхцөл байдал дээр оччихсон. Эдийн засагт эзэлж байгаа төсвийн хэмжээ, эдийн засагт эзэлж байгаа ТӨК-иудын хэмжээ ямар байдалд хүрдгийг нөхцөл байдал одоо харуулж байна. Яг одоо бид нар бас бүгдээрээ бараг мэдэж байгаа, дарга гэж байгаа тэр хүмүүс зөвхөн цалингаараа амьдардаггүй бүхэл бүтэн давхарга байгаа яг үнэнийг хэлэхэд. Энд байгаа төрийн албан хаагч, ихэнх нь сая төгрөгийн цалинтай, УИХ-ын гишүүн хоёр сая төгрөгийн цалинтай. Яг үнэндээ цалингаараа амьдардаггүй шүү дээ. Энийг бид нар бүгдээрээ мэддэг. Энэ идээ бээрийн нэг хэсэгт энэ бас очиж задрах ёстой. Тэр төрийн өмчит компаниуд байж байна. Зөвхөн Тавантолгой дээр ярья, 2011 онд байгуулагдсан компани, анхны захирал нь гадаадад зугтаж яваа, 2 дахь захирал нь шоронд орсон, 3 дахь, 4 дэх Ариунболд, Ганхуяг гээд өөр захирал нь шоронд орчихсон. Улс төрийн томилгоогоор захирлууд тавьдаг тэдгээр нь шоронд ороод дамждаг, цаана нь улс төрчид нь үлддэг энэ тогтолцооны идээ бээр бас л задрах ёстой. Олон олон зүйлүүдийг бид нар энэ дээр ярьж болно. Одоо зөвхөн энэ худал хулгайн тухай ярьж байна. Энэ оффтэйк гэрээ, нүүрсний гэрээ, нүүрсний хулгай, мөргөцөг гээд олон тал руу салаад байх шиг байна. Миний бодлоор бол энэ хулгайг хоёрхон зүйлд л ангилж болно. Хуулиар хийж байгаа хулгай, хуйвалдаанаар хийж байгаа хулгай. Хуулиар тэгвэл яаж хулгай хийж байгаа юм. Би зөвхөн сүүлийн гуравхан удаагийн түүхийг л ярьчихъя. Арилжааны банкаар дамждаг байсан зээлийг хуулийг нь өөрчлөөд журмыг нь өөрчлөөд яамны сайд өгдөг болоод ЖДҮ-гийн хулгай гэж гарсан, энэ яасан, хуулийн хулгай. УИХ-аар төсөл хөтөлбөрүүдийг баталдаг байсныг ТУЗ нэртэй тавиулуудаар баталдаг болоод Хөгжлийн банкин дээр хулгай гарсан. Энэ бол хуулийн хулгай. Одоо дахиад энэ нүүрсний хулгай гарч байна, энэ яасан юм шат шатанд нь нууцалсаар байгаад сонгон шалгаруулалтгүй, хэн нэгэнд давуу тал олгодог, гэрээ хийдэг. Энэ бол дахиад хуулийн л хулгай. Хуулийн хулгайг хэн хийдэг юм, эрх барих эрх мэдэлтнүүд л хийнэ. Хуулийн хулгайг эрх мэдэлтнүүд хийж байгаа, за тэгээд бараг илрэхгүй дээ. Хуйвалдааны хулгай гээд хэдэн хүн, тэр нэг жолооч, тээвэр гээд хэдэн хүнийг шоронд хийгээд л дуусах биз, тэрүүгээрээ шонд өлгөхийг зорьж байгаа биз? нэг ийм л нөхцөл байдалтай. Тэгээд энд иргэд үг хэлж байгаа болохоор надад хоёрхон асуулт байна. Хоёрхон асуудлыг хоёр газрын дунд тавьчихъя. Эхлээд АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР, Улсын Ерөнхий прокурорын газар хоёрын дунд нэг асуулт байна. Та нар тэр микрофон руу бас дөхөж байгаарай. Сая Улсын Их Хурал дээр Эрүүгийн хуулийг баталсан, хялбаршуулсан журмаар шийдэхгүй гэж. Аливаа зүйл бас 2 талтай, энийг нийтээрээ л алга ташаад хүлээж авах шиг болсон. Хялбаршуулсан журмаар шийдэхгүй болохоор нөгөө хуйвалдсан хүмүүсээ, нөлөөлсөн хүмүүсээ, тэр хулгайг хамтран хийсэн хүмүүсээ шоронд байгаа Ганхуяг гэдэг нөхөр чинь хэлэхгүй. Яагаад гэвэл Эрүүгийн хуулиар тэртэй тэргүй хоригдох ялтай. Харин олон хүний нэр хэлэх тусам зохион байгуулалттай хам хэрэг учраас ял ихэснэ, ийм учраас Ганхуяг одоо бараг хүний нэр нэрлэж чадахгүй ийм нөхцөл байдал үүсэж байна гэж бас хуулийн салбарын зарим хүмүүс хэлж байна. Энэ дээр Авлигатай тэмцэх газрын төлөөлөл, прокурорын төлөөлөл хоёр энэ зүйл заалт дээр бас тодорхой байр сууриа хэлж өгөөч. Хэрэг илрэх магадлалыг тэр оролцогчдын тоог чинь бараг зохион байгуулалттайгаар дахиад хуулийн хулгай хийж хумьж байгаа юм биш шүү. Нэгдүгээрт нь, хоёрдугаарт нь “Эрдэнэс

Тавантолгой” ХК, Бодь компани хоёрын төлөөлөл дундаас нэг асуулт асуух гээд байгаа юм. Яаж яваад энэ гэрээ нь нууцлагдчихваа. Ер нь энэ гэрээ нууц байгуулсан учраас шууд гэрээ хийсэн юм уу? шууд гэрээ хийх шаардлагатай, хүсэлтэй байсан учраас энэ гэрээг нууцалсан юм уу гэдэг үндсэн асуултад бид нар хариулах ёстой. Өрсөлдөгчгүйгээр шууд гэрээ хийх хүсэл төрсөн учраас нууцалчихсан юм уу? Тэгэхээр энэний тогтолцоо нь саяны хоёр газар дээр би байна гэж үзээд байгаа юм. Өчигдөр тэр Бодь компанийн захирлын ярианд ч тэр, Тавантолгойн танилцуулга дээр ч тэр байна. Засгийн Газраас оффтэйк гэрээ байгуулах чиглэл ирсэн. ТУЗ-д эрх олгогдсон учраас ТУЗ Бодь компанитай гэрээ байгуулсан гэж байгаа юм. Тэгээд ер нь Бодь, Тавантолгойн ТУЗ, Ганхуяг эд нар яаж яваад уулзсан юм бэ? Гудамжинд явж байгаад таардаг юм уу? Тавантолгойн ТУЗ-аас Бодь компанид нэг цаасаар санал өгдөг юм уу? Хаалттай тендер зарладаг юм уу?

УИХ-ын гишүүн С.Одонтуяа: За хариулъя. “Эрдэнэс Тавантолгой” ХК байна уу? Ганбат дарга хариулчих, бүрэн эрхт төлөөлөгчөөр томилогдсон. Дараа нь прокурор, АТГ.

“Эрдэнэс Тавантолгой” ХК дахь Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат: Ил болгосон 7 гэрээний 5 нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар дээр тухайн төслийг хэрэгжүүлэх, төмөр замын төслийг явуулах нь зөв гэдэг шийдвэрүүд нь дээд түвшиндээ гарсан юм байна. Тэгэхээр энэ төслүүдийг явах нь зөв юм гэдэг байдлаар шийдвэр нь дээд түвшиндээ гараад хэрэгжүүлэхдээ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн тухайн үеийн захирал Бодь компанитай хийсэн. Яагаад Бодийг сонгосон гэдэг талаар надад мэдээлэл алга байна. Яг нөгөө сүүлийн 6, 7 дахь 2 гэрээ байгаа юм. Нэг нь усны төсөл, нөгөөдөх нь тэр далд уурхайн геологи хайгуул судалгааны гэсэн 2 төсөл. Үүнийг компаниас санал болгоод тендергүйгээр шууд худалдан авалт хийх байдлаар өөрсдөө хүсэлт гаргаад шууд гэрээ хийх зорилгоор тэрийгээ нууцад хамааруулчихсан. Үүний талаар би түрүүнд бол мэдээлэл өгсөн, Далд уурхайн тэр геологи, хайгуул судалгааны ажлыг нь зогсоочихсон, нээлттэй сонгон шалгаруулалт явуулж ил тод явах нь зөв гэдэг ийм байр сууринаас ажиллаж байгаа. ТУЗ дээр ТУЗ-ийн шийдвэр, ТУЗ-ийн ажлын алба нь бол тусдаа. Би юмнуудыг нарийн бол үзээгүй, За одоо тэрүүн дээр танилцаад яах вэ, нэгэнт ийм шийдвэр гарсан гээд эрх олгох байдлаар юмнуудаа танилцуулаад тэгээд хийсэн гэдэг. Яг тэр ТУЗ дээрх нарийн мэдээллийг нь бол мэдэхгүй. ТУЗ дээрээ бол танилцаад ингэчихсэн, Оффтэйк гэрээний 5 гэрээтэй асуудлын талаар тайлбараа хэлчихсэн, тэрийг нь бол ТУЗ-аас тодруулах хэрэгтэй. ТУЗ-ийн тухайн үед байсан ТУЗ-ийн ажлын алба нь тусдаа байгаа, гүйцэтгэх захиралд хамаарахгүйгээр эндээс тодруулах нь зүйтэй л гэж...

УИХ-ын гишүүн С.Одонтуяа: За одоо Улсын Ерөнхий прокуророос хариулт.

Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Д.Баянжаргал: За саяын УИХ-аас баталсан Эрүүгийн хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлтэй холбоотой асуудал яригдаж байна, бид нарын гар дээр бол одоо хууль албан ёсоор ирээгүй байна, хууль албан ёсоор хэрэгжиж эхлээгүй байна гэж үзэж байна. Тэгэхээр батлагдсан ба батлагдан гарсан хууль маань ямар хууль ирж байгааг бол мэдэхгүй байна. Ер нь Эрүүгийн хууль бол буцаан хэрэглэгдэхгүй гэдэг ашигтай зарчмыг барьж Эрүүгийн хуулийг хэрэглэдэг. Тухайн гэмт хэрэг үйлдсэн хүнд ашигтай байх юм бол Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэдэг. Эрүүгийн процессын хууль бол батлагдсан цагаасаа, хэрэгжиж эхэлсэн цаг хугацаанаасаа үйлчилдэг ийм л эрүүгийн эрх зүйн суурь зарчим бол бий. Хариулт бол ийм байна. Сая би танд хэллээ шүү дээ Процессын хууль бол батлагдсан цаг хугацаанаасаа хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлдэг. Эрүүгийн хууль бол буцаан хэрэглэх, хэрэглэхгүй байх асуудал бол тухайн гэмт хэрэгтэн этгээдэд ашигтайгаар, ашигтай зарчмаар асуудлыг шийддэг. Хялбаржуулсан журам гэдэг бол эрүүгийн процессын ойлголт шүү дээ. Эрүүгийн процессын хуулийн ойлголт. Яг хууль маань бид нарын гар дээр ирээгүй байна, ирээгүй байгаа хуулийн талаар бид нар урьдчилж

бас хэлэх боломжгүй байна. Хуулиа авч харж байж ямар заалттай, ямар хууль байж байгаа юм, энэ хэрэгжиж эхэлсэн үеэсээ хуульчид хэрхэн яаж хэрэглэх вэ гэдэг тийм л асуудал болж байгаа юм.

УИХ-ын гишүүн С.Одонтуяа: За Авлигатай тэмцэх газрын дарга.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга Х.Буянтүмэн: Түрүүн тэр Ерөнхий прокурорын газраас хуультай холбоотой асуудлаар О.Цогтгэрэл гишүүний асуултад тодорхой хариулт өгчихлөө. Бид хуулиа гардаж аваагүй байна. Чуулганы мэдээллээс, хэвлэл мэдээллээс авсан мэдээллээр бол хялбаршуулах, журмаар хэрэг шийдвэрлэх ажиллагаа байгаа байна юм, гэхдээ улс төрд нөлөө бүхий этгээдүүд, мөн 22-дугаар бүлэгт заасан гэмт хэргийн үндэслэлгүйгээр хөрөнгөжих, хахууль авах, улс төрд нөлөө бүхий этгээд бусдад давуу байдал олгох гэсэн үг, ийм 3 төрлийн чиглэлээр бол хялбаршихгүй юм байна гэсэн ийм л ойлголттой байгаа. Одоо ингээд хуулиа гардаж аваагүй учраас би яг тодорхой мэдэхгүй байна, зүгээр авсан мэдээллээр бол ийм байна. Тэр бол хэрэг болгон дээр онцлог шүү дээ, одоо яг нийтээрээ хялбарших журмыг хэрэглэхгүй бол хэрэг илрэхгүй гэдэг чинь бол тухайн хэргийн нөхцөл байдлаас шалтгаална.

УИХ-ын гишүүн С.Одонтуяа: За одоо Хан-Уул дүүргийн иргэн Ц.Бээжин.

Сонсголд оролцогч, иргэн Ц.Бээжин: За дараах хүмүүсийг ирүүлээрэй, шаардлага өгнө. Ерөнхийлөгчийн Тамгын газраас, Их хурлын Тамгын газраас, Ерөнхий сайдын ажлын албанаас, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга заавал ирнэ шүү, дуудаарай. Ганбат гуай байна, Ганболд гуай байна. За баярлалаа, тайлан мэдээлэлтэй танилцах сонсгол гэсэн гарчиг байна, За тэгэхээр.

1072 Хувьцаа эзэмшигч тайлан мэдээллийг авах эрхтэй. Тайлан мэдээллийг хуулийн хүрээнд бид нар хувьцаа эзэмшигчид гуйж биш гуядаж авна. Хуулийн заалтыг нь уншиж өгье. Компанийн тухай хуулийн 98-ын зүйл, компанийн талаар мэдээлэл авах, компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, компанийн гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал, шийдвэр, бусад баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах бололцоог хувьцаа эзэмшигчдэд олгох үүрэгтэй гэж байна. Энэ үүргээ биелүүлж бидэнд мэдээлэл өг өө, ямар мэдээлэл хүсэж байна гэхээр нэгдүгээрт бүрэн эрхт төлөөлөгч Ганбат гуайг томилсон ЗГ-ын шийдвэрийг цаасан хэлбэрээр, хоёрдугаарт, түр хороонд хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг оруулах, гуравдугаарт, 1072 хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2010 оноос хойших анхан шатны болон нягтлан бүртгэлийн бүх бичиг баримт, мөн компанийн гүйцэтгэх удирдлагын хурлын бүх тэмдэглэл, 2010 оноос хойших бүх гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэрүүд, 2010 оноос хойших нүүрс худалдах болон оффтэйк нөхцөлөөр байгуулсан бүх гэрээнүүд, 2010 оноос хойших худалдан авах ханган нийлүүлэлтийн бүх гэрээнүүдийг бидэнд одоо олго, хуулийн дагуу. Энэ бүх мэдээллийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас авчрахаас нааш энэ нийтийн сонсголыг хаахгүй. 1072 хувьцаа эзэмшигчид хуулийн дагуу дээрх мэдээллийг мэдэх эрхтэй. Ийм байна, 2 дахь асуудал Нийгмийн тулгамдсан асуудлыг яаж шийддэг, Одоо Оюутолгойн УИХ-ын ажлын хэсэгт иргэний нийгмийн төлөөлөл орж, жишээ нь би орж хорин хоёр тэрбум долларын өрийг дарж, Дубайн гэрээг цуцалж, арван хоёр тэрбум долларын өрийг Монгол Улсын гадаад өрөнд албан ёсоор байдаг гэдгийг Занданшатар дарга мэдээлсэн. Ингэхдээ зэрэг “Эрдэнэс Тавантолгой” ХК бол онцлогтой компани, төр 85, иргэд 15. Үндсэн хуулиа харцгаая, хөрөнгө чинээгээр ялгаварлахгүй, Тэгэхээр төр, хувьцаа эзэмшигч 2 адил тэнцүү эрхтэй, хоёрдугаарт өмчийн олон хэлбэрийг хуульчлан зөвшөөрсөн, Тэгэхээр 1072 хувьцаа эзэмшигчдийн маань эрх ашгийг төр маань арай үл тоогоод байгаа юм биш биз дээ. Гуравдугаарт төрд байвал хулгай гараад байна гэж байгаа юм. Тэгвэл цаашид яах вэ, Гарц шийдлийг чинь томьёолж өгье. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн засаглалыг эздэд нь

шилжүүлэх боломжтой нүүрсний хулгай дахин гаргахгүй байх хуулийн баталгааг өргөн барья. Монгол Улсын Хурлын Эдийн засгийн байнгын хороонд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 хувьцаа эзэмшигч-гурван сая иргэний төлөөлөл дараах шаардлагыг хүргүүлж байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн бүх хувьцааг Монгол Улсын бүх иргэдэд үнэ төлбөргүй шилжүүлж, өмчлүүлэх хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг 1072 хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг оролцуулан нэн даруй байгуулж, тус хуулийг яаралтай горимоор 2022 онд багтаан УИХ-аар хэлэлцэн батлуулахыг шаардаж байна. Шаардлага хүргүүлсэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл, 1072 хувьцаагаа хамгаалах хөдөлгөөн, Модун 33 иргэний нэгдэл. Энэ шаардлагыг... нөгөө хүмүүс хаа байна. Одоо би гардуулж өгөх гэж байна. гараад ир. Парламентад суудалтай 3 намын дарга гаргаад ир, Чинзориг гуай, би шаардлагаа өгье. би асуулт асуухгүй зөвхөн шаардлагаа өгье. 3 намын дарга, Ерөнхийлөгчийн тамгын газар, Их хурлын Тамгын газар, Ерөнхий сайдын ажлын алба гараад зогсоод байгаарай. Ганбат гуай, Ганболд гуай байж байна, БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ-Ганбат гуай байна. тэр нарийн бичгийн дарга хаана байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн... бидэнд энэ мэдээллийг хуулийн дагуу компанийн хуулийн 98-ын 2-дугаар зүйлийн дагуу энэ бүх мэдээллийг бидэнд гаргаж өгөх үүрэгтэй. Үүрэгтэй шүү

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Их хурлын тамгын газраас хэн байна.

Сонсголд оролцогч, иргэн Ц.Бээжин: Ганбат төлөөлөгч энэ хүмүүсийг гаргаад ир, Ганбат гуай. минут дуусаагүй байна, гаргаад ир. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг урьж байна, хувьцаа эзэмшигчдийнхээ шаардлагыг хүлээж ав. Парламентад суудалтай 3 намын даргыг урьж байна. 3 намын дарга.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Шадар сайдад өгчих, шадар сайд наана чинь байна. За одоо Ж.Энхбат, Сүхбаатар дүүргийн 10-дугаар хороо.

Сонсголд оролцогч, иргэн Ж.Энхбат: Та бүхэнд энэ оройн мэнд хүргэе. Үндсэн илтгэлтэй холбоотой асуултауд асууна. Намайг Жаргалсайханы Энхбат гэдэг. би өөрөө авто тээврийн салбарт диспетчерээс авхуулаад газрын дарга хийж байсан, яг зөвлөх инженер хүн байгаа. Яг энэ нүүрс тээвэр болон энэ тээвэртэй холбоотой асуудлуудыг бас бодлогын хэмжээнд бид нар бас үнэн зөв мэдээллүүдийг ярих ёстой. Хамтдаа бид нар гарц шийдлүүдээ ярих ёстой, Би энд ямар нэгэн шүүмжлэл нэг их ярихгүй, жишээ нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төлөөлөн удирдах Ганбат дарга маш хариуцлагагүй шийдвэр гаргасан байна. 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдөр нүүрс тээвэр буюу улс хоорондын байнгын ачиж тээвэрлэдэг ААН, байгууллагуудад албан тоотоор хүргүүлсэн. Өнөөдөр та бүхний илтгэл дээр яригдаж байгаа Өмнөговь аймагт 392 тээврийн аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ 392 аж ахуйн нэгж байгууллагууд хаалгаа хаах, үүдээ барих хэмжээнд хүрчихлээ. Тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, авто баазтай, өөрийн гэсэн инженер механиктай, өөрийн гэсэн кемптэй, өөрийн гэсэн ажиллах хүчинтэй аж ахуйн нэгж байгууллагуудад Ганбат дарга 4 заалттай албан бичиг өгсөн байгаа юм.

Нэгдүгээрт нь 2022 оны тээвэрлэлтийн хариуцлагын гэрээг сунгана. Сунгахдаа 2022 оны 12 сарын 23-ны өдөр аж ахуйн нэгж байгууллагуудаас материал хүлээж авна гэж байна, хоёрдугаарт, тээвэрлэлтийн хариуцлагын гэрээг байгуулахдаа тээвэрлэлт гүйцэтгэх гэрээний сонгон шалгаруулалтыг зарлаж байгаа юм. Тэгээд одоо явж байгаа 392 аж ахуйн нэгж байгууллагуудын бүгдийнх нь тээвэрлэлтийн гэрээг цуцлаад, шинээр дахиад аж ахуйн нэгж байгууллага оруулах гэж байна. Одоо байгаа 300 хэдэн компани чинь нэг гишүүн хэлсэн шүү дээ, улны амьдралаас бүр долоон дор болгож байна. Зээл аваад парк шинэчлэлтээ хийсэн, маш олон жолооч нарыг ажлын байраар хангадаг аж ахуйн нэгж

байгууллагууд маань үүд хаалгаа хаах хэмжээнд хүрчихлээ, Чинзориг дарга аа, Чинзориг даргаа, танаас хичээнгүйлэн гуйя. Та энийг онцгойлон анхаараадхаач, Бүрэн эрхт төлөөлөгчийн энэ гаргасан шийдвэрийг Засгийн Газар дээрээ ярьж байгаад энэ гаргасан шийдвэрийг хүчингүй болгож өгөөч. Энэ дээр нэг юм байгаа юм. АТҮТ-өөс олгодог Ц төрлийн зөвшөөрлийн бичгийг гуравны нэгт нь олгоно гэж байгаа юм.

Одоо нөгөө нэг төлөвлөгөөт эдийн засаг, төлөвлөгөөт тээвэрлэлтийн үйл ажиллагаа зогсонги байдалд орох нь ээ, одоо бүртгэлтэй, стандартын шаардлага хангачихсан, авто тээврийн хяналтын улсын байцаагчаас дүгнэлтээ гарчихсан, хил гааль дээрээ бүртгэлтэй байгаа, тээврийн хэрэгслүүд чинь хөдөлгөөнд оролцохгүй нь ээ, хоёрдугаарт нь албан тушаалаа урвуулан ашиглаж, төр түмний хөрөнгийг хулгайлсан хэсэг бүлэг этгээдүүдийн нэрс ерөөсөө яригдахгүй байна аа, яагаад Чимэдийн Хүрэлбаатар гэдэг хүний нэр энд яригдахгүй байгаа юм, Яагаад Нийслэлийн МАН-ын дарга, НЗДарга Сумъяабазарын нэр яригдахгүй байгаа юм, Өөрөө УУЯ-ны сайд байсан, сайд байхдаа ашиг сонирхлын зөрчил гаргаж, өөрийнх нь хамаарал бүхий сайдын зөвлөх нь Эрдэнэс 5 толгой компанийн дэд захирал байсан, би гэрээнүүдийнх нь хавсралтуудыг авчирсан. Яагаад энэ хууль хяналтын байгууллага нь Уул уурхайн сайд байсан, Сумъяабазарыг яагаад дуудаж шалгахгүй байгаа юм, яагаад зарлахгүй байгаа юм. Энэ хүн өнөөдөр Улаанбаатар хотыг аз жаргалтай хот болгоно гэж амлаж гарч ирсэн.

Аз жаргалтай хот байтугай аз жаргалгүй хот болгож байгаа байхгүй юу. Ийм нүүрсний гол эзэд хулгайчдыг яагаад зарлахгүй байгаа юм бэ? Энийг бас хууль хяналтын байгууллага, Ерөнхий прокурор, Авлигатай тэмцэх газрынхан яг одоо бодит байдлаар нь хэлээч ээ. Энэ яриад байгаа хүмүүс нүүрсний хулгайч мөн юм уу, биш юм уу, Су.Батболд гэдэг хүн нүүрсний хулгайч мөн юм уу, биш юм уу, нэр нь холбогдсон юм уу, холбогдоогүй юм уу, шалгагдаж байгаа юм уу, шалгагдаагүй юм уу гэдгийг яг бодит байдлаар хэлээч ээ, юугаа нуугаад байгаа юм бэ, өнөөдөр 9 цаг 30 минутад ирсэн өнөөдрийн энэ хэлэлцүүлэг дээр ийм ийм хүмүүс шалгагдаж байгаа, эрүүгийн хариуцлага хүлээчихсэн, яллах дүгнэлтийг өргөн барьчихсан, УИХ-ын гишүүнээс нь түдгэлзүүлэх саналыг УИХ-д өргөн барьсан гэдэг мэдээлэл авах байх гэж би бодож ирсэн. Өнөөдөр ямар ч мэдээлэлгүй, ямар ч үр дүнгүй хэлэлцүүлэг болж байна. Тэгэхээр миний хэлэх гэж байгаа гол санаа нь энэ нээлттэй сонсголыг хаахгүй байгаач ээ, дараа энэ хэлэлцүүлэг маань үргэлжлээд...

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Ганбат дарга хариулах уу. ТУЗ-ын шийдвэр гээд байсан, за асуултад хариулъя.

“Эрдэнэс Тавантолгой” ХК дахь Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат: За асуултад хариулъя. Би 10 сарын 26-нд Эрдэнэс 5 толгой компанид бүрэн эрхт төлөөлөгчөөр томилогдсон, намайг ажил авах үед өдөрт 200 машин тээвэрт явж байсан,. Энийг 3-аас 4 дахин нэмсэн, одоо тогтмол 800 гаруй машин, хамгийн оргил үедээ 1100-аад машин явж байна . Энэ хэмжээгээр монгол тээвэрчдийн орлого нэмэгдэж, ажлын байр нэмэгдэж байгаа, үүнтэй холбоотой ЗГ-аас шинээр зарах нүүрсийг хил нөхцөлөөр зарах үүрэг өгөгдсөн, бид Хил үнээр нүүрсээ зарах, үнэ хүргэлж Монголын баялгийг зарж орлогоо нэмэгдүүлэх ёстой, үүнтэй холбогдуулан тээвэрлэлтийн асуудал гарч ирж байгаа, яг өнөөдрийн байдлаар бол Эрдэнэс 5 толгой компанитай Ам нөхцлөөр зарж байгаа, Ам нөхцөлөөр зарна гэдэг нь таны нүүрс тээврийг чинь хийгээд байгаа Хятадын компаниуд, худалдан авагч тал маань тээвэрлэлтээ зуун хувь хариуцаж байгаа, бид аман дээрээсээ коксжих нүүрсийг яг өнөөдрийн байдлаар 109 ам. доллар, эрчим хүчний нүүрсийг 37 ам. Доллар-аар зарж байна, уурхай дээрээс нүүрс ачигдлаа, тээвэрт яваад цагаан хад руу бууж ирнэ, энэ тээврийг хэн хийж байна гэвэл худалдан авагч тал хариуцаж байгаа шүү дээ. тэгээд таны тээврийн хөлсний зардлыг хятадууд дээр худалдан авагч нар төлж байгаа.

За би нэг юмыг хариуцлагатайгаар хэлж байгаа. Монгол тээвэрчидтэйгээ бол хамтарч ажиллана аа, бид энэ хил нөхцөлөөр зарахтай холбоотой монгол тээврийн компаниудтайгаа хамтарч ажиллана гэдгээ удаа дараа албан ёсоор илэрхийлсэн. Тээврийн төлөөллүүдтэй уулзсан, удаа дараа уулзалт хийсэн. 260,270-аад хүн оролцуулсан цахимаар уулзалт хийж санал авсан. Мөн бид одоо тендерээ зарлачихсан, бид одоо он гарангуут шинээр зарах нүүрсээ хил нөхцлөөр зарна, бид хил дээр хүргэж өгнө. Үүнтэй холбогдуулаад бид тээврээ өөрсдөө хийнэ. Тендерийг зарлачихсан. Зарлахаас өөр аргагүй. За энийг зарлахдаа бид монгол тээвэрчиддээ нэг л хүсэлт тавьсан. Хятад компаниуд одоо үнэ цохиж орж ирнэ, том олон машинтай компаниуд хятад эзэнтэй байдаг. Бид аль болох монголд тээвэрчдээ оруулахын тулд 21 50 100 гээд багцалсан. 21 дотроо 10 машин нь өөрийнх чинь бусад 10 нь өөр хүнийх байж болно 10. Ингээд зохион байгуулалтад оруулаад авах, аль болох багцаа бид жижиглэж тээвэрчдийн саналаар хийсэн, Тендерээ зарлачихсан. Үүнтэй холбогдуулаад бид хэн нэгэн хүнийг ажлын байраараа хангах буюу одоо энэ явж байгаа юмыг зогсооё гэдэг байдлаар хандаагүй. Та бас буруу зөрүү мэдээлэл өгч болохгүй ээ.

Өнөөдрийн байдлаар Эрдэнэс 5 толгой компани дээр уртын болон богинын тээвэр дээр яг Эрдэнэс 5 толгой компанийн худалдан авагчийн авсан нүүрсийг тээвэрлэж байгаа 10 гаран мянган машин байна. Энэ бол нэмэгдсэн тоо. Бид боломжоор нь хангахын тулд тээвэрлэлтээ ирэх жил хамгийн багадаа 23 сая тонн нүүрс бид борлуулна гэсэн төлөвлөгөөтэй байгаа,. Энийг тээвэрлэхэд энэ тооны авто тээвэр хэрэгтэй юм байна, бид Цагаан хад, Гашуун сухайт тэгээд Ханги-Замын Үүд гэсэн чиглэлээр тээвэрлэдэг. Төмөр зам болон Авто тээврийн хэрэгслээр. Үүнтэй холбоотой нээлттэй тендер зарласан,. Иймд Сснгон шалгаруулалтдаа орох хэрэгтэй, бид аль болох жижиглээд багцалчихсан, монгол тээвэрчдээ дэмжинэ, ийм байдлаар л өрнөөд явж байгаа. Одоо ялангуяа тэр богинын тээвэр дээр бол өндөр тарифтай яваад байгаа, Тэр бол хятад компаниуд, тэр богинын тээврийг бол Хятадын компаниуд хариуцаж байгаа. Монгол жолооч нар явж байгаа. тэр тээврийн компанийн бүх орлого Хятад талдаа үлдэж байгаа нь үнэн. Монгол тээвэрчид орлогоо олоод энд бид татвараа төлдөг, ил тод, нээлттэй болгохын төлөө л ажиллаж байгаа шүү дээ. Тэрнээс буруу шийдвэр гаргачихаад хууль зөрчөөд Монгол тээврийн компаниудынхаа хүмүүсийг шахаж байгаа юм огт байхгүй. Хүмүүсээс асуугаарай, Би бол удаа дараа нь нээлттэй уулзаж, энэ талаар ярилцаж саналыг нь сонсож, хамтарч ажиллаж байгаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За баярлалаа Д.Даваасүрэн Өвөрхангай аймаг, Уянга сум.

Сонсголд оролцогч, иргэн Д.Даваасүрэн: Би Өвөрхангай аймгийн Уянга сумаас ирсэн Д.Даваасүрэн байна аа. Манай Өвөрхангай аймгийн Уянга сум бол том сум. Гурван 12 жилийн дунд сургуультай, 2000-д хүн суудаг, тэгээд хүмүүс маань энэ суулт, жагсаалыг их идэвхтэй сонирхож, 40-50-д улсууд одоо ярилцаж, тэгээд бүр цахимаар хэлэлцүүлэг, хурал зохион байгуулсан, гадаад, дотоодын, бусад, аймаг, сумд, хотын олон хүмүүс оролцоод, нэг бага зэргийн судалгаа хийгээд доорх саналуудыг нэгтгэж та бүхэнд одоо хүргэж байна аа. Нэгдүгээрт, Монгол Улсын Ерөнхийлөгч, үндэсний хэмжээний зөвшилцөлийг ахал аа, ард түмнээсээ сонгогдсон Ерөнхийлөгчийн хувьд ийм санал гарсан, тэгээд энэ асуудал бол нэлээн ужиграх байх аа? Нэг намын Ерөнхий сайд, үндэсний хэмжээний бас энэ зөвшилцлийг ахлах нь олон улсын хэмжээнд ч гэсэн тийм их зохимжтой байдаггүй юм байна аа? Ийм учраас Ерөнхийлөгч одоо энэ асуудалд анхаарал хандуулах хэрэгтэй гэсэн санал гарсан, Ер нь тэгээд энэ 12 сард болсон тэмцлүүд дандаа л үр дүнд хүрч байсан. 12 сарын 06 Их Монгол улс байгуулагдсан гээд л. Тэгээд л 12 сар 10 Ардчилсан холбоо байгуулагдсан. 2 сар битгий хэл 3 сар ингээд л явчихдаг. 12 сарын 29 Монгол улсын үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын, нөгөө хувьсгалын өдөр энэ тэр гээд л ингээд явчихдаг. За тэгээд ийм саналууд байна. Нэг дэх нь энэ.

2 дахь нь шүүх, прокурорын газруудыг одоо үндсээр нь шинэчилье ээ гэсэн санал

байсан. Энэ хүрээнд Ерөнхийлөгч, УИХ, Улсын мөрдөн байцаах товчоог одоо байгуулъя аа. энэ Америкийн нөгөө Холбооны мөрдөх товчоо гэдэг шиг. Энэ Авлигатай тэмцэх газрыг шинэчлээд, ингэж шинээр байгуулъя аа гэж байгаа юм. Ер нь энэ шүүх, прокурор л гээд байна, мөрдөн байцаах шатанд хэргийг хэрэг биш, хэрэг бишийг хэрэг болгодог их асуудал байдаг юм байна аа, энд маш их учир байдаг учраас энийг шинэчилж ээ гэсэн асуудал гаргасан байна аа? За тэгээд энэ төрийн өндөр албан тушаалтнуудад хариуцлагын тухай хуулийг бас гаргах хэрэгтэй гэсэн байна.

Тэгээд одоо Үндсэн хуульд ингээд шинэчлэл юу оруулна гэж байхаар Ерөнхийлөгч ахлаад Үндсэн хуулийн хороо байгуулаад, тэгээд бүх улс төрийн намууд, ард түмнээ оролцуулаад шинэ Үндсэн хуулийн төлөө явах уу? эсвэл Үндсэн хуулийн шинэ найруулгын тухай явах уу? энийгээ 2026 оны хооронд хийхээр ингээд одоо явбал яасан юм бэ? гэсэн ийм санал гарсан, Үндсэн хуулиараа энэ тогтолцоогоо, энэ сонгуулийн бүх асуудлаа нөгөө талаар Үндсэн хуулиар шийдэх юм чинь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн асуудал гэж маш хүнд асуудал байна аа? 331 сумын бараг одоо 200 хэд нь сумын төвдөө хүнгүй болж байна, 110 гаруй суманд сумын төв нь хүнгүй болчихсон байна аа, Улаанбаатарын энэ түгжрэл, энэ утааг чинь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуульд өөрчлөлт оруулж байж Төв аймгийн Улаанбаатар байх юм уу, Улаанбаатар нь бараг тэр чигээрээ Төв аймгийн бүс байх юм уу гэдгийг шийдэх хэрэгтэй байна аа. тэгээд энэ рүүгээ явахгүй бол ерөөсөө болохгүй юм байна, тэгээд хоёрын хооронд нэг тойрогт гишүүдийн тоо нэмээд хэрэггүй. Ийм асуудал бас тавьсан байна.

Ганц 2 асуулт байна. Энэ хаалтын гэрээ гэдэг юмаа ерөөсөө хүчингүй болгоё гэсэн байна шүү. Энэ одоо яг яадаг вэ? Одоо энэ гэрээг хаана хийдэг юм? За тэгээд Сонгуулийн хуульд одоо өөрчлөлт оруулаад улс төрийн намуудын санхүүжилтийг ерөөсөө ил болгоё, ил тод болгоё. Төрийн бүх мэдээллийг ил тод болгоё, шилэн данс руу бүгдээрээ явъя. Энэ улс төрийн намуудын санхүүжилт тэр чигээрээ одоо Авлига, хээл хахууль болж байна гэдэг юмыг хэлэх гэсэн юмаа. Нөгөө талаар энэ Баялгийн сан билүү, Ирээдүйн сан билүү нэг сан байгуулаад нэг баахан мөнгө хуримтлаад татаад байсан. Үгүй тэр одоо санд мөнгө байна уу, үгүй юу? Нэр нь юу билээ? Одоо ер нь хэдэн төгрөг байгаа юм? Он онд хэдэн төгрөг орсон юм? тэр сангийн талаар, хэдэн төгрөг байна энийг тодорхой хэлээдэх гэсэн ийм саналууд гарсан юм аа.

Ер нь тэгээд улс төрийн намуудын санхүүжилтийг сүүлийн 10 жилээр нь юм уу? Одоо ингээд Их Хуралд суудалтай намуудын санхүүжилтийг ер нь одоо шалгавал яасан юм? аудит хийвэл яасан юм? Олон улсын аудит орвол яасан юм бэ?. Энэ юм чинь одоо энэ дээр л бугшиж байгаа шүү дээ. За ийм асуудал бас байна. За тэгээд бизнес эрхлэлт, баялаг бүтээгчдийгээ хамгаалъя гэж байна шүү.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За баярлалаа, Даваасүрэн. Нутгийн хүнтэй таарсных мэндэлье. Өвөлжөө сайхан уу? Баяржаргал прокурор хариулах уу?

Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Д.Баянжаргал: За түрүүний Энхбат гээд иргэний асуултад хариулъя, Хулгайчийн нэрийг зарлалаа гээд хуулийн байгууллагаас танхимд өглөөнөөс хойш нэлээн хэдэн удаа иргэд маань бас хэллээ. За хуулийн байгууллага бол гэмт хэрэгтнийг илрүүлэх, мөрдөн шалгах, хяналт тавих, шүүх ажиллагаа бол процессын хуулийн дагуу явагдана. Үндсэн хуульд зааснаар бол аливаа хүнийг гэмт хэрэг үйлдсэн, үйлдээгүйг, эцсийн гэм буруутай асуудлыг шүүхээр шийдэж байж сая тэр хүн гэмт хэрэг үйлдсэн гэх нь нэр нь тодорхой болно. Тэгэхээр тэр хулгайчийг зарла гэдэг асуудал бол одоо энэ хуулийн хүрээнд бид нарын хувьд бол одоо боломжгүй асуудал. Харин гэмт

хэргийн мөрдөн шалгах ажиллагаа хэрхэн яаж явагдаж байна, ямар байдалтай байна гэдгийг бид нар иргэдийн мэдээлэл авах эрхийн хүрээнд, одоогоор хязгаартайгаар энэ мэдээллийг боломжит хэмжээнд нь мөрдөн шалгах ажиллагааны явц, үр дүнгийн байдлаас хамаараад та бүхэнд мэдээллийг өгөөд явж байгаа.

2 дахь асуудал нь түрүүн Энхбат иргэний асуултад нэр бүхий улсуудыг эрүүгийн хэрэг үүсгэж ялагдагчаар татаач ээ гэдэг асуудал яригдаж байна. За хэн нэгэн хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж, ялагдагчаар татах ажиллагаа бол хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтаар одоо шийдэгддэг асуудал. Өглөө би та бүхэнд мэдээлэл дээр хэлсэн, одоо хуулийн байгууллагад 39 хэрэг, одоо “нүүрсний” гэсэн нэрлэгдэж байгаа асуудлын хүрээнд шалгагдаж байна, тэрний 22 нь хэрэг бүртгэлтийн шатанд буюу нотлох баримт цуглуулах ийм ажиллагаа хийгдээд явж байна, дийлэнх хэрэг нь одоо нотолгооны шатандаа явж байна, нотлох баримт цуглуулах шатандаа энэ ажиллагаа бол тасралтгүй явагдаж байгаа, өглөө би та бүхэнд 2871 хүнийг одоо гэрчээр байцаасан гээд мэдээлэл өгч байсан, тэр нь бол бүтэн сайн өдрийн оройны байдлаар бид нар мэдээлэл авсан мөрдөх байгууллагуудаас. Гэтэл сүүлийн 2 хоногийн хугацаанд гэхэд одоо мянга гаруй хүнийг дахиад нэмээд байцаасан байх жишээтэй, мэдүүлэг авч байна. Тэгэхээр энэ ажиллагаа бол тасралтгүй одоо инээд нэлээн ачаалал дунд ингээд явж байгаа нүүрсний хэрэг маань өөрөө нэг хэрэг биш, бүхэлдээ одоо энэ 30 гаруй хэрэг байж байгаа. Тэгэхээр энэ ажиллагаа бол тасралтгүй нэлээн ачаалалтай явж байна.

Нүүрсний хэрэг маань ерөөсөө нэг хэрэг биш, бүхэлдээ 30 гаруй хэрэг байж байгаа. Хамрагдах хүрээ нь 2013 оноос хойшоо 10 гаруй жилийг хамрагдсан, ийм өргөн цар хүрээтэй хэрэг байгаа. Тэгэхээр нотолгоо цуглуулж байж хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж ялагдагчаар татдаг, тэгэхээр хангалттай нотлох баримт цугларсан тохиолдолд хуулийн байгууллага, мөрдөх байгууллага ялагдагчаар татах саналаа прокурорын байгууллагад ирүүлнэ, прокурор татах эсэх асуудлыг шийддэг ийм л хуулийн процесстой байгаа гэж хариулмаар байна.

Одоогийн байдлаар, түрүүний таны нэр дурдагдсан хүмүүсийг эрүүгийн хэрэг үүсгэж, ялагдагчаар татсан ийм нөхцөл байдал үүсээгүй байна. Татагдаагүй байна гэж хэлэхээр байна.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За баярлалаа. Д.Үүрцайх Хан-Уул дүүрэг, 19-дүгээр хороо.

Сонсголд оролцогч, иргэн Д.Үүрцайх: За оройн мэнд хүргэе, өглөөнөөс хойш тэвчээртэй суулаа, ингээд ярих боломж олдсонд баяртай байна.

Нэгдүгээрт, би энэ Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх дээр алдаа гаргачхаагүй байгаа гэдэг асуудлыг хөндмөөр байна. Тэгэхээр өнөөдөр энд бол Улсын Их Хурлын Ерөнхий хяналтын сонсгол явж байна. Нийтийн сонсгол биш, нийтийн сонсголын хуулиар явдаг нийтийн сонсгол биш. Түр хорооны хяналтын сонсгол биш, тэгэхээр энэ дэгээ түрүү сонсгол даргалагч маань ямар байдлаар баталчихсан бэ. Энэ хуралд Улсын Их Хурлын гишүүд байсан учраас магадгүй, Эдийн засгийн байнгын хорооны хурал явагдаж байна. Эдийн засгийн байнгын хорооны гишүүд баталсан байх гэж найдаж байна.

Тамгын газрынхан тэрийг шалганахэрэгтэй. Үгүй бол Үндсэн хууль зөрчсөн асуудал болохоор ийм юм явчих шиг боллоо, өөрөөр хэлбэл оролцогчдын саналаар дэг батална гэдэг юм байхгүй. Оролцогчдын шаардлага бол зөв, эхнээсээ ийм байдлаар зохион байгуулахгүй, зохион байгуулах тал дээрээ Тамгын газар ямар байдлаар ажилласан юм бэ, энэ бол нэг ийм асуудалтай юм болчихлоо.

За дараа нь Авлигатай тэмцэх газраас, “Х.Нямбаатар сайд хэд хоногийн өмнө хэлэхдээ Ерөнхийлөгч асан Х.Баттулга гэдэг хүнийг яллагдагчаар татсан, тэгээд хувийн баталгаа гаргах, таслан сэргийлэх арга хэмжээ авсан” гэсэн мэдээ хэвлэл мэдээллийн байгууллагаар яваад байгаа. Тэгэхээр яллагдагчаар татсан юм уу, татаагүй юм уу гэдгийг Авлигатай тэмцэх газар, Прокурорын байгууллагаас асуумаар байна. Энэ хүнийг яллагдагчаар татаагүй юм бол энэ хүн ингээд чөлөөтэй зорчих боломжтой байх, тэгэхдээ яагаад татдаггүй юм, гадуур хүн болгон ингээд хулгай худлыг нь яриад байхад энэ хүнийг яагаад өдий болтол нэг тодорхой цөөн хэдэн нотлох баримт бүрдүүлээд яллагдагчаар хэрэг үүсгээд шалгачхаж болдоггүй юм бэ? Энэний цаад шалтгаан нь юу байдаг юм бол гэж энийг бас асуумаар байна.

Тэгэхээр энэ хүнийг яллагдагчаар татсан байхад, хамгийн амархан, хөнгөн таслан сэргийлэх арга хэмжээг авч энэ хүн гадагшаа гарч явсан байна. Т.Доржханд гишүүн ч гэсэн тэр Х.Нямбаатар сайдын хэлсэн дээр хэлээд байна шүү дээ. Энэ хүн чинь ингээд оргон зайлчихсан юм биш үү? Ингээд энэ хүн гадагшаа гарчхад эргэж ирэхгүй мөрдөн шалгах ажиллагаа цааш явах боломжгүй болоод ингээд саад учраад ингэх юм бол хариуцлагыг нь хэн хүлээх вэ, прокурорт хандсан юм уу? Энэ хүнийг ялагдчихаад татъя, таслан сэргийлэх арга хэмжээ авъя гээд Прокурорын байгууллага зөвшөөрөөгүй юм уу, эсвэл мөрдөгч нь өөрөө мэдээд хамгийн наад захын ийм юмыг авсан юм уу гэсэн нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт, Хүн намын мэргэжилтнүүд 7 хоног энэ хэлэлцүүлэгт бэлдээд Т.Доржханд гишүүн энийг санаачлаад бусад гишүүд дэмжээд энэ нээлттэй сонсгол явж байгаа, тэгэхээр энийг бид нар бэлдээд арваад хоног ажиллаад бүх юмнуудыг үзлээ, тэгээд ингээд байхад гэрээнүүдийг ил болгосон гээд байсан ил болоогүй байна. Яаж байна гэхээр нэгдүгээрт Зам, тээврийн хөгжлийн яамнаас ил олгосон тэр гэрээн дотор Улаанбаатар төмөр замтай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний хавсралтууд нь алга, 13 хавсралттай 1, 2 нь л байна. 3-13 дахь нь алга. Тооцоо хийж болохгүй, тэрэн дээр үнэ ажлын гүйцэтгэл юмнууд нь мэдэгдэхгүй. Ингэж ил болгодог юм уу?

За дараа нь тэр Бодь компанитай хийсэн Гашуунсухайтын төмөр зам дээр хийсэн санхүүжилтийн гэрээ нь ил болчихоод ажил гүйцэтгэх гэрээ нь ил болохгүй, тэрийг нь ил болгочихооч. Дээрээс нь тэр Бодь компанийн ханган нийлүүлэлт, туслан гүйцэтгэгчдийн гэрээг за яах вэ, бизнесийн нууц гэх байх. Тэр тохиолдолд Улсын Их Хурлын Боомтын түр хороон дээрээ энэ асуудлаа гаргаж тавиад, нотлох баримтын шаардлага хангасан байдлаар тэд нарыг нь аваад хянаж шалгаад олон нийтэд мэдээлээд, тэр дотор, тэр улс төрд хамаарал бүхий этгээдүүдийн компани, ашиг сонирхол юм байна уу? гэдгийг нь зарлаад, олон нийтийн мэдэх эрхийг хангаач. Энэ сонсгол чинь олон нийтийн мэдэх эрхийг хангах зорилготой сонсгол шүү, телевизээр Монголын үндэсний олон нийтийн телевиз шууд дамжуулж байх шиг байна. Монголын ард түмэн энэ бүхнээс хараад хулгай болчихсон юм уу, хэн хаана яачихсан гээд энийгээ мэдэх ёстой. Энэ бүхэн чинь чиглэх ёстой шүү.

Уг нь бол өглөөний тэр хэлбэрээрээ явагдсан бол гишүүд тодорхойгүй, сонирхсон тэр асуултуудаа асуугаад, холбогдох этгээдүүдээс хариултуудаа шаардаж аваад, ингээд иргэдийн мэдэх эрх илүү бодитой хангагдах байсан боловч тодорхой зохион байгуулалттай энэ юмнаас болоод энэ сонсгол үр дүнгүй болж байгаад харамсаж байна.

Гуравдугаар асуулт, Прокурор, Авлигатай тэмцэх газар, мөрдөн шалгах байгууллагуудаас асуумаар байна.

Эрүүгийн хуулийн саяын нэмэлт өөрчлөлт бол буцаан хэрэглэгдэхгүй, сая Буянжаргал прокурор хэлж байна. Өөрөөр хэлбэл, эрх зүйн байдлыг дордуулсан нэмэлт

өөрчлөлтийг Эрүүгийн хуулийн ялангуяа хатуу, буцаан хэрэглэхгүй байх зарчимтай. Тэгэхээр энэ тохиолдолд өнөөдөр 5 гишүүн холбогдсон гээд явж байна, цаашдаа ингээд шалгаад ирэхээр өөр олон гишүүд нэр холбогдоод ирэх байх. Энэ хүмүүс чинь энэ төмөр хашааныхаа цаана орж сууж байгаад халдашгүй дархан эрхээрээ хамгаалагдаад, магадгүй 2024 онд дахиж сонгогдоод ингэж явсаар байгаад хөөн хэлэлцэх хугацаа дуусаад ял эдлэхгүй болчих юм биш биз дээ? Энэ асуудлыг яаж шийдэх боломжтой вэ, яаж шийдье гэж бодож байгаа вэ? дээрээс нь Улсын Их Хурал нэр холбогдсон гишүүддээ бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх шийд...

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За хэн хариулах вэ? Дашдаваа дарга хариулах уу? Прокурор хариулах юм уу? , яллагдагчаар татсан, татаагүй л гээд байх юм. Түрүүн хариулсан юм л даа. За Д.Баянжаргал прокурор.

Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Д.Баянжаргал: Иргэн Үүрцайхын асуултад хариулъя. Х.Баттулга гэдэг хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах саналыг Авлигатай тэмцэх газраас прокурорт ирүүлсэн, энэ хүнийг бол эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан байж байгаа.

Таслан сэргийлэх арга хэмжээ гээд процессын хуульд 6 төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ байж байгаа. Энэний гурвыг нь буюу цагдан хорих, хилийн хориг тавих, тодорхой албан тушаал эрхлэх эрхийг нь түдгэлзүүлэх энэ гурван таслан сэргээлгэх арга хэмжээг бол шүүхийн зөвшөөрөлтэй өгдөг.

Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ гэж байгаа. Тэрийг нь прокурорын зөвшөөрлөөр өгдөг, үлдсэн, тэр хувийн баталгаа гаргах, цэргийн албан хаагч байх юм бол цэргийн анги нэгтгэлийн удирдлага хянан харгалзуулах гээд ийм таслан сэргийлэх арга хэмжээг бол мөрдөгч авдаг.

Хуульд заасан 6 төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг тухайн хэргийн нөхцөл байдал, гэмт хэрэгт холбогдож байгаа хүний хувийн байдлыг харгалзаад мөрдөгч өөрөө хараат бусаар шийддэг асуудал байгаа. Тэгэхээр энэ хүн дээр хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээг бол мөрдөгч өөрөө авсан байж байгаа.

Дараагийн асуудал бол процессын хуулийн асуудал яригдаад байсан, би түрүүн хариулсан. Хуулийн байгууллага, хуульчид, ялангуяа энэ хуулийг хэрэглэж, байнга өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэдэг мөрдөгч, прокурор, шүүгч бол албан ёсны батлагдсан, батлагдаж гарсан бид нарын гар дээр ирсэн хуулийг уншиж судалж байж асуудлыг хэрхэн яаж хэрэглэх вэ гэдэг хууль хэрэглээний асуудал байж байгаа юм. Тэгэхээр процессын түрүүн бид тайлбарласан ерөнхий эрүүгийн эрх зүйн суурь хэд хэдэн зарчмууд бий, Эрүүгийн хууль бол тухайн гэмт хэрэг, гэмт хэрэгтэн этгээдэд ашигтай байдлаар хэрэглэгддэг буцаан хэрэглэх үү, хэрэглэхгүй юу гэдэг ийм Процессын хууль бол батлагдсан цагаасаа хэрэгжээд явдаг ийм л хууль гэж түрүүн тайлбарласан, тэгэхээр хууль ирээгүй байгаа учраас бид нар одоо тодорхой энэ талаар тайлбар хэлэх боломжгүй байна.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Гэрээний хавсралтуудтай холбоотой, замын гэрээтэй холбоотой, хавсралтууд ил болоогүй. Бодийн ажил гүйцэтгэх гэрээ, ханган нийлүүлэх гэрээнүүд ил болоогүй гээд байх юм. Тэр дээр Ж.Ганбат дарга хариулах уу?, П.Ганхүү дарга хариулах юм уу? За П.Ганхүү дарга.

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал П.Ганхүү: За сонсголд оролцож байгаа та бүгдийн энэ оройн мэндийг хүргэе. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн

гүйцэтгэх захирал П.Ганхүү. Түрүүн ил болсон 7 гэрээний тухай ярьсан, үүний дээр нэмээд 2 нууц гэрээг “Монголын төмөр зам” Төрийн өмчит хувьцаат компани нэг гэрээг нь Зэвсэгт хвчний жанжин штабтай, нөгөө гэрээг нь Улаанбаатар төмөр замтай байгуулсан. Ерөнхий захирал, ерөнхий гүйцэтгэгчийн ийм 2 гэрээ байгаа юм. Д.Үүрцайх иргэн сая асуулаа.

Тэгэхээр энэ 2 гэрээн дээр бол төсөвт өртөгтэй, дүнтэй гэрээ биш, ерөнхийдөө Тавантолгой, Зүүнбаян чиглэлийн төмөр замын доод бүтцийн ажил буюу далан хоолойн ажлыг Зэвсэгт хвчний жанжин штаб хийж гүйцэтгэхээр, тэгээд одоогийн байдлаар бол энэ хийсэн энэ нууц гэрээний нийт дүн 454.9 тэрбум төгрөг, ийм дүнтэй гэрээ гэсэн үг.

Нөгөө гэрээ нь Улаанбаатар төмөр замтай байгуулсан Тавантолгой, Зүүнбаян чиглэлийн төмөр замын дээд бүтцийн ажлын гэрээ буюу төмөр замын дээд бүтэц, шилэн кабель, эрчим хүч бусад барилга байгууламжийн гэрээ нь нийтдээ 557.9 тэрбум төгрөгийн ерөнхий гүйцэтгэгчийн гэрээ. Энэ 2 гэрээ бол нууц байсан. Ингээд энэ 2 гэрээ цаашаа задраад үндсэндээ Тавантолгой, Зүүнбаян чиглэлийн төмөр замыг 1 их наяд 392.0 тэрбум төгрөгөөр урьдчилсан төсөвт өртөг нь гарсан байж байгаа. Та бүгд мэдэж байгаа байх.

750.0 тэрбум төгрөгийн бондыг “Монголын төмөр зам” Төрийн өмчит хувьцаат компани гаргаад энийг нь “Эрдэнэс Тавантолгой” ХК худалдаж авсан, 20 жилийн хугацаатай хүүгүй 20 жил хувааж төлнө. Тээврийн орлогоосоо, дээр нь нэмээд 642.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг бас зээлийн гэрээгээр хийхээр тохиролцоод явж байгаа ийм ажил байж байгаа.

За үүн дотроо Зэвсэгт хвчний жанжин штаб 454.9 тэрбум төгрөгийн доод бүтцийн далангийн ажлынхаа 165.4 тэрбум төгрөг буюу 36.4 хувийг нь өөрөө хийсэн. Зэвсэгт хвчний жанжин штабын 8 анги нэгтгэл хийсэн байгаа юм. За энэ Зэвсэгт хвчний жанжин штабтай хийсэн энэ үндсэн гэрээний 289.5 тэрбум төгрөг буюу 63.6 хувийг 81 гэрээгээр туслан гүйцэтгэгч компаниудаар хийлгэсэн.

Улаанбаатар төмөр замтай байгуулсан 557.9 тэрбум төгрөгийн гэрээний 194.3 тэрбум буюу 34.8 хувийг Улаанбаатар төмөр зам өөрөө хийж гүйцэтгэсэн байна. 363.6 тэрбум буюу нийтдээ 38 гэрээгээр 65.2 хувийг нь туслан гүйцэтгэгч компаниудаар хийлгэсэн байна.

Тэгээд “Монголын төмөр зам” Төрийн өмчит хувьцаат компани хийсэн 84 гэрээ байна. Нийтдээ энэ төслийг хэрэгжүүлэхэд 203 туслан гүйцэтгэгчийн гэрээ хийсэн байна. Энэ гэрээнүүд бол бүгдээрээ шууд гэрээ буюу тендергүйгээр хийгдсэн ийм гэрээ байж байгаа.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 315 тоот тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсгийг Зэвсэгт хвчний жанжин штабын дарга ахалсан ийм ажлын хэсэг дээр орж танилцуулаад ингээд шууд хийгдсэн ийм гэрээнүүдээр хийгдсэн ажлууд байж байгаа. Нийтдээ энэ 203 гэрээг 10 хоногийн өмнө “Монголын төмөр зам” Төрийн өмчит хувьцаат компанийн вэб сайт руу ороод үзээрэй, та бүгд. 10 хоногийн өмнө тавьчихсан байж байгаа, эхлээд бол 203 гэрээний жагсаалт, ямар компанийн ямар хэдний өдөр гэрээ байгуулсан юм, ямар ажил хийх гэж гэрээ байгуулсан юм, ямар үнийн дүнтэй гэсэн 203 компанийн жагсаалт байж байгаа эхний ээлжид. Энд бол давхардаж байгуулсан гэрээтэй компаниуд ч байгаа нэг компани 4, 5 ажил ч авч хийсэн байж байгаа, тэрийг та нар тэр жагсаалтаас харна.

Дараа нь 3 ангилаад Зэвсэгт хвчний жанжин штабын туслан гүйцэтгэгчтэйгээ хийсэн ажлын гэрээ, Улаанбаатар төмөр замын туслан гүйцэтгэгчтэйгээ хийсэн ажлын гэрээ, “Монголын төмөр зам” Төрийн өмчит хувьцаат компанийн туслан гүйцэтгэгчтэй хийсэн ажлын гэрээ гээд ингээд 203 ажлын гэрээний бодит гэрээг нь сканердаад 10 хоногийн өмнө

манайх вэб сайтдаа нээлттэй оруулчихсан байгаа гэдгийг хэлье. За баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Б.Туяацэцэг ЧД 3 дугаар хороо, Б.Туяацэцэг гэж алга уу? Алга байна. Г.Цог-Өрнөх Хан-Уул дүүрэг байна уу? Г.Цог-Өрнөх мөн үү?

Сонсголд оролцогч, иргэн Г.Цог-Өрнөх: Би тэгээд 2, 3 асуулт асуугаад үгээ хэлье гэж бодож байна.

Нэгдүгээр асуулт, ер нь энэ “Эрдэнэс Тавантолгой” ХК ч байна уу, Тавантолгой ч байна уу, энэ дээр энэ бүрэн эрхт төлөөлөгч гэж томилоод байгаа. Тэгээд бүрэн эрхийн төлөөлөгч нь дандаа Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар байгаад байдаг, энэ нь Төрийн албаны хуулиараа бол энэ яамныхаа өндөр албан тушаалтан, тэгээд нөгөө очиж байгаа, томилогдож байгаа газар нь дандаа аж ахуйн тооцоотой газар байгаад байна. Тэгэхлээр энэ ер нь зөв юм уу, буруу юм уу гэдэг нэг асуулт байна. Төрийн албаны хуулийн талаасаа ч тэр энэ болж байна уу гэж.

Хоёрдугаар асуудал, Тавантолгой дээр одоо Тавантолгой хувьцаат компани дээр бүрэн эрхт төлөөлөгч томилж байгаа. орон нутгийн 51 хувийн өмчтэй, 49 хувь нь хувийн өмч, тэгэхлээр төр 51 хувь дээрээ бүрэн эрхт төлөөлөгчөө томилж байна уу, аль эсвэл 100 хувийн өмч дээр томилж байна уу?, хэрвээ 100 хувийн өмч дээр томилж байвал 49 хувийн өмч нь минийх, надаас ямар зөвшөөрөл авсан бэ гэж, ийм юмыг хэлье.

За тэгээд дараад нь ер нь миний хувьд бол энэ орон нутгийн Тавантолгой дээр тавьсан, энэ бүрэн эрхт төлөөлөгчийг бол хууль бус гэж үзэж байгаа. Сая би нэг их эмзэг юм сонслоо. Ер нь бол энэ орон нутгийн Тавантолгойг төрд авах юм байна. Сая Сангийн сайд өөрөө тодорхой хэлчихлээ, тодорхой шалгалт оруулаад ингээд авна. Төр юмаа мэдэж байгаа гэж.

Тэгэхдээ Өмнөговь аймаг шиг өөрийн өмчтэй, бүх аймгуудаа тийм өмчтэй болгочихвол улсын төсөвтөө ч тэр, аймаг орон нутагтаа ч тэр уг нь хэрэгтэй баймаар гэж боддог юм. Нутгийн ард иргэд нь тухайн орон нутаг дээр байгаа байгалийн баялгаасаа хүртэх үр шим нь өмчтэй байснаараа их юм болов уу гэж боддог. Өнөөдөр Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Монгол Улсын хэмжээнд 330 сумын цорын ганц хувийн хэвшлийн 100 хувийн төрийн өмчийн, 51 хувийн орон нутгийн өмчтэй ийм уурхайтай сум. Өнөөгийн байдлаар 2 төрийн өмчийн болон орон нутгийн 51 хувийн өмчтэй уурхай дээр нь бүрэн эрхт төлөөлөгч томилсон, онцгой байдал тогтоосон, дотоодын цэргээр хамгаалуулчихсан байж байдаг.

За тэгтэл Сангийн сайдын хэлж байгаагаар дээрээс нь Хэрэг эрхлэх газрын дарга, сайдын хэлж байгаагаар бол тэнд байгаа хувийн өмч, Эрдэнэс энерги ресурс дээр бас бүрэн эрхт төлөөлөгч томилчих ийм магадлал их өндөр юм байна лээ гэж ярьж байна. Тэгэхлээр өнөөдөр бид ямар нийгэмд, ямар орчинд амьдраад байна вэ, өнөөдөр эргээд бид нар социализм руу явах гэж байна уу даа гэсэн ийм хандлага байна.

Өнөөдөр Өмнөговьчууд, Тавантолгой компани Өмнөговьчуудын өмч байснаараа төрөөсөө мөнгө гуйгаагүй, татаас аваагүй, харин ч төрдөө мөнгө өгч байгаа юм, татварыг нь төлж байгаа, өөрөө өөрийгөө санхүүжүүлж байгаа. Өөрийнх нь 15 суманд сургууль, цэцэрлэг, боловсролын байгууллага, эрүүл мэндийн салбар гээд бүх хөрөнгө оруулалтыг өөрөө хийж байна. Сүүлийн жилүүдэд Засгийн газрынхаа бодлогыг дэмжиж, хот хөдөөгийн сэргэлтийн бодлого гээд хотоос хөдөө рүү чиглэх бодлогыг дэмжиж, орон нутгийн төсвийн байгууллагын төрийн албан хаагчдынхаа цалинг нэмэгдүүлж байна. Сургууль цэцэрлэгтээ

анхаарч байна. Ингээд энэ Засгийн газрын хот, хөдөөгийн бодлогын хүрээнд энэ төвлөрлийг сааруулах бодлогыг тэр аймаг дэмжээд байна. Тэгтэл энэ аймаг өмчтэй байж болохгүй гээд ард иргэдээс нь өмчийг нь булааж дээрэмдээд байна.

Энэ нь ямар төр засаг гэж байх вэ?, бүх аймагтаа бүгдэд нь өмчтэй болго л доо, бүгдийг нь хураагаад бүгдийг нь төвлөрүүлээд, бүгдийг нь өөрсдөө энэ ордноос захирах гээд байх юм тэр өмчийг.

Яагаад энэ бүх аймгуудаа юутай болгож болдоггүй юм, ер нь бол Өмнөговь аймгийг тусгаар улс гэж тусгай болчих гэж байна гэж айх хэрэг байхгүй, хэзээ ч тийм юм байхгүй, Монгол Улс нэгдмэл улс, тийм учраас өнөөдөр Өмнөговь аймгийн ард иргэдийн энэ өмчид халдсан энэ түрэмгий явдлаа энэ Засгийн газар зогсоох ёстой.

Бүрэн эрхт төлөөлөгчөө болих хэрэгтэй. Өмнөговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд очиж тайлагнах ёстой.

Манай Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд 6 сарын өмнө Өмнөговь аймгийн ард иргэдэд юу гэж хэлснийг одоо тод санах ёстой, та нарт хамгийн их хайртай гэж хэлээ биз дээ.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Энэ тухай түрүүн зөндөө ярьсан, зөндөө хариулсан. Шадар сайд зөндөө хариулсан, Сангийн сайд зөндөө хариулсан, ойлгож байгаа байх, ойлголт сайтай байгаа байх. За Ч.Эрдэнэгэрэл Хууль зүйн шинжлэх ухааны доктор. Ч.Эрдэнэгэрэл мөн үү та?

Сонсголд оролцогч Ч.Эрдэнэгэрэл: Энгийн иргэн болохоор нөгөө автобус зогсохоос өмнө явчих гээд л байна. 3 цаг түгжирдэг болохоор өнөө шөнөдөө харихгүй л юм болов уу даа гэж бодож байна. За баярлалаа, тэгээд ер нь явъя даа гэж бодож суулаа. Ер нь манай Монголын ард түмэн бол ухаантай, ард түмэн. Бүгдийг ярилаа, бүгдийг ярьчихлаа одоо гол нь хийчих юм бол.

Өнөөдөр Эдийн засгийн байнгын хороо хуралдаж байгаа болохоор Эдийн засгийн байнгын хорооны хурлын маань энэ үр дүнг Улсын Их Хурал, Засгийн газарт, Ерөнхийлөгчид өргөн барих нь зөв юм байна гэж ойлгож байна.

Миний хэлэх гээд байгаа юм бол энэ Монгол улсын хүний эрхийн байгууллагууд хайчихсан юм. Гадаа өнөөдөр бид нар энэ гадаа зогсоод байгаа энэ залуучуудынхаа, иргэдийнхээ төлөөллөөс орж ирсэн шүү дээ. Түүнээс биш бид нар дулаан газар ингэж дулаацах гэж орж ирээгүй шүү дээ. Миний иргэд тэнд ингээд цагдаагаар мануулаад, ингээд цаашаа хөөгдөж туугдаж байхад, бид яагаад өнөөдөр гадаа гараад хурлаа хийж болохгүй гэж?

Миний энэ шинжилгээ судалгааны ажил бол баривчлах шийтгэл, гүйцэтгэлтэй ажиллагааны эрх зүйн онол практикийн ач холбогдол дээр судалгаа хийж байгаа. Гэртээ тэтгэвэртээ гараад зүгээр суучих гэсэн чинь ард иргэдийн хүүхдүүдийг зулгааж аваачаад ингээд 461 рүү хориод байх юм. Тэгэхээр аргаа барахдаа хуучин оны хуульч хүн учраас шинэ оны хуульчийг харьцуулж судлах гээд ингээд орсоор байгаад ороод явж байна. Төгсөх, төгсөх эсэх нь бол одоо тэгээд тухайн үедээ л болох байх, миний гол нь юу хэлэх гээд байна вэ гэвэл 2006 оноос эхлэлтэй юм шүү, энэ улсын энэ нүүрс чинь ... /бичлэг сонсогдоогүй/.

Монгол улс өнөөдөр байна уу? өнөөдөр ард түмэндээ илтгэлээ тавиад өгнө гэдэг чинь бол Монголын хөрс байхгүй болчихсон, би ойлгохдоо бол Монгол Улсыг 21 аймагтай гэж боддог юм, тэгсэн чинь 150 аж ахуйн нэгж нь, хэд гэвээ 53 гаруй уулыг ухчихсан гэнэ. Тэгтэл

нэг би тоо бодоод 21 аймгаас давчхаад байх шиг байх юм. Энэ аргаа бараад та нар нь нээрээ гараад ирчихсэн юм биш биз дээ? эсвэл та нар нэг уул авчих гэсэн чинь юмгүй болчхож уу?

Энэ чинь 2006 оны Эм Си Эс компани дээр олон улсын хурал зарлагдсаныг Намбарын Энхбаяр гуай тэр сонгууль дээрээ би тэр хуралд суусан гээд хэлчихсэн шүү дээ. Тэгэхээр 2012, 2013 оноос эхлэлтэй гэж энэ яриад байх юм.

Нөгөө босоо Ганбаатар маань ер нь энэ олон нөгөө Оюутолгой энэ тэр гээд байснаа ер нь яг детальчлан өгвөл яасан юм?

Өнөөдрийн бид нарын энэ микрон доор ард иргэдийнхээ өмнө хүсэл бодол зорилго зорилгоо өөрийнхөө хүсэл зорилгын илэрхийлэл дээр хэлж байгаа учраас бид ерөөсөө бид нар баривчилгаанд орохгүй. Хуулиас захиалагч гэдэг үгийг аваад хаячихсан болохоор гадаа болж байгаа хууль маань нөгөө хуулийнхаа дагуу үйлчлээд л зохион байгуулагчгүй хийж байгаа юм байна лээ. Зохион байгуулчихвал зохион байгуулагч маань хар дээр цагаанаар бичсэн нөгөө хуулиараа, нөгөө ялаа аваад явчихна зүгээр тодорхой.

Тэгээд энэ Улсын Их Хурлын гишүүд чинь одоо сандал хараад байх юм би, сандал л хараад байгаа юм, би ч бас. Эд нар бол машинтай л байх л даа, арай над шиг ингээд насаараа явган яваад байхгүй. Үгүй ээ, тэгээд одоо юундаа яардаг юм? Та нарын талбайн урд талд 3 цаг иргэдээ зогсоож байгаад л гүпэрлээд явдаг шүү дээ гэр лүүгээ. Амьд махаараа ойлгодог юм.

Миний юу хэлэх гээд байна вэ гэвэл энэ байна, их удаасан учраас би жоохон яасан, түрүүн нэг өгүүлбэр хэлчхээд л гараад явчихсан бол уг нь та нарт амар байх байлаа. Миний хэлэх гээд байгаа бол энэ төгс үйлдэгдсэн гэмт хэрэг юм. Төгс үйлдэгдчихсэн гэмт хэрэг энэ 2006 оноос авхуулаад энэ 4 жилийн одоогийн яг сууж байгаа Улсын Их Хурлын гишүүдээс өмнөхөөр таслахаараа төгс үйлдэгдчихсэн гэмт хэрэг. Тэгж харагдаад байна. Энийг одоо нөгөө тэр авлига юу билээ? Прокурорын ерөнхий газрын даргын туслах, даргыг төлөөлөгч бүсгүй тайлбарлах байх аа, надаас илүү прокурор хүн.

За хоёрдоод ирэхэд юу вэ? гэвэл тэр хүмүүс нь төгс үлдчихсэн байна шүү дээ хэргээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ороод тэгээд ялаа аваад явах ёстой юм.

Дараагийн энэ жилийн одоогийн 4 жилийн төрийн түшээ та бүхэн, та бүхний ял байна шүү дээ, үргэлжлүүлэн гэмт хэрэг. Яагаад гэвэл Сангийн сайд маань өнөөдөр алгаа ташсан хүнийг та босгодог хэн юм? бид өнөөдөр өөрийнхөө хүсэл зоригоор орж ирсэн болохоос таны эрхшээлд, таны албанд ажиллаж байгаа юм уу. Яадаг юм яагаад алгаа ташиж болохгүй юм? Өнөөдөр тэнд хүмүүс ганц эмэгтэйг би муу хэлэхгүй, хөлдлөө барилаа гээд нөгөө төрийнхөө ажлыг юу билээ? Нөгөө Ерөнхий сайдаасаа Ерөнхийлөгч болчихсон байгаа хүн байгаад байгаа биз дээ?

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За баярлалаа, санал хэллээ Ч.Энхгэрэл. Т.Баярхүү Өргүй Монголын төлөө Төрийн бус байгууллага, Т.Баярхүү байна уу? байхгүй юу? Б.Энхмөнх, Сүхбаатар дүүрэг байна уу?

Сонсголд оролцогч, иргэн Б.Энхмөнх: За анхнаасаа л хурлынхаа зохион байгуулалтыг зөв цэгцтэй, иргэдтэйгээ хамтдаа суугаад хийчихсэн бол өнөөдрийн асуудал үүсэхгүй байсан л гэж би хувьдаа хэлмээр байгаа юм. Төр нээлттэй бай, юунаас айгаад байгаа юм, зүгээр л иргэддээ нээлттэй бай, ойлгох цаг үед нь иргэд чинь ойлгоно шүү дээ.

Монгол ардын нам эрх барьж байгаа он, цаг, хугацааг ингээд анзаараад байхлаар

надад нэг хэд хэдэн юм анзаарагдаад байгаа юм. 2016 онд эхлээд 2017 онд нэлээн хүчийг аваад явсан 60 тэрбум гэгчийн хэргийг гаргаж ирснээр Монгол ардын нам Миеэгомбын Энхболд тэргүүтэй хотын фракцынхаа гар хөлөөс салсан юм. Энэ 60.0 тэрбумын хэрэг дээр ямар ч хүн хариуцлага хүлээгээгүй.

Үүний дараа 2018 оны 11 дүгээр сард дээр Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийн сангийн хэрэг гэгчийг гаргаж ирсэн. Энэ ажлаараа Янгугийн Содбаатар, Жадамбаагийн Энхбаяр тэргүүтэй Улсын Их Хуралд олон удаа сонгогдсон, 30-40 орчим гишүүдээсээ салсан юм. 2020 оны сонгуулийн өмнө. Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийн сангийн хэргээр нэг ч Монгол ардын намын гишүүн хариуцлага хүлээгээгүй. Магадгүй сангийнх нь дарга хөөрхий чааваас дохио зангаагаар хөдөлж байсан хүн шоронд ял аваад явсан байж магадгүй.

Үүний ар дээр 2018 оны 12 дугаар сард шударга ёс шаардсан 5 гишүүний жагсаал, үүгээрээ далимдуулаад Улсын Их Хурлын дарга, тухайн үед Монгол ардын намын дарга байсан Миеэгомбын Энхболд гэж хүнээс салж авсан юм. Хотын фракцын үлдэгдлээс салж авсан гэсэн үг. За ингээд хотын фракц үндсэндээ 2018 оны 12 дугаар сараар дуусгавар болоод Монгол ардын нам хүмүүсээс салж авч байгаа юм.

За үүний ар дээр 2022 оны 2 дугаар сараас эхлээд Хөгжлийн банкны луйвар гэх хэргээр дамжуулаад Монгол ардын намын лав л 8-10 гишүүн энэ хэрэгт холбогдож 2024 оны өмнө байхгүй болно. Энэ бүхний цаад талд яаж байна гэхлээр зэрэг иргэдийн амьдрал хэцүү байна аа, иргэд чинь ажлаа хийгээд өгөөч ээ, эрх баригчид аа ажлаа хийгээд өгөөч ээ гээд гараад ирэхлээр Монгол ардын нам иргэдийн өмнө нэг том дайсан гаргаж ирдэг юм. Нэг том дайсан гаргаж ирнэ, тэр дайсан руугаа иргэдтэйгээ нийлээд оръё, тэмцье, бидний хүч дутаад байна, шүдгүй арслан болчихоод байна гэж хэлээд иргэдтэйгээ нийлээд дайрдаг байхгүй юу. Ингээд эцсийн бүлэгтээ яадаг вэ гэхээр зэрэг энэ бүх улс төрийн цаад тал дээр Монгол ардын намын голыг зангидаж байсан хүмүүс намынхаа дотоод хоронд хордоод, өөрсдөө хэн ч үгүй болоод, ард иргэд болохоор зэрэг бүх зовлон зүдгүүр нь асуудал нь шийдэгдээгүй, хэрнээсээ нэг том мангасыг дарсан сэтгэл зүйтэй болоод гэр лүүгээ харьдаг байхгүй юу.

Өнөөдөр энэ нүүрсний хэрэг гэдэг асуудлыг үүсгээд гаргаж ирээд явж байна. Энд Монгол ардын намын маш олон гишүүд хамааралтай холбоотой байгаа, энэний ар тал дээр юу хийж байна гээч. Энэний ар тал дээр Ерөнхий сайд чадваргүй байгаагаа, Засгийн газар чадамжгүй байгаагаа, иргэдийн амьдралын амьжиргааг өөдрөг дээшлүүлж чадахгүй байгаа алдаа дутагдлаа бүх юмаа нууж хаацайлж байгаа. Тэгэхэд бид нар яаж байна гэж нүүрсний хулгайчдыг зарла, нүүрсний хулгайчид хариуцлага тооц. Мэдээж зарлаад хариуцлага тооцоод явах асуудал өнгөрсөн 6 жилийн хугацаанд бол юу хийж байсан юм. 65 суудалтай 4 жил, одоо 62 суудалтай 3 дахь жил рүүгээ ороод явж байгаа эрх баригчид энэ нүүрсний хулгайтай, тэгвэл өнгөрсөн 6 жилийн хугацаанд тэмцэхгүй, одоо юугаа хийж байсан юм бэ.

Өнөөдөр нүдэнд нь нулимс цийлгэнээд л нүүрсний хулгайтай тэмцэх гэж байхад Ардчилсан намынхан ингэлээ тэглээ гээд муу юм болгоныг Ардчилсан намтай аваачиж хольдог, муу юм болгон дээр Ардчилсан намынхныг аваачиж харлуулдаг. Сүүлийн 6, 7 жилийн хугацаанд гудамжинд байгаа Ардчилсан намынхныг бүгдийг нь аваачиж гэмт хэрэгтэн болгодог ийм процессыг энэ эрх баригчид хийж байна.

Иргэдээ нэг юман дээр маш ухаалаг хандах хэрэгтэй. Ерөнхий сайдаас яагаад амьдрал чинь өөдлөхгүй байгаа тухай асуу. Орлого чинь яагаад сар тутамдаа орж ирдэг мөнгө чинь бараа бүтээгдэхүүн авч чадахгүй байгаа тухайгаа Ерөнхий сайдаас асуу. Ерөнхий сайдыг ажлаа хийж чадахгүй бол огцор гэж шаард. Мэдээж энэ нүүрсний хулгай үүний ар тал дээр ямар процесс үйл явдал өрнөж байгаа гэдгийг шаардах хэрэгтэй. Хууль хяналтын байгууллагууд энэ дээр ажил. Би энэ дээр гайхаад байдаг юм.

Тэр хил дээр байж байгаа мэргэжлийн 7 агентлаг байж байгаа шүү дээ. Тагнуул, мэргэжлийн хяналт, татвар, гааль энэ улсууд ер нь яг тэр өнгөрсөн хэдэн жилийн хугацаанд ер нь яг юу хийсэн юм, энийг хэн томилж байсан юм, эрх баригчид л томилж байсан шүү дээ тэгэхлээр хулгайч нь та нарын дотор бий.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Төрийн албан хаагч гээд татвар төлөгчдийн мөнгөнөөс цалинжиж байгаа хүн шүү. За одоо ингээд нөгөө хуулиараа урьдчилаад Ерөнхий хяналтын сонсголд үг хэлнэ гэсэн 55 иргэд маань үг хэлээд дууслаа. За одоо тэгээд дараагийн ажил бий. Дараагийн үе дуусаагүй байхад чинь юун түрүүнд хөл, гар нь гозойгоод ирдэг юм. Заалнаас нэр өгсөн улсууд байна. Үг хэлнэ гээд 27 хүн нэр өгсөн байна аа. Тэгээд одоо яриад л байх уу? Одоо Улсын Их Хурлын 2 гишүүн үг хэлэх юм. Нэг нь үг хэлнэ шүү. Цогтбаатар гишүүн байна уу? Цогтбаатар гишүүнээр үг хэлүүлчихье. Асуулт асуугаад, үг хэлнэ гэсэн юм. Цогтбаатар гишүүн байхгүй байна уу? Аан за. Том дэлгэцийн араас харагдахгүй байна.

УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар: За та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Надад хоёр асуулт, нэг хэлэх зүйл байна.

Нэгдүгээрт, энэ маш ноцтой асуудал яриад байгаа. Та бидний бүгдийн одоо өнөөгийн амьдарч байгаа Монгол Улсын хувь заяанд ямар нэгэн байдлаар хуруу дүрчихсэн, таны, миний, бидний бүгдийн амьдрал руу хуруу дүрчихсэн ийм асуудал яриад байна л даа. Тэгэхдээ энэ дээр энэ зөвхөн Монголын асуудал биш болсон. Энэ одоо дэлхийн асуудал болсон шүү. Дэлхийн бүх мэдээгээр Монголын төр шившгээ тарилаа. Гэхдээ энэ дээр нэг юмыг орхиж болохгүй, ийм тодорхойгүй тоогоор дэлхий дээр гараад яриад байж болохгүй. Энэ бүх тоонууд нь маш тодорхой болох ёстой. Тэгэхээр энд одоо хууль хяналтын байгууллагынхан байж байна, энэ Монгол Улсын чинь нэр хүнд та нар яг яаж ажиллахаас аягүй их хамаарах болчихоод байна. Тэгэхээр энэ тоонууд бүгдээрээ эцэстээ баримттай. Түүнээс улс төрийн яриан дунд дурддаг ийм тоогоороо үлдэж болохгүй шүү. Би тэгэхээр хууль хяналтынхнаас энэ дээр онцгой анхаарч ажиллаасай гэж хүсэж байгаа. За миний хэлэх гэсэн юм энэ.

За Гаалиас асуух асуулт байна. Нэг зүйлийг аягүй их ярилаа. Тэгэхээр энэ ингээд хулгай гээд яриад байхад хамгийн гол гогцоог нь гаргаж ирэх юм нь энэ үнийн динамик байгаа. 10 жилийг ярьж байгаа. Энэ үнэ нэг хэмжээндээ тогтоод байгаагүй. Гаалийнхан энийг ярихгүй байна. Энэ 10 жилд энэ нүүрсний чинь үнэ хамгийн доод цэг нь хэзээ байсан юм бэ? Хамгийн дээд цэг нь хэзээ байсан юм бэ? Хамгийн доод цэгтээ хэр удсан юм бэ? Энэ 10 жилд мэдээж өсөөд л, хөдлөөд л явж байсан. Тэгэхээр нийт нийлсэн хугацаандаа энэ доод хэмжээндээ хэр удсан бэ? Дээд хэмжээндээ хэр удсан бэ? Энийг тооцож байж дараа нь тэр хулгайч нь гарна. Яагаад гэвэл та нар ингээд нүүрс алга болчихсон тэрийг хулгай гэж бодоод байна. Нүүрс чинь байж байхад ч хулгай явж болно. Яагаад гэвэл үнийн зөрүү дээрээс л хулгай хийх байхгүй юу? Нүүрс нь гардгаараа гарчихсан. Гэтэл нэг үнээр зараад, тэнд очоод өөр үнээр хийж байгаа бол гаалийн бүртгэл дээр нүүрс чинь хэвээрээ л байж байгаа. Гэхдээ мөнгө шал өөр газар хийгдчихсэн явж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр энэ үнийн динамикийг би мэдмээр байна? Хэзээ, ямар доод цэг нь, дээд цэг нь ямар байсан юм бэ?

Хоёр дахь миний асуулт. Аан тэгээд үнэлгээний энэ арга дээрээ их анхаарах хэрэгтэй. Одоо энэ Жавхлан сайд ч яриад байна. Ер нь Дэлхийн худалдааны байгууллагын GATS 94-ийн 7 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хэлэлцээрийн дагуу гаалийн үнэлгээ гэдэг чинь аягүй нарийн процесс өөрөө. 7 байна уу, 6 арга байгаа. Хэлцлийн үнэ гэж байгаа. Тэгээд манайх бол шууд жишиг үнэ рүү яваад байдаг. Тэр жишиг үнэ АМНАТ дээр бариад байгаа. Тэгтэл энэ 10 жилийн хугацаанд энэ үнэлгээг хийхэд хэлцлийн үнийг нь хэзээ, хэзээ барьж байсан

бэ? Хэзээ тэр жишиг үнүүд рүү орж байсан бэ? Эндээс маш том ялгаа гарна шүү. Хятадын тэр худалдааны статистиктай зөрөөд байгаа чинь Хятад Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орон болохоор энэ үнэлгээний нэгдүгээр дүрмийг ашиглаад байгаа буюу тэр нь шууд хэлцлийн үнэ байх ёстой. Тэгээд эндээс манайх жишиг үнэ ашиглаад байхаар ялгаа гарсан байж магадгүй. Энийгээ та нар нягталж үзээрэй. Хамгийн гол юм нь сая миний хэлдэг тэр. Би хүлээж байгаад л, би өглөөнөөс асууж байгаад л, өглөөнөөс хүлээж байгаад л надад олдож байгаа цаг нь энэ. Гэхдээ энэ бол аягүй чухал шүү. Энэ хэргийг илрүүлэхэд энэ мэргэжил би бол худалдааны чиглэлээр маш олон юм бичиж байсан хүн. Тийм учраас энийгээ мэдэхгүйгээр энэ үнийн зөрүү хаанаас гараад, юу болоод байгааг бид нар үнэхээр олж тогтоохгүй шүү. Тэгээд энийг хууль хяналтын байгууллагынханд хэлмээр байгаа юм. Бид нар харж байгаа шүү. Эндээс нэг ингээд хялбархан арга саам хэрэглээд гарчихна гэж байхгүй шүү. Энэ олон хүн харж байгаа шүү гэдгийг хэлэх гэсэн юм. Энэ харин үнэлгээний тэр арга дээрээ аргачлалаа нэг тайлбарламаар байна аа. Алийгаа илүү их бариад байгаа вэ?

Гурав дахь миний нэг хэлэх гэсэн юм юу гэхээр түрүүн энэ залуучууд хэлээд байна лээ. Олон улсын аудит хийлгэнэ гээд. Тэгэхээр зөвхөн энэ хэрэгтэйгээ холбогдуулж хэлэх гээд байна. Би энэ байгууллага чинь одоо энэ хямралын дараа цаашаа амьдрал үргэлжлээд явна. Тэгэхээр миний бодож байгаагаар бараг 3 жил онцгой дэглэм тогтоогоод, гадаадын аудитын байгууллагаас тэр аудитынхаа хяналтыг тавиулаад явж байх нь зөв байх. Мэдээжийн хэрэг үнэтэй тусч магадгүй. Гэхдээ дотооддоо үгсэн нийлж байгаад хулгайлаад байгаа бол тэр хулгайнаас чинь хамаагүй хямдхан тусна. Тийм учраас тэр гадны байгууллагаар аудит хийлгэж байх нь энэ хөрөнгө оруулагчдын эрх нь.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За хэн хариулах юм бэ? Тэр үнийн динамик гээд байх юм. Хэн хариулах юм? Гаалийнхан хариулах юм уу Сангийн сайд? Хууль хяналтынхан хариулах юм уу? За Гаалийнхан хариул. Тэр үнийн динамиктай холбоотой асуулт асуугаад байна. За иргэд минь бие биедээ хүндэтгэлтэй хандана шүү. Гишүүд бас ч гэж их тэвчээртэй хүлээгээд. Тав, зургаан иргэн үг хэлүүлээд нэг гишүүн үг хэлж байгаа шүү. Бие биедээ жаахан хүндэтгэлтэй, хаа хаанаа жаахан тэвчээртэй байна шүү. За Гаалийн дарга хариулъя. Тэр үнийн динамиктай холбоотой. За Гаалийн ерөнхий газар, Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газрын дарга Сүхбаатар хариулъя.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Одоо тэгээд тэр энэ заалнаас өгсөн нэр чинь одоо л эхлэх гэж байна шүү дээ энэний дараагаар. За Гаалийн дарга хариулъя.

Гаалийн ерөнхий газрын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газрын дарга Б.Сүхбаатар: Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орон. Дэлхийн худалдааны байгууллагын Тариф, худалдааны ерөнхий хэлцэл гэж байдаг. Энэ хэлэлцээрийн холбогдох заалтуудад үндэслэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаар экспортын барааны гаалийн үнийг үндсэн 4 аргаар тодорхойлдог. Энэ дээр барьж байгаа ялангуяа экспортын ашигт малтмал дээр барьж байгаа гаалийн үнэ тодорхойлох үндсэн аргачлал бол хэлцлийн үнийн аргыг баримталдаг. Өөрөөр хэлбэл гадаад худалдаанд оролцож байгаа худалдагч, худалдан авагч талуудын хооронд хийгдсэн хэлцлийн үнэ дээр Монгол Улсын хилийн өртөө хүртэлх зохих нэмэгдэх зардлуудыг нэмээд тухайн одоо гаалийн үнийг тодорхойлж гаргаж ирдэг. Гэхдээ энэ дээр би нэг зүйлийг тодотгож хэлэхэд экспортын бараан дээр бол Монгол Улс гаалийн татваргүй орон. За сүүлийн ингээд арваад жилийн үнэлгээний одоо үнийн дундаж динамикийг харах юм бол, 2013 оны байдлаар Монгол Улсын хилийн 4 боомтоор экспортлогдсон нүүрсний нийт үнийн дүн 1.1 сая ам.доллар гэх мэтээр 2014 онд 847 мянга, 2015 онд 548 мянга, 2016 онд 971 мянган ам.доллар гэх мэтээр ингээд явж байгаа. За 2020 оны байдлаар нийтдээ 2.1 сая америк долларын нүүрс экспортолсон байгаа бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 2.7 сая, 2022 оны 9 сарын байдлаар 4.5 сая америк долларын нүүрс экспортоор гаргасан байгаа.

Тэгээд эндээс ер нь бол дундаж үнэ жил ирэх тусам ер нь өссөн ийм динамиктай байгаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За одоо ингээд заалнаас шинээр нэр өгсөн 27 хүн байна. Энэ 27 хүнийг надад ажлын албанаас дараалалд оруулж өгсөн байна. Одоо дарааллаар үг хэлнэ ээ. С.Эрдэнэбат Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо.

МҮЭХ-ны ерөнхийлөгч С.Эрдэнэбат: Би яриагүй шүү. Түрүүн өдрөөс хойш дандаа намын хүмүүс үг хэллээ. Би Үйлдвэрчний Эвлэлийн байгууллагыг төлөөлж байна. За юу ч яриагүй байна. Та нар байж байгаарай. За цаг яваад байна шүү. Тэр хүмүүсээ. Би бас нэлээн юм ярих учраас. Цагаа байж байгаарай.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За хоёрдугаар микрофоныг өгье.

МҮЭХ-ны ерөнхийлөгч С.Эрдэнэбат: Би товчхон хэдэн асуулт асуугаад, тэгээд санал хэлчихье гэж бодож байна. 17,000 машин хоосон гарсан гэж байна. Хил рүү цаашаа хоосон гарах шалтгаан бараг байхгүй л дээ. Тэгээд хэрэг нь тодорхой. 515,000 тонн эх үүсвэргүй нүүрс гарсан байна аа гэж. Хаанаас авсан нь тодорхойгүй. Мөргөцөг алга болгосон. Одоо хэдэн мянган тоннын, 370 гаруй мянган тонн тэрнээс ч их байж магадгүй. Бүхэл бүтэн мөргөцөг гэж уулархуу юм алга болсон гэж. За тэгэхээр ер нь энэ гэрээ контрактуудыг яагаад нуусан юм бэ? Аж ахуйн нэгж байгууллагын шинжтэй гэрээнүүдийг анхнаасаа нууна гэдэг чинь өөрөө энэ хулгай луйвар бий болох эх үүсвэрийн хөрсийг нь бэлдэж өгсөн асуудал байна гэж.

Хоёрдугаарт, өчигдөр 2 УИХ-ын гишүүн бас үг хэлж байсан. Тэр төмөр замыг барихад 1.5 тэрбум ам.доллар буюу нэлээн өндөр өртөгтэй барьсан гэж. За өчигдөр тэр барьсан хүн бол мэдэгдэл хийж байна лээ. Би яг тэрүүтгээр бариагүй гэж. 1.2 тэрбум ам.долларыг 234 километр хуваахаар нэг километр нь ойролцоогоор 1.5 сая ам.доллар, тэрбум ам.доллар, одоо сая ам.доллороор барьсан байгаа. Энэ нь өөрөө олон улсын жишгээс нэлээн өндөр өртөгтэй байна аа гэж нэг. Тийм учраас энэ тал дээрээ одоо тэр мэдэж байгаа хүмүүс нь тодорхой баримттай учраас тэрийгээ гаргаж ирээрэй гэж.

За хоёрдугаарт нь маш олон аж ахуйн нэгж, байгууллагууд үйлчилгээ нийлүүлжээ. “Эрдэнэс Тавантолгой” ХК-д одоо ажил олгогчийн хариуцлагын даатгал, янз бүрийн даатгал нэрээрээ хэдэн арван тэрбумаар нь хийсэн байна. Ажилтны даатгалыг тийм их, одоо 1 жилд гэхэд хэдэн тэрбумаар нь хийдэггүй юмаа. Тэнд ажиллаж байгаа ажилчдаас би асуусан. Та нарт ямар үйлчилгээ үзүүлсэн яасан юм гэж? Энэ бол зөвхөн жишээ татаж байгаа юм. Дээрээс нь энэ төрийн өмчит төсөл болгон концесс болгон нийлүүлж байгаа нь дандаа өндөр өртөгтэй байна аа гэж. Тийм учраас би юу хэлэх гэж байна вэ гэхээр одоо энэ ажлын хэсэг, хянан шалгах ажлын хэсэг дээр дэд ажлын хэсгүүд оруулаад энэ гэрээ контракт болгоныг нь энэ жагсаж байгаа, цуглаж байгаа хүмүүсийн тодорхой төлөөллийг нь оруулаад, институт байгууллагуудыг оруулаад, мэргэжлийн одоо аудитуудыг оруулаад ингээд ажиллахгүй бол энэ ажил урагшаа явахгүй ээ. За нөгөө талаараа хууль хяналтын байгууллагууд маань бас эр зориг гаргаарай, магадгүй дарамт шахалтад өртөж байж магадгүй. Би энэ ЗГ-ыг одоо энийгээ өөрсдөө ил гаргаж ирээд энэний төлөө бас улс төрийн эр зориг гаргаад хариуцлагыг нь тооцье гээд ийм зүйл ярьж байгаад нь баяртай байгаа. 10 жилийн хэргийг сөхөж ярих юм байна. Тэгэхээр намууд ч гэсэн дотроо асуудлаа яриарай. Ардын нам ч байгаа, Ардчилсан нам ч байгаа. Өөр одоо сүүлийн хэдэн жил ямар нам байсан юм.

За ард түмэн өнөөдөр яг өнөөдөр юу хүлээж байна вэ гэхээр энэ хулгайг илрүүлээд, хулгайлсан мөнгийг нь буцааж авчраад нэгдүгээрт 1072 хувьцааныхаа ашгийг авмаар байна

аа гэж. Тэгэхээр ойрын хугацаанд би Ганбат даргаас асуумаар байна. Тэр 1072 хувьцаанд ноогдол ашиг өгөх тийм найдвар байна уу, байхгүй байна уу? Эс үгүй бол аль хэдийн 2024 оноос нааш одоо байхгүйгээр ингээд оффтэйк гэрээгээрээ юу хийж байна уу?

Хоёрдугаарт, сүүлийн 10 жилийн хугацаанд цалин хөлс маань 450 доллар дээр л гацлаа Монголын ард түмний. 10 жил. Гэтэл жил болгоны төсөв дээр санхүүгийн эх үүсвэр байхгүй байна аа, хүнд байна аа гэдэг асуудал яригддаг. Гэтэл цаана нь энэ их наяд, тэрбумаар нь яригдах мөнгөнүүд ингээд явж байдаг. Төсвөөс гадуур маш том мөнгө эргэлдэж байгаа. Тийм учраас цаашдаа энэ асуудал дээр манай хууль хяналтын байгууллагууд бол тодорхой, үнэхээр одоо өөрөө орооцолдчихсон, өөрөө хараат байгаад шалгаж чадахгүй бол энэ албан тушаалаасаа больж байгаад өөр хүмүүсээр шалгуулах бас ийм юм байгаа шүү. Тийм учраас би энэ Авлигатай тэмцэх газар маань бас нэг талаар бас заримдаа хүн хэлмэгдүүлээд байдаг бас тийм угшилтай газар. Тэгэхдээ одоо бас өөрчлөгдсөн байх гэж бодож байгаа.

Нөгөө талаар энэ УИХ одоо сүүлийн энэ жилүүдэд байгаа 500-аад албан тушаалтан байна гэсэн. Энэ хүмүүс маань одоо үнэхээр ямар нэгэн байдлаар бараа бүтээгдэхүүн нийлүүлээд нүүрстэй холилчихсон бол өөрсдөө сайн дураараа бүрэн эрхээсээ татгалзаж байгаад шалгуулаад ингээд бүгдээрээ ингэчих юм бол одоо энэ талбай дээр заавал нэг хэдэн залуучууд өлсөөд, хэвтээд л, хөлдөж үхэх гээд байх шаардлагагүй юм болов уу гэж би бодож байна. Дээрээс нь нэг зүйлийг хэлье, одоо цаашдаа яах вэ гэж. Ард түмэнд одоо өнөөдөр цалин орлого л хэрэгтэй байна. Энэ үнийн өсөлтийн эсрэг л юм хэрэгтэй байна. Түүнээс биш одоо хэн нэгэн хүнийг шонд аваачиж дүүжлэх гэдэг нь тэр хууль эрх зүйн хувьд хүлээх болов ч гол үр дүн нь цаашаа яваа. Бүх төрийн өмчийн компаниудын ТУЗ-ууд ажилчдад нь хувьцаа олго оо. Дотроосоо хулгай хийгээд байгаа юм. Ажилчдад нь хувьцаа олгочих юм бол тэр хулгайг хийлгэхгүй.

Дээрээс нь шүгэл үлээсэн хүн болгоныг дарамталдаг, шахдаг хэн ч биш болгодог. Түүрүүн Цогтбаатар дарга бас нэлээн зөв юм ярьж байна шүү. Олон улсын хэрэг болчихсон. Би одоо яагаад түүрүүн үг хэлэх гээд байсан бэ гэхээр яг одоо манай Олон улсын үйлдвэрчний эвлэлийн холбооны хурлаар яг энэ асуудлыг би тавьсан. Олон улсын экспертүүдийг би олон улсын үйлдвэрчний эвлэлээс дуудаж авчирна.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За санал хэлчихлээ дээ, үг хэлчихлээ. За иргэн Х.Батсуурь хаана байна вэ? Х.Батсуурь.

Сонсголд оролцогч, иргэн Х.Батсуурь: Байна. Их тэвчээртэй суулаа. Өмнө нь гомдол мэдүүлмээр байна, яг энэ гомдол мэдүүлчих гээд болдоггүй, за больё доо тэгээд. За одоо эхэлье, эхэлье. За баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Юу эхэлье гэж?

Сонсголд оролцогч, иргэн Х.Батсуурь: Цаг.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За нэгдүгээр микрофон.

Сонсголд оролцогч, иргэн Х.Батсуурь: Та цагаа эхэлчих. За баярлалаа. Тэгэхээр юу юмаа Чинзориг сайдаа. Би түүрүүн энэ Цогтбаатар гишүүний хэлсэн үгтэй санал нийлж байна. Үнийн зөрүү бол асар том асуудал юм аа гэсэн. Ингээд хараад байхад та нар өөрсдөө эрх баригчид өөрсдөө сайд нар, гишүүд маань өөрсдөө баахан тоо хэлээд, тэрэндээ будилаад өөрсдөө учрыг нь олохоо байгаад ингээд тийм хачин байдал үүсгээд байна л даа. Зарим нэг нь ингээд 40 их наяд гэнэ. Тэрэндээ логиктой зөв тайлбар аль нь ч хэлсэнгүй энэ удаан

хугацаанд харахад тийм ээ. Зарим нэг нь улсын төсөвтэй тэнцэх хэмжээний алдагдал гарлаа гэнэ. Тэрийгээ тооцоод үзэхээр тэр үнэхээр улсын төсөв гэдэг чинь 4-өөс 5-хан тэрбум доллар л байдаг сүүлийн 5 жилийн байдлаар аваад үзэхэд. Тэрийг нь 4, 5 жилээр бодоод үзэх юм бол арван тав, хорин тэрбум доллар болдог. Тэгээд арван тав, хорин тэрбум долларыг чинь бодохоор тавь, жаран их наяд болоод байгаа юм. Тэгээд тэр нь бодитой юм шиг харагдаад байна. Гэтэл энийгээ нэг зөв логиктой, уялдаатай ойлгоод тайлбарлаж чадахгүй байна. Үнэндээ харамсалтай байна шүү.

За 40 их наяд гэж яриад байна. Тийм ээ, би магадгүй одоо тэгсэн хэрнээ энэ тээвэр дээр аваачаад нэг тонныг нь 27, 30 километр газар 400,000 доллароор зөөж байж гэж. Ийм утга авцалдаагүй логикгүй юм битгий ярь аа, үнэмшилтэй юм ярь. Тэрүүгээр чинь бодох юм бол ердөө хоёр, гуравхан өдрийн дотор тийм ээ, энэ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн орлоготой тэнцэх хэмжээний зардал гаргаад тээвэрлээд гаргачих юм байна лээ. Тэгэхээр энийгээ зөв бодож ойлгож яриач ээ. Юмаа ойлгоогүй байж ингэж битгий худлаа яриад байгаач ээ гэж хэлмээр байна та нарт. За тэр үнэхээрийн тийм их алдагдал гараад байгаа юм уу гээд тооцоод үзэхээр үнэн юм билээ, бодитой юм билээ тийм ээ. Тэгэхээр хүний санаанд оромгүй 50, 60 их наяд төгрөгийн алдагдал гарсан юм уу гэвэл үнэхээр бодитой юм байна лээ. Энийг би тооцоолсон гэдгийг та нарт одоо харуулмаар байна.

Сая энэ Цогтбаатар гишүүний ярьсан тэр үнийн зөрүү, ганцхан үнийн зөрүүгээр тооцоод үзэхээр л тэгж гараад байгаа байхгүй юу? Түрүүн бас Уул уурхайн ассоциацийн нөхөр ярилаа. Энэ үнийн зөрүү асар их байна аа. Энэ Хятад, Монголын хамтарсан бүлэглэл энэ боомт дээр ажиллаад байна аа гэж яриад байгаа. Тэгэхээр үнийн зөрүүг үнэхээрийн тэр хувийн компаниуд тийм ээ, Ганц модны боомтын нөхцөлөөр ч юм уу, хил давуулаад зараад болоод байгаа юмыг яагаад заавал манай “Эрдэнэс Тавантолгой” ХК аман дээр нь 60 доллароор зарах гээд гүрийгээд улайраад байгаа юм бэ? Энэ талаар би олон жил ярьж байгаа шүү. Тэгэхээр энэ дээр үнийн зөрүүг тооцох юм бол болж байна за юу. Яг одоо өнөөдрийн байдлаар, за энэ 7 хоногийн байдлаар за юу, энэ ирсэн мэдээгээр би энэ Хятадын нүүрсний зах зээлийн судалгаа хийдэг институттэй ингэж холбогдож энэ мэдээллийг аваад байна л даа. Тэгэхээр энэ дээр одоо түүхий нүүрс, Монголоос ирсэн түүхий нүүрс, Ганц модны боомт дээр гэж байгаа шүү энэ тодорхой бичсэн байна энэ. Ганц модны боомт дээр одоо өнөөгийн байдлаар 2000-аас 2100 юань гэж байгаа юм. Энийг нь тооцоод үзэх юм бол 298-аас 315 доллар болчихоод байгаа юм аа. Энэ бол Ганц модны боомтын үнэ байгаа юм. Тэгээд энэ чинь 270 километр зөөгөөд л тэнд аваачаад зарчих юм шүү дээ. Энэ үнийн зөрүү одоо жишээ нь 200 доллароор тооцоолоод. Хамгийн даруухан тооцооллоор 270 доллар. Гэтэл манай “Эрдэнэс Тавантолгой” ХК жилдээ хэдийг гаргадаг билээ? 15-аас 23 сая тонныг гаргадаг. Тэгээд та нар 16 сая тонноор бодоод 200 гэсэн зөрүүгээр нь, доллароор нь үржүүлээд үзэх юм бол энэ чинь түрүүний яриад байгаа тэр 50, 60 их наяд болчихоод байгаа юм аа. Ганцхан үнийн зөрүү дээр ийм их алдагдал гарч байгаа шүү.

За дээрээс нь бас хоосон гарсан машин, тэр юуны тээврийн хөлс гээд оффтэйк гэрээ гээд дээрээс нь үнийн зөрүү, чанарын зөрүү, нүүрсний чанарын зөрүү түрүүн ярьсан тийм ээ. Коксожсон нүүрсийг аваачиж Чойр руу зөөгөөд Чойроос хүрэн нүүрс болгоод зөөгөөд байна аа гээд ингээд тооцох юм бол тэр асар их алдагдал нь гараад байгаа юм аа. 5, 6 жилийн алдагдлыг нь тооцох юм бол тэр 50, 60 байтугай одоо 70, 80 их наяд гарцаагүй гарч байгаа шүү. Үүнийг би та нарт харуулж ч болно. Миний ярьж байгаа бүхэн эх сурвалжтай, энэ эх сурвалжууд нь байна. Яг өнөөдрийн байдлаар байна шүү дээ тийм ээ, тээвэр дээр 27-хон километр газарт за юу нэг тонныг 94-өөс 110 доллароор энэ 7 хоногийн байдлаар зөөж байна аа гэсэн мэдээ надад ирсэн байна. Тэгээд энэ бол одоо үнэхээрийн том мөнгө угаалт явагдаж байгаа шүү.

За одоо нэг ноцтой асуудлыг бас ярья энэ юу вэ гэх юм бол энэ чоно борооноор гэдэг

үг байна. Түүн шиг ч юм уу, хаашаа ч юм гэдэг юм энэ үймээнээр чинь “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр IPO хийнэ гэнэ ээ? За тэр IPO-оор нь хэд хэдэн удаа хийх гэж оролдсон. 2019 онд Сумъяабазар Уул уурхайн сайд байхдаа IPO хийнэ гэж оролдоод ингээд энэ надад энэ мэдээлэл нь байна. Энэ мэдээлэл нь Ройтерс агентлагийн гаргасан мэдээлэл. Блүүмберг бас гаргасан байна. Нэг тэрбум доллароор 30 хувийг нь зарна гэнэ ээ? Ийм юм байж болохгүй ээ, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн борлуулалтын орлого гэхэд чинь 1.5-2.0 тэрбум доллар байгаа. Гэтэл байна шүү дээ яг энэ замаараа ингэж яваад “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн борлуулалтын орлогын 50 хувьд ч хүрэхгүй үнээр 30 хувийг нь зарна гэж ийм юм бол байж болохгүй ээ. “Эрдэнэс Тавантолгой” ХК ард түмний өмч. Ард түмний өмчөөр үлдэх ёстой, ард түмний өмчид зуун хувь болох ёстой гэдэг дээр би санал нэгтэй байгаа шүү.

За баярлалаа, боломж олгосонд.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Санал хэлчихлээ. За Х.Бат-Ялалт. Иргэдийн шударга шүүх ТББ. Бат-Ялалт байна уу, байхгүй юу? Түүрүүн байсан явчихсан юм уу? Бат-Ялалт алга. За иргэн Г.Энхтөр байна уу? За алга. Иргэн Г.Оюунгэрэл байна уу?

Сонсголд оролцогч Г.Оюунгэрэл: За энэ сонсголд оролцож байгаа бүх хүмүүстээ энэ оройн мэнд хүргэе. За би Хөвсгөл аймгийн иргэн байна. Манай Хөвсгөлийн залуучууд Чингүнжавынхаа талбайд бас шударга ёсыг шаардаад, хариуцлагатай байдлыг шаардаад ингээд бас жагсаж цуглацгаагаад байгаа. Тэгээд намайг бас одоо тэднийхээ хүсэлтийг уламжлаад энэ нийтийн сонсголд оролцоод та үгээ хэлээч гэдэг байдлаар би оролцож байна аа.

За би төрийн тусгай албанд ажиллаж байгаад тэтгэвэртээ гарсан ийм хүн. Төрийн аудитын байгууллагад. Ингээд яриад байхаар энэ хулгайтай, энэ шударга бус байдалтай, ингээд яваад байгаа хүмүүс нь төрийн албан хаагчид, тэр тусмаа төрийн тусгай албан хаагчид байгаад нь би үнэхээр гайхаж байна. Яах гэж төрд тангараг өргөдөг юм бэ? Тэр Төрийн албаны тухай хуульд чинь албан тушаалтны гэм буруутай үйлдэлтэй эвлэршгүй байна аа гээд заачихсан байдаг. Яагаад тэр төрийн албан хаагчид тэр Гааль дээр ажиллаж байгаа, тэр Монгол Улсын хилийг манаж байгаа тэр хилчид, өшөө Мэргэжлийн хяналтынхан тэр хоосон машинууд гараад байхад юу харж байдаг юм бэ? Монгол Улсын тусгаар тогтнол гэж байна уу? Энэ хүмүүстээ одоо 2013 оноос хойш хоосон машин гараад байсан, бид нар дотоод хяналтаараа илрүүлсэн гээд энэ Гаалийн дарга түрүүн ярьж байна лээ. Үгүй ээ, тэгээд 2013 оноос хэчнээн тэр хууль бус, одоо бүртгэл хийгээд гаргасан тэр гаальчид тэр төрийн тусгай албан хаагчидтай хариуцлага тооцсон юм уу? Хэчнээн хүн өнөөдөр одоо шүүхээр гэм буруутай нь тогтоогдоод ингээд явж байна аа? Ерөөсөө хариуцлага тооцохгүй байгаагаас энэ чинь угшаад байна аа. Хариуцлага тооцохгүй, шударга ёс байхгүй болохоор одоо төрд итгэх хүн ч алга, төрийн албан хаагчдаа ч итгэх хүн алга, шүүх засаглалдаа ч итгэх хүн байхгүй боллоо. Гадаа юу шаардаж байна? Бүх сум хаа хол тэнд байгаа хүмүүс та биднээс шударга ёсыг шаардаж байна, хариуцлагатай байхыг шаардаж байна, маш хурдан энэ хулгайчуудаа илрүүлээч гэж шаардаж байна. Өнөөдрийн сонсголоос маш их үр дүн харж байгаа. Өнөөдөр энд УИХ-ын гишүүдийн за нэг сууж байдаг хэдэн нөхөд л байна. Бусад нь хаачихсан юм? Тэр сонгосон тойрогтоо очоод тэд нар юу хэлэх гэж байгаа юм бэ? Энэ одоо нийгэм даяараа ингээд хүн болгон хүсэн хүлээж байгаа энэ юман дээр яагаад оролцдоггүй, юу хийгээд яваад байгаа юм? Хаана байгаа юм бэ тэр сайд дарга нар нь? Үнэхээр гайхаж байна.

За тэгээд төрийн хяналтын чиг, төрийн төсвийн санхүүгийн хяналтыг төрийн аудитын байгууллага биелүүлнэ ээ гэж байгаа. Үндсэн хуульд заачихсан шүү. Үндсэн

хуулийн 25 дугаар зүйлд байхаа, манай төрийн аудитын байгууллагын харагдаад байна. Энэ “Эрдэнэс Тавантолгой” ХК гэдэг компани дээр жил бүхний санхүүгийн тайлангийн аудитад нь дүгнэлт хийж байгаа, дүгнэлт гаргаж байгаа. Зөвлөмж өгч байгаа. Та нар хэчнээн зөвлөмжийг хэн хэнд өгөөд, хэн хэн биелүүлээгүй юм бэ? хэлээд өгөөч. Хэрвээ зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй бол хууль хяналтын байгууллагад одоо хандана аа гэдэг манай төрийн аудитын байгууллагын угаасаа дүрэм байгаа шүү дээ. Мөн тухайн жилд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон олон нийтийн анхаарлыг татаж байгаа тэр сэдвээр бүр аудит хийж, гүйцэтгэлийн аудит юм уу, нийцлийн аудит хийж олон түмэнд нээлттэй тайлагнана аа гэж байгаа. Тийм зүйл хийсэн юм уу?

За энэ төрийн албан хаагчдыг Төрийн албаны зөвлөл сонгон шалгаруулж ажилд томилох эрхийг нь олгож байгаа. Тэр Төрийн албаны зөвлөлийн нөхөд энэ хэрэгт холбогдоод байгаа, шоронд орчихсон байгаад байгаа хүмүүсийг сонгон шалгаруулсан юм уу? Хэн томилсон юм бэ? Энийгээ бас ард түмэнд хэлмээр байна аа. Мөн одоо төлөөлөн удирдах зөвлөл гэж байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн нэг гишүүн нь лав тэр Сангийн сайд одоо тэр Бүрэн эрхт төлөөлөгчийн Ганбат гэж нөхөр байх шиг байна. Та төлөөлөн удирдах зөвлөлд байхдаа юу харж байсан юм бэ? Одоо гэнэтхэн л нэг Бүрэн эрхт төлөөлөгчийн төлөөлөгч болчхонгуутаа юм илрүүлээд, тодруулаад гараад ирлээ. ТУЗ чинь бүх юмыг ил тод мэдэж, шийдвэр гаргахад нь оролцож байдаг шүү дээ. Та хэдэн төгрөгийн урамшуулал энэ төрийн нарийн бичгийнхээ даргын цалин дээр нэмж авч байгаа вэ? хэдэн хүн байна аа? Гуравны нэг нь хараат бус гишүүн байх ёстой. Ямар ямар хараат бус гишүүн энэ ард түмэн бид нарыг төлөөлөөд тэнд сууж байна аа? Энийг нэг хэлээд өгөөч ээ. За дээр нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар гэж бүх энэ төрийн өмчит үйлдвэрийн газруудыг бас бодлогоор, зохицуулалтаар, хяналтаар хангаж байдаг байгууллага байгаа. Түүрэн тэр бас гарч ирээд байх шиг байна. Тэр төрийн албан хаагч бас юу хийж байна аа? юу хянаж байсан юм бэ? Одоо тэгээд эцэстээ ингээд бүгдээрээ бүр дээр доор...

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За Ж.Ганбат дарга хариулах уу? ТУЗ-ийн гишүүн байсан, юу хийсэн юм бэ гэж байна, урамшуулал авч байгаа юу гээд байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК дахь Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбат: Би “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-д 1 сарын 28-ны өдрийн шийдвэрээр байлаа. Тэгээд энэ оны 4 сарын 22-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар ингээд Сангийн яамнаас төлөөлөл хэрэгжүүлэхээр “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр орж ажилласан байгаа. Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол энэ оны 4 сарын 22-ноос “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр томилогдсон байгаа. Одоо энэ үүсээд байгаа асуудлууд бол миний бие томилогдохоос өмнөх үеийн асуудлууд үүсээд байгаа гэдгийг бас ялгаж салгаж ойлгоорой гэж хүсье.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За Ж.Сандуйжав.

МСДН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Сандуйжав: Үг хэлэх боломж олгосонд баярлалаа. За би түрүүчийн үг хэлсэн хүмүүсийн бүх саналуудыг дэмжиж байна. Энд маш олон чухал чухал асуудлуудыг ярилаа. Эндээс би нэг зүйлийг ойлгож авлаа. Юу гэвэл өнөөдөр Монгол Улс маань Монгол орон маань тэр чигээрээ худалдагдчихжээ. Хулгай болж, хулгайд алдагдчихаж Монгол орон маань. Хэрвээ Монгол орон маань хулгайд алдагдсан бол Монгол Улсын маань эдийн засгийн аюулгүй байдал алдагдах ийм хэмжээнд одоо хүрчихжээ. Хэрвээ бид эдийн засгийн аюулгүй байдлаа алдвал гадаад дотоодын мафийн бүлэглэлд Монгол Улсын маань ард түмэн боол болж хувирах нь ээ. Энэ маш ноцтой асуудал гэдгийг би өөрөө эдийн засагч хүний хувьд би та бүхэнд хэлэх байна. Ингээд хүмүүсийн хэлээгүй үлдсэн асуудлыг би энд хөндөх гэсэн юм. Энэ бол төмөр замын бүтээн байгуулалт, төмөр замын тээврийн асуудал юм.

2008 оноос хойш энэ нүүрсийг тээвэрлэх, гадаад руу гаргах, ОХУ-аар дамжуулаад Владивостокоор олон улсын зах зээлд гаргах, Хятад руу төмөр замаар тээвэрлэх маш хямд зардлаар экспортод гаргах, энэ асуудлыг тухай тухайн засгийн газрууд, холбогдох яамдууд, Ерөнхий сайдаас авхуулаад сайд нар хоорондоо ярилцаж шийдэх гэж оролдож байсан. Тэгсэн мөртөө гэнэт зогсдог. Гэрээгээ өөр тийш нь шилжүүлдэг, ийм олон асуудлууд дамжиж явсаар байгаад энэ бүтээн байгуулалт хийгдээгүй ирсэн байдаг юм байна. Эндээс асар их хэмжээний алдагдсан боломж үүссэн гэж би харж байгаа юм нэгдүгээрт. Хоёрдугаарт, энэ бүтээн байгуулалтыг хийлгэхгүй байх ямар нэгэн хүчин зүйл үйлдэж байсан эсэхийг би яг хэлж мэдэхгүй боловч энийг хурдлуулах, бүтээн байгуулалтыг хийлгэхийн төлөө тэмцэж байсан байгууллага нь Монголын төмөр замчдын нэгдсэн холбоо байдаг юм байна аа, Надад өнөөдөр энэ бүтээн байгуулалтыг хийх гэж байсан гэрээ тушаалууд, гэрээгээр шилжүүлж байсан баримтууд, энд оролцож байсан Монголын компаниудын бичиг баримтууд тодорхой хэмжээгээр надад байна. Би баримт бичиг ярьж байгаа.

Хоёрдугаарт, Монголын төмөр замчдын нэгдсэн холбоо энэ бүтээн байгуулалтыг хийхийн төлөө зүтгэж байсан, ажиллаж байсан баримтууд нь бас надад байна. За тэгвэл манай Засгийн газар бас их сайхан мөрөөдөлтэй байсан юм байна л даа. Юу гэвэл энэ бүтээн байгуулалтыг хийгээд Монголынхоо нүүрсийг, ялангуяа Тавантолгойн нүүрсийг Владивостокоороо дамжуулаад олон улсын зах зээл дээр гаргаад үнэ хүргэж худалдах асуудлыг ярьж байсан байдаг юм байна. За энийг ОХУ-ын тодорхой хэмжээний байгууллагуудтай ярьж байсан, баримтжуулсан байдаг юм байна, гэрээ хэлэлцээр байгуулж байсан байдаг юм байна. Гэтэл эндээс Монгол Улс алдаад Орос улс завсчихжээ. Яг өнөөдөр хэрэгжиж байгаа байдлаар Монгол Улсаар дамжиж байгаа ОХУ-ын бараа, транзит тээвэр 65 хувийн хөнгөлөлт эдэлж байна. Төмөр замын тээвэр 65 хувь шүү. Манай Монгол Улс Оросоор дамжуулж байгаа ямар ч хөнгөлөлт байхгүй. Бараа ч тээвэрлэж байгаа юм байхгүй ийм байдалтай.

Өнөөдөр Монгол Улс орноор ОХУ-ын өдөр болгон таван застав тус бүр 50 вагонтой ачаа дамжиж байна. Тэгвэл энэ дээр одоо Зам тээврийн яам анхаарлаа хандуулаач ээ нэгдүгээрт. Хоёрдугаарт, 2 өдрийн өмнө интернэтэд тавигдсан фэйсбүүкээр Монголын төмөр замчдын авлига таван зуун сая төгрөг байна аа гэж Энэ юу вэ гэхээр зэрэг 50 вагоноос үүдсэн нэг застав одоо нүүрс тээвэрлэдэг Хятадын Эрээн боомтоор одоо гарахад өртөг нь миний тооцоогоор нэг зуун саяас илүү гарахгүй төмөр замын тээвэр. Тэгвэл энэ чинь таван зуун сая буюу тав дахин өсчихжээ. Энийг таслан зогсоогооч. Энийг таслан зогсоох ямар хүч одоо байдаг юм бэ? Энэ бол интернэтэд тавигдсан мэдээллийг би харсан асуудал шүү. За ийм асуудлуудыг та бүхэнд би хэлэх гэсэн юм аа. Өөрөөр хэлэх юм бол алдагдсан боломж маань дахиад цаашаа үргэлжилж байна аа. Энийгээ таслан зогсоогооч ээ нэгдүгээрт. Хоёрдугаарт, түрүүчийн тэр олон жил танигдаагүй байсан, таслан зогсоож чадаагүй байсан энэ төмөр замынхаа тэр алдагдсан боломжийг тооцож гаргаач. Ямар мөнгөн дүн гарч ирэх вэ? Бид нар их хэмжээний алдагдалд орсон байна гэдгийг би хэлэх гэсэн юм. За баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За баярлалаа, санал хэллээ. За Б.Жаргалсайхан Бүгд найрамдах нам.

Бүгд найрамдах намын дарга Б.Жаргалсайхан: За одоо болсон уу? Эхэлж болох уу? Хүний тооноос л хасчих юм аа. Тэгэхээр ийм байна аа нөхөд өө. Би энэ зааланд үнэн хэлэх үү? Худлааг ярих уу? Энэ шударга ёсны төлөө гээд байгаа нөхдийн талд орох уу? Энэ төр барьж байгаа Ардын намын талд орох уу? Алинд нь орох уу? За би яг үнэнээр нь ярих уу? За баярлалаа. За би нэг сайд хиймээр аядсан юм аа 1 жил 6 сар. Энэ хулгай луйвартай чинь би тэр үед тэмцэж байсан. Та нар тэр үед анзаараагүй, тоогоо ч үгүй байх. Эрдэнэт үйлдвэрийн 2 орд байдаг юм нэмэлт. Социализмын үед хайгуулыг нь хийчихсэн, алт, зэсийн

орд. Энэ 2 ордыг албан хаагч хувьдаа авчихсан байсан. За тэрийг хүчингүй болгоод Эрдэнэт үйлдвэрт өгсөн. Төмөртэйн хустай төмрийн ордыг, бас хятадын нөхөд Баярцогт гэдэг нэг этгээдтэй нийлээд авчихсан байсныг нь бас таслан зогсоогоод хүчингүй болгоод Дарханы төмрийн үйлдвэрт өгсөн. За Хөтлийн цементийн үйлдвэр байж байна. Мөн ялгаагүй шохойных нь ордыг бас нэг хувийн компанийн нөхөр дээрэмдээд авчихсан байсан. За тэрийг нь бас хүчингүй болгоод өгсөн. Тэрний хариуд нь надыг ч аягүй амархан огцруулсан л даа. Янз бүрийн юмаар дамжуулаад. За өнөөдөр юу болсон? Нэг хэсэг нь энэ улс орныхоо өмч хөрөнгө, ирээдүйн төлөө амьдралаа зориулж, сэтгэж, бодож хөдөлмөрлөж байна. Тийм ээ, харж байна.

Эрдэнэтийн маань 49 хувийг аль намын үед төр барьж байхад хэн авсан билээ? Ардчилсан намын үед. Үнэн юм үнэнээрээ л байя. За ардын намынх нь үед, тэрийг хурааж байгаад хүчингүй болгоод төрийн мэдэлд аваад та нар сая карантины 2 жил дулаан цахилгааныхаа мөнгийг төлүүлсэн тэндээс. Тийм биз? Жишээ нь тэтгэврийнхээ өрийг тэглүүлсэн. Бид бас авах юмнаас гадна өгөх юмаа боддог байх хэрэгтэй юм байна лээ. За дараа нь та нар өнөөдөр ганцхан нүүрс гээд байна. Баянголын төмрийн ордыг Дэлгэрсайхан гэж нэг этгээд өдөр шөнөгүй зөөсөн шүү дээ. Хятадуудтай өдөрт хоёр гурван зуун вагон цуваа төмрийн хүдэр гарч байгаа. Тэгвэл хэдэн тонн төмрийн хүдэр гарсан юм бэ? Тэрний тайлан бий юу? Тийм, бид тэрийгээ бодох ёстой юм байна лээ. За одоо одоо хойноос нь нүүрс. За энэ нүүрсээр бол одоо бид нар зөндөө л гурвалжин дөрвөлжин хэрэлдээд л маргалдаад байна. Төр гэж байгаа биз дээ? Хууль хяналтын байгууллага байгаа биз дээ? Энд одоо Жаргалсайхан хулгайчийг барь энэ хулгайн эзэн байж магадгүй гэж яриад байх шаардлагагүй гэж бодож байна. Зүгээр тэр цагдаа, прокурор энийг үнэн зөвөөр нь шалгаад өгчих л дөө. Өгөхгүй бол ажлаа өг. Цагдаагийн дарга, прокурорын дарга. Энийг тодорхой хугацаанд шалгаад өгчих тийм хэцүү юм уу? За дээр нь Сангийн яам байж байна. Монгол банк байж байна. Эдийн засгийн яам байж байна. Яг нүүрс энэ 10 жилд хэдэн доллароор гарсан юм бэ? Нийт яг хэдэн тонн нүүрс гарчхаад байгаа юм бэ? Хэдэн төгрөгийн ашиг олсон юм бэ? хэдэн төгрөгийн алдагдал, хэдэн төгрөгийн хулгай гарчихсан юм бэ? гэдэг нь яг үнэн зөвөөр нь энэ эдийн засагч нар ил гаргаад л тавьчих л даа. Тэгвэл одоо хэрэлдээд байх юм байхгүй байлгүй дээ.

Тэгээд цаашаа хөгжих хэрэгтэй болчихоод байгаа биз дээ? За дараачийн асуудал түрүүн тэр нэг нөхөр ярьж байсан, тэр бодвол Өмнөговийнх байх тэ. Үгүй ээ, үгүй одоо бүгдээрээ нэг л хуулийн дор амьдаръя. Өмнөговийнх нэг алтан цээжтэй, мөнгөн бөгстэй, шүрэн толгойтой нөхөд. Энэ Улаанбаатарын хогных гээд хогийн хэдэн юм ямар ч, юу ч үгүй, гол нь цохичихсон хэдэн юм байх нь байна шүү дээ? Өмнөговийнх бол том том хөөрөг, нударгатай торгон дээр өмсчхөөд даналзаад явж байх юм уу. Энэ талаар нэг малтай гээд л ийм шударга биш байж болохгүй ээ. Хэрвээ өмч эзэмшиж байгаа бол бүгдээрээ л эзэмш. Эзэмшихгүй бол бүгдээрээ эзэмшихээ больё. Тийм учраас тэр жижиг Тавантолгойг энэ том таваг толгойд нэгтгэх нь зөв. Яагаад тэнд Өмнөговийнхон эзэмших ёстой юм? Үгүй ээ тэгвэл би ч гэсэн эзэмшье л дээ. Яагаад болохгүй байгаа юм. За ер нь Өмнөговь аймаг. Ер нь энэ аймгуудад одоо дур зоргоороо их авирлаж байна. Хараад л байхад ерөөсөө. Ингээд нэг уул уурхайнхан, компаниуд очоод юм хийх гэхээр нутгийн нөхөд очоод, өө ухуулахгүй, төнхүүлэхгүй гээд дээр нь гараад хэвтчихнэ.

УИХ-ын гишүүн С.Одонтуяа: За энэ бүгдийг дэгээр 5 минутаар тааруулчихсан юм байна лээ Жаргалсайхан гуай. За баярлалаа одоо иргэн Д.Гэрэлгуа. За нэгдүгээр микрофон.

Уул уурхайн инженер Д.Гэрэлгуа: За энэ оройн мэндийг хүргэе. Өнөөдрийн энэ хэлэлцүүлэгт оролцуулж байгаад баярлалаа. За би уул уурхайн улсын байцаагч хийж байгаад тэтгэвэртээ гарсан Монгол улсын зөвлөх инженер байна. За өнөөдөр энэ хэлэлцүүлэгт миний гол хэлэх гэж байгаа санал бол олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг

санаачлах гээд Үндэсний зөвлөл байдаг юм. Энэ байгууллага анх 2006 оноос эхлээд Засгийн газрын дэргэдэх байгууллага байх ёстой. Өнөөдөр энэ байгууллага чинь Уул уурхайн сайд даргалаад ингээд тэ. Өөрөө өөрийгөө хяналт хийдэггүй. Энэ байгууллага бол дэлхийн стандартын дагуу ажиллаж байгаа, ажиллах ёстой байгууллага байгаа юм. Бид чинь дэлхийтэй хөл нийлүүлж ажиллаж байгаа шүү дээ. Тэгээд өнөөдөр мэргэжлийн бид нар яагаад одоо энэ дэлхийн стандартыг өнөөдөр хэрэгжүүлэхгүй, хэн нэгэн дуртай нь нөгөө ашиг сонирхол, нам эвсэл бүх талаасаа ингээд энд оролцож байгаад надад бол үнэхээр одоо нүдний эмч шүдний эмч хийдэггүй шүү дээ.

Та нар бод доо, миний нүд өвдсөн байхад шүдний эмч дээр ангайгаад очоод байж байдаггүйтэй яг адилхан энэ салбарын инженерүүд олон улсынхаа стандартыг хэрэгжүүлж ажиллаагүй. Дэлхийн стандарт “Эй Ти” стандарт гэж байдаг юм. Энд оролцож байгаа энэ байгууллага чинь бол Засгийн газар тэргүүлээд энэ тодорхой, уул уурхайн, Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын төлөөлөл, мэргэжлийн холбоод, компанийн төлөөлөл, иргэний нийгмийн төлөөллүүд байдаг. Гэтэл өнөөдөр энэ Үндэсний зөвлөлийг Уул уурхайн сайд нь удирдах дээд байгууллага нь хийж байна, нарийн бичиг нь төрийн нарийн бичиг хийж байна, эд нар өөрөө өөрсдийнхөө энэ ТЭЗҮ-д одоо яг мэргэжлийн инженерүүдийг нь оролцуулсан юм уу, үгүй юм уу, одоо мэргэжлийн байгууллага нь оролцсон юм уу, үгүй юм уу, энэ аягүй эргэлзээтэй байдаг юм аа. Тэгэхээр өнөөдөр олон улсынхаа стандартад нийцэж ажиллах, хөндлөнгийн аудит оруулья, шинжээчид хаана байна аа, тэгээд гаднын шинжээчдийг оруулж ирье гэж байна. Одоо Монгол Улсын Үндсэн хуулиар тэр улсууд чинь бидний Үндсэн хуулийг мэдэх юм уу? Яагаад энэ мэргэжлийн байгууллагууд бас шинжээчдийг оролцуулсан байх ёстой юм байхгүй юу. Тэгэхээр би эндээс ганц энд байна уу, үгүй юу. Үндэсний аудитын газар гэдэг чинь 2012 оноос эхлээд энэ улсын өмчит газар, одоо энэ ТЭЗҮ хөндлөнгийн шинжээчдийг оролцуулдаг биз дээ, энэ улсуудын тайланг сонсмоор байна аа. Яагаад энд мэргэжлийн улсуудын тэр хүлээн зөвшөөрөгдсөн инженерүүд нь энэ ТЭЗҮ-ийг батлуулдаг, энэ нэг ААН-үүд нь ч гэсэн өөрийн улсын төсвийн хөрөнгөөр болон хувийн хөрөнгөөр хийсэн ТЭЗҮ-ийг батлуулдаг энд сонирхлын зөрчил маш их байдаг аа. Энэ бүгд чинь ил тод биш учраас энэ гэмт хэрэг нуун дарагддаг.

Хоёрдугаарт, одоо Засгийн газар өнөөдөр хяналтаа тавиад энэ мэргэжлийнхээ улсуудыг байлгах ёстой байтал Сумьяабазарыг Уул уурхайн сайд байхад энэ Үндэсний зөвлөлийнхөн хуульд өөрчлөлт ороогүй байхад мэргэжлийн улсуудынхаа эрхийг хассан. Тэгээд өнөөдөр мэргэжлийнхээ улсуудын эрхийг хасчхаад олон улсын аудитыг оруулна гэж юу яриад байгаа юм бэ? За энэ олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагч Засгийн газрын тогтоол нь 2006 оноос эхлээд хамгийн анхны тогтоол нь гарсан байдаг юм. Одоо энэ 2020 он гэхэд энэ бас дандаа сайд нарын тогтоол гаргаад ингээд ажиллаж байна. Энэ чинь жинхэнэ гэмт хэргийг илчлэхгүй байгаа учраас энд оролцож байгаа улсууд үнэн зөв мэдээлэл гаргаагүй учраас өнөөдөр энэ хэлмэгдэл энэ асуудал чинь сөхөгдөж байна шүү дээ. Яагаад энэ мэргэжлийн улсуудыг хэлэлцүүлэг ярилцлагад нь оролцуулаагүй юм бэ? За тэгээд би эцэст нь ганцхан юм хэлэх гэсэн юм. Өнөөдөр яагаад Засгийн газрын төлөөлөл энд суугаагүй юм? Энэ олон улсын стандартаараа эд нар чинь хяналтаа суугаад хийгээд байж байдаг ёстой улсууд шүү дээ. Гэтэл Засгийн газрын Хууль зүйн сайд Нямбаатар өнөөдөр захиргааны хэм хэмжээний актад өөрчлөлт оруулаад, өнөөдөр хүмүүсийг шүүгч дээр очоод хүмүүс ингээд хариуцлага тохоод? Төрийн мэдээлэл гарчихсан учраас энэ хүчин төгөлдөр үйлчилж байгаа байхгүй юу. Та нар өнөөдөр Монгол улсад ажиллах инженер техникийн ажилчдыгаа одоо ингээд хуулиар хуу хамж, хуулиар одоо өөрсдийгөө хамгаалуулчихсан байна шүү дээ. Энэ хариуцлага хэн үүрэх юм. Би энийг л асуух гэсэн юм.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За хэн хариулах юм. За шадар сайд хариулах уу?

УИХ-ын гишүүн, Шадар сайд С.Амарсайхан: За дотоодын мэргэжилтэн болон экспертүүддээ итгэхгүй байгаа асуудал биш ээ, би түрүүн ч бас хэлсэн. Энэ ингээд бүтэн 10 гаруй жил маргаантай явж ирсэн асуудал. Өмнө нь хуулийн байгууллагууд шалгасан, экспертүүд ч орсон аудит, мэргэжлийн байгууллагууд бүгд орсон. Гэсэн хэдий ч өнөөдөр энэ хардлага, сэрдлэг, хулгай, хууль бус үйл ажиллагаатай холбоотой асуудлууд өнөөдөр хүртэл эцэслэгдээгүй, шийдэгдээгүй, харин цэцэглээд байгаа учраас, тэр боломжууд нь байгаад байгаа учраас тэр бүгдийг нэг мөр одоо эцэслэж цэг тавих гэж л Засгийн газар ийм шийдвэр гаргаж байгаа гэж та бүхэн маань ойлгож байгаа байх нэгдүгээрт. Хоёрдугаарт, энд ерөөсөө ямар нэгэн тийм бухимдах гэдэг юм уу, эсхүл үгүйсгэх туйлшрах асуудал байж болохгүй ээ гэж бодож байгаа. Яалт ч үгүй төрийн өмчийн компаниуд, жишээлбэл, “Эрдэнэс Тавантолгой” ХК, за Тавантолгой компани нийт орон нутгийн 51 хувьтай холбоотой асуудал дээр Засгийн газар оролцохоос өөр аргагүй ийм нөхцөл байдалд орсон.

Засгийн газар өөрөө энэ хууль бус үйл ажиллагааг ил болгож таслан зогсоохтой холбоотой асуудлуудыг бүх талаар одоо зөвхөн энэ ч биш та бүхэн маань мэдэж байгаа, Эрдэнэтийн 49 за, тэгээд одоо хөтлийн цемент, Дарханы төмөрлөг, Хөгжлийн банк гээд үндсэндээ одоо ингээд байгуулагдсан цагаасаа хойш дандаа төрийн өмч алдагдсан, өмч иргэдэд очих ёстой, алдагдсан боломж, төсвийн хөрөнгө хулгайд алдагдаж байгаа асуудлууд, иргэдийн ажил амьдралтай холбоотой асуудлууд гээд нийтийн эрх ашигт нийцсэн энэ одоо хардлага сэрдлэгтэй ч гэж ярьдаг, дээрээс нь одоо маргаан дагуулсан, эцэс төгсөлгүй асуудлуудыг цааш нь үргэлжлүүлээд бид бүгдээрээ өмчөө хулгайд алдаад, бүгдээрээ ядуурч, зүдүүрээд ингээд байгаад байх уу, үүнтэйгээ эвлэрээд. Эсвэл хамтдаа энэ асуудлуудаа ил гаргаж явах уу гэдэг асуудал дээр байр суурь тодорхой болгож, энэ нууцын гэрээнээс эхлээд бүгдийг нь гаргаад явж байгаа шүү дээ. Энд 51 хувийн хувьцаа эзэмшигчийн эрх ашиг яригдаж байгаа.

Эрдэнэс Монгол компанийн, Тавантолгой компанийн эрх ашгийн асуудал яригдаж байгаа. Эд нарыг дагасан олон хууль бус үйлдлүүд байгаа. Тэртээ тэргүй олон нийт бүгдээрээ мэдэж байгаа. Энд зөвхөн хувийн хэвшил гэдэг юм уу, аль нэгэн хувьцаа эзэмшигч рүү дайрч байгаа тухай асуудал ерөөсөө биш. Аль аль хувьцаа эзэмшигчдийнх нь эрх ашгийг хамгаалж байгаа асуудал. Эцэст нь иргэдэд хүрэх тэр баялгийн өгөөжийг бий болгох, тэр эрх ашгийг хамгаалж байгаа асуудал. Тийм учраас энэ асуудал дээр хоёр бүрэн эрхт төлөөлөгч томилсон, яагаад томилсон гэхээр энэ дээр хоёулаа нэг нэгнийхээ газар дээгүүр дамжиж ордог. Үнэхээр “Эрдэнэс Тавантолгой” ХК нь өөрсдөө нүүрсээ хулгайлаад жижиг Тавантолгой буюу Тавантолгой ХК руугаа чихээд байна уу, эсвэл жижиг нь энийгээ хулгайлчихаад том руугаа чихээд байна уу, эсхүл хоёулаа хулгайлаад байгаа юм уу гэдэг чинь яг нэг нэгнийхээ газар дээгүүр дамжиж ороод байна шүү дээ. Тэрний энэний гэж одоо ялгах юмгүйгээр энэ дунд маш их тийм эргэлзээтэй асуудал байгаа учраас нэгдүгээрт, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн саяын ярьдаг том гэрээ, төсөв санхүүтэй холбоотой асуудлууд, үргүй зардлуудтай холбоотой, энэ замбараагүй асуудлыг цэгцлэхийн тулд Сангийн яамны төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбатыг Бүрэн эрхт төлөөлөгчөөр томилсон. За энэ хоёр Тавантолгойтой холбоотой тэр олборлолт, үйл ажиллагаа, худалдан борлуулалттай холбоотой хууль эрх зүйн олон асуудлууд байгаа учраас Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийг бүрэн эрхт төлөөлөгчөөр Тавантолгой компани дээр томилсон. Ингээд энэ хоёр ажиллаж байж хөндлөнгийн байгууллагуудтай ажиллаж байж бүх асуудлуудаа шийдвэрлэж тодорхой болгох юм аа гэдэг ийм л асуудал байгаа юм.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За баярлалаа, за одоо Х.Владимир уул уурхайн мэргэшсэн инженерийн зөвлөл хоёрдугаар микрофон.

Уул уурхайн мэргэшсэн инженерийн зөвлөл Х.Владимир: Та бүгдэд оройн мэнд хүргэе. За би мэргэжлийн үүднээс та нарт бодитой тоо хэлж өгье. Ер нь бид Монголын эдийн

засгийг яг сүүлийн 10 жилд одоо өнөөдрийн байдлаар хөл дээр нь босгох хоёр том орд байгаа. Оюутолгойн орд, Тавантолгойн орд. За Оюутолгой дээр бөөн маргаан үүссээр байгаад дахиад 15 тэрбум долларын өртэй үлдсэн. Яах вэ, энэ дахиад яригдах байх аа Тавантолгой дээр өнөөдөр бас ингэж ярьж байгаа дээр би мэргэжлийн хүний хувьд харамсаж байгаа. Яагаад гэвэл үнэндээ Тавантолгой бол энэ Монголын ард түмнийг үнэхээр гэжээх гал голомт Оюутолгойгоос илүү ашигтай орд байхгүй юу. Өнөөдөр Австралид нэг тонн коксжих нүүрсийг гаргахын тулд зуун метр куб хөрс хуулдаг. Тэгээд дэлхийн зах зээл дээр зардаг.

Оюутолгой, Тавантолгой дээр хоёр гуравхан метр куб хөрс хуулаад зах зээл дээр зарж байгаа шүү дээ. Тэгэхдээ бид нар өнөөдөр Энержи Ресурс гээд нэг компани байгаа. Энэ компанийг яахав үнэндээ бол нийт баглагдсан нөөцийн 25 хувийг Баяр дарга өгчихсөн тэр лицензээр. Яахав энэ дээр эд нар 150 сая тонн нүүрсийг угаагаад өнөөдөр маш ашигтай ажиллаж байгаа. Энэ дээр надад бодит Энержи Ресурс компани, Монголиан Майнинг корпорэйшн гээд ороод хараарай. Хувьцаа эзэмшигчид нь бүгдээрээ байгаа. Тэрний нэг дөчөөд хувийг нь монголчууд эзэмшдэг. Гучин хэдэн хувь нь бас Хонконгийн компани, 30 хувь нь бирж дээр байдаг ийм л компани. Энэ компанийн яг ингээд юуг нь аваад үз л дээ. Эд нарын тоо баримтууд байж л байгаа. Яг 2016-2021 онд эд нар нийтдээ Энержи Ресурс компани 45 сая тонн, түрүүн юун дээр 49 сая гэж байна лээ 46 сая. Тэгээд угаасан нүүрс нь 21 сая тонн байхгүй юу? Нийт борлуулалтын өртөг нь 2.4 олсон ашиг нь, нийт зардал нь 1 тэрбум доллар, жилдээ 200 сая доллар ашигтай ажилсан. Эд нар байна шүү дээ цэвэр хатуу кокс, зөөлөн коксын баяжмал үйлдвэрлэсэн. Мөн эрчим хүчний нүүрс нь хагас юу гээд 7.8 саяыг эд нар зүгээр нөөцөлчихсэн байгаа. Хэн ч авахгүй. Энэ 7.8 сая тонн нөөц гэдэг маань юу гэвэл 1000 мегаватт эрчим хүчийг суурилсан эрчим хүчийг гэжээх байхгүй юу. Энэний өртөг гэдэг чинь 1.3 их наяд төгрөг байхгүй юу.

Тэгэхээр бид нар Тавантолгой дээр юу алдаж байна гэвэл энэ Тавантолгойн орд чинь ердөөсөө кокс эрчим хүчний нүүрс нь шүү дээ 50 хувь нь Кокс, 50 хувь нь эрчим хүч. Тэгээд тэнд мэргэжлийн уурхай байгаа учраас уурхайн өртөг ярья л даа. Уурхай ердөөсөө 14 доллароор өртөг гаргаад таван доллароор борлуулалт хийгээд өртөг нь ийм шүү дээ. Тэгсэн чинь жижиг Тавантолгой дээр юу яаж байна вэ гэвэл тэд нар ердөөс хамгийн сайн чанарын коксжих нүүрсээ шууд хил нөхцөлөөр таваас 10 долларын ашигтай ажилласан байна шүү дээ. Үгүй ээ, ингэж бид нар ордыг сорчилж болох юм уу? Энэ чинь мэргэжлийн уурхай биш байхгүй юу? Тэндээ мэргэжлийн уурхай байгуулах хэрэгтэй байхгүй юу. Тэгсэн чинь энэ “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр юу ярих вэ гэхээр тэнд 25 сая тонн эрчим хүчний нүүрсийг одоо говийн халуун наранд шатаагаад байж байна шүү дээ ээ. Энэ 25 сая тонн нүүрс гэдэг чинь та нар үз л дээ. 3000 мегаватт чадлын эрчим хүч үйлдвэрлэх ийм боломж байгаа байхгүй юу. Энийг бид нар алдаад байна шүү дээ, Өшөө бид нар ингээд сорчлоод яваад байх юм уу?. Ер нь энэ баяжмал дахь коксжих нүүрсийг түүхийгээр экспортлохыг зогсоох хэрэгтэй. Яг бид нар бол оновчтой хүчин чадлыг 2010 онд бид нар тооцоолж байсан шүү дээ. Энэ Цанхийн хэсгийн 2 тэрбумын нөөцлөлтэй.

Одоо 2010 онд 15 тонн нүүрс угаах хүчин чадал байна Ухаа худаг дээр. Тэндээ бид нар угаасан нүүрсээ гаргая л даа. Өшөө хаана ч гэлээ нэг 5 ингээд нийт 20 сая байгаа. Өшөө дээр нь байна, ингээд гучин сая тонн угаах нүүрс гэдэг чинь хангалттай байхгүй юу. Тэрний эрчим хүчний нүүрсийг 3000 мегаваттыг бид нар үйлдвэрлэх, одоо цахилгаан үйлдвэрлэх тэрийгээ борлуулж чадахгүй байна шүү дээ. Яагаад гэвэл тээвэрлэлтийн зардал. Тийм учраас бид нар эхний ээлжид яах ёстой вэ гэвэл бид мэргэжлийн холбоодоос тэр мэргэжлийн бус тарваганы нүх ухсан тэр Тавантолгой уурхайг чинь бид нар мэргэжлийн болгож өгөх хэрэгтэй байна аа. Мэргэжлийн уурхай за юу. Нэг тонн нүүрс гаргахад 2 метр куб хөрс хуулдаг тийм уул уурхайн загварыг эхлээд боловсруулах хэрэгтэй. Тэгэхгүй тэд нар чинь ингээд хамгийн сайн гарцтай гурав, дөрөв хамгийн доод талын давхар луу ингээд тарваганы

нүх ухаад орчихсон байна шүү дээ. Өнөөдөр тэр мэргэжлийн бус менежмент, уурхайн инженерүүд тэнд ажиллаж байгаа. Тэгээд тэнд өөрийн гэсэн техник байхгүй, яасан гэвэл дандаа түрээсийн техник. Өртөг нь 28-аас 33 доллар байна шүү дээ. Тэгэхэд Энержиресурс өөрөө техниктэй, өөрийн үйлдвэрлэлтээ тэд 14 доллароор гаргаж 5 доллар угаагаад ингээд ашиг олоод Монголд явж байгаа байхгүй юу. Тийм учраас тэнд ердөө энэ Тавантолгой ордыг бүхэлд нь энергийн тийм корпорац болгоод энэ дээр бас хяналт тавьж ажиллах юм. Ердөөсөө түүхий. Хоёрдугаарт хашаалах хэрэгтэй. Хашаалаад одоо Эрдэнэтэд ч гэсэн хулгай байсан хашаа барьсан Оюутолгой та нар мэднэ шүү дээ тэнд амьд юм нэвтрэх ямар ч бололцоо байхгүй хашаатай. Тийм учраас нэн түрүүнд хашаал. Тэгээд тэр хашаагаар гарч байгаа килограмм нүүрс болгоныг тооцоонд ав. Ингэж байж ард түмний өмчийг хамгаална шүү. Өөрөөр хамгаалах ямар ч бололцоо байхгүй ээ. Тийм учраас яаралтай тэр төмөр замын логистикийг ашиглалтад оруул, цахилгаан станцыг яаралтай өргөтгөх хэрэгтэй. Энэ хоёрыг нэн түрүүнд хий л дээ. Тэнд боломжтой нөөцүүд байдаг шүү дээ эрчим хүчний. Ингэж л хэлмээр байна.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За баярлалаа Х.Владимир гуай санал хэлчихлээ. За одоо ганцхан Улсын Их Хурлын гишүүн үлдсэн байна. Үг хэлүүлчихнэ ээ. Нэр өгсөн гишүүдээс. Ингээд гишүүдийн үг хэлэх боломж дуусаж байгаа юм. За Ж.Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ: Би товчхон ярина. Өнөөдөр бас цөөхөн хэдэн гишүүд л байлаа. Өглөөнөөс хойш тэгээд бас ч гэж одоо иргэдээсээ сонгогдсоны хувьд та бүхнийг сонсьё гээд л гишүүд маань эргэлдээд л орж гараад л, сонсох шиг л боллоо л доо. Энэ сонсгол маань түрүүн нэг хүн хэлсэн шүү дээ. Сонсгол бол хуулийн дагуу явж байгаа УИХ-ын хяналтын сонсгол. Хуулийн дагуу. Энэ бол хэлэлцүүлэг биш юм аа. Гэхдээ энэ хяналтын сонсголыг хийнэ гээд уг нь УИХ-аас хууль гаргаад иргэдээ сонсьё гэсэн хууль гаргаад явж байгаа шүү дээ. Ерөөсөө гурав дахь хяналтын сонсгол нь энэ. Урьд нь би бас өөрөө удирдаад явсан. Хөгжлийн банкаар хийсэн сонсголыг та бүхэн мэдэж байгаа. Энэ бол 3 дахь нь. Би юу хэлээд байна гэхээр Улсын Их Хурлаас тодорхой хэмжээний иргэдээ сонсьё гэсэн итгэл үнэмшил гаргаад байгаа байхгүй юу даа. Хоёрдугаарт, энэ сонсгол хуультай. Өнөөдрийн хувьд энэ сонсгол маань урьдын миний сонсгол дээр ч бас бид нар жоохон жоохон задгай тавьчихсан. Өнөөдөр Чинзориг гишүүн маань үнэхээр задгай бас хийж чадлаа шүү дээ. Тэгэхээр бид заавал ингээд хууль дотор баригдаад байхгүй, бас жоохон задгай болгоё, та бүхнийг сонсьё гэсэн энэ байдал руу алхам хийж байгаа гэдгийг та бүхэн маань бас нэг ойлгооч.

Хоёрдугаарт, энэ үр дүнгүй болох болов уу гээд байх шиг байна. Үр дүнгүй болгохгүйн тулд бид нар эндээс нэг тодорхой хэмжээний шийдлүүдийг гаргах хэрэгтэй байгаа юм. Та бүхнээс сонсож байгаа, санал тавьж байгаа зүйлүүдийг бид нар зайлшгүй хууль юм уу, ямар нэгэн зүйлээ тусгаад засах хэрэгтэй байна шүү дээ. Олон хүмүүс одоо хэлж байна. Иргэд хэлж байна, тогтолцоо болохгүй байна гээд ер нь хулгай гэдэг юм бол хулгайг одоо хүмүүжлээр байхгүй болгодоггүй шүү дээ, хулгай хийхгүй нөхцөлийг бий болгож байж бид хулгайг алга болгоно. Тэгэхийн тулд бид нар тогтолцоон дээрээ өөрчлөлт хийе гээд нэлээд олон иргэд маань хэлээд байх шиг байна. Өөрчлөлт хийхийн тулд та бүхнээс орж ирж байгаа, магадгүй бид нар өөрсдөө дотор нь байгаа болохоор зарим нэг зүйлийг анзаарахгүй байж болно, харахгүй байж болно, магадгүй хүсэхгүй ч байж болно. Тийм болохоор та бүхнээс тодорхой саналуудыг оруулж ирээд яваач гэж байгаа.

Тэгэхээр эндээс одоо Түр хороо гэх юм уу, бас зайлшгүй иргэдтэйгээ хамтарч, гадаа байгаа иргэдээсээ оролцуулаад, та нарыг оролцуулаад яг юугаар бид нар өөрчлөлт хийх юм, энэ рүүгээ хэдүүлээ орё л доо. Үндсэн хуулиасаа авхуулаад ямар хуульд өөрчлөлт оруулах юм, ийм алдаа дутагдал гаргахгүй, сүүлдээ дахиад хэдэн жилийн дараа хулгай болчихлоо

гээд хэдүүлээ энэ зааланд ингээд хэрэлдэхгүй ийм тогтолцоог бид нар бий болгох хэрэгтэй болчхоод байна шүү дээ. Энэ одоотой уялдуулаад магадгүй Улсын Их Хурлынхаа бүрэн эрхээс бид нар татгалзъя, та нар энийг хүсээд байгаа шүү дээ, иргэд маань хүсэж байгаа хэдүүлээ хийе, дээрээс нь Улсын Их Хурлын хэлсэн үгэндээ хариуцлага тооцдоггүй гэдэг юман дээр хэдүүлээ хийе, энийг засъя, хуульд оруулъя, Үндсэн хуульд оруулъя. Тэгээд хулгай хийхгүй байх, шударга байх, худлаа хэлбэл баригддаг ийм нөхцөл байдал ил тод байх, ямар ил тод байх, одоо нөхцөл бололцоог бид нар хууль болон бусад журамд оруулах бололцоо байна. Энийгээ та бүхэнтэйгээ хамтарч сууж байгаад, нэг танхимд сууж байгаа, тэгээд төлөөллүүд нь оролцож ирж байгаад ингээд хийсэн нь зүйтэй байх гэсэн нэг ийм саналыг гаргах гээд байгаа юм.

Хоёрдугаарт нэг, хоёр асуулт байна. Одоо Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд гишүүн маань 40 их наяд гээд нэг айхтар том тоо яриад л байгаа. Жишээ нь түрүүн та бүхэн маань хэлж байсан намар болсон жагсаалаар “Засгийн газар ажлаа хий” гэсэн шүү дээ. Ер нь өнөөдөр Улсын Их Хурал руугаа та бүхэн нэлээн л дайрлаа. Улсын Их Хурлын энэ том тогтолцоог бид нар үгүйсгэж алга болгож ерөөсөө болохгүй. Ганцхан төгөлдөржүүлэх нь чухал асуудал болчхоод байгаа шүү. Дээрээс нь Засгийн газар “ажлаа хийе” гээд хэлсэн, үнэхээр би ч бас одоо Засгийн газар ажлаа хий гэдэг дээр л зогсмоор байна. Өнөөдөр энэ олон том дарга нар нь алга байна шүү дээ, орлогч нар нь хүрч ирээд олигтой юм ярихгүй ийм л зүйлтэй болчхоод байна. Гэхдээ энэ нүүрсний хулгайг Засгийн газрын тэргүүн Л.Оюун-Эрдэнэ өөрөө гаргаж ирсэн шүү. Тэгэхээр энийгээ гүйцээгээд одоо дуустал нь хийх хэрэгтэй байх.

Хууль хяналтын байгууллагуудыг бид нар урьдын хэлэлцүүлэг дээр ч оруулж л байсан, үгийг нь сонсож л байсан. Гэхдээ бид нар одоо маш яаралтай хийнэ гээд хүмүүсийг хэлмэгдүүлдэг ч юм уу, түрүүнд хэлсэн шүү дээ, прокурорынхны процессоор явах ёстой хууль тийм үү, энэ процессыг бид нар түргэвчилдэг ч юм уу, ийм зүйлүүд бол бас байж болохгүй юм. Тэгэхээр 40 их наядтай холбоотой асуудлуудыг би яах гээд байна гэхээр эндээс хүмүүсээсээ асуух гээд байгаа юм. Энэ хуулийнхан яг энэ дээр хэлээд өгөөч. Нэг мөр болгох гээд байгаа байхгүй юу. За нэг минут авчихъя. Би бас манай тээвэрчидтэй холбоотой нэг асуудлыг яримаар байгаа юм. Жишээ нь энд тээвэрчин нь хүртэл хүрч ирээд сууж байна. Тэгэхээр адилхан л тээвэрчдийнхээ эрх ашгийг яримаар байна. Одоо бид нар нүүрсний хулгай гэж яриад байна. Өнөөдөр нүүрсний хулгайн ихэнх хэсгийг жолооч нар, тээвэрлэгч нар идчихээд байгаа юм шиг яриад байгаа байхгүй юу даа? Үгүй шүү дээ хоорондоо хэлэлцэх нь гол.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа, санал, үг хэллээ. Одоо Р.Мэндсайхан өмгөөлөгч гэж байна уу, байхгүй юу? Байж бай, нэрээрээ явна. Р.Даваадорж жагсагчдын төлөөлөл гэсэн байна.

Сонсголд оролцогч, иргэн Р.Даваадорж: За баярлалаа. Энэ нээлттэй сонсголыг зохион байгуулж байгаа Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүддээ талархал илэрхийлье.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Р.Даваадорж аль нь юм бэ? Нэгдүгээр микрофон эхнээс нь тавьчих уу? Даваадорж гараад ирсэн байна.

Сонсголд оролцогч, иргэн Р.Даваадорж: Би иргэн Даваадорж байна. Эдийн засагч Даваадорж би хэдэн тоо хэлнээ өнөөдөр энэ сонсголыг харж байхад байна шүү дээ энэ ард түмэнд яаж хандаж байгаа, төр яаж хандаж байгаа нь та нарын нүдэн дээр харагдаж байна шүү дээ. Хэдэн гишүүн сууж байна? Төрийн агентлагуудын дарга нар байна уу? Дандаа орлогч, хэлтсийнх нь дарга нар нь байж байна шүү дээ. Энэ данхар Засгийн газраас хэдэн сайд сууж байна, ганц хоёрхон сайд сууж байна шүү дээ. Тэгэхээр энэ хулгайн асуудалд энэ

төр яаж хандаж байгаа нь шууд харагдаж байгаа байхгүй юу. Үл хүндэлж байна, үл тоож байна. Энэ шууд анзаарагдаж байна шүү дээ. Тэгэхээр би энэ хуулийнхны тэр хариулж байгаа яриаг сонслоо л доо. Их ажил хийж байгаа юм байна, олон жолооч нарыг шалгаж байгаа гэж байна. Би та нарт нэг, хоёр зөвлөгөө өгье, хуулийнханд. Энэ хулгай хаанаас эхтэй юм гэдэг дээр та нарын тэр гаргаж ирсэн 17 хүн дотор чинь маш их ноотой асуудлууд байна лээ шүү дээ. Тэгэхээр энэ хулгай хаанаас үүссэн гэж? Эрх мэдэл гэдэг хүн нууц гэдэг гэрээтэй нийлээд төрийн өмч дээр гараад хэвтчихээр бий болсон юм. Тэгэхээр энэ 17 дотор чинь эрх мэдэлтэй хүн, эрх мэдэлгүй хүмүүс байж байна. Төрийн өмчтэй холбоогүй хүмүүс байж байна. Нууц гэрээтэй холбоогүй хүмүүс байж байна шүү дээ, та нар дээрээс нь шалгалдаа чадахгүй шүү дээ, та нар ерөөсөө ийм 3 субъектээс хулгайгаа ярина ойлгож байна уу?

Хоёрдугаарт, түрүүн тэр Д.Цогтбаатар гишүүн их зөв яриад байна лээ. Нүүрсний үнэ ямар үнэтэй юм бэ гэдгээс шалтгаална, дэлхийн зах зээлийн ханш надад байна. 2012 оноос хойш, 2021 оноос хойш шалга та нар за юу? Дэлхийн зах зээл дээр 400 доллар хүрсэн. Тэгэхээр энэ хулгай чинь цаанаас нь худалдаж авдаг хүн санал болгодог юм. Өндөр үнэтэй байгаа үед цаад нөхдөд чинь та нар санал болгосон. 2021 оноос энэ асуудал замбараагүй болсон. Энэ графикайг харахаар 2012-2016 онд бол хорь гучхан долларын ханштай байсан байна шүү дээ. Энэ үед оффтэйк гэрээ хийх үү, хэн ч хийхгүй шүү дээ. 17 доллароор нэг тонныг зөөнө, 30 долларын ханштай нүүрсийг чинь нийлж хулгайлъя гэж хэн ч хэлэхгүй байхгүй юу. Энэ 400 хүрчихсэн, 300-аас дээш гарсан 2021 оноос хойш энэ хулгайгаа хай. Хууль хяналтынхаа ойлгосон уу? Ийм 2 зөвлөгөө өгөх байна.

Тэгэхээр энэ төрийн хулгай шүү дээ. Энэ бол төрийн хулгай, дэлхий нийтээрээ шившиг болж байна шүү. Ард түмнийхээ өмч, байгалийн баялгаа хулгайлсан хулгай бол хамгийн шившигийн хулгай гэж ярьдаг. Ард түмэн та нарыг итгэж сонгосон, та нар ийм зүйл хийж байна шүү. Тэгээд одоо энэ төрөөс хийж байгаа хулгай бол төгсөрчихлөө шүү дээ. Эхлээд ЖДҮ-ээр эхэлсэн, 50 хүн, тэгээд ганц хоёр хүнийг шийтгэсэн болоод ихэнх нь буцаад 2020 онд сонгуульдаа гараад ирчихсэн юм. Тэгэхээр юу гэж бодож байна гээч, болдог юм байна, хулгай хийж болдог юм байна гэж бодсон. Дараа нь Хөгжлийн банкны хулгай гарч ирсэн. Хөгжлийн банкнаас хүүгүйгээр зээл аваад шийтгэгдэх ёстой дарга, сайд нар өчнөөн байна. Энэ Засгийн газар дотор гишүүд нь зөндөө байна. Хэл ам болгоод ерөөсөө ганц хоёр хүн дээр тохоод ингээд хаячихсан. Ингээд 2 удаа эд нар төрийн хулгайг амжилттай хийчихлээ. Одоо 3 дахь нь ингээд явж байна шүү дээ. Би маш тодорхой хэлж байна шүү дээ. Хаанаас хулгайчаа хайх юм? Эрх мэдэл нууц гэдэг гэрээтэй нийлээд төрийн өмч дээр сандайлчихаар энэ хулгай чинь бий болсон юм. Түүнээс 9000 жолоочийг та нар хайх биш, тэр аль дээр хоорондоо маргаад маргаантай хувийн компани Тавантолгой, тэр Оюутолгой, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг ярих шаардлага байхгүй. Наадхыг чинь тэр орон нутгийнх нь цагдаа нар нь тогтоогоод гаргаад ирэх юм.

Тэгэхээр ийм заль байгаа байхгүй юу, зүгээр нэг гөлөг төөрүүлэх заль. Тэгээд дээр үеийнхээ юмыг яриад л, эсхүл тэс өөр жолооч яриад л маш тодорхой байгаа биз дээ? Ямар хүмүүсийг шалгах юм? Та нар чадахгүй шүү дээ. Одоо энэ дээр худлаа хэдэн жижигхэн жараахайгаа шийтгээд ингээд явна. Монголын төр шившиг болж байна. Дэлхий нийтэд шившиг болж байна. Та нарыг энэ хууль хяналтын байгууллагынхан шалгаж байгаа. Ичмээр тэр нууц гэрээ хэн байгуулдаг юм? Тэр эрх мэдэл хэнд байсан юм? Монгол Ардын намд бүгд байсан. Тэр ард түмний өмч нэрээр төрд авсан өмч дээр чинь хулгай явж байна шүү дээ, ойлгож байна уу та нар.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Б.Даваадоржоо, би чамайг нөгөө жагсагчдын төлөөлөл гээд тэмдэглээд, бүртгэчихсэн болохлоор нь танихгүй байсан чинь сая харах нь Ардчилсан намын бүлгийн эдийн засагч байна шүү дээ. Яагаад

жагсагчдын нэр барьж бүртгүүлсэн юм? Бас тэгж болохгүй шүү дээ. Иргэн Б.Бат-Очир гэж байна уу? Чи чинь түрүүн нэлээн яриад байсан уу, үгүй бил үү?

Сонголд оролцогч, иргэн Б.Бат-Очир: Би түрүүн нэрээ бичээд бүртгүүлээд орлоо болохгүй юм уу? Тэр цагаа эхлүүлчихье. За баярлалаа. Сая хүмүүсийн яриаг сонслоо. Шинжээравдан гуай л ганцхан гарц шийдэл ярьсан бусад нь ерөөсөө дандаа тоо баримт ярилаа. Өнөөдөр энд гарц гаргалгаа ярих юм болов уу? гэж бодсон чинь 10 жил тоо баримт ярьсан байгаа байхгүй юу? Дандаа ингээд тоо баримт ярьж байсан болохоос биш ерөөсөө гарц шийдэл яриагүй байна. Өнөөдөр энэ нүүрсний хулгай, яагаад ингээд нууцаар гэрээ хийгээд байдаг юм? Энэ чинь Монголын ард түмний өмч биш юм уу? Энийг би ойлгохгүй байна энэ дээр тайлбар авъя.

Нэгдүгээрт, Т.Доржханд гишүүнээс асуулт байна. Гадаа байгаа 17 жагсагч хувцсаа тайлаад 2, 3 цаг гадаа шалдан суугаад ачигдаад явсан. Тэр Дэнжийн мянгын хориход очиж, тэнд саатуулагдаж байгаад тэндээсээ эмнэлэг явсан гэж байна. Та гадаад, дотоодод сурч явсан гээд л гайхуулдаг юм байна лээ. Тэгээд хүний эрхийн мэдрэмжээрээ юу гэж хэлэхээр байна? Энэ төр засгаа юу гэж үнэлэхээр сөрөг хүчин гэдгээрээ та нэг хэлчхээрэй.

Тэгээд одоо хэрвээ энэ хэрэг ингээд явж байгаа ч шүүх дээр очих юм бол тэр шүүх хурлыг нь нээлттэй явуулмаар байна. Одоо ингээд фэйсбүүк дээр лайв үзэж байгаа шиг төрийн эрх мэдэлтнүүд, тэр нүүрсний хулгайд холбогдсон хүн бүрийн шүүх хурлыг нээлттэй явуулаад, Монголын ард түмэн үзмээр байна. Шүүгч нь яаж шүүдэг юм? Нөгөө нэг хүмүүс нь яаж хуураад байгаа юм? Хуулийн цоорхойг яаж ашиглаад байгаа юм? Бид нар хармаар байна. Бид нар үзэх хэрэгтэй. Бид нарын ирээдүйг хулгайлсан асуудал дээр бид нар өнөөдөр ярьж байна. Дараа нь Монголын үйлдвэрчний эвлэл гээд хүмүүс ярьсан. Үйлдвэрчний эвлэлээс ерөөсөө тэмцэлд оролцоогүй, би ерөөсөө хараагүй, аягүй мундаг мундаг хүмүүс сая завсарлагаагаар юм яриад, инээгээд суугаад байна.

Өнөөдөр энд инээдтэй зүйл байхгүй байна. 17 залуу хувцсаа тайлаад, эрүүл мэндээ алдаад, ирээдүйнхээ төлөө сууж байна. За 40 их наяд гэж байна. 40 их наяд нь явсаар байгаад 10 их наяд болсон. 10 их наяд нүүрсний хулгай гээд, тэгсэн чинь нүүрсний хулгай чинь нүүрсний хулгай биш авлига, албан тушаалтай холбоотой дарга нарын гарын үсэг зурсан, нуусан ийм хулгай юм байна. Авлига, албан тушаалын гэмт хэрэг юм байна. 10 их наяд төгрөг нь өөрөө Монголын ард түмэнд хэрвээ хүрсэн бол энэ чинь бид нарт юу болох байсан юм? Маш их зүйл, сургууль цэцэрлэг өнөөдөр эмнэлэг хүртэл ямар байгаа билээ? Бидний ирээдүй хулгайлсан юм байна. Энэ чинь Үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн зүйл байхад Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 гишүүн яагаад юу ч хийхгүй, юу ч дуугарахгүй байгаад байгаа юм. Энд байгаа хүмүүс ирээдүйд яах юм? Одоо энэ хулгай дээр яах юм? Шүүх, цагдаа, прокурор энд байгаа тэр мундаг хүмүүс нь одоо яаж энэ хулгайг таслан зогсоох юм, цаашдаа энд гарахгүй байх тал дээр яаж анхаарах юм гэдэг юмыг яагаад ерөөсөө ярихгүй, зүгээр тоо баримт яриад байгаа юм бэ? Тэгэхээр тэр эрүүгийн хууль баталсан, чангаруулсан, сайжруулсан гээд байгаа. Жагсагчдын шаардлагын дагуу бид нар Эрүүгийн хуулийг баталсан, одоо ингээд 1994 оноос хойш түүхэндээ нэг удаа ингээд баталсан, чангалсан гээд байна. Чангалсан юм бол яагаад тэр хуулиа бүр ингээд цоорхойгүй юм хийчхэж болдоггүй юм? Яагаад хүмүүст ял завших боломж олгоод байгаа юм? Өнөөдөр 3.4 сая иргэдтэй, яг ингээд МҮОНРТ-ээрээ өмнөх хууль нь ийм байж байгаад одоо энэ хууль нь ийм болчихлоо, ингэж сайжирсан юм, ингэж чангарсан юм гэдгийг нь харуулаад тайлбарлаж өг. Хууль зүйн сайд нь өөрөө сууж байгаад энэ хүмүүст мэдээлэл өг.

Өнөөдөр Монголын ард түмэн аймаар харанхуй байгаа. Та нарын хэлээд байгаа юмыг чинь ороод харчих тийм чадваргүй байна. Тийм учраас та нар МҮОНРТ-ээр, тэрийг тэгж харуул. Ямар хуулийг нь яаж сайжруулсан юм? Энд ямар хуулийн цоорхой байгаа юм?

Хамгийн мундаг гэсэн Монголын хуульч хүмүүсийг нь авчирч байгаад судалгаа хийлгэж байгаад, хамт суулгаж байгаад яривал. Тэгээд гадаа байгаа цагдаагийн газрын дэд дарга ингээд худлаа ярьчихаад гараад явчхаж байгаа байхгүй юу. Бид нар ерөөсөө гадаа хүн амьтан тараагаагүй ээ, эрүүл мэндийн үзлэг хийж байна гээд. Тэгсэн чинь одоо та нар гараад хараарай хөөе. Би энд юм ярьж байна. Наашаа хар, гадаа байгаа жагсагчдыг бүгдийг нь тараагаад баривчлаад аваад явчихсан. Нөгөө тэнд байсан ард түмний авчирч өгсөн эсгий, гэр юу ч байхгүй. Бүгдийг нь аваад явчихсан. Та нар яагаад ингэж худлаа яриад байгаа юм.

Бид нар яасан юм? Чулуу шидсэн юм уу? Мод барьсан юм уу? Бид нар алдагдсан боломжоо авъя гээд залуучууд тэмцсэн шүү дээ. Тэгэх эрх байхгүй юм уу? Ардчилсан нийгэм биш юм уу? Яагаад та нар индэр дээр суучихаад инээгээд байгаа юм бэ? Ард түмний амьдрал хэцүү байхад та нар яагаад инээгээд байгаа юм бэ? Жаргалтай байна уу? Инээд чинь хүрч байна уу? Түүрүүн тэр нөгөө тэмцэгч ах хэн билээ 5 минутад наад 5 хуулиа батлуулчих гээд хэлсэн үгэн дээр нь нэг гишүүн инээгээд байгаа шүү дээ. Би та нарыг энд сууж өдөржингөө харлаа, хүлээцтэй хүлээлээ, ах, эгч нар муухай соёлгүй байна. Тэнд очоод үг хэлэх хүмүүс оочирлож, бичүүлдэг гэж байна.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Үг, санал хэллээ. За Д.Сарантуяа эдийн засагч гэсэн байна. Байна уу? Д.Сарантуяа алга. А.Төмөр-Очир. Энэ хүн чинь өдөр хэлчихсэн дээ. Байхгүй байгаа биз дээ? Н.Энхээ өдөр бас хэлчихсэн үү? С.Нэргүй багш гэсэн байна.

Сонсголд оролцогч, иргэн С.Нэргүй: Ямар ч гэсэн өглөөнөөс хойш энэ хэлэлцүүлэгт байлаа. Өдөржингөө анзаарлаа. Та үг хэлэх боломж олдсонд бас их талархалтай байна. Өнөө оройны мэндийг та бүхэнд хүргэе. Тэгээд санал байна. Асуулт байна. Бас тодорхой шийдэл байна. Нэгдүгээрт, энэ нүүрсний хулгайтай тэмцэж байгаа, энэ асуудлаар шүгэл хүлээсэн жагсагчдаадаа юуны өмнө баярлалаа гэж хэлмээр байна, органик жагсагчдаадаа. Мөн энэ асуудлыг хөндөж гаргаж ирсэн Засгийн газар бол зөв өө. Ажлаа хийх ёстой, энэний ард гарах ёстой. Нүүрсний хулгайчдыг заавал яллаж, Монголын төр авдаг арга хэмжээгээ авах ёстой. Монголын төрийн албан хаагчид, жирийн албан хаагчид, цагдаагийн албан хаагчид энэ бүхний ард гарч чадна гэж би бодож байна. Тийм учраас энэ асуудал цаашаа явах ёстой. Засгийн газар үргэлжлүүлж шалгах ёстой. Энэ хулгайчдад заавал арга хэмжээ авах ёстой.

Хоёрдугаарт, тэр шалгуулж байгаа хүмүүс дээр 17 хүний нэр зарлагдлаа. Юунд нь сандраад байгаа юм бэ? Хүмүүсээ, тэр 17 хүмүүс эхний ээлжид шалгуулаа. Улсын Их Хурлын гишүүд, Монгол ардын намын гишүүд хэвлэлийн бага хурал хийгээд иргэдийн сэтгэл зүйд нөлөөлөх гэж оролдож байгаагаа больё. Шалгуулчихаа. Хэрэв асуудал байхгүй бол гараад ирнэ. Гэм буруутай гэсэн үг биш, шалгуулчих. Ардчилсан намын 2 гишүүн байгаа, мөн шалгуулчих. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эзэмшигч Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ та шалгуулчих аа. Энд араасаа хоёрдугаар эгнээнд манай Өмнөговийнхон байх шиг байна лээ. Би хэлчихье. Өмнөговийнхон минь, та нар минь хулгай хийчихсэн байна. Монголын ард түмний хувьцааг нь эзэмшдэг том Тавантолгойгоос 340,000 тонн нүүрсийг нь хулгай хийчихсэн байна. Энийгээ төл, ер нь төлж байна гэсэн үү? Авсан нь үнэн юм билээ. Тэгэхээр энэ асуудлаа шалгуул. Төрийн өмчид байна уу? Хувийн өмчит байна уу? Бүх хувьцааг нь эзэмшдэг Монголын ард түмний хувьцаа эзэмшиж байгаа компаниас, нүүрсний ордоос хулгай хийсэн бол бүгдээрээ шалгуул. Ийм санал байна.

За асуулт байна. Ардын намын 5 гишүүний төлөөллөөс Ц.Сэргэлэн генерал байх шиг байна лээ. Ганцхан үгээр хэлбэл сайн байна. Та бүхэн энэ хууль хүчний шалгалтынхандаа элдэв хэвлэлийн хурал гэдэг юм уу, ард түмэнд нөлөөлөхгүйгээр шалгуулж чадах уу, үгүй юу гэдгээ хэлчихвэл сайн байна. Д.Бат-Эрдэнэ гишүүнийг бас хэлчихмээр байна. Та

Тавантолгой дээр 340,000 тонн нүүрс хулгайлагдсан нь үнэн юм уу? Та нөлөөлөхгүйгээр шалгуулчхаж чадах уу? Тэрийгээ бас хэлчихмээр байна. Тийм асуултаа асууж байна. Дээрээс нь Авлигатай тэмцэх газар, прокурорынхон хэн нь байна? Хариулдаг хүмүүс нь тэр яллагдагчаар одоо татагдсан хүн дөнгөж тогтоолоо авсан даруйдаа гадагшаа нисээд явчихлаа, эрүүл мэндийн шалтгаантай гээд. Би Т.Доржханд гишүүнтэй санал нэг байна. Энэ асуудал дээр ямар хариуцлага байна вэ? Одоо үлдсэн хүмүүс дээр бүгд дээр нь хилийн хориг тавьчихмаар юм байна. Тийм бүгдийг нь шалгах ёстой юм байна. Тэгэхгүй бол тэр хүмүүс ирэхгүй бол яах вэ? Ийм санал байна.

Шийдэл нь ямар байна вэ гэхээр нэгдүгээрт, Тавантолгойн нүүрсний ордууд хувиараа, хувьсгалаараа явна гэж байгаа юм бол хилийнх нь заагийг маш нарийн тодорхойл. Үгүй бол нэгтгээд ард түмний өмчид аваач. Ард түмний өмчид авна гэдэг нь төрийн өмчид байна гэсэн үг биш. IPO гаргаж олон нийтийн хяналтад оруулах ёстой. Гэхдээ оруулах цаг нь одоо биш, одоо бол эдийн засаг хямралтай байна. Тэр IPO-г худалдаж авахад хямдхан зарагдана. Эдийн засаг өссөн хойно, үнэтэй болсон хойно IPO гаргаж олон нийтийн хяналтад оруулах ёстой. Энэ хооронд тэр хулгайчуудыг бүгдийг нь шалгаж, илрүүлж, яллаж арга хэмжээ авах ёстой. Их наяд гэхээр бас үнэхээр уур хүрээд байна. Багш хүний хувьд бухимдахгүй гэж биеэ барья гэж бодсон.

Монголын түүхэнд их наядын хулгай гарсан түүх байхгүй. Тэгэхээр 40 их наяд дээр би жоохон эргэлзэж байна. Би өөрөө эдийн засагч хүн, доктор хүн. Гэхдээ их наядын хэмжээний хулгай бол явагдчихсан байна. 340,000 тонн нүүрсийг хилийн үнээр үржүүлэх юм бол их наяд гарна шүү. Энэ асуудлыг цэгцлэх ёстой. Үнэхээр жижиг Тавантолгойнхон хулгай хийгээгүй юм бол тэрийгээ сайхан нотлоод шалгуулчих. Тэгээд энэ бүх зүйлийг эцэслэж ард нь гарах ёстой. Засгийн газар заавал ажлаа хийх ёстой. Энэ бүгдийн заавал ард нь гарах ёстой. Сонсгол явагдах ёстой. Хойшилж болохгүй. Сонсгол явагддагаараа явагдаад шүүх, хуулийнхан ажлаа хийдгээрээ хийгээд энэ бүх хулгайчуудыг яллах ёстой. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа санал хэлчихлээ. За С.Ганболд Монгол тээвэр нэгдэл байна уу? С.Ганболд байна уу? Аль нь юм бэ?

“Монгол тээвэр нэгдэл” ХХК-ийн Ерөнхийлөгч С.Ганболд: Би байна. Бүгдэд нь оройн мэнд хүргэе ээ. Би “Монгол тээвэр нэгдэл” гээд Монголын үндэсний компанийг төлөөлөөд ярьж байна. Төвчхон бас компанийнхаа талаар ярья. Энэ зүгээр нэг маркетинг бол биш шүү. Бид нар 10 гаруй жилийн өмнө Монголын 26 компани нэгдээд Монголын үндэсний ийм тээврийн компани байгуулсан. Бид нар нүүрсний тээвэр болон бусад орон нутаг, олон улсын тээвэрт бас үйл ажиллагаа явуулдаг ийм үндэсний тээврийн компани. Эндээс нэг асуудал байгаа юм. Ерөнхийдөө бол бид нар хуулийг дээдэлдэг ийм хүмүүс. Гэтэл тээврийн бодлого, тээврийн зохицуулалтыг хэрэгжүүлдэг Зам тээврийн яам сүүлийн бараг хагас жил орчим тээврийн бодлого руугаа орохоо байсан. Ийм байдалтай болсон учраас бид нар ямар хүсэлт тавих гэж байгаа вэ гэвэл тээврийн байгууллага нь тээврийнхээ ажлыг хийе, уул уурхайн байгууллага нь уул уурхайгаа хийе. Ерөнхийдөө ийм чиг чигээ харсан, хуулийнхаа дагуу үйл ажиллагаа явуулахгүй бол одоо ийм байдал руу орчихсон явж байна.

Хоёрдугаарт, одоо хүн болгоны яриад байдаг биржийн бичиг гэсэн ийм асуудал байгаа. Биржийн бичгийг Монгол Улс, Хятадын Засгийн газрын тээврийн байгууллагууд хамтраад энийгээ хэрэгжүүлээд явдаг байсан. Одоогоор энэ маань бас өөр газар луу шилжээд явчихсан учраас өнөөдрийн байдлаар Зам тээврийн яам, Авто тээврийн үндэсний төв маань тодорхой хэмжээний энэ уул уурхайн тээвэрт оролцохоо байсан. Энийгээ хуулийн хүрээнд хэрэгжүүл гэдэг ийм шаардлагыг бид нар тавьж байна.

Өнөөдрийн байдлаар тээвэрчид асар их айдастай байгаа. Ямар айдастай байна гэхээр өнөөдөр нийт 21 мянга гаруй машин Гашуунсухайтад ажиллаж байна. Энэ тээврийн хэрэгслүүдийн 10 хүрэхгүй хувийг Монголын болон үндэсний тээврийн компаниуд эзэлж байгаа. Бас нэг асуудал юу байна гэхээр өнөөдөр нүүрс худалдаж авч байгаа гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд бүгд тээврийн компани байгуулчихсан. Эд нар бүгдээрээ тээврийн компанитай. Тийм учраас тэд Монголын үндэсний компанийг хараад байх үнэхээр шаардлага байхгүй болсон учраас Монголын үндэсний тээврийн компаниуд асар хүнд байдалд орчихсон. Цаашдаа оршин тогтнох уу, үйл ажиллагаа явуулах уу гэдэг эгзэгтэй байдалд орчихсон. Одоо бас нэг компаниудын ярьж байгаа, хэлж байгаа нэг хүндрэлтэй асуудал байна. Сая ингээд тендер зарлагдсан, тендер дээр “Эрдэнэс Тавантолгой” ХК болон Эрдэнэс Монгол компаниуд монголынхоо үндэсний компаниудыг дэмжье гэдэг санаагаа бид нарт байнга илэрхийлж байгаа. Бид нар энэ дээр талархалтай хүлээж авч байгаа боловч амьдрал дээр юу болох гэж байна гэвэл нөгөө хятадын компаниуд чинь нүүрсээ худалдаж авдаг учраас эд нарт тээврийн зардал сонин биш, одоо тэр шалны үнэ гээд байгаа хамгийн доод үнээ өгөөд энэ тендерт ороод тэд нар авах магадлал асар өндөр байгаа. Тийм учраас сүүлийн 4, 5 хоног монголын нүүрсний компаниуд анх удаа энэ тээвэрт явж байгаа компани бүгд нийлээд хүнд байдалд ороод байна. Бид нар цаашдаа оршин тогтнох уу, үгүй юу гэдэг асуудал яригдаж байна.

Та бүхэн нэг юмыг анзаар, бид нар 26 компанийн нэгдэл, нийтдээ 1000 гаруйхан автомашинтай. Тэгэхлээр 26 компани нэг нь 5, 10, 20 дээд тал нь 30 машинтай тээврийн компани ажиллаж байгаа. Гэтэл гаднын хөрөнгө оруулалттай нэг компани гэхэд 24 настай нэг охиноор толгойлуулаад 500-700 машинтай явж байна. Эцсийн хэрэглэгч гэдэг юмыг бүгд ярьж байгаа, өнөөдөр гаднын хөрөнгө оруулалттай компаниуд эцсийн хэрэглэгчийг монгол хүнээр хийлгэчихсэн, тэгэхлээр бид нар энэ монгол компани юм уу, хятад компани уу гэдгийг ялгах тийм юм ерөөсөө байхгүй байна. За сүүлийн үед яг энэ асуудал үүсээд ирэнгүүт монгол компаниуд нэгдээд хоорондоо одоо яах вэ гээд ярингуут нийтдээ 150 орчим монголын компани байна гэдэг нь гарч ирж байгаа, өөр утгаар бол аль нь Монголынх, аль нь гаднын хөрөнгө оруулалттайг бид нар ялгахад үнэхээр бэрхшээлтэй болсон. Хамгийн сүүлд хэлэхэд мэдээж ямар асуудал шийдэх вэ, шийдэл юу байна гэхээр Түр хороо байгуулья гэж байна. Энэ Түр хороон дээр монголын тээвэрчдийг төлөөлүүлээд бид нарыг оруулж өгөөч гэдэг хүсэлтийг хурал удирдагчдаас хүсэж байна аа. За ерөнхийдөө бол ийм саналтай байна.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За баярлалаа, санал хэлж, үг хэлчихлээ. Б.Батболд байна уу, Б.Батболд алга. Д.Болдхуяг.

Сонсголд оролцогч, жагсагчдын төлөөлөл Ч.Болдхуяг: За баярлалаа сонсголыг хийж жагсагчдыг ярих боломж олгосонд, жинхэнэ жагсагч шүү. Д.Болдхуяг энэ жагсагч залуучуудаас гадаа жагсаж байгаа сэхээтний төлөөлөл байна. Өнөөдөр жинхэнэ жагсагч хоёр хүн л үгээ хэллээ, хоёр дахь нь би боллоо. Түрүүний тэр залуу үгээ хэлсэн, тэгээд бид нарт үгээ хэлэх боломж олдохгүй байна, тэгээд энэ жагсагчдын дунд байгаа сэхээтний төлөөлөл үгээ хэлж байна аа. Ямар ч байсан энэ Засгийн газрын гишүүд, Улсын Их Хурлын гишүүд нээлттэй сонсгол зохион байгуулж байгаад баярлалаа. Өнөөдөр жагсагчид хоёр удаа муухай харагдчихлаа, харамсалтай байна. Эхнийх нь өглөө сонсголд ирсэн чинь хоёр тусдаа танхимд хуваарилагдсан, тэгэхээс уул нь ингээд нэг танхимд орохоор жагсагчид ингээд томоотой сууж байгаа шүү дээ.

Хоёр дахь нь энэ залуугийн асуудал, энэ залуу уул нь их зоригтой залуу байна, гадаа яах аргагүй хүчээр жагсагчдыг тараачхаад тэрийг та нарт харуулах гэж, олны анхаарлыг татах гэж энэ залуу үймүүлчихсэн юм шиг муухай харагдчихлаа. Одоо та бүхэн гараад

хараарай, талбай дээр нэг ч хүн байхгүй, нэг жагсагч байхгүй шүү. Тэгээд уул нь энэ залуу үймүүлэх гэж тэгээгүй шүү дээ, хөөрхий амьтан гадаа ийм болж байна гээд олны анхаарлыг татах гээд, одоо ингээд гарахад нь баривчлах гээд энэ танхимаас гарч чадахгүй сууж байгаа шүү. За яах вэ тэгээд жагсагчид муухай харагдчихлаа тэгээд одоо яах вэ? За уул нь энэ шүглийг үлээсэн Засгийн газрын гишүүд, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандыг байгаагүй бол энэ жагсагч залуучууд өнөөдөр энэ талбай дээр гарч ирэхгүй л байсан юм даа. Л.Оюун-Эрдэнэ сайдыг дэмжээд, Засгийн газрын гишүүдийг дэмжээд энэ нүүрсний хулгайтай тэмцье гээд энэ бухимдсан залуучууд одоо ингээд гараад ирсэн, одоо бүгдийг нь баривчилсан сурагтай байна. Бид нар одоо мэдэхгүй байна л даа, утсаар л хүмүүс хэлж байна, эхлээд эмнэлэг рүү авч явсан гэж байна, дараа нь бүгдийг 100 гаруй залуусыг баривчилсан гэж байна шүү. Засгийн газрын гишүүд, Л.Оюун-Эрдэнэ сайдаа, Т.Доржханд гишүүнээ жагсаж байгаад баривчлагдсан улсуудад санаа тавиарай гэж гуйж байна. Жагсагчид маань үгээ хэлэх боломж гарсангүй, үндсэн асуултаа тавьж чадахгүй, би цаг маань дуусчих вий гэж болгоомжлоод байна.

Ингээд жагсагчдын зүгээс төрийн 3 өндөрлөгт зориулаад нэг, нэг хүсэлт гаргасан юм, бүгдээрээ гарын үсгээ зурчихсан юм, нэгийг нь уншиж өгье бүгдээрээ адилхан юм аа. Тэгээд энийг хэнд гардуулах вэ. Уул нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн ажлын албанд, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн ажлын албанд, Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын ажлын албанд өгмөөр байна, тэгээд бүр болохгүй бол Т.Доржханд гишүүнд хүлээлгэж өгье өө, таныг энийг хүлээлгэж өгнө гэж найдаж байна. За Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх танаа хүсэлт гаргах нь: Та 2022 оны 12 дугаар сарын 22-нд төрийн ордны гадаа гарч ирж, жагсагчид болон суулт хийж байгаа иргэдтэй Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувьд уулзана уу. Таныг ард түмэнтэйгээ хамт байгаа гэдэгт итгэж байна. 2022 оны 12 дугаар сарын 21, жагсагчид гээд энэ ийм шаардлага байгаа юм. Тэгээд энэ жагсагчдынхаа шаардлагыг одоо гардуулж өгөхийн тулд энд ажлын албаныхан байна уу, би хэнд гардуулж өгөх вэ, бүгдээрээ адилхан шүү. Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар танаа гээд жинхэнэ жагсагчид шүү. Тэгээд гарын үсгээ зурчихсан, органикаар жагссан улсууд. Шадар сайдаа танд гардуулаад өгчих үү, за би өөрөө гардуулаад өгчихье, баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За Улсын Их Хурлын Тамгын газрын хэлтсийн дарга Ц.Батбаатар байна, Улсын Их Хурлынхыг ав, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрынхыг хаана, хэнд өгөх юм. За тэгээд нэгмөсөн гурвууланг нь Шадар сайдад өгчих, Шадар сайд дамжуулаад өгчих.

За Б.Ганболд гэж байна уу? Чи түүрүүн хэлсэн шүү дээ, чи түүрүүн үг хэлчхээд буусан, одоо хүний нэр барьж дахихгүй. Б.Ганболд байхгүй юм байна. За С.Арслан гэр бүл судлаач гэсэн байх юм, хоёрдугаар микрофон.

Сонсголд оролцогч, иргэн С.Арслан: За би судлаач хүн, ер нь бол инженер хүн байгаа, би сүүлийн 10 гаруй жил энэ эрдэс баялгийн хулгайтай холбоотой, ер нь бид нар юу гаргаад юу авдаг юм гэж судалгаа хийсэн. Энэ судалгааны материал бол ийм том охь нь энэ байгаа юм, бусад нь бол 16 ийм ном байгаа, ийм дэвтэр энийг та нар үзээрэй. Энэ судалгаагаа би Монгол ардын нам болон Ардчилсан намынханд танилцуулж болно, танилцуулья гэж бодож байгаа. Тэгээд энэ судалгаагаар юу гарсан гэхээр бид нар, манай улс 2008 оноос эхлээд эрдэс баялгийн буюу уул уурхайн эдийн засагтай болсон. Ингээд 9 нэр төрлийн бүтээгдэхүүн дээр судалгаа хийгээд үзсэн чинь нийтдээ 143 их наяд төгрөгийн борлуулалт хийсэн байгаа юм, түүнээсээ улсын төсөвт орсон нь дөнгөж 22 их наяд төгрөг, цаана нь 121 их наяд төгрөг нь улсын кармаанд ороогүй ээ, энэ хаана орсон нөгөө 30 гэр бүл гэж ярьдаг, нөгөө 300 ч гэж ярьдаг энэний кармаанд орчихсон байгаа юм.

Энэ материалыг би ямар үндэстэй хийсэн гэхээр Татварын ерөнхий газрын материал, Гаалийн ерөнхий газрын материалд үндэслэж хийсэн байгаа шүү. Тэгээд энэ 121 их наяд төгрөгийг ярихгүй мөртөө Хөгжлийн банкны 1.8 их наяд дээр үхэн хатан яриад байгаа юм аа. Тэгээд ийм хэдэн санал байна, одоо манайх чинь ядуу буурай орон болчихоод байгаа шүү дээ, гуравны нэг нь бараг хоёр хүний нэг нь ядуу. Гэтэл одоо баян Австрали мэтийн нүүрсний орнууд экспортын татвартай нүүрсэн дээр 6.6-25 хүртэл хувийн экспортын татвартай, манайх экспортын татвартай болох хэрэгтэй. Дараа нь 56-70 хувь нь улсын төсөвт орж байдаг ийм байдаг юм байна шүү дээ. Ингэж байж тэр чинь баян чинээлэг байдаг юм байна. Энийг манай Сангийн яамныхан судлаарай, ийм амьд жишээ байна шүү. Тэгээд дараа нь би бас нэг юм хэлэх гэсэн нь манай орон чинь ерөөсөө хулгайн эх орон болчихсон байна шүү дээ. Би Пунцагийн Бадарчид нэг шүлэг захимаар байгаа юм. Ерөөсөө манай эх орон бол нүүрсний хулгайн эх орон гэдэг шүлэг бичээч ээ, миний эх орон ган эрдэнийн орон гэдэгтэй адилхан, тэгээд манайх одоо удахгүй Улсын Их Хурлаараа 3 хууль хэлэлцэх гэж байгаа. Нэгдүгээрт, Үндэсний татварын, үндэсний баялгийн хууль, хоёрдугаарт, Ашигт малтмалын хууль, гуравдугаарт, Биржийн хууль. Энэ хууль чинь дандаа худлаа, гаднын захиалгаар хийсэн ийм хууль байгаа юм аа. Биржийн хууль дээр юу гэж байна вэ гэхээр саяхан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд ярьж байсан хувийн компанийн эзэмшиж байгааг бол оруулахгүй ээ гэж байгаа юм. Гэтэл хувийн компани гэдэг чинь зөвхөн тусгай зөвшөөрлийг эзэмших эрхтэй, цаад газар доор байгаа баялаг нь нийтийн өмч шүү дээ, хамгийн түрүүнд оруулах хэрэгтэй. Ингээд биржид худалдаалахад нөгөө биржийн үнээс доогуур зарвал яах юм бэ. Тийм учраас энэ гурван хуулийг ард түмнээр хэлэлцүүлэх ёстой, ингэж байж Улсын Их Хуралд орох ёстой гэсэн байгаа юм.

Манай улс хулгайн эх орон болчихсон, шахааны бизнес болчихсон жишээлэх юм бол энэ дээр хоёр, гуравхан жишээ хэлье. Жишээлэх юм бол манай Буянт-Ухаа нисэх онгоцны буудлыг Хөх хотын буудалтай харьцуулах юм бол 4 дахин өндөр үнээр байгуулж өгсөн. Хөшигтийн хөндийн уурхай бол долоо дахин их үнээр хийлгэсэн, ингээд бизнес хийгээд байж байгаа юм. Хоёрдугаарт нь ТЭЦ-4-ийн шинэчлэлийг 6 дахин их үнээр Японоор хийлгэсэн байж байгаа, гэтэл Оросууд 6 дахин, ингээд дээр доргүй. Дараа нь нэг санал байгаа, зөвхөн энэ нүүрс биш цаана нь зэсийн хүдэр, төмрийн хүдэр дээрээ яг адилхан ийм сонсгол хийгээч ээ гэсэн нэг санал тавья аа. За баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За санал хэлчихлээ. Ц.Сайнбилэг, хоёрдугаар микрофон.

Сонсголд оролцогч, иргэн Ц.Сайнбилэг: За сайн байна уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Энэ нээлттэй сонсголд орж үг хэлэх боломж олгосон бас жагсагчдадаа баярлалаа. Зөв зүйлийн төлөө тэмцэж байгаа залуучууддаа баярлалаа. За би бас нэг нүүрсний хулгайн нэг жишээг ярих гэсэн юм. Би ямар нэгэн байдлаар нэргүй, эзэнгүй, баримтгүй зүйл ярьсангүй. Энэ Гаалийн ерөнхий газраас 2022 оны 05 сарын 19-ний өдрийн 03/1414 гэсэн Монгол Улсын үнэн шударгыг тогтоох шүүхэд нотлох баримтын хүрээнд гаргаж өгсөн баримтын хүрээнд би ярьж байгаа юм. Энэ яасан бэ гэхлээр “Штайнколе” ХХК гэж компани 2016-2022 он хүртэл нийт 1,320,862.22 тонн нүүрс гаргасан байгаа. Энэ нь доллароор үржүүлэх юм бол 83.7 сая доллар, төгрөгөөр үржүүлэх юм бол 211.0 тэрбум төгрөг. “Штайнколе” ХХК-ийн гүйцэтгэх захирал болон нягтлан улсад тайлагнахдаа 71 тэрбум төгрөг гээд тайлагначихсан байгаа юм. Ингээд 144 тэрбум төгрөгийн орлогоо нуусан, магадгүй татвараас зайлсхийсэн байж болзошгүй үйлдлийн талаар би цагдаагийн байгууллагад гомдол гаргаад 2 жилийн нүүрийг үзлээ.

Эрүүгийн цагдаагийн алба, Улсын мөрдөн байцаах алба, Прокурорын байгууллагын хэмжээнд нийт 100 орчим санал хүсэлт гомдлыг гаргаад одоогийн байдлаар явж байна аа, ямар нэгэн байдлаар үр дүнд хүрдэггүй. Тийм учир одоо энэ баримтын хүрээнд би бол өөрөө

энийг чинь санаанаасаа зохиож хийгээгүй шүү дээ, энэ баримт маань өөрөө яриад байгаа юм, би гаргаж өгөөгүй юм. Гаалийн ерөнхий газраас Чингэлтэй дүүргийн шүүхэд гаргаж өгсөн баримтын хүрээнд ярьж байгаа зүйл шүү. Ингээд энэ баримтыг ийм байж болзошгүй үйлдлийг шалгуулахаар миний бие хандаад, би нэг л жишээ ярья, үнэхээр одоо тодорхой хэмжээний мөнгө, хуулийн байгууллагад танил талтай, ийм хүмүүсийн өмнө энгийн иргэн миний бие хүчин мөхөстлөө, тэгээд одоо энэний нэг л жишээг нь ярья. 2022 оны 05 сарын 30-ны өдөр Эрүүгийн цагдаагийн албанд өгч байгаа юм, надад 2022 оны 07 сарын 22-ны өдөр хариу өгч байгаа юм бүхэл бүтэн 37 хоног миний гомдол сейфэнд дарагдаж байгаа юм. Тэгээд надад өгч байгаа хариу нь 2022 оны 07 сарын 22-ны өдрийн дугаар 8А/5857 гэсэн, энэ дээр манай ажилтан танд мэдэгдээгүй байна, тийм учир энэ ажилтныг 15 хувиар шийтгэлээ гэж байгаа юм цалингийн 1 сарын. Миний 37 хоног энэ хэргийг шийдэхгүй байгаа юм бэ гэдэг тал дээр нэг ч хариулт байхгүй, энэ бүх асуудлууд, энэ баримттай зүйлийн талаар би Монгол Улсын Ерөнхий Прокурор Б.Жаргалсайханд 3 удаа гомдол, санал, хүсэлт өгсөн, уулзъя гэдэг талаар нэлээдгүй баримтуудыг өгсөн.

Харин энэ зөв зүйлийн төлөө тэмцэж байгаа болон Улсын Их Хурлын гишүүдийн нээлттэй сонсголын үеэр энэ хүн хурлын танхимд сууж таарлаа, энд бас би олзуурхаж, энэ баримтыг бас өөрт нь өгье гэж бодлоо. Ер нь Монгол Улсын Ерөнхий Прокурор Б.Жаргалсайхан ард иргэдийнхээ төлөөлөлтэй уулздаггүй юм уу? Энэ талаар асуумаар байна. Цагдаагийн ерөнхий газраас энд төлөөлөл байгаа учраас би энэ баримтыг бас өгчихье гэж бодож байна. Миний хүсээд байгаа зүйл ерөөсөө л энэ улсад төлөх ёстой татвараа төл, дээрээс нь энэ асуудлыг хууль дүрэм журмын дагуу л шалгаад өг л гэж байгаа юм. Би өөр юм ерөөсөө хүсэхгүй. 2 жил энэний талаар хуулийн байгууллагуудад хандлаа. Гэсэн хэдий боловч энэ компани нь өөрөө татварт 3.8 тэрбум төгрөгийн өртэй, өртэй хэр нь компанийн дансанд мөнгө байдаг. Би энд баримттай ярьж байна л даа. Компанийн данснаас 2021 оны 1 сарын 22-ны өдөр бэлэн чек бичиж 1.1 тэрбум төгрөг аваад байдаг. Би энэ дээр хэн нэгний нэр хэлсэнгүй. Би өөрөө компанийнх нь нэрийг бол хэлчихлээ. Ямар нэгэн байдлаар хэн нэгний нэр хэлэх юм бол сүүлд нь нэр хүндэд халдсан гэдэг асуудал яригдана. Одоо ингээд энэ баримтуудыг Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, дээрээс нь Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайханыг орлож байгаа эмэгтэй байх шиг байна, би нэр усыг нь сайн мэдэхгүй байна. Энэ 2 хүнд өгье. Тэгээд Б.Жаргалсайхан прокуророос нийт ард иргэдийн өмнө бас нэг зүйл хүсэлт байна. Намайг нэг хүлээж авч уулзаач, би байгаа бодит зүйлийн талаар ярья. Өнөөдөр хэрвээ ямар нэгэн байдлаар Ц.Сайнбилэг гэдэг хүн хууль бус юм хийчихсэн бол энэ хууль хяналтын байгууллагын танил тал нь аль хэдийн 461 рүү аваачаад хийчихсэн.Харамсалтай нь тийм юм байхгүй учир өнөөдөр надад ийм юм ярих боломж олдлоо. Анхаарал тавьсанд баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За Д.Баянжаргал прокурор байна уу? Д.Баянжаргал прокурор байна, Цагдаагаас хүн байна уу? За дараагийн үг хэлэх У.Болортуяа сэтгүүлч гэж байна. Хоёрдугаар микрофон.

Сонсголд оролцогч, сэтгүүлч У.Болортуяа: За сайн байцгаана уу? Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Намайг У.Болортуяа гэдэг. Маш олон хүмүүс надад үг дайсан асуулт асуухыг хүссэн учраас өнөөдөр иргэний хувиар биш зөвхөн сэтгүүлчийнхээ хувиар асуулт асуух гэж байна? Нэгдүгээрт оффтэйк гэрээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нууцад оруулсан гэж байгаа. Гэхдээ тэр нь бол зөвлөмж. Зөвлөмжийг заавал биелүүлэх шаардлагагүй байдаг. Тэгэхээр эцсийн шийдвэрийг яг хаанаас гаргасан юм бэ гэдгийг асуумаар байна, хэнээс асуух уу? хэн хариулах вэ? Эцсийн шийдвэрийг Засгийн газар гаргасан юм уу? Улсын Их Хурал гаргасан юм уу? 2016 оноос өмнөх хуулиар бол эцсийн шийдвэрийг Улсын Их Хурал гаргадаг. 2017 оны 9 сарын 1-нээс хэрэгжсэн Нууцын тухай хуулиар бол эцсийн шийдвэрийг хаанах гаргасан юм бэ? Засгийн газар уу? Улсын Их Хурал уу? Энд хариулт хэлээд өгөх хүн байна уу?

Дараагийнх нь, хэрвээ Засгийн газар болоод Улсын Их Хурал эцсийн шийдвэрийг эцэслэн гаргасан бол хариуцлагыг хэн хүлээх вэ? Оффтэйк гэрээ үнэхээр улсад тийм их хэмжээний хохирол учруулсан юм бол уг шийдвэрийг гаргасан хүмүүс нь хариуцлага хүлээх үү? За эдгээр Засгийн газрын гишүүд болоод Улсын Их Хурлын гишүүд хариуцлага хүлээнэ гэж үзэх юм бол хууль, эрх зүйн хувьд Авлигатай тэмцэх газар мөрдөн шалгах үйл ажиллагаагаа явуулахад ямар нэгэн саад тоггор гарах уу? Энэ дээр З.Дашдаваа дарга хариулж өгөөч. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл энэ асуудлыг нууцад оруулсан гэж хэлж байна. Санаачилгыг хэн гаргасан юм бэ? Нэгэнт бүх мэдээллийг ил болгосных санаачилга хэн гаргасныг олон нийтэд хэлж өгөөч. Гаалиар ийм их хэмжээний нүүрс гарсан юм байна. Гаалийн мэдээлэл дээрээс харахад 379,000 тонн нүүрсийг гаргасан юм байна. Өөрөөр хэлбэл, гаалиар бүртгэлгүй нүүрс гарч байхад цалингаа авч байсан гаалийнхан яг юу хийж байсан юм бэ? Б.Асралт дарга ажлаа өгчихсөн байгаа. Танай намын гишүүн энэ Б.Асралт гэдэг хүн чинь улс төрийн хувьд ч гэсэн хариуцлага хүлээхгүй юм уу? Ажлаа өгөөд л болоо юм уу? Гаалиар ийм их хэмжээний нүүрс гарч байхад Б.Асралт дарга яагаад хариуцлага хүлээхгүй ажлаа өгөөд явчхаж байгаа юм бэ? Энд хэн хариулах вэ? Намын гишүүний хувьд Д.Тогтохсүрэн гишүүн байвал хариулаад өгөхгүй юу.

БНХАУ 20 жилийн нүүрсний хэргээ нөхөн мөрдөж, 942 хүнд ял оногдуулсан байна. Бид хэдэн жилийн нүүрсний хулгайгаа нөхөн шалгаж байгаа вэ? Хэдэн жилийнхийг нөхөн сэргээж шалгах юм. 2012 онд батлагдсан Чалкогийн гэрээг буюу тухайн үеийн Ерөнхий сайд Сү.Батболдын Засгийн газрын баталсан гэрээг шалгах уу? Авлигатай тэмцэх газрын шалгаж байгаа хүмүүс дотор Засгийн газрын гишүүд болоод Улсын Их Хурлын гишүүд байгаа юу? Нүүрсний хууль бус мөнгө хаашаа ордог юм бэ? Энэ тухай Авлигатай тэмцэх газар 2017, 2018 онд хууль бус мөнгө хаашаа орж байгаа талаар судалгаа хийж байсан. Энэ судалгаагаа яагаад олон нийтэд одоо хүртэл ил тод, нээлттэй өгөхгүй байгаа юм бэ? Уулын ам бүрд баригдаж байгаа орон сууцны хороолол энэ нүүрсний хулгайн мөнгөнд чинь орж байгаа юм уу? Сэтгүүл зүй биш тархи угаадаг, пропаганда хийдэг медиа руу энэ мөнгө орж байгаа юм уу? Энэ хууль бус мөнгө чинь яг хаашаа орж байгаа юм бэ? Энэ хууль бус мөнгө сайн сайхан зүйлд лав зарцуулагдаагүй байх. Энэ мөнгө шударга бусын эсрэг зарцуулагдаж байгаа. Тэгвэл яг шударга бус хаашаа орсон юм бэ? Энийг тогтоож өгөөч, энэ тухай мэдээлэл өгөөч. Авлигатай тэмцэх газрын З.Дашдаваа дарга “бид нар одоо сайн ажиллана, нэг ч хүнийг ял завшуулахгүй байх тал дээр анхаарч ажиллана” гэдэг мэдээллийг өдөр өглөө. Хөндлөнгийн нөлөөгүй, улс төрчдөөс хараат бус ажиллана гэдэг ямар нэг итгэлцлийн хэмжүүр бий юу? Авлигатай тэмцэх газарт яаж итгэх вэ?

Авлигатай тэмцэх газар, хууль хяналтын байгууллагууд шалгаж байна гэдэг. Эхнээсээ С.Баярцогт, Сү.Батболд, Ч.Сайханбилэгийн хэрэг нь бүгд хаагдаад алга болчихдог. Тэгээд яах юм, яг энэ зарчмаараа хаагдаад явах юм уу, хаагдахгүй гэдэг дээр ямар баталгаа өгөх юм. Итгэлцлийн хэмжүүр байдаг юм уу, энийг яаж хэмждэг юм бэ? Энэ дээр хариулт өгөөч. Гаалийн байгууллага 370,000 тонн нүүрсийг бүртгэлгүй гаргачихсан юм байна. Одоо тэгээд юу хийх юм. Цаашдаа ингээд бүртгэлгүйгээр хилээрээ гаргасаар байх юм уу? Бодлогын хувьд, тоног төхөөрөмжийн хувьд, эрх зүйн хувьд гаалийн байгууллага яг ямар шинэчлэлт өөрчлөлт хийж байгаа юм бэ? Урагшаа харъя гэж байгаа юм бол яг ямар өөрчлөлт хийж байгаагаа тайлбарлаач. Мөн “Эрдэнэс Тавантолгой” ХК буюу энэ их нүүрсийг нүүрсний мафиуд, төрийн хулгайчид эзэмшээд байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг цаашдаа яах вэ? Хувьчлах уу, IPO хийх үү.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За хэн хариулах уу? Б.Жавхлан сайд хариулах уу, Шадар сайд хариулах юм уу? Эцсийн шийдвэр хаана байгаа, Улсын Их Хурал гаргасан юм уу, Засгийн газар гаргасан юм уу, хаана гарсан юм гэж байна. Шийдвэр гаргасан албан тушаалтанд хариуцлага хүлээхгүй гэж байна. Гаалийн дарга Б.Асралтад

хариуцлага хүлээлгэсэн үү, хүлээлгэхгүй байна уу?

УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан: За бид хоёр хуваагаад хариулъя. Процессын хувьд бол сая У.Болортуяа сэтгүүлч их зөв хэллээ. 2017 оны 9 сарын зохицуулалтаас хойш Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр гэрээ хийх гэсэн ойлголт байхгүй шүү дээ. Тэндээс зөвлөмж гарна. Засгийн газар энэ хүрээнд гэрээ хийх субъект рүү чиглэл, үүрэг даалгавар өгдөг. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьд бол яг эцсийн гэрээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс ирсэн зөвлөмжийн хүрээнд Засгийн газар зохион байгуулж, “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр Ж.Ганбат дарга гэрээгээ үзэглэдэг биз дээ. Хоёрдугаарт, гааль дээр бол өнөөдөр миний танилцуулсан гаалийн зөрчилтэй холбоотой асуудлуудыг бид дахин дахин хэлээд байгаа юм. Гаалийн дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүд Б.Асралт даргын өөрийнх нь ажиллаж байсан үед гарын үсэг зураад хуулийн байгууллага руу энэ бүхнийг шилжүүлсэн байдаг юм. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьд цаашдаа IPO гаргана. 1072-оос нэмж хяналтын багц 34 хувь хүртэл ч юм уу, ер нь ингэж олон нийтийн хяналтад оруулж, засаглалыг сайжруулах замаар энэ компанийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нь нэмэгдүүлэх шийдвэр Засгийн газраас гарсан байгаа. Энэ хүрээнд Засгийн газар ойрын хугацаанд зохион байгуулалтуудыг хийнэ.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Авлигатай тэмцэх газраас хүн байна уу? Хэдэн оноос эхэлж шалгах юм. Засгийн газрын гишүүн шалгагдаж байгаа юм уу? Энэ хууль бус мөнгө хаашаа ороод байна гээд олон асуулт байна.

Сонсголд оролцогч, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах газрын дарга Х.Буянтүмэн: За гэрээтэй холбоотой асуудал бол “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр хийгдсэн байгаа. Авлигатай тэмцэх газраас мөрдөн шалгах ажиллагаа явуулахад улс төрийн нөхцөл талаас болон хууль тогтоомжийн хүрээнд ямар нэгэн хүндрэл байхгүй. Мөрдөн шалгах ажиллагаанд гарч байгаа нэг хүндрэлтэй асуудал бол эрх зүйн харилцан туслах ажиллагаа юм. Бид БНХАУ-ын талд хүсэлт явуулсан, хүсэлтийн хариуны асуудал дээр нэг асуудал үүсэж байгаа. БНХАУ 20 жилийн хугацааны нүүрсний асуудлыг шалгаж байна. Бид өнөөдрийн байдлаар 2012 оноос хойших буюу сүүлийн 10 жилийн байдлаар шалгалтын ажиллагаануудыг явуулж байгаа. Үнийн судалгаа гээд байсан хаусууд болон Богд уулын газартай холбоотой асуудлыг ярьж байгаа болов уу? гэж бид үзэж байна. Цагдаагийн байгууллагатай хамтраад Богд уулыг тойрсон Дархан цаазат газрын амуудад баригдсан хувийн хаус, барилгын асуудал судалгааны шатандаа явагдаж байгаа. Нэлээдгүй ажиллагаа орж байгаа. Эхнээс нь хууль бусаар олгогдсон газруудыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж, цуцлуулах арга хэмжээ авч байгаа. Авлигатай тэмцэх газар бол хуулиар хараат бус байгууллага, тэр чиглэлээрээ үйл ажиллагаа явуулна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулж, бидний үйл ажиллагаанд прокурорын байгууллага хяналт тавьж ажиллана. Бид ямар ч байсан энэ хэргийн ард гарна гэсэн итгэлтэй цагдаагийн байгууллагатай хамтарсан ажлын хэсэг ажиллаж байгаа. Одоо бол нэр хэлэх бололцоогүй.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За баярлалаа, манай Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл түрүүнд С.Эрдэнэбат ерөнхийлөгч үг хэлчихсэн. Одоо үг хэлнэ гэж таван хүн нэр өгсөн байх юм. Тавуулаа үг хэлэх юм уу? За З.Цогтгэрэл хэлээд бусад нь болих юм байна гэж ойлголоо шүү.

Сонсголд оролцогч, МҮЭ-ийн төлөөлөгч З.Цогтгэрэл: За Үйлдвэрчний эвлэлээс таван хүн биш 3 хүн хэлнэ. Миний ард дахиад 2 хүн хэлнэ шүү. За ерөнхийдөө нүүрсний асуудлаар МҮЭХ 11 сарын 07-ны өдөр анх шүгэл үлээж, хэвлэлийн хурлаараа энэ асуудлыг ярьж эхэлсэн байгаа. Ерөөсөө дуугардаггүй, хэлдэггүй гэж байгаа биш. Хэлж ярьдаг, жагсаал цуглаан хийсэн ийм асуудал байгаа. Манай ард иргэд зөв ойлголттой байж, зөв

ойлголтыг бусад иргэдэд түгээхийг хүсэж байна. Энэ дээр би маш олон төгрөгийн тоотой мөнгөн дүнгүүд яваад байгаа асуудал дээр санал хэлэх гэж байна. Ерөнхийдөө асуух асуултуудыг маань ихэнх оролцогчид асуусан учраас санал хэлэх гэсэн юм. Ер нь энэ хулгай төрийн хулгай, хэний хулгай байх нь хамаагүй. Энэ Монгол Ардын намынхан, Ардчилсан намынхны хооронд зөрчлүүд үүссэн. Энэ заалны уур амьсгал бол байнга тийм байна. Бид нарын хувьд цэвэр хөдөлмөрчин ард түмнийхээ дуу хоолой болж, эдгээр хүмүүсийн дуу хоолойг төр засагт хүргэж, нийгэмд байгаа зөрчлийг хэлэлцэж, энэ асуудлуудаараа шийдвэр гаргаж явдаг ийм байгууллага байгаа. Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний холбоо бол боловсролын салбарын 70 гаруй мянган гишүүдийнхээ хөдөлмөрлөх эрх ашигтай холбоотой асуудлаар дуу хоолойгоо хүргэсээр өнөөдрийг хүрч байгаа. Тэгэхээр ер нь энэ асуудал маань хүндэрч байна, боловсролын салбар туйлдаж байгаа, боловсон хүчний дутагдалд орж байгаа. Эдгээр асуудлуудад нүүрсний хулгайтай холбоотойгоор энэ төр засагт нүүрлээд байгаа эдийн засаг, санхүүгийн өөрсдийнх нь хулгайтай тэмцэх цаг нь болжээ гэдгийг албан ёсоор боловсролын салбараа төлөөлөөд энэ индэр дээрээс хэлж байна. Ер нь нийгмийн зөвшлийн талуудыг байнгын зөвлөлдүүлж, хуралдуулья гэж байгаа асуудлыг дэмжиж байна. Засгийн газар энийг дэмжиж, энэ зөвлөгөөнийг, энэ санал хэлэлцүүлгийг хийж байгаад талархал илэрхийлж байна. Энд оролцогчдын дуу хоолойг нь сонсох ёстой гэж байгаа. Хүн болгоны дуу хоолойг сонсох ёстой шүү гэж хэлье. Мөн гадаа цэвэр өөрсдөө жагсаж байгаа залуучуудыг битгий улс төрчдийн нүдээр харж, битгий улс төржүүлээчээ гэдгийг хүсмээр байна.

Өнөөдөр хүртэл Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны гишүүд төлөөлөгчид биднийг энд дуу хоолойгоо хүргэх явцад талбай дээр дуу хоолойгоо хүргэж, жагсаалаа хийгээд тарсан байгаа гэдгийг мэдэгдмээр байна. За Б.Жавхлан гишүүнээс асууя. Энэ Чалкогоос оруулж ирж байгаа хөрөнгө оруулалтаас энэ жил төсөв дээр боловсролын салбарын ажилчдын цалинг нэмэх асуудлаар мөнгө төгрөг тусаагүй ээ. Тэгвэл энэ орж ирж байгаа хулгайлагдсан мөнгө, хүмүүсээс хураах мөнгөнөөс цалин хөлс, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх боломж байна уу? Төсөвт тодотгол хийх үү? Мөн төрийн албан хаагчид маань хөрөнгө орлогын мэдүүлгээ ил тод зарладаг байгаачээ. Хэрвээ зарлаад нотолж чадахгүй бол сургууль цэцэрлэгээ бариачээ, энэ ард иргэдийнхээ туйлдаж буй амьдралыг дэмжээчээ гэдгийг хэлье. Өнөөдөр боловсролын салбар, тэр дундаа сургуулийн өмнөх боловсрол дээр 2-18, ерөнхий боловсрол дээр 2-17 хүний боловсон хүчний дутагдалд орчихсон байна. Эдгээр хүмүүсийн ажлыг нөгөө хүмүүс давхар үүрч байна. Үүндээ тохирсон цалин хөлсийг авж чадаж байна уу? Үүн дээрээ анхаараачээ гэдэг саналыг бас давхар хэлж байна. Бүрэн эрхт төлөөлөгч томилсон гэж ярьж байна. Бүрэн эрхт төлөөлөгч томилогдсон хүмүүс давуу байдлаа оруулж, бидэнд хөрөнгө оруулалтын оруулж ирэх ёстой. Хэдий хэмжээний мөнгө оруулж ирэх юм бэ гэдэг дээр хяналт тавья.

Магадгүй боловсролын салбарынхан хяналтын хороо байгуулж, хяналтын хороонд нь орж энэ хөдөлгөөнд нь нэгдэн орж ажиллах мянга мянган саналаа ирүүлээд байна. Мөн орлогоо нотолж чадахгүй байгаа гишүүд, ерөнхийлөгчөөс эхлүүлээд Та өөрөө эхлүүлээч ээ, Та орлогоо нотлооч ээ гэж хэлмээр санагдаж байна. Япон, Солонгост энэ төрлийн орлогыг боловсролын салбарт улс эх орны хойч ирээдүйд зарж байгаа.

Сонголд оролцогч, иргэн С.Орхонбаяр: Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 сарын 24-ний өдөр гарсан 41 дүгээр тогтоол одоо хэрэгжиж байгаа юу? Үгүй юу? Үүнийг асууя.

Хоёрдугаарт, олон улс болон иргэнийхээ өмнө хүлээсэн үүргийг би уншаад өгье. 1-д Монгол Улсад НҮБ, НҮБ-д гишүүнээр элсэж, хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүлээн зөвшөөрч улмаар иргэний болон нийгэм соёлын эрхийн тухай олон улсын гэрээнд нэгдэн орж хэрэгжсэн, үүн дээр олон улсад үүрэг хүлээсэн байгаа юм. 2-т Үндсэн хууль болон

хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, зөрчигдсөн эрхийг нь сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээнэ гэсэн энэ хоёр заалтыг хэрэгжүүлээгүйгээс болоод Монгол Улс чинь сүйрчихлээ. Энэ хөтөлбөр чинь хэрэгжиж байгаа юу үгүй юу.

Одоо нүүрс тээвэрт явж байгаа жолооч нарын эрх ашгийг хамгаалдаг Монголын авто тээвэрчний үйлдвэрчний эвлэлийн хороо болон хувиараа тээвэрчний нэгдсэн холбоо ганцхан мэдэгдэл хийсэн. Энэ монгол жолооч нарын төлөөлөл болон сүүлийн 30 гаруй жил нийслэлийн нийтийн тээврийг хувийн хөрөнгөөрөө үүрэлцэж, улс орны эдийн засгийг нуруун дээрээ үүрэлцэж байсан. Гэтэл өнөөдөр Монголын баялгийг болон эх орон ирээдүй хойч үеийнхээ гишгэх баялгийг албан тушаалаа ашиглан үгсэн хуйвалдаж, тонон дээрэмдсэн хулгайчдын гар хөл болж байснаа өнөөдөр мэдлээ. Энэ асуудлыг зөв шийдтэл үйлдвэрчний эвлэлийн гишүүд тодорхой хугацаанд улс оронд ашигтай болгох тал дээр дараагийн шатны арга хэмжээг авна. Шаардлагатай бол хилээр гарахад үйлчилдэггүй жолооч нартай болно. Монгол Улсын Үндсэн хуульд заасан болон бусад хуулиудыг зөрчсөн энэ асуудлуудыг чинь Монголын ард түмэн, ард түмний хурал хийж байж шийднэ. Энэ асуудал дээр шийдвэр гаргал манай байгууллагын гишүүд жолооч нар хариуцлагатай тэмцэх болно гэдгийг албан ёсоор мэдэгдье. За баярлалаа.

Сонголд оролцогч, иргэн Б.Мөнхсоёл: Намайг Б.Мөнхсоёл гэдэг. Эдийн засагч мэргэжилтэй иргэн хүн байна. Би нарийн тоо статистиктай холбоотой зүйл асуух гээгүй. Ерөнхийдөө танилцуулга хийсэн хүмүүст хувь хүний зөвлөмж өгөхөд энэ боломжийг ашиглаад яг асуудалтай хэсэг дээр нарийн төвлөрөөд, яагаад үүнд хүрэх гэдэг дээр ярих байсан юм болов уу гэж бодсон. Тэгэхгүй онолын юм ярьчихаар иргэд хүлээж авахгүй, шингээж ойлгож чадсангүй юу гэж харлаа. Одоо яригдаж байгаа Үндэсний баялгийн тухай хуулийг түрүүн нэг хүн 3 хуулийн нэг болгоод ярьж байсан. Тэрний өмнө Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийг бас батлах хэрэгтэй гэж бодож байна. Яагаад гэхээр энэ бол олон улсын түвшинд уул уурхайн салбар хөгжсөн, баялагтай ийм улсуудад угаасаа байдаг хууль. Монгол Улс бол байгалийн баялагтай, энэ салбараа чадан ядан хөгжүүлэх гэж явж байгаа. Сайн засаглал бий болж амжаагүй учраас маш их авлига, луйварын асуудлууд яригдаж байна. Цаашлаад Үндэсний баялгийн тухай хууль батлагдчих юм бол өмнөх Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулиа батлаагүй тохиолдолд дахиад ийм хулгай, луйварын асуудал гарч ирэх магадлалтай. Тийм учраас энэ ил тод байдлын хууль батлагдсанаар олон улсын түвшинд аудит хийлгэнэ, түүнийхээ тайланг ил тод байлгах ёстой, тухайн уул уурхайн компаниуд ТУЗ-ынхаа шийдвэрийг ил тод байлгах ёстой гээд ийм олон улсын түвшинд стандартын тавигдах ёстой тайлангууд болон санхүү тоо мэдээнүүд ил байлгах шаардлагууд байдаг. Анхнаас нь ингээд ил тавьчих юм бол дараа нь бие биеэ хардах оффтэйк гэх мэт энэ байдал чинь байхгүй болох хууль, эрх зүйн орчин чинь бий болно гэдгийг хэлмээр байгаа юм.

Хоёрдугаарт, би иргэний нийгмээр гарч ирсэн хүн. Улмаар намд орсон улс төрч хүн байна. ХҮН-ын Удирдах зөвлөлийн гишүүн хүн байна. Юуг хэлмээр байна вэ гэхээр Та бүхэн анзаарсан байх. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаар бид нэлээн хүчтэй дуугарч байгаа. Яагаад вэ гэхээр хулгай, луйвраас хол байа гэвэл шударга сонгуулийн систем л хэрэгтэй. Тэгэхгүй бол түрүүн У.Болортуяа сэтгүүлч асуусан энэ их оффтэйк, энэ их алдагдал чинь хаашаа ороод байна. Эдийн засгийн ухааны ойлголтоор алдагдсан боломжийн өртөг ярих юм бол дүн мэдээ улам ихсэнэ. Тэгэхээр шударга сайн сонгуулийг бий болгохын тулд бүгдээрээ зөв, сайн хүнийг гаргая. Энэ бүхний өөрчлөлт нь сонгуулийн холимог тогтолцооны өөрчлөлт шүү.

У.Болортуяагийн асуусан нүүрсний хулгайн мөнгө хаашаа ороод байна гэдэгт, мэдээж нэг хэсэг нь сонгуулийн зардал шүү дээ. Тухайн хувь хүн улс төрчдийн зардал, фракцын зардал, улс төрийн намуудын зардал. Сая 2019 онд Үндсэн хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулахад намын гишүүдийн тоогоос эхлүүлээд зарим нэг буруу өөрчлөлт хийсэн. Улс төрийн намын бүтэц нүсэр байх тусмаа зардал ихсэнэ, тэр нь эргээд улс төрчдийг төсвөөсөө хулгайлах сэдлийг бий болгодог. Магадгүй улс төрчид энэ чөтгөрийн тойргоос гарахыг хүсдэг байх гэж найдаж байна. Амар тайван нийгмийг бий болгохын тулд тогтолцоогоо л эрүүлжүүлье гэж хэлмээр байна. Баярлалаа.

Сонсголд оролцогч, МҮЭ-ийн төлөөлөгч М.Болдсайхан: За ер нь бол эхнээс нь анзаарлаа. Зохион байгуулалттай 2 намын хүмүүс орж ирээд байгаа юм биш үү. Зохион байгуулалттай иргэн, иргэн гээд байх юм. Ер нь бол энэ залуучууд болоод нийгмийн бухимдал нь энэ нүүрсний хулгайгаар тэсэрч байна. Хүү, торгууль гээд л өчнөөн асуудлууд байна. Эдгээр зүйлүүдээс бухимдлыг нэгдүгээрт харах хэрэгтэй. За асуулт байна.

9000 жолоочийг шалгаж байгаа гэж байна. 9000 жолоочийг шалгаад амьдрал дээр ял тулгаад гарч ирнэ гэсэн ойлголт байхгүй шүү. Нэгдүгээрт энэ улсууд бол зүгээр нэг компаний төрийн нүүрсийг зөөдөг хүмүүс. Зүгээр хувьдаа, халаасандаа хийгээд гараад явчихсан зүйл байхгүй. Тэгэхээр энэ хууль хяналтын байгууллага хил, гааль дээрх хяналтаа чангатгах хэрэгтэй. Энийг шалгах хэрэгтэй. Түүрүүн ярьж байна Асралт дарга ажлаа өгөөд, өөрөө санаачлаад явчихсан. Тэгвэл Гаалын ерөнхий газрын дарга Б.Асралтын өмнө хэн байсан юм? Хариуцлага хүлээх юм уу?

Цагдаа, хуулийнхнаас асууя. Авлигатай тэмцэх газраас 2-3 жилийн өмнө цахим орчинд Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн нь чи нүүрсний хулгайч гээд байсан. Бидний нүдэн дээр ил байгаа зүйл шүү дээ. Энэ сэдлээ шалгасан юм уу? Нүүрэн дээр яриад байна. Үүнийг шалгасан юм уу?

Бид 2022 оны 11 дүгээр сарын 07-нд жагсаал цуглаан хийсэн. Энд манай Гашуун сухайт дахь нүүрс тээврийн жолооч нар ирсэн. Төрийн аваад байгаа ПСР шинжилгээ Улаанбаатар хотод байхад сөрөг, Өмнөговьд эерэг гараад байна гэсэн шүү дээ. Энэ тохиолдлуудаа шалгахгүй юм уу? Шадар сайд С.Амарсайхан бас ярьж л байсан. Энэ ПСР-ийн асуудлыг хэн шалгах юм бэ?

Гуравдугаарт, энэ нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, татвартай холбоотой асуудлыг шалгаж байгаа юм уу? Өнөөдөр ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулж, татвараас зугтаадаг том, том байгууллагууд байна. Сая манай энэ ажил олгогчдын төлөөлөл тээврийн компаниуд хэлж байна. Тэр олон тээврийн компаниуд олон машинтай. Эдгээр энэ компаниудыг энэ шалгалтаар шалгаж байгаа юу гэдгийг асуумаар байна.

За саналын хувьд, гурван сайдын баталсан журам гэж байгаа. Энэ журам дээр битүүмжлэгдсэн тээврийн хэрэгсэл гэж байгаа. Үүнийг урд хөрштэйгөө яриачээ, цаашид анхаараачээ. Битүүмжлэгдсэн тээврийн хэрэгсэл гэдэг нь хилээр гарч байгаа, урагшаагаар орж байгаа тээврийн хэрэгслийг лацдаад гаргаж байгаа. Сая өнгөрсөн сарын өмнө кабиндаа нас барсан тохиолдол гарсан. Хилээр гарахад нь лацдаад явдаг. Үндсэндээ 4-10 цаг явж байгаа. Тэнд агаар дутагдах, амьсгалын асуудал яах уу? Мөн энэ жолооч нарын цалин хөлсийг Та нар мэдэхгүй байгаа шүү дээ. Энд ажил олгогч, үйлдвэрчин гурав тарифын цалин руу шилжих хэрэгтэй.

Дараагийн нь энэ ард иргэд зээлийн хүүгийн дарамтад маш их өртөж байна. ЖДҮ, Хөгжлийн банк болохоороо УИХ дахь хэдэн улсууд нь хөнгөлөлттэй зээл аваад байдаг юм билээ. Зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоосон хуулийг баталж өгөөчээ.

С.Амарсайхан сайдын гаргаж байгаа Ипотекын зээлийн ... /минут дуусав./

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За хэн хариулах вэ? Авлигатай тэмцэх газар хариулах уу? Тэр хэргүүд шалгагдаж байгаа юу? гэж асууж байна. Дараагаар нь хэвлэл мэдээллээр яваад байгааг асуудлуудыг шалгадаг уу гэж байна? Татварын ерөнхий газрын дарга байна уу?

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах газрын дарга Х.Буянтүмэн: Мөрдөн шалгах байгууллагаас олон нийтийн хэрэгсэл болон хэвлэл мэдээлэл, байгууллага, албан тушаалтнаас мэдээ мэдээлэл олж, өөрсдийн хариуцсан ажил үүргийн хүрээнд эдгээр хэргүүдийг анхааралтай шалгаж судалж байгаа. Сошиал буюу нийтийн мэдээллийн сан дээр тавигдсан мэдээллүүд дээр бид анхааралтай судалж үзээд тухайн асуудлуудаар мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа.

Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал: Татварын хувьд тээврийн компаниудиа татварын албанд бүртгэлтэй 396 тээврийн компани байгаа. Эндээс үзэх юм бол 252 компани Монгол Улсын иргэний хамааралтай, 68 компани нь Хятад Улсын иргэнийх, 1 компани Хонгконг Улсын иргэнийх, 8 компани Сингапур Улсын иргэний харьяалалд байдаг компаниуд байгаа. Татвар төлөлтийг аваад үзэхэд 2021 онд нийтдээ 396 компани 67.3 тэрбум төгрөгийн татвар төлсөн. 2022 оны байдлаар 129 тэрбум төгрөгийн татвар төлсөн байгаа. Татварын алба жил болгон тээврийн компаниуд дээр хяналт шалгалт хийж ирсэн. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд нийтдээ 267 тээврийн компаниудад татварын хяналт шалгалт хийж, нийтдээ 82 тэрбум төгрөгийн төлбөр актыг тавьсан байгаа. Үргэлжлүүлэн яг одоо 22 тээврийн компаниуд шалгагдаж байгаа. Энэ 7 хоногоос тал нь баталгаажиж, мэдээлэл нь гарна.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Хан-Уул дүүргийн иргэн Ж.Баярмаа гэж байна уу?

Сонсголд оролцогч, иргэн Ж.Баярмаа: За ер нь бол энэ асуудал зүгээр нэг нүүрсний асуудал биш гэдгийг мэдэж байгаа. Уг нь бол УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат ирэх ёстой байсан юм. Яагаад гэвэл хууль, эрх зүйн нөхцөл нь бүрдсэн юм уу, үгүй юу гэдэг дээр ярилцах байсан. Нэлээд өргөн хүрээнд ярьж гэвэл энэ асуудлуудыг хөндөх байсан юм.

Монгол Улсын Үндсэн хуульд төр, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах ёстой. Гэтэл төрийн зохицуулж байгаа эдийн засгийн харилцаа нь энэ юм уу? Хэдэн их наядын хулгай гаргачхаад ингээд сууж байгаа нь энэ төр чинь Үндсэн хуулийг зөрчиж байгаа юм биш үү. За УИХ энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ёстой, гарсан шийдвэрийн биелэлтийг шалгах ёстой. Энийгээ УИХ ер нь хэрэгжүүлсэн юм уу? Яаж, ямар аргаар хэрэгжүүлдэг юм бэ? Зүйрлэвээс, аав ээж хоёр нь нийлж байгаад хүүхдүүдээсээ олон зүйл нуугаад баахан найрлаад, ууж идчихсэн ийм зүйл болоод байна. Тэгээд одоо салахдаа тулаад үгүй чи идсэн, би идсэн гээд хоорондоо хэрэлдээд байгаа дүр зураг харагдаж байна. Монгол Ардын намын тухайд өмнөх эхнэр нөхөртөө үгүй ээ энэ идсэн гэж чихэх гэж оролдож байна. Гэтэл бүхэл бүтэн 32 жилийн хугацаанд Монгол Ардын Нам засагласан үе нь 75 хувь нь байна. Ардчилсан нам 8 жил буюу 25 хувь нь л байна. Тэгэхээр хулгайгаа хуваая гэвэл 75 хувь Монгол Ардын Намд хамаарч байгаа байхгүй юу. Гэтэл өөрөөсөө холдуулаад бид биш тэд гээд байна.

За оффтэйк гээд гэрээ байна. Нууц гээд гэрээнүүд. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн чиг үүрэг нь юу юм бэ? Үндэсний аюулгүй байдлыг хангах, тухайлбал, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах. Гэтэл Төрийн болон албаны нууцын тухай хуульд юу гэж заасан байдаг вэ гэхээр, ямар гэрээг юуг нууцална гэж заасан байдаг гэвэл Үндэсний

аюулгүй байдалд хортой, үндэсний эрх ашгийг хохироох хэмжээний зүйлийг л нууцад авна гэж заасан байна. Гэтэл эсрэгээрээ энэ гэрээг нууцалж байгаад эдийн засгийг хохироосон байна ш тээ. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд нь хамаг асуудлыг тарьж хаячаад хаана байгаа юм бэ?

УИХ-ын дарга, УИХ хяналт шалгалт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна шүү дээ. Дээрээс нь УИХ-ын дарга хаана байна? Үндэсний аюулгүй байдлын гишүүн У.Хүрэлсүх ерөнхийлөгч болчихсон. Өмнө нь Ерөнхий сайд болчихсон. Монгол Ардын намын гишүүн үзвэл 2 нь ардын намын гишүүд байна. Ийм атал яагаад дандаа сөрөг хүчингээ буруутгах гэж оролдоод байдаг юм бэ? Энэ гаргаад тавьчихсан байгаа нэрс нь дандаа Ардын намын гишүүд, үгүй бол Ардын намын зарим гишүүд намайг дуугайгаар нь дээрэлхэж байна гэсэн. Жинхэнэ хулгайчдынхаа нэрсийг хэзээ зарлах юм бэ? Дээрээс нь энэ УИХ-д асуудал байна. Энэ түүхэндээ УИХ-аас УИХ гишүүнийхээ бүрэн эрхээс түдгэлзэж байсан тохиолдол бий юу? Бараг байхгүй. Харин эсрэгээрээ Н.Номтойбаяр, Д.Гантулга нарын бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай асуудлыг прокуророос оруулаад ирэхээр аваад л үлддэг. Дээрээс нь Г.Амартүвшин гишүүн миний санаж байгаагаар өөрөө саналаа гаргаад, түдгэлзэж байгаад шалгуулья гэхэд аваад үлддэг. Энийг би ерөөсөө ойлгохгүй байна. Тэр хүн өөрөө сайн дураараа татгалзъя гэж байна. Энэ хуулиндаа өөрчлөлт оруул аа. Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад ийм дархан эрхтэй газар байхгүй ээ. Дархан эрх хаана хэрэгждэг вэ гэхээр Улсын Их Хурлын танхимд хэлсэн үгнийхээ төлөө хариуцлага хүлээх ёстой асуудал дээр үйлчлэх болохоос биш хулгай хийчхээд түүнээсээ зугтах оромж Улсын Их Хурал биш ээ. Энэ халдашгүй дархан эрхийнхээ асуудлыг Улсын Их Хурлынхаа тухай хуулинд нэмэлт, өөрчлөлтийг яаралтай оруулах хэрэгтэй байна. Америкийн Нэгдсэн Улсын ёс зүйн код дээр цагаан дээр хараар бичээстэй байгаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За баярлалаа Иргэн Н.Хөхөө гэж байна уу?

Сонсголд оролцогч, иргэн Н.Хөхөө: Би Дорноговь аймгийн Н.Хөхөө гэж хүн байна. Ураны үйл дээр ... явдаг. Сүүлийн 6 жил явсан. Явсан км-ыг нь тооцвол 20-30 мянган км явсан байх. Зөвхөн энэний төлөө. Мөнгийг нь яривал 100-150 сая төгрөг зарцуулсан байх. Захиргааны хэргийн шүүх дээр үйл тамаа үздэг, хүчин мөхөсддөг. Нэг ийм органик хүн байна. Та нар бол миний нүдэнд Гитлерийн номон дээр гардаг энэ сайхан ордныг маань эзэгнээд суучихсан бузрын урвагч дүлзэнгүүд харагдаж байна. Тэгээд л элдвийн онол ярьсан. Энэ хайран сайхан төрийн маань, хайран сайхан ордныг маань бузарласан. Улсаар нь ингээд хулгай хийгээд хаячихсан. Том жижиггүй ийм нэг балай юмнууд харагдаж байна. Үнэхээр гомдож байна, уур хүрч байна, харамсаж байна, алмаар байна. Та нар бол энэ залуучуудын өмнө ичих хэрэгтэй. Энэ нүүрс гэдэг том асуудал дээр энэ залуучуудын салхинд би бас энэ залуучуудынхаа буянд энэ олон бөөгнөрөл дунд хийсэж орж ирсэн хүн байна. Гадаа байсан залуучуудын маань зохион байгуулалттай талыг нь энд оруулж ирж байгаад, талыг нь нухчин дарлаа. Жоохон хүүхэд байхад үздэг байсан кино шүү дээ. Хэн нь мэдэгдэхгүй онолчингууд оруулж ирээд энэ хурлыг жонхуу болгож байна. Наадах нүүрсний тэмцэл чинь ахиц дэвшил байгаа боловч бүрэн утгаараа үр дүн үзэхгүй. Энэ бол миний хувийн бодол. Та нар залуучуудыг эдийн засгийн аллага гэдэг ийм зальт мэхээр аллага хийж байна. Би Баяр гуайн үгнээс нэг үг сонссон юм. Ард түмний уур хилэн бол дээд цэгтээ хүрсэн, та муусайн нарын хямрал, ялзрал доройтол бол дээд цэгтээ хүрсэн. Яг энэ 2-ын мөргөлдөөн цаг үе өнөөдөр болж байна. Нутгаа аврахын тулд энэ дунд би явж байна. Та нарт бол цааш явах зам ч байхгүй, энэ уурссан ард түмнийг буцаах зам ч байхгүй. Та нарын заль бол дууссан.

Би адаг сүүлд нь нэг хувийн тактиктэй явж байна. Энэ аймшигтай үгүйрэл хоосролын ард бол мэдээж там байж байдаг. Энэ тойруу замаар дандаа үхэл байдаг. Би өөрөө үхлийн

дундуур туучдаг хүн байхгүй юу. Тийм нотлох баримтыг бүрдүүлдэг хүн. За ингээд миний тактик юу байсан бэ гэвэл, энэ дотор нэг жоохон монгол сэтгэхүйтэй хамгийн том акул нь хэн бэ? Би тэр Тагнуулын дарга, Авлигатай тэмцэх газрын дарга, Прокурорын газрын даргатай нэг халз тулья гэж бодож байсан юм. Энэ гурван хүнийг хэрвээ Монгол хүн бол формоо тайлаад Монгол дээлээ өмсөөд миний машинд суугаад “1000 сонссоноос нэг удаа үз” гэдэг өвөг дээдсийнхээ үгээр миний нутаг руу надтай хамт, яг тэр хөнөөлийн нутаг руу надтай хамт яваарай гэж урих гэсэн юм. Энэ гурван хүнд хүртэл шейрлээд өгөөрэй. Н.Хөхөө гэж хүнтэй уулзаад 99285982-руу яриад Тагнуулын ерөнхий газрын дарга, Улсын ерөнхий прокурорын газрын дарга, Авлигатай тэмцэх газрын дарга миний муу бонгонд суугаад яг тэр малчин айлуудаар юу болчихсоныг амь биеэрээ үзэхийг энэ олон нийтийн танхимаар дамжуулаад хэлмээр байна.

За ийм л байна даа. Энэ заль мэхэнд бол итгэхгүй, хэзээ ч та нарт итгэхгүй. “Хулгайч хулгайч аа барьдаг” гэж хаашаа янзын үлгэр байдаг юм. За ингээд болсон хэлэх үг маань.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За санал хэлчихлээ. Өнөөдрийн ерөнхий хяналтын сонсголд оролцож байгаа оролцогчдоос үг хэлье гэсэн иргэд бүгд үг хэлж, асуулт асууж, санал бодлоо хэлж дууслаа. Нийтдээ 85 хүн үг хэлж, асуулт асуулаа. Хэнээс хариулт авах гээд байгаа юм? За Т.Доржханд түрүүн хариулсан ш дээ. Адъяасүрэн гэж надад нэр ирээгүй байна. За Д.Нарантуяа асуугаад Үйлдвэрчний эвлэл дууслаа.

Сонсголд оролцогч, МҮЭ-ийн төлөөлөгч Д.Нарантуяа: За уучлаарай би С.Чинзориг гишүүнд шүүмжлэлтэй хандмаар байна. Яагаад гэвэл, өнөөдөр хүний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэхийг Та боомилж болохгүй. Түрүүн нэг төрийн албан хаагч залуу үг хэлсэн чинь “чи татвар төлж байгаа, татвар төлөгчдийн мөнгөөр цалинжаад байж бараг үг хэлж болохгүй шүү” гэсэн юм ярьж байна, Ингэж болохгүй шүү дээ. Өнөөдөр ямар ч хүн үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх ийм бүрэн эрхтэй. Ийм төрийн дарамт байж болохгүй. Төрөөсөө эхлээд дарамттай байгаа учраас бусад төрийн бус төрийн байгууллагууд чинь доод шатандаа маш их дарамттай байгаа гэдгийг бас хэлмээр байна. Уучлаарай, Та жаахан дарамтынхаа асуудлыг зогсоовол яасан юм бэ? Өнөөдөр хүмүүс үзэл бодлоо илэрхийлэх ёстой. За ингээд эх орныхоо хөгжлийн төлөө, ирээдүй хойчийнхоо аз жаргалтай амьдрах амьдралын төлөө, хөхөө өвлийн хүйтнээр хүйтэн цементэн дээр өдөр шөнөгүй жагсаж, тэмцэж, өөрсдийнхөө үзэл бодлыг илэрхийлж байгаа залуучуудын жагсаалыг манай эрүүл мэндийн салбарын мянга мянган эмч, ажилтнууд дэмжиж байгаа, өөрсдөө сайн дураараа иргэн, хувь хүний өнцгөөсөө ирж, жагсаалд нэгдэж байгаа. Тэрнээс үйлдвэрчний байгууллага бол тусдаа хуультай, дүрэмтэй байгууллага учраас жагсаал цуглаан, ажил хаялт хийх юм бол холбогдох хууль дүрмийнхээ хүрээнд явна.

Түүнээс биш өнөөдрийн залуучуудын жагсаалыг манай жирийн эмч, ажилтнууд бүгд дэмжиж байгаа гэдгийг хэлмээр байна. За би нэг асуултыг асууя, нүүрсний хулгайг илрүүлэх гэж байгаа гээд гэрч байцааж байгаа юм байх. Яг хамгийн сүүлд хэдийг байцааж дуусах юм бэ, гэрч байцааж байгаа гэж явсаар байгаад 1 жил болох юм уу, 10 сар болох юм уу, хэдийд яг гэрчээ байж байцааж дуусаад нүүрсний хулгайчдыг илрүүлэх юм бэ?. Нүүрсний хулгайгаа илрүүлээд тэр хүмүүсийн хөрөнгийг хураа, ард иргэдийнхээ амьдралыг дээшлүүлэхэд энэ мөнгийг зарцуул, төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүл, эрүүл мэндийн салбарын эмч, ажилтнуудын үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүл, тэтгэвэрт байгаа тэтгэврийн хөгшдийн тэтгэврийг нэмэгдүүл, залуучуудын нийгмийн баталгааг хангаж, ажил хөдөлмөрөө эрхлэх, төсөл хөтөлбөрийг нь хэрэгжүүлэх ж хүмүүст мөнгийг нь олго. Ингэж бид нар ажиллах ёстой. Зүгээр 76 гишүүнээс хоёрхон гишүүнээс нь хариу ирсэн, бусад 74 гишүүнээс нь хариу ирээгүй, энэ салбарт ажиллаж байгаа 58000 гишүүдийн шаардлагыг би хүргүүлсэн.

1.Онц байдал зарласан, ковидын үед үхтлээ ажилласан, бүр цөхөртлөө ажилласан хүмүүс үндсэн цалингаа нэмээч гээд талбай дээр халуун наранд хүйтэн бороонд суусныг та нар мэдэж байгаа, цалинг нэмээгүй, одоо ч нэмээгүй. Гүйцэтгэлийн санхүүжилт гэдэг юм ярьж байгаа. Гүйцэтгэлийн санхүүжилтээр цалингаа нэмж байгаа эмнэлгүүд тоотой хэд байгаа. Улаанбаатарт л бий. Хөдөөгийн сум, өрхийн эмнэлэг, аймгийн эмнэлгүүд цалингаа нэг ч төгрөгөөр нэмээгүй. Түрүүхэн Дорнод аймгаас санхүүжилт байхгүй, бид нарын цалинг өгөөгүй байна гээд утасдаж байна. Ингэж болохгүй шүү дээ, та нар.

2.Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа хүмүүс улаан гараараа ажиллаж байна. Хөдөлмөр хамгааллын иж бүрэн нормын хувцсыг олгож өгөөч гэсэн шаардлагыг хүргүүлсэн. Өмсдөг халаад, тавчигаа өөрсдийнхөө хуруу хумсаа маажиж олсон цалингаасаа авч байна.

Гадаах жагсаал цуглаанд өвлийн хүйтэнд түргэн тусламжаар ирж байгаа эмч нарыг хар, өөрсдийнхөө цалингаар зузаан хувцас авч өмсөж байна. Иж бүрэн нормын хувцасны зардлыг улсын төсөвт тусгаж өгөөч ээ гэж шаардаж байна. Улс орны онц аюултай байдал бий болоход цагдаа, онцгой, эрүүл мэндийн салбарынхан л явдаг. Нөгөө 2 нь иж бүрэн нормын хувцсаа өвөл, зунгүй авчаж байна.

Эрүүл мэндийн салбарынханд шаардлагатай мөнгийг нь улсын төсөвт тусгаж өгч болдоггүй юм уу? Тавьсан 2 шаардлагынхаа төлөө эрүүл мэндийн салбарынхан бол тууштай тэмцэнэ ээ, цаашдаа явна. Улсын Их Хурлын 76 гишүүд үүн дээр байр сууриа илэрхийлээрэй. Иргэдийнхээ төлөөлөл болоод Их Хурлын гишүүн болсон гишүүдээс өнөөдөр цөөхөн хүмүүс энэ хэлэлцүүлгийг дуустал сууж байна. Бусад нь хаачихсан юм бэ? Олон мянган иргэд та нарыг миний төлөөлөгч гээд сонгочихсон байгаа шүү дээ. Яагаад сонголд энэ олон түмнийг хүндэтгээд сууж болдоггүй юм? Нэг юм эхлүүлээд л хаяад гараад явна, дуустал сонсдоггүй. Ийм байж бид нар улс орны хөгжлийг ярих уу? Ингэж байж та нар Их Хурлын гишүүн гээд энэ хүмүүсийн асуудлыг шийдэх үү? Өөрсдийгөө өөрчил! Энэ салбарынхаа хөгжлийн төлөө.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За үг хэлчихлээ, Тамир гэдэг оролцогч үг хэлэх юм уу? Хишигсүрэн чи нэр өгөөгүй шүү дээ. Жавзандулам үг хэлэх юм уу? За больж байгаа юм уу? Хишигсүрэн хэлчихдээ. Та нар нэрээ өгөхгүй зовлон юмаа.

Сонсголд оролцогч, иргэн Ц.Хишигсүрэн: Нэг, хоёр асуулт нэг хүсэлт хэлье. Нийгмээрээ их хүнд байна. Бид нар хулгайч гэсэн нэр хаяг зүүгээд байгаа ч эрүүл саруулаар хөдөлмөрлөж яваа, ямар ч гэм зэмгүй Монгол Улсынхаа экспортын валютын орлогыг олох гээд гэмгүй мөрөөрөө хөдөлмөрлөж байгаа нүүрс тээврийн үндэсний компаниуд байна.

Энэ хэдэн компани өөрийн өнгө аясаар үйл ажиллагаагаа явуулсаар 10 гаруй жилийн түүхийг бүтээж өдийг хүрлээ. Түүх бүтээсэн хүмүүс нь тавиас дээш насны, зарим нь бол жар гарчихсан сайхан ахмад, туршлагатай тээвэрчид байна. Тээвэрчдийн үндсэн боломжийг нь устгачихвал ирээдүйд энэ том тээврийн салбарыг босгож ирэх ямар ч боломжгүй болно.

Шинэ үеийн залуучууд бид нар шиг ингэж улайрч махарч, хүнд ажлыг хийж босгож ирэхгүй. Үүнтэй холбоотойгоор та бүхэндээ хандсан, бас Сангийн сайд, Гаалийн ерөнхий газрын даргад хандсан хүсэлт байна.

Манай тээврийн компаниуд төрийнхөө шалгалтад орж байна. Гаалийн байгууллагаас цахимаар хоосон гарсан, хоосон орж ирсэн гэсэн бүртгэлээ авчихсан юм шиг байна аа. 2013, 2014 оны үед компаниуд “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас, Монгол тээврийн компаниуд Чалко компанийн 350 сая долларын өрийн нүүрсийг зөөж байсан. “Эрдэнэс Тавантолгой” ХК дээр

гаалийн анхных нь салбар байгуулагдаж байсан хэдий ч мэдүүлгээ өгдөггүй, араас нь ачаа буулгасан ачсан баримтаа өгдөггүй байсан.

Хил дээр очирлож байхад гаалийн байгууллага араас нь мэдүүлгийг нь авчраад Гашуунсухайтын гаальдаа өгөөд шууд нүүрсийг нь гаргачихдаг байсан. Манай Б.Жавхлан сайд, Гаалийн ерөнхий газрын дарга хоёр, бид нар бас хүсэлтээ өгөөд гэм зэмгүй, мөрөөрөө тээвэр хийж явсан хүмүүсийг нүүрсний 9 жилийн асуудалтай холбож шалгаад, эцэст нь олон хүн эрүүгийн хариуцлага хүлээх нөхцөл байдлаас сэргийлмээр байна. Компаниудын хураагдсан их хэмжээний цаасан баримтыг шалгаж өгөх боломжгүй байгаа юм шиг байна.

Үүний та бүхэн бодолцоод туслаарай гэж хүсэж байна. Ингээд нэгдүгээр асуулт бол энэ хилийн нөхцөл гээд байгаа нь Ганц модны боомт дотор ороод нүүрс ачиж буулгах талбай дээр нүүрс бууж байгааг хэлж байна уу? Аль эсвэл Цагаан хадны нүүрс ачиж буулгах талбайнуудыг хэлж байна уу? Эсвэл терминалын талбайг хэлж байна уу? Эдгээрийг ялгаатайгаар хэлж өгмөөр байна.

Хоёрдугаар асуултаа асууя. Бид нар тээвэр дээрээ тааз үнэ тогтоогоод тендер зарлачихлаа. Цагаан хаднаас цааш авч байгаа нүүрсний үнийн зөрүү нь үнэхээр манай “Эрдэнэс Тавантолгой” ХК-д буюу манай улсад ашиг олж ирж чадах уу?

Тэгж чадахгүйгээр үндэснийхээ хэдэн тээврийн компаниудыг хамгийн бага үнээр дамжуулан дампууруулаад, цаана нь үнийн зөрүүгээ ч олж чадахгүй нөхцөлөөр нүүрс худалдаж авсан худалдан авагч нарын хоол болоод дуусвал яах вэ?

Манай улсын үндэсний томоохон эрх ашиг гэж байгаа. Төрийн ой санамжид багтаах нэг зүйлийг хэлье. Манай УИХ-ын гишүүд, Засгийн Газрын буюу гүйцэтгэх засаглалынхан байж байна. Авто тээврийг авто тээврийн тухай хуульд “авто тээврийг авто аж ахуйн системээр хөгжүүлнэ, авто аж ахуйн хэлбэрээр оршин тогтноно” гэж заасан. Автобаазыг манай ард түмэн цөмөөрөө мэднэ.

Монгол Улс өргөн уудам нутагтай. 70 жилийн социализмын түүхэнд олон автобаазыг хөгжүүлж аюулгүй байдлаа хангаж байсан. Баазыг байгуулснаараа эрсдэлгүй, мэргэшсэн, стандарт хангасан тээврийн компаниуд төлөвшдөг. Байгаа хэдэн компаниудаа, тендерийн шуурганд хамгийн бага үнээр аюултай юманд оруулчхалгүй шиг төрийн хар хайрцгийн бодлого явуулж өгч туслаарай.

Бид нар Монгол Улсынхаа эрх ашгийн төлөө ажиллаж амьдарч олсон орлого, татвараа татварын байгууллагадаа нээлттэй тайлагнаж байгаа. Монгол хүнийг зөв төлөвшүүлж сургадаг, хөдөлмөрийн гэрээ хэлцлийн харилцаанд оруулж зөв авч явдаг, төрийнхөө өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлдэг хэдэн компаниуд байдаг юм шүү. Үүнийг бодож яваарай. Авто тээврээ их зөв авч үлдээрэй. Хэн дуртай болгоны амаар хуулиа өөрчилж Засгийн газар ямар нэгэн тогтоол гаргаад байвал энэ том тээврийн салбар ирээдүйд байхгүй болно шүү гэж та бүхэндээ хэлье. Төрийн ой санамждаа аваарай.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За баярлалаа Б.Жавхлан сайд хариулах уу? Тэр талбайтай холбоотой юм асуугаад байна шүү дээ 2 талбайтай холбоотой юм ярьдаг.

УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан: За боловсролын байгууллагын залуу асуулт асуусан. Та аль байгууллагад нь ажилладаг гэсэн бэ?

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Талбай нь наанаа юмуу цаанаа

юм уу? гээд л асуугаад байсан даа. Хулгайн мөнгөөр хэдээр нь цалин нэмэх юм гээд байгаа вэ? Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл асуугаад байгаа.

УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан: Харин хариулах гээд л байна. Залуу маань мэдээллээс нэлээд хол байгаа юм шиг байна даа? Боловсролын салбар, эрүүл мэндийн салбар дээр бид гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн цоо шинэ систем рүү шилжчихсэн шүү дээ.

Эрүүл мэндийн салбарын хувьд дээрх систем рүү 2021 онд шилжсэн. Боловсролын салбар 2022 онд шилжиж байна. Багш нарын цалинг суурь цалинг нь бид нар 1,200.000 төгрөг болгосон, одоо энэ дээрээ гүйцэтгэлд суурилсан цалингаа нэмэлтээр аваад явна.

Уучлаарай, чи мэдээллээ сайн унш. Чи сонсчих асуусан юм аа. Сонсчих л доо, хэрэлдээд байх юм. Эрүүл мэндийн салбар, боловсролын салбарын үр дүнг авахад хугацааны хувьд жоохон өөр шүү. Эрүүл мэндийн салбар сараар гүйцэтгэлээ аваад явна. Боловсролын салбарын хувьд сургуулийн өмнөх боловсролын элсэлтийн ерөнхий шалгалтын хүүхдүүдийн сурагч нарын сурлагын ахиц чанар дээр суурилж гардаг учраас хагас жил, жилээр үнэлэгдэж явах учиртай.

Боловсролын байгууллага, Боловсролын яам бэлтгэл ажлыг хийгээд Монголын бүх Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт стандарт тавиад түвшнийг нь тогтоочихсон байгаа. Үүнд үндэслэж, гүйцэтгэлд суурилоод тухайн сургууль дээр хүүхдүүдийн сурлагын дундаж ахиц хэрхэн гарсныг гол шалгуур болгоно. Сургуулийн өмнөх боловсролын хувьд ч гэсэн энэ үзүүлэлтээр гүйцэтгэлийн санхүүжилтийг нь хийгээд багш нар илүү цалингаа аваад явна.

Сайн багш нар сайн үр дүн гаргасан, боловсролын салбарын төрийн үйлчилгээг илүү чанартайгаар хүргэсэн байгаа. Тааруухан түвшинд хүргэсэн нь тааруухан цалингаа аваад явна.

Тэдний суурь цалин нь 1,200.000 төгрөг. Эрүүл мэндийн салбарт бид нар алдаа оноотой ч гэсэн дээ маш том реформыг эхлүүлсэн байгаа. Сайн цалин авч байгаа эмнэлгүүд ч байгаа, маш сайн санхүүжилт авч байгаа эмнэлгүүд байгаа. 2000-аас доош, ялангуяа 1500-аас доош хүн амтай сумуудад клиник үйлчилгээ бага учраас тэнд өндөр тарифтай санхүүжилтээ авч чадахгүй асуудал байгаа.

Бид суурь татаасыг нэмэх замаар энэ асуудлыг шийдээд явж байгаа. Тэгэхээр та яах вэ? Үйлдвэрчний эвлэлийн хүн бол ажлаа л хийж байна. Сургууль дээр очоод багш нартай уулзаад явбал гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоо дээр боловсролын салбарынхан сэтгэл хангалуун байгаа, энийг их сайн хэрэгжүүлэхээр явж байгаа, та энэ дээр битгий маргалд.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За маш сайхан байгаа гээд хариулчихлаа, ганцхан хүн, тэнд 2 дугаар микрофонд хүн үг хэлэх гээд байна. Энэ хүнээр үг хэлэх үйл ажиллагааг тасаллаа. Одоо та ганц асуултаа асуу, тэгээд үгээ хэл.

Сонсголд оролцогч, иргэн Н.Адьяацэрэн: Та бүгдэд оройн мэнд хүргэе. Сүүлийн 2 сар гаруй бүгдээрээ нүүрсний хулгай ярилаа, нүүрсний салбарын экспорт Монголыг гэжээж байгаа салбар, Улсын Их Хурлын гишүүдээс эхлээд иргэд маань бүгдээрээ асуудалд их болгоомжтой хандаарай. Улсын төсвийг бүрдүүлдэг хамгийн том салбарыгаа бүгдээрээ уурхайтай нь, жолоочтой нь, эзэмшигчтэй нь бүх юмтай нь хулгайч болгож байна.

Худалдан авагчийнхаа эрхэнд халдаж, экспортоо зогсоогоод цалин мөнгөгүй улсын

төсвөө бүрдүүлж болохгүй нөхцөлд хүрвэл яах вэ? Тийм учраас Улсын Их хурлын гишүүд, энэ байгууллагууд маань тоо баримтаа их зөв гаргаж, иргэддээ зөв мэдээлэл өгч, хулгай гэж юуг хэлээд байгаа, алдагдсан боломж гэж алийг нь хэлээд байгаа талаар зөв ойлголт өгөхгүй бол их дүнтэй тооноос болоод хүмүүсийн уур бухимдал хүрээд бүгдээрээ төрөө үзэн яддаг, бизнес эрхэлж байгаа хүмүүсийгээ бүгдээрээ хулгайч гэж боддог, бүгдийг нь хөрөнгийг нь хураа гэдэг боллоо. Иймд гишүүд маань энэ дээр бас их зөв манлайлал үзүүлээрэй гэж хүсэж байна.

Хоёрдугаарт нь би Өмнөговь аймгийн иргэн учраас би та нарт зөв ойлголт өгье гэж хүсэж байна. Өнөөдөр Өмнөговь аймгийг та бүхэн мэднэ. Дээр үед говьд хүн болсноос хангайд бух болсон нь дээр гэдэг байсан. Гэтэл өнөөдөр Өмнөговь аймаг баялгаараа Монгол Улсын олон асуудлыг шийдэж байгаа аймаг. Сүүлийн 15 жил өмнөговьчууд өгөөмөр сэтгэлээ гаргасан, нэг ч уурхайг эсэргүүцээгүй. Өнөөдөр Өмнөговь аймагт 17 уурхай үйл ажиллагаа явуулж байгаа, бүгдээрээ хариуцлагатай сайн уу гэхээр үгүй. Өмнөговьчууд өнөөдөр уух ус нь ховордчихсон, ургамал ногоо нь байхгүй болчихсон, жил дараалан ган болдог, хаашаа нүүхээ мэдэхгүй мал нь бэлчих газаргүй, ийм гандуухан, тоос шороонд булагдсан байдалтай амьдарч байна.

Гэхдээ Өмнөговьчууд үүнийхээ төлөө хэзээ ч төр засагтаа уурлаж, бухимдаж байгаагүй юм. Энэ болгоныг хүлээн зөвшөөрч ирсэн Өмнөговьчууд. Өмнөговьчуудын тэвчээр барагдаж байна. Тийм болохоор энэ танхимд хүмүүс олноороо ирсэн. Гурван жил дараалан ган болж, зудад нэрвэгдэн малаа бэлчээх газаргүй болоод ирэхээрээ хүмүүс бухимдаж байна.

Худгийнхаа усыг булаацалдаад нэг хүн амиа егүүтгэж, нэгнийхээ амийг бүрэлгэж байна. Өмнөговьчууд өнөөдөр хэцүү байгаа учраас Өмнөговийн хүмүүс өнөөдөр энд ирээд үгээ хэлж байна. Тэрийг та бүхэн буруу ойлгоод Монголын баялаг, та нарынх биш гэж хэлж байна.

Өмнөговьчууд баялгаа өгсөн, Өмнөговьчуудыгаа бас харааж зүхэж болохгүй, хоёрдугаарт нь Өмнөговь аймгийн үндсэн иргэд бол их цөөхөн, 45,000 хүн амтай байж байгаад уул уурхай хөгжөөд Өмнөговь аймагт бүртгэлтэй 73,000, суурьшсан хөдөлгөөнт хүн амыг оруулаад 100,000 гаруй хүн байна. Монголын Солонгос болж байгаа нутаг. 21 аймаг, 330 сум, 9 дүүргээс хүн ажиллаж байгаа, тэнд ажиллаж байгаа хүн болгоныг Өмнөговьчууд ад үзээгүй, бүгдээрээ өөрийнхөө үр хүүхэд шиг хүлээгээд авсан ард түмэн.

Тийм учраас өнөөдөр Өмнөговьчууд бухимдах нь аргагүй шүү дээ, бүх уурхай, бүх газар нутгаа өгчихсөн. Байгаа нэг уурхай дээр төр хууль бус, үйл ажиллагаа явуулаад байхаар. Хүмүүс бухимдаад бид яагаад ингээд зовж амьдраад байх ёстой юм гэж хэлж байна. Тэр уурхайг заавал дэмжих ёстой юм уу? Тэгвэл Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцыг хүмүүс эсэргүүцэж байгаа шиг яагаад эсэргүүцэж болохгүй вэ? гэсэн уур амьсгалаар хүмүүс ирж үгээ хэлсэн юм шүү.

Тийм учраас хүмүүс маань зөв ойлгоорой. Та бүхэн маш олон гэр бүл, улс орны эдийн засгийн эх үүсвэр Өмнөговь аймгаас бүрдэж байна. Өмнөговьчууд маш өгөөмөр сэтгэлтэй, хүнд тусархаг, сайхан сэтгэлтэй ард түмэн. Төр сая ингээд хулгайчдыг зарлаж байна. Нүүрс гэхээр Өмнөговийнхон байдаг юм шиг. Улсын Их Хурлын гишүүнтэй хамаарах нүүрстэй холбоод аймгийн дарга нарыг болон бусад бүх хүмүүсийг нь чичлээд байхаар мэдээж хүн л юм чинь уурлана, бухимдана тэр хүмүүс ирж үгээ хэлсэн гэж ойлгоорой. Бүгдэд нь баярлалаа. Бид бүхэн хэн хэнийхээ жаргалыг ойлгодог, хэн хэнийхээ зовлонг нь ойлгодог байх ёстой. Өмнөговьчууд бол төр засгийнхаа өмнө хүлээсэн үүргээ маш сайн биелүүлж байгаа, хэзээ ч юуг ч эсэргүүцдэггүй. Хэцүү байлаа гээд төрийнхнийг очихоор чулуу шидээд

хөөдөггүй ард түмэн шүү. Ойлгож хүлээж аваарай.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Баярлалаа. Үг хэлчихлээ. Т.Доржханд гишүүн тэр залуугийн асуултад товч хариулаарай. Хариулт авна л гээд тэгээд байгаа юм.

УИХ-ын гишүүн Т.Доржханд: За баярлалаа, би маш товчхон хэлье. Цагдаагийн дарга жагсаж байгаа залуучуудыг эмчлэх зорилгоор л авч явсан шүү гэдгээ хэлсэн.

Шадар сайд сууж байх шиг байна, Хууль зүйн сайддаа бас хэлээрэй залуучууд өнөөдөр үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлэх эрх нь бол Үндсэн хуулиар хангагдсан байгаа.

Монгол Улс ардчилсан улс, иргэн хүнийхээ хувиар ч гэсэн Хүн намын даргын хувиар ч Улсын Их Хурлын гишүүний хувиар ч гэсэн 10 хэдэн хоног 15,16,17 хоног гадаа жагссан залуучуудыг, өнөөдрийн энэ нөхцөл байдлыг үүсгэсэн болохоор хорьж цагдаж болохгүй гэсэн байр суурин дээр хатуу зогсож байгаа. Харин ч хүний эрхийг нь хангах ёстой. Хоёрдугаарт, өглөө 9 цаг 30 минутаас манай оролцогчид ирсэн байна, 13 цаг ярилаа, тэгээд хурал даргалагчийн зүгээс зүгээр нэг л юм хэлэх гэсэн юм. Өнөөдрийн хурал бол үр дүнтэй болж байгаа шүү.

Нийт оролцсон хүмүүстээ талархлаа илэрхийлье. Магадгүй санаачлаад шахаад явсан гишүүний хувиар, гишүүдийн нэгийнх нь хувиар хэлэхэд төр өнөөдөр нээлттэй байна, иргэдтэйгээ уулзаж байна, ярьж байна, албан тушаалтнуудыг авчирч байгаад асуудлуудыг нь тулгаж асууж байна. Үр дүн гарч байна. Одоо хуулийн байгууллагынхан ажиллаарай. Иргэд чинь өнөөдөр шударга ёс нэхэж байгаа шүү. Хуулийн байгууллагынхан хэн нэгнээс хамаарахгүйгээр, хэн нэгний эрх мэдлээс хамаарахгүйгээр, хэн нэгэн улс төрийн хүчнээс хамаарахгүйгээр ажлаа хийгээрэй.

Шаардлагатай бол дэмжлэг үзүүлж бас болно шүү. Эцэст нь хэлэхэд нээлттэй хэлэлцсэнээрээ бид тодорхой мэдээллүүдийг олж авч байгаа шүү. Энэ нь цаашаагаа үргэлжлээд явах байх. Та бүхэнд хүрэлцэн ирж бас идэвхтэй орсонд баярлалаа гэж хэлье.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За одоо больё оо, чи одоо бас яах гээд дахин гараад ирэв? Нөгөө эрээн цамцат. Одоо дахин асуухгүй. Энэ арай дэндлээ шүү дээ, өдөржингөө л одоо та нар ингээд ярилаа шүү дээ. За тэгээд та 2 юм уу? Нэг нэг юмаа асуу.

Сонсголд оролцогч /нэрээ хэлээгүй/: За би үгээ хэлээдэхье. баярлалаа, ямар ч байсан тэгээд бид нар энд байна. Залуучууд тэнд одоо яах вэ? Эмнэлэг, эмнэлэг гээд явчих шиг боллоо.

Сая 7, 8 залуучууд, бас хар масктай нэг ах машин хүлээж байгаа шүү гээд яриад байх шиг байна. Нэр усыг нь асуусан чинь хэлэхгүй байна. Тэр нь юу гэж байгаа юм бол? Бид нарыг шууд эмнэлэг хүргэж өгөх гээд байгаа юм болов уу? Яг яах гээд байгаа нь мэдэгдэхгүй.

Тэгээд түрүүн намайг ингээд чирч гарсан. Тэгээд би асуулаа л даа яасан юм бэ гэсэн чинь та нарыг гадаа хар машинтай хүлээж байгаа шүү. Буцаж ороод одоо гараад ирээрэй л гэж байна. энэ юу гэсэн үг юм бол оо? Та үүнийг бас хэлээд өгөөч. Энэ хууль хүчний байгууллагууд болон Т.Доржханд гишүүнээс бас асуугаадахья. Та хэд өнөөдөр энд байж байдаг, гараад бид нар яах вэ, бид “Та нар огцор”, “УИХ” тар, энэ ордныг шатаая гээгүй шүү дээ. Нэг л зүйл хэлж байгаа юм, Нүүрсний хулгайчидтай тэмцээч ээ, аль нэг нам биш, тийм

ээ, АН-аараа биш, МАН-аараа биш, зүгээр л нүүрсний хулгайчтайгаа тэмцчих.

Тэгээд энэ УИХ-д байгаа нэр холбогдсон гишүүдийнхээ бүрэн эрхийг түдгэлзүүлж байгаад шалгачих. Гуравдугаарт хорин хоёрын нэг буюу авлига, албан тушаалын хуулийг чангатгаач. Энэ л 3 зүйлийг хэлж бид одоо хүртэл зогсож байгаа.

Сайхан нийгмийг бадраая л даа. Одоо алийн болгон одоо гадагшааа явах вэ? Байгалийн баялгаараа дэлхийд тавд, газар нутгаараа дэлхийд нэгд ордог энэ сайхан монголчууд, цөөхөн монголчууд нэг эвлэн нэгдэж болдоггүй юм уу?

Ах эгч нар аа, энэ одоо мундаг, одоо хүчний байгууллагын ах эгч нар аа. Юмыг дандаа буруутгаж байх юм. Хэн нэгнээс мөнгө авсан юм уу? энэ тэр гээд байх юм. Өмнөх тогтолцооныхоо арга барилаа нэг сольчихооч ээ. Тэр одоо энэ гадаа сонсож байгаа байх, би нэрийг нь мэдэхгүй байна, тэр ах нар одоо болиорой. Бид нар аль нэг хүнээс мөнгө төгрөг аваагүй, зүгээр нэг л зүйл хэлж байгаа шүү дээ. Сайхан нийгмийг бий болгож, ирээдүйг хулгайлсан нүүрсний хулгайч нартайгаа тэмцээч ээ л гэж хүсэж байгаа юм. За баярлалаа. Бид нар эрүүл мэндээ та хэдэд даатгаж байгаа шүү. Баярлалаа, айж байгаа юм биш шүү. Зүгээр үнэнийг нь хэлж байгаа юм. За баярлалаа.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Дууслаа гэсэн. Яагаад ингээд дахиад дахиад гараад ирдэг юм? Ингээд байвал дуусахгүй шүү дээ наадах чинь. За Хишигсүрэн байж бай л даа чи. Байж бай л даа чи. Мэдэж байна ш дээ наадахыг чинь. Яах гээд байгаа юм. Сангийн сайд чинь хариулж чадахгүй, мэдэхгүй гэсэн шүү дээ наад асуултыг чинь. За чи асуу, чи одоо хэд хэдэн удаа ч босов доо.

Сонсголд оролцогч /нэрээ хэлээгүй/: За баярлалаа, олон гэж 3 дахиа гарч ирж байна.

Сонсгол даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: Юу гурав дахь аа гэж.

Сонсголд оролцогч /нэрээ хэлээгүй/: Цагдаагийн газрын дэд даргаас би асуучихъя аа. Цагдаа нар ингээд гадаа байгаа иргэдийг яасан гэж хүчээр авч явж байгаа юм?

Та нарт хүчээр авч явах эрх байдаг юм уу? Залуучууд ерөөсөө хүч хэрэглээгүй зүгээр 20 настай 18 настай охидыг зүгээр байхад нь та нар хүчээр эрүүл мэндийн үзлэгт хамруулах эрхтэй юм уу?

Яг энэ дээр яг одоо хариулт авчихъя ах аа, та сая яагаад худлаа ярьж байгаа юм? Тэнд байгаа тэр хүмүүсийг зүгээр байхад эрүүл мэндийн үзлэгт яагаад оруулж байгаа юм бол тэндээ үзэл бодлоо илэрхийлээд хэвтэж байгаа байх, тэр эсгий болон бусад юмыг нь яагаад бүгдийг нь хурааж аваад тарааж байгаа юм, яг энэ дээр яг бодит хариултыг нь авчихъя ах аа, яг одоо авчихъя, гадаа ямар ч хүн байхгүй, ард түмний авчирч өгсөн эсгий, дулаалга бүх юмыг нь хураагаад ачаад аваад явчихсан, бүгдийг нь сугадаад хүчээр аваад явсан байгаа,

Энэ залуучууд чинь бас гэр гэртээ хариад эм тангаа уугаад хоол ундаа хийгээд амарч сэлгэчхээд хүрч ирдэг. 18, 19 настай охидыг бүр ингээд чирээд хүчээр аваад явж байгаа. Бид нар ерөөсөө танай энэ ордон руу чинь, танай цагдаа нар руу ерөөсөө бид нар хараагаа ч үгүй, муухай ч хараагүй, тэгсэн чинь яагаад тэд нар ингээд хүчээр аваад явж байгаа юм бэ?, залуучуудыг эрүүл мэндийн төв дээр аваачаад хорьчихсон, гаргахгүй, гарах юм бол, талбай руу явах юм бол та нарыг хорино, цагдана гэж хэлсэн гэж байна. Над руу ингээд чат биччихсэн, би худлаа яриагүй, энэ дээр ахиад тодруулга авчихъя даа. Та ингээд олон

нийтийн өмнө ийм юмаар ингээд худлаа яриад байж болдог юм уу?

Цагдаагийн ерөнхий газрын Дэд дарга, цагдаагийн хурандаа П.Оростогоо: За хариулт хэлье ээ, өдөр би бас хэд хэдэн удаагийн асуултад хариулт хэлсэн, тэгээд намайг худлаа яриад байна гэсэн. Би албан ёсоор энэ төв штабын мэдээллийг аваад ирлээ, тийм учраас би уншаад өгчихье.

Нийслэлийн СБД-ийн 6 дугаар хороо Сүхбаатарын талбайд энэ оны 12 дугаар сарын дөрөвний өдрөөс эхлэн зохион байгуулагдаж буй жагсаал цуглаан 17 дахь өдрөө үргэлжилж байгаа бөгөөд цагдаагийн байгууллагаас хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлж буй иргэнээ гэмтэл, халдлагаас хамгаалж, хэв журам сахиулах үйл ажиллагаанд нээлттэй, хүндэтгэлтэй хандан ажиллаж байна.

Мөн жагсаал цуглаанд оролцогч иргэд олон хоногоор гадаа суулт хийсэн. Цаг агаарын байдлаас шалтгаалан жагсагчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлээс сэргийлэх үүднээс эмнэлгийн байгууллага, эмч тогтмол эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж ажилласан. Улмаар энэ оны 21-ний өдөр хяналтын ерөнхий сонголт нээлттэйгээр зохион байгуулагдахтай холбоотойгоор Төрийн ордны баруун хойд талын хаалганд нэр бүхий 30 иргэн нүцгэлэн тодорхой шаардлага тавьж эсэргүүцлээ илэрхийлсэн тул эрүүл мэндийн ажилтнууд Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн нэгийн нэг, 43 дугаар зүйлийн хоёрын тавдугаар зүйлд заасны дагуу эрүүл мэндээ эрсдэлд учруулахгүй байх, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах талаар шаардлага, зөвлөмж өгсөн боловч хүлээн авахаас татгалзсан.

Тиймээс тэдгээр иргэдийнхээ амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эмч, эмнэлгийн ажилтнуудын албан үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжийг хангах зорилгоор эрүүл мэндийн байгууллагад хүргэх ажлыг зохион байгуулсан. Мөн СБД-ийн Эрүүл мэндийн нэгдсэн төвөөс Сүхбаатарын талбайд суулт хийж байгаа жагсагчдын эрүүл мэнд, амь настай холбоотойгоор нарийн мэргэжлийн шинжилгээнд хамруулах шаардлага үүссэнтэй холбогдуулан дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах хүсэлтийн дагуу 18 цаг 30 минутад суулт хийж байсан 16 иргэнээс Гэмтэл судлалын үндэсний төвийн түлэгдэлтийн эмнэлэгт 12 иргэнийг, үлдсэнийг нь Цэргийн төв эмнэлэгт тус тус хүлээлгэн өгсөн.

Одоогоор дээрх үйл ажиллагаанд холбоотойгоор баривчилсан саатуулсан хүн байхгүй байна. Хүйтний цаг агаарын нөхцөл байдалтай холбоотойгоор иргэдийнхээ амь нас, эрүүл мэндийг хамгаалах суулт зарласан иргэдийг Соёлын төв өргөөнд байрлуулан үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, тайван замаар хуран цуглах эрхийг нь хангах зорилгоор Сүхбаатарын талбайд Цагдаагийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх үүднээс шаардлага тавих замаар чөлөөлсөн болно. Ийм хариулт авсан байна шүү дээ.

Сонголт даргалагч, УИХ-ын гишүүн С.Чинзориг: За баярлалаа. За ингээд сонголт оролцсон иргэдээс асуулт асууж, үг хэлье гэсэн 85 иргэнээс 55 иргэн үг хэлж дууслаа. Ингээд сонголын үйл ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье.

Тэмдэглэлтэй танилцсан:

СОНСГОЛ ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

С.ЧИНЗОРИГ

Тэмдэглэл хөтөлсөн:

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАР